



ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

ХУУЛЬ ДЭЭДЛЭХ ЁС

ХУУЛЬ ЗҮЙН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, СУДАЛГАА, ОНОЛ,
ПРАКТИКИЙН СЭТГҮҮЛ



2007 №4(19)

ЭНЭ ДУГААРТ:

Төрийн байгууллагын хууль тогтоомж

Нийтийн эрх зүй дэх захиргааны гэрээ хувийн эрх зүйн гэрээгээс ялгагдах онцлог, шүүхийн хяналт
/Нийслэлийн Захиргааны хэргийн шүүхийн шүүгч
Ц.Цогт/.....4-8

Шүүх эрх мэдэл

Шинээр илэрсэн нөхцөл байдал
/Улсын дээд шүүхийн шүүгч **А.Доржготов**/.....9-16

Шүүхийн жишиг ба заншил
/ХЗУТ-ийн Олон улсын эрх зүйн секторын эрдэм шинжилгээний ажилтан **Б.Гүнбилэг**/.....(17-20)

Криминологит

Хүүхдийн гэмт хэргийн шүүн таслах ажиллагаанд гарч буй хүндрэл бэрхшээл, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ
/Нийслэлийн шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн **Б.Сарантуяа**/.....21-22

Криминаликтикийн экспертизийн ангиллын онол, практикийн зарим асуудал
/НЦГ-ын Эрэлч нохойн алба, Үнэрийн лабораторийн эрхлэгч, докторант, цагдаагийн дэд хурандаа **Б.Жаргалсайхан**/.....23-28

Цагдаагийн байгууллагын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэдийг татан оролцуулах зарим асуудал
/НЦГ-ын Олон нийтийн харилцааны хэлтсийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тасгийн ахлах байцаагч, цагдаагийн хошууч, магистрант **Л.Цэрэнням**/.....29-33

Мансууруулах олсны ургамлын хууль бус хэрэглээтэй холбоотой зарим асуудал
/Их Засаг" их сургуулийн магистрант **С.Хаш-Эрдэнэ**/.....34-36

Прокурорын хяналт

Эд хөрөнгийн хохирол, түүнийг нотлох ажиллагаа
/УЕПГ-ын хяналтын прокурор, хууль зүйн магистр **Х.Батчимэг**/.....37-41

Иргэний хууль тогтоомж

Гэр бүлийн эд хөрөнгийн маргаан ба шүүхийн практик
/ХЗУТ-ийн Иргэний хууль тогтоомжийн секторын эрдэм шинжилгээний ажилтан **О.Отгонтуяа**/.....42-45

Сэтгэл санааны гэм хорын тухай ойлголт буюу гүтгэлэг, нэр төр гутаах асуудлын талаарх эрх зүйн зохицуулалт
/ХЗДХЯ-ны мэргэжилтэн **Ш.Үнэнтөгс**/.....46-54

Олон улсын эрх зүй, харьцуулсан эрх зүй

Харьцуулах, эс харьцуулах эрх зүй
/ХЗУТ-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор, профессор, гавьяат хуульч **Б.Чимид**/.....55-60

Оросын эрүүгийн эрх зүй дэх ял шийтгэлийн зорилгын тухай

/Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсийн мөрдөн байцаагч, комиссар, докторант **Д.Золжаргал**/.....61-63

Олон улсын эрүүгийн Шүүхийн Ромын дүрмийг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх асуудал
/МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Олон улсын эрх зүйн тэнхимийн багш **М.Уянга**/.....64-67

Олон улсын худалдааны эрх зүй ба хүний эрхийн хоорондын уялдаа, холбоо
/ХЗУТ-ийн Олон улсын эрх зүйн секторын эрдэм шинжилгээний ажилтан **П.Баяр**/.....68-70

Дэлхийн худалдааны байгууллагын эрх зүйн ач холбогдлыг эргэцүүлэхүй
/ХБНГУ, Бремений их сургуулийн магистрант **Ц.Монголхатан**/.....71-74

"Гадаад улсын иргэн" гэх ойлголтын ОХУ-ын хууль тогтоомж дахь эрх зүйн зохицуулалт
/Буриадын улсын их сургуулийн Хууль зүйн факультетын Олон улсын болон Үндсэн хуулийн эрх зүйн тэнхимийн ассистент **А.Г.Тышкенова**/.....75-76

Шүүхийн шийдвэр гүйцэтгэл

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 67 дугаар зүйлд хийх мониторингийн дүн, цаашид хэрэгжүүлэх зөвлөмж
/МУИС-ийн Хууль зүйн сургуулийн багш, докторант **С.Болормаа**/.....77-79

Албадан ажил хийлгэх ял ногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг гүйцэтгэх ажиллагааны онцлог, практикийн зарим асуудал
/ШШГЕГ-ын Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих тасгийн ахлах байцаагч, ахлах дэслэгч **Ч.Өнөрцэцэг**/.....80-83

Хорих ялын үр нөлөө, түүнд хийсэн дүн шинжилгээ
/ХЗУТ-ийн Криминологийн судалгааны секторын эрдэм шинжилгээний ажилтан **Г.Оюунболд**/.....84-89

Эрх зүйн үйлчилгээ

Шилжин суурьших хөдөлгөөний өнөөгийн байдал, цаашид анхаарах асуудал
/ИБМУТ-ийн Иргэний үнэмлэх, шилжилт хөдөлгөөний асуудал хариуцсан мэргэжилтэн **М.Сэлэнгэмөрөн**/.....90-92

Мэдээ, мэдээлэл

Монгол Улсын хууль зүйн салбарт 12 жил.....93

Монгол дархны гайхамшиг.....94-95

Монголын Шүүгч эмэгтэйчүүдийн холбоо Олон улсын Шүүгч эмэгтэйчүүдийн холбооны гишүүн боллоо.....96

"Хууль дээдлэх ёс" сэтгүүлийн 2007 оны нийтлэлийн жагсаалт.....97-100

CONTENT:

State organization legislation

The differences between private law contracts, administrative law contracts of public law, and judicial supervision

/Ts.Tsogt, Judge, Capital City Administrative court/.....4-8

Judicial power

Special plea in bar

/A.Dorjgotov, Judge, Supreme court/.....9-16

Judicial precedent and customary law

/B.Gunbileg, Researcher of NLC/.....17-20

Criminology

Problems on pending in court of child criminality, and possible solutions

/B.Sarantuya, Head of criminal chamber, Metropolitan court/.....21-22

Theoretical and practical issues on classification of different types of crimes and expert examination

/B.Jargalsaihan, The lieutenant colonel of police, Ph.D candidate, Head of Odourology laboratory, Police canine service of Metropolitan Police Department/.....23-28

Some issues involving citizens to prevent from offences

/L.Tserennyam, The major of police, the senior inspector of Metropolitan Police Department/.....29-33

Some issues related to the drug addiction

/S.Hash-Erdene, The taking postgraduate course at the "Ikh Zasag" University/.....34-36

Prosecutors supervision

Property loss and its demonstrative actions

/H.Batchimeg, Supervising prosecutor, The State General Prosecutor's Office, MA/.....37-41

Civil legislation

Family property disputes and practice of court

/O.Otgontuya, Researcher of NLC/.....42-45

Legal regulation of dishonour, denigration and personal injury

/Sh.Unentogs, Specialist of the Ministry of the Justice and Home affairs/.....46-54

International law, comparative law

Comparative and non-comparative law

/B.Chimid, Merited lawyer, Dr., Prof., Scientific secretary of NLC/.....55-60

Purpose of sentencing someone through Russian criminal law

/D.Zoljargal, Inspector of Independent Authority Against Corruption, Ph.D candidate/.....61-63

Issues on implementing the Rome statute of International Criminal Court nationwide

/M.Uyanga, Teacher, School of law, National University of Mongolia/.....64-67

Coherence between human rights and International merchandise law

/P.Bayar, Researcher of NLC/.....68-70

Pondering into legal significance of World Trade Organization

/Ts.Mongolhatan, The taking postgraduate course at the University of the Bremen, Germany/.....71-74

Legal regulation of concept "the foreign citizen" in the legislation of Russia

/A.G.Tishkenova, The assistant of the University of the Buryatia/.....75-76

Executory process

Monitoring result for article 67 of Implementing court decisions, and some considering issues to further implementation

/S.Bolormaa, Teacher, School of law, National University of Mongolia, Ph.D candidate/.....77-79

Characteristic of executory process, assignment of punishment for forced labour and issue of practice

/Ch.Onortsetseg, The senior lieutenant, the senior inspector of General Authority for Implementing court decisions/.....80-83

Analyze for impact of liberties efficacy

/G.Oyunbold, Researcher of NLC/.....84-89

Legal service

Present situation of migration and the further issues to consider

/M.Selengemoron, Specialist of CRO/.....90-92

News

12 years in the Mongolian legislative sector.....93

Wonder of Mongolian craftsman.....94-95

The Mongolian Association of Women Judges joined to the International Judges Women Federation.....96

List of "Huuli deedlekh yos" magazine, 2007 years.....97-100

Сэтгүүлийн зөвлөлийн гишүүд:

Ц.БАТ-ОРИНХ Сэтгүүлийн зөвлөлийн ерөнхий эрхлэгч

ГИШҮҮД:

Л.Бямбаа	- Улсын дээд шүүхийн шүүгч, доктор
Гарри Лэдбэтгэр	- АНУ-ын ОУХА-ийн ШЭМШХ-ийн удирдагч
Д.Даваа-Очир	- Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албаны дарга, доктор
Н.Дагва	- Нийслэлийн нүүхийн Тамгын хэлтсийн дарга
А.Доржготов	- Улсын дээд шүүхийн шүүгч
Л.Заяа	- ГТХАН-ийн ХСДСТ-ийн удирдагч
О.Зоригт	- Цагдаагийн ерөнхий газрын Тамгын газрын дарга, доктор
Э.Лхагвасүрэн	- Үндсэн хуулийн цэцийн ажилтан
Д.Наранчимэг	- Отгонтэнгэр Их сургуулийн захирал
А.Оюунчимэг	- Монголын нотариатчдын танхимын ерөнхийлөгч
Б.Пүрэвням	- Үндсэн хуулийн цэцийн гишүүн
Т.Уранцэцэг	- Сонгинохайрхан дүүргийн шүүхийн шүүгч
Ш.Үнснотгс	- ХЗДХЯ-ны мэргэжилтэн
Б.Цэрэнбалтав	- Улсын ерөнхий прокурорын орлогч
Б.Чимид	- ХЗҮТ-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, гавьяат хуульч, доктор, профессор
Н.Чиябат	- Оюуны өмчийн газрын дарга
А.Эвхжав	- Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төвийн дарга

Дугаарыг эрхэлсэн: Д.УЯНГА

Сэтгүүлийн хариуцлагатай
нарийн бичгийн дарга

НИЙТИЙН ЭРХ ЗҮЙ ДЭХ ЗАХИРГААНЫ ГЭРЭЭ ХУВИЙН ЭРХ ЗҮЙН ГЭРЭЭНЭЭС ЯЛГАГДАХ ОНЦЛОГ, ШҮҮХИЙН ХЯНАЛТ

Нийтийн эрх зүйд хамаарах улс төрийн (үндсэн хуулийн) болон шүүхийн (процессын) харилцаанаас бусад дийлэнхийг захиргааны эрх зүй болон түүнд зарим талаараа хамаарах салбар эрх зүйгээр зохицуулна хэмээн тооцвол "алд дэлэм" алдсан хэрэг болохгүй гэж найдъя. Үүнд нийтийн захиргааны дотоод үйл ажиллагаа болон чиг үүргээ хэрэгжүүлэхээр бусад оролцогчтой харилцсан үйл ажиллагааг зохицуулсан эрх зүйн хэмжээ хамаарна. Захиргааны эрх зүй нь нийтийн захиргааны үйл ажиллагааг зохицуулж буй (хүн болгонд биш зөвхөн төрөөс тусгайлан эрх олгогдсон этгээдүүдийн хувьд) эрх зүйн хэм хэмжээний нийлбэр цогц юм¹.

Ингээд "нийтийн захиргаа" -ны үйл ажиллагаа зөвхөн захиргааны эрх зүйгээр зохицуулагдана гэж дүгнэвэл "захиргааны эрх зүйн гэрээ" болон "нийтийн эрх зүй дэх захиргааны гэрээ" гэсэн хоёр нэр томьёо агуулгын хувьд зарчмын ялгаагүй болно. Нийтийн эрх зүй дэх захиргааны гэрээ² буюу Захиргааны эрх зүй гэрээний үндсэн шинжүүд нь нийтийн ашиг сонирхлыг илэрхийлэн удирдан зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлэх "захиргаа" -ны үйл ажиллагааны хэлбэр болон хуульд хэлбэржсэн, зөвхөн захиргааны (нийтийн) эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагдах харилцааг үүсгэж, өөрчилж, дуусгавар болгож байх явдал юм.

Нийтийн болон захиргааны эрх зүйн харилцаанд оролцох байхдаа буюу нийтийн эрх зүйн хэм хэмжээгээр өөрт олгогдсон үндсэн эрх, үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны явцад захиргаа хувийн эрх зүйгээр зохицуулагдах (иргэний гэрээ) гэрээ байгуулах тохиолдолд



Нийслэлийн Захиргааны хэргийн шүүхийн шүүгч Ц.ЦОГТ

байх уу? Жишээ: төрийн өмчийг түрээслүүлж буй гэрээний хувьд нэг талаас, Эрүүл мэндийн яам чиг үүргээ буюу Эрүүл мэндийн тухай, Засгийн газрын тухай, Яамдын эрх зүйн байдлын тухай хуулиудаар ногдуулсан эрх, үүргээ биелүүлж хувийн хэвшлийн эмнэлгүүдийг дэмжиж, тэднийг ажиллах нөхцөл болгож оор хангахын тулд түрээсийн байраар хангах шийдвэр (эрх олгосон захиргааны акт) гаргажээ. Нөгөө талаас, Төрийн өмчийн хороо Эрүүл мэндийн яамны шийдвэрийг хэрэгжүүлэхийн тулд мөн л захиргааны эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагдсан төрийн өмчийг түрээслүүлэх гэрээ³ (захиргааны хамтын ажиллагааны хэлбэр) байгуулсан байна.

Энэ жишээнд төрийн өмчийг түрээслүүлэх гэрээг байгуулах, түүгээр зогсохгүй уг түрээсийн гэрээнд заавал тусгагдах зарим нөхцөлийг⁴ захиргааны эрх зүйн хэмжээ болох Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар зохицуулсан байдаг боловч захиргаа

иргэний эрх зүйн гэрээний хэлбэрийг ашиглаж байна.

Дүгнэвэл, нийтийн захиргааны байгууллага (Эрүүл мэндийн яам, Төрийн өмчийн хороо) өөрийн үйл ажиллагааг хэвийн явуулахад ашиглах зорилгоор дээрх "түрээсийн гэрээ" –г байгуулаагүй харин захиргааны байгууллагаас өөрийн үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хэлбэр болгон ашигласан. Нөгөө талаас захиргааны байгууллага нэг тал болон оролцсон гэрээ бүхэн захиргааны эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагдахгүй, төрийн өмчийг түрээслүүлэх журам нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Иргэний хуульд үндэслэгдсэн буюу зохицуулагдсан байдаг.

Хувийн эрх зүйн гэрээнээс ялгагдах онцлог: Үндэсний эрх зүйн тогтолцоонд дахь салбар эрх зүйг ангилгах гол шинж нь тэдгээрээр зохицуулагдах зүйл, зохицуулалтын арга байдагт судлаачид санал нэгтэй байдаг ажээ. Тэгвэл "гэрээ" өөрөө эрх зүйн зохицуулалтын түгээмэл арга болохын хувьд нийтийн болон хувийн эрх зүйн аль алинд зохицуулалтын арга болох нь тодорхой байна.

Гэрээний ерөнхий ойлголтоос захиргааны оролцсон гэрээг тодорхойлон гаргаж, дараа нь нийтийн эрх зүй дэх захиргааны гэрээ болон хувийн эрх зүйн гэрээний онцлог ялгааг тодруулахыг хичээе.

Гэрээний талаарх ерөнхий тодорхойлолтыг иргэний (хувийн) эрх зүй дэх гэрээний ойлголтоос иш татах нь гарцаагүй, учир нь хувийн эрх зүй дэх зохицуулалтын үндсэн арга нь харилцан зөвшилцөж тохиролцох (хэлбэр нь гэрээ) байдаг. Иргэний эрх зүйн судлаачид гэрээг дараах байдлаар тодорхойжээ.

¹ Одгэрэл.П. Захиргааны эрх зүйн ерөнхий анги. УБ: 2004 он. 21 дэх тал

² Гэрээ –захиргааны гэрээ –нийтийн эрх зүй дэх захиргааны гэрээ; Ц.Цогт

³ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль. 1996 он. Хорин наймдугаар зүйл.

⁴ Түрээсийн гэрээнд Иргэний хуулийн 105 дугаар зүйлд заасан нөхцөлөөс гадна эд хөрөнгө түрээслүүлэх хугацаа, төлбөр, нөхцөл, хугацаанаас өмнө цуцлах үндэслэл, үүсэх үр дагавар, түүнийг арилгах журмыг заавал тусгана.

Үүнд, "Гэрээ гэдэг нь иргэний эрх, үүргийг үүсгэж, өөрчилж, дуусгавар болгоход чиглэсэн, хоёр буюу түүнээс дээш этгээдийн хооронд хийсэн тохиролцоо юм"⁵, "Хоёр буюу түүнээс дээш тал ямар нэгэн зүйлийг хийхээр эсвэл хийхгүй байхаар тохиролцсон хуулийн хувьд хүчин төгөлдөр хэлэлцээрийг гэрээ гэнэ" гэж Австрали улсын Мельбурнын Их сургуулиас 1999 онд хэвлүүлсэн "Гэрээний хууль" нэртэй номонд тодорхойлсон байхыг өөр нэгэн судлаач харьцуулсан судалгаандаа⁶ дурджээ.

Эдгээрээс "гэрээ нь эрх зүйн харилцаанд оролцогчдод эрх, үүрэг үүсгэх, өөрчлөх, дуусгавар болгоход чиглэсэн хоёр буюу түүнээс дээш талын тохиролцоо" гэсэн ерөнхий ойлголтдод хүрэх боломжтой байна.

Гэрээ нь зөвхөн тэгш эрхтэй субъектүүдийн хооронд хийддэг гэсэн ойлголт нь нэлээд хуучирсан шинжийг агуулж байна. Учир нь эрх зүйн хөгжлийн хандлагаас шууд шалтгаалан тэгш бус эрхтэй субъектүүд хүртэл аливаа үйл ажиллагааг хийх эсхүл хийхгүй байхаар гэрээ байгуулах боломж нийгмийн харилцаанд өргөн байна.

Иймд "гэрээ" -г тодорхойлох хамгийн гол шинж бол тухайн гэрээгээр эрх, үүрэг хүлээсэн талууд "гэрээний нөхцөлийг зөвшөөрсөн" байх шинж юм. Жишээ нь нэг талд хэтэрхий давамгай эрх олгогдсон гэрээг нөгөө тал зөвшөөрсөн бол "гэрээ" болно.

Дээрхээс үзвэл эрх зүйн харилцаанд бие даан оролцож буй "нийтийн захиргаа" -ны байгууллагаас өөр бусад этгээдтэй тодорхой асуудлаар эрх, үүрэг үүсгэх, өөрчлөх, дуусгавар болгох зорилготойгоор хийсэн тохиролцоо нь захиргаанаас байгуулсан гэрээ болно. Өөрөөр хэлбэл нийтийн захиргаа, түүний байгууллага оролцогч болсон аливаа гэрээ нь захиргааны оролцсон гэрээ буюу захиргаанаас байгуулсан гэрээ мөн юм. Хувийн эрх зүйн харилцаанд оролцож буй нийтийн захиргааны байгууллага гэрээний оролцогч

байж болно.

Гэвч энэ бүгдийг "захиргааны гэрээ" гэдэг ойлголтдод хамруулах боломжгүй. Учир нь сонгодог утгаараа "захиргааны гэрээ" гэж нэрлэгдэх нь нийтийн захиргаа чиг үүргээ хэрэгжүүлэхийн тулд явуулж буй үйл ажиллагааны хэлбэр болсон тэр гэрээ байх юм.

Харин нийтийн захиргааны байгууллага хувийн эрх зүйн харилцаанд субъектээр оролцох явцада буюу гагцхүү "захиргаа" өөрөө нийгмийн бүрэлдэхүүн, элемент болохын хувьд оршин тогтнох, үйл ажиллагаагаа хэвийн явуулахад зориулагдан хийгдэж буй гэрээ нь "захиргааны гэрээ" болж чадахгүй. Энэ нь нийтийн захиргааны чиг үүрэгт огт хамааралгүй, тухайн захиргааны байгууллагын дотоод ашиг сонирхол, хэрэгцээг хангахад чиглэгдсэн, түүнийгээ гүйцэлдүүлсэн үйл ажиллагааных нь хэлбэр юм.

Жишээ нь, "Х" сэдэвт гарын авлага бичих талаар Хууль зүйн үндэсний төв, зохиогч хоёрын хооронд байгуулсан "ажил гүйцэтгэх гэрээ" нь хэлбэрийн хувьд иргэний эрх зүйн ажил гүйцэтгэх гэрээ мөн боловч, энэхүү гэрээний үр дүн хэлд хэрэгтэй болох (хэний эрх ашгийг илэрхийлж байгаа) талаас нь үзвэл нийтэд Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн талаарх мэдээлэл, сурталчилгаа хийх Засгийн газрын үүргийг гүйцэтгэхийн тулд Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа Хууль зүйн үндэсний төвөөс хэрэгжүүлсэн нийтийн эрх ашгийг (шууд бусаар) илэрхийлсэн шинжтэй гэрээ болох нь харагдана.

Нийтийн эрх зүй дэх захиргааны гэрээний хувийн эрх зүйн гэрээнээс ялгагдах гол шинж нь тухайн гэрээг байгуулснаар хүрэх үр дүн нь захиргааны (төрийн) чиг үүргийг хэрэгжүүлсэн байх явдал юм.

Гол нь тухайн гэрээг байгуулсан талуудаас хамааралгүйгээр гэрээний нөхцөл, гэрээгээр хүрэх үр дүн юу болох энэ нь аль эрх зүйгээр

зохицуулагдахаас хамаарч нийтийн эрх зүй дэх захиргааны гэрээ, хувийн эрх зүйн гэрээний алин болохыг тодруулах боломжтой юм. Энэ нь юуны өмнө захиргааны эрх зүйн салбарт гэсэн утгатай бөгөөд энэ шинжээрээ "захиргааны гэрээ" нь хувийн эрх зүйн, нийтийн эрх зүйн бусад салбар болох үндсэн хуулийн, олон улсын эрх зүйн гэрээ болон эрх зүйн хүрээнээс хальсан буюу эрх зүйн бус үйлдлээс ялгаатай.

Нийтийн эрх зүйн хүрээнд байх шаардлага нь гагцхүү "захиргааны эрх зүйн салбар" гэсэн утгатай. Энд захиргааны байгууллага гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлээгүй бол түүний үйлдлийг мөн хамааруулахгүй байх болно.

Нийтийн эрх зүй дэх "захиргааны гэрээ" -ний ойлголт нь зарим судлаачийн тодорхойлсон "захиргааны эрх зүйн гэрээ" -тэй утга агуулгын хувьд ойролцоо байдлаар тодорхойлогдсон болно.

Хууль тогтоогчид нийгмийн харилцааг мэдэрч уг харилцаанд тохирсон аргыг хуульчлах шаардлагатай байдаг. Хувийн эрх зүй дэх харилцааны явцад "захиргаа" гэрээний аль нэг тал болох оролцсон тохиолдолд нийтийн захиргааны байгууллагын хуулиар хүлээсэн эрх, үүргийг хэрэгжүүлэхэд хамааралгүй зөвхөн тухайн байгууллагын өөрийн хэвийн үйл ажиллагааг хангах, оршин тогтноход шаардлагатай нөхцөлийг бий болгоход чиглэсэн нөхцөлийг тохиролцсон байдаг.

Монгол улсын нийтийн захиргааны байгууллага "төр ашгийн төлөө аж ахуйн үйл ажиллагааг зөвхөн төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн хэлбэрээр явуулна", "улсын төсвийн байгууллага ашиглагдаагүй мөнгөн хөрөнгөө... банкнд хүтэйг хадгалуулж болно", "төсвийн байгууллага... төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээнээс гадуур бүтээгдэхүүнээ худалдаж нэмэлт орлого олж болно"⁸ гэх зэрэг хуульчлагдсан эрхийн дагуу аж ахуйн үйл

⁵ Наранчимэг Д. Иргэний эрх зүйн үндсэн асуудал. 1 дүгээр дэвтр. УБ, 1999 он. 92 дахь тал

⁶ Цолмон Д. Гэрээний эрх зүй УБ, 2003 он. 16 дахь тал

⁷ Монголын Нээлттэй Нийгэм Хүрээлэн (Соросын сам). Олдрэл, П. Гадаадын их, дээд, сургууль төгсгөчдийн эрдмийн бүтээлийн эмхтгэл. УБ, 2003. 21 дэх тал

⁸ Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтын тухай хууль, 2002 он. 13 дугаар зүйлийн 3, 13 дугаар зүйлийн 5, 20 дугаар зүйлийн 3-т.

ажиллагааг явуулж, энэ хүрээнд үүсэх харилцааг зохицуулахдаа иргэний эрх зүйн гэрээ байгуулна.

Энгийн жишээ бол Нийслэлийн Засаг даргын Тамгын газар бичиг хэргийн материал олж авахаар худалдах, худалдан авах гэрээ байгуулсан нь захиргаа нэг тал болон оролцогч болсон гэрээ мөн боловч нийтийн эрх ашгийг илэрхийлсэн захиргааны үйл ажиллагааны хэлбэр болж чадахгүй. Зөвхөн өдөр тутмын бүтээгдэхүүн болсон захиргааны актуудаа бичмэл хэлбэрт оруулах цааसाа бэлтгэж буй явдал юм. Энэ утгаараа нийтийн эрх зүй дэх захиргааны гэрээ биш болно.

Захирах – захирагдах харилцаанд ихэнх тохиолдолд нийтийн эрх зүй, харин тэгш эрхийн зарчимг харилцаанд хувийн эрх зүй үйлчилдэг. Гэхдээ нийтийн эрх зүйд ч ижил төвшин эсхүл бие биетэйгээ шууд захирах, захирагдах харилцаатай Бус захиргааны субъектуудийн хооронд тэгш эрхийн харилцаа байж болно.

Тэгвэл хуулиар захиргааны хүлээсэн чиг үүргийг иргэд хооронд⁹ байгуулсан гэрээгээр зохицуулах боломж бий юу? Онолын хувьд бараг боломжгүй, учир нь дор хаяж гэрээний аль нэг оролцогч нийтийн захиргааны байгууллага байх ёстой, яагаад гэвэл олныг төлөөлөн удирдах, эсхүл нийтийн эрх ашгийг хэрэгжүүлэх эрх хуулиар гагцхүү нийтийн захиргааны байгууллагад олгогдсон байдаг.

Харин нийтийн захиргааны байгууллагаас хуулиар олгогдсон эрх, үүргээ (гагцхүү хуульд заасан тохиолдолд) нийтийн захиргааны бус байгууллага, иргэнд шилжүүлсэн тохиолдолд, уг эрхийг шилжүүлэн авсан этгээд тухайн эрхийг хэрэгжүүлэх зорилгоор өөр бусад байгууллага (нийтийн захиргааны бус), иргэнтэй байгуулсан гэрээний тохиолдол байж болно. Үүнд нийтийн эрх зүй дэх захиргааны гэрээний хүчин төгөлдөр байх нэг гол шалгуур нь тухайн гэрээнд

заавал тусгах нөхцөлүүдийг холбогдох харилцааг зохицуулсан хэм хэмжээнд тодорхойлсон байхыг шаарддаг.

Нийтийн захиргааны байгууллагуудын хооронд хувийн эрх зүйгээр зохицуулагдах гэрээ байгуулагдах боломжтой юу? Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар төрийн өмчит хуулийн этгээд, түүний албан тушаалтны төрийн болон орон нутгийн өмчийн өмчлөх эрхийг хэрэгжүүлдэгтэй холбогдсон эрх хэмжээ, (мөн өөр Бусад) харилцааг зохицуулдаг. Жишээ нь, худалдах, худалдан авах гэх мэт гэрээгээр өөрт илүүдэлтэй их хэмжээний бичгийн цаасыг бусад захиргааны байгууллагад худалдаж болох юм. Төрийн өмчийн эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын шийдвэрээр концессийн болон түрээсийн гэрээгээр, мөн хуулиар зөвшөөрсөн бол үнэ төлбөргүйгээр бусдад эзэмшүүлж, ашиглуулж болно. Бусад гэдэгт зөвхөн иргэн, хуулийн этгээд бус захиргааны байгууллага ч байж болно.

Шүүхийн хяналт: Нийтийн ашиг сонирхлыг илэрхийлж байна гээд "нийтийн захиргааны байгууллага" нь эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн үйл ажиллагаа явуулах эрхгүй. Энэ нь захиргааны бүхий л үйл ажиллагааны хэлбэрт (захиргааны акт, захиргааны гэрээ, захиргааны хэм хэмжээ тогтоосон акт зэрэг) хамааралтай юм.

Нийтийн захиргааны байгууллагын үйл ажиллагаа нь зорилго, зохицуулагдах хэм хэмжээ, ашиглаж буй эрх зүйн хэлбэр зэргээс хамааран олон төрөл байдаг.

Захираганы байгууллага нь нийтийн ашиг сонирхол (тэдгээр нь хошшуулаг болохгүй байсан хэдий ч) гэсэн "шалгаж заан" хуулийг дагаж мөрдөх үүргээс чөлөөлөгдөхгүй¹⁰. Ардчилсан нийгэмд аль ч захиргааны байгууллага, түүний албан тушаалтны үйл ажиллагаа, иргэдийн гомдолд үндэслэгдэн хуульд заасан журмын дагуу

шүүхээр (бие даасан, хараат бус шүүх) хянагдаж байх ёстой.

Тийм учир нийтийн эрх зүй дэх захиргааны гэрээ шүүхээр шийдвэрлэгдэх үү? гэсэн асуултад мэдэж, ойлгомжтой гэсэн хариулт гарна байх. Харин "нийтийн захиргаа"–наас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг нөгөө оролцогч хувь этгээд эсхүл захиргаа түүнээс үүргээ биелүүлэхийг шаардсанаас үүссэн маргааныг аль шүүхэд, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ямар зарчмын дагуу хянах вэ? гэсэн асуулт эргэдээ төрүүлж болох юм.

Ялангуяа захиргааны байгууллагын нийтийн болон хувийн эрх зүйн аль алинд хамаарах "хосолмон шинжтэй үйл ажиллагаа"¹¹-нд гарсан гомдлын шаардлага аль эрх зүйн хүрээний харилцаанд чиглэсэн болохыг тогтоосноор нэхэмжлэлийн хүлээн авах шүүхийн харьяаллыг тодорхойлох боломжтой.

Захираганы гэрээний хэрэглээний түвшин нь эрх зүйн зохицуулалтаас (хуульчлагдсан байдлаас) шууд хамааралтай. Учир нь нийтийн эрх зүйн захиргааны гэрээний нэг шинж нь тухайн харилцааг зохицуулж буй хэм хэмжээнд "нийтийн захиргааны байгууллага тодорхой үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхдээ гэрээ байгуулна" гэж тусгагдсан байх явдал юм.

Нийтийн захиргааны үйл ажиллагааг эрх зүйн хэлбэр олохоос эхлэн үр дүн гарч хүртэл нэг цогц болгон авч үзвэл үр дүндээ хүрч, биеллээ олох хүртэл хоёр үндсэн үе шаттай шаардлагыг¹² давдаг байна. Эдгээр нь -хуулиар эрх олгогдсон байх, -хуульд нийцсэн байх шаардлага юм.

Юуны өмнө тухайн хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулах эрх хуулиар захираганы байгууллага, албан тушаалтанд олгогдсон байх ёстой. (захиргааны акт гаргах, гэрээ байгуулах)

⁹ Энэ нь нийгмийн ашиг сонирхлыг илэрхийлсэн үйл ажиллагаа явуулахын тулд байгуулагдаж, нийтийн эрх зүйн хэм хэмжээгээр ногдоосон үүрэг хүлээсэн этгээд биш байх. Ц.Цогт

¹⁰ Онц болон дайнд байдал зарласан тохиолдолд Үндсэн хууль, бусад хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг гагцхүү хуулиар хязгаарлаж болно. Үндсэн хууль. 1992 он Арван есдүгээр зүйлийн 2–т.

¹¹ Нийтийн захиргаанаас чиг үүргээ хэрэгжүүлэхдээ захиргааны акт, захиргааны гэрээ гэсэн бие даасан болон хамтын үйл ажиллагааны хэлбэрийг хослуулан хэрэглэх тохиолдолд байдаг. Ц.Цогт

¹² Бүдүүв сөм №1 харна уу. Ц.Цогт

Бүдүүгч схем №1



Захиргааны акт: бие даан үйлдэж гаргана, дараа нь иргэдэд мэдэгдэнэ, гомдол гаргаагүй бол үйл ажиллагааны зорилго биелж үр дүн гарна. Харин захиргаа актаа (бие даан) гаргасны дараа тухайн шийдвэрийн дагуу захиргаатай харилцанд оролцож буй хувь этгээд зөвшөөрч биелүүлэх (эсхүл гомдол гаргах эрхтэй байдаг) асуудал буюу хуульд нийцсэн эсэх тухай шаардлага хөндөгдөнө.

Захиргааны актын хувьд эхний шаардлага буюу хуулиар олгогдсон эрхийг захиргаа хэрэгжүүлдэг үйл ажиллагаа явуулсан (хэлбэрээрээ буюу захиргааны акт гарснаар илэрнэ), харин энэ нь хуульд нийцээгүй тухай гомдол гарсан тохиолдолд түүний үр дүн шууд гарахгүй, өөрөөр хэлбэл биелэгдэхгүй.

Захиргааны гэрээ: талууд гэрээг байгуулах үед захиргаатай

хамт тухайн тодорхой асуудлаар харилцанд орж буй хувь этгээд захиргааны шийдвэрийг (санал, магадгүй гэрээний нөхцөл) хүлээн зөвшөөрөөгүй бол гэрээ байгуулагдахгүй, өөрөөр хэлбэл үйл ажиллагаа явагдахгүй, харин талууд зөвшөөрөлцөж гэрээ байгуулагдана. Гэрээний хувьд ийнхүү үйл ажиллагааг хэлбэржүүлэн гаргах үедээ нөгөө талын зөвшөөрлийг өөртөө агуулсан байдаг. Харин захиргааны актын хувьд хэлбэржин гарах үед нөгөө талд оролцож хэрхэн хүлээн авах (биелэх эсэх) нь тодорхойгүй байдаг.

Тодруулбал, захиргааны гэрээ нь хэдийгээр захиргааны үйл ажиллагааны хэлбэр мөн боловч үйлдэгч эзэн болох нийтийн захиргаа, үр дүнг хүлээн авагч болох иргэн гэсэн талууд энэхүү үйл ажиллагаа хуульд нийцсэн эсэх талаар маргасан тохиолдолд

үйл ажиллагааг явуулсан зарчмаас хамааран тэгш эрхтэй субъектүүдийн хоорондын маргааныг харьяалан шийдвэрлэдэг шүүх, энэ харилцаанд үйлчилдэг зарчмыг баримтлан хянан шийдвэрлэх нь зүйтэй болов уу.

Харин захиргааны актын хувьд анх захиргаанаас энэ хэлбэрийг ашиглан үйл ажиллагаа явуулахдаа баримталсан зарчим (бие даасан) -аас хамааран энэхүү үйл ажиллагааны үр дүнг хүлээн авагч-иргэн биелүүлэхдээ хуульд нийцсэн эсэх талаар маргах боломжтой. Эрх зүйн хувьд хүч тэнцвэргүй харилцаанд оролцогч талуудын маргааныг харьяалан шийдвэрлэдэг шүүх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны онцлогтой зарчмын (шүүх нотлох баримт цуглуулах) үндсэн дээр захиргааны үйл ажиллагааны энэ хэлбэртэй холбоотой маргааныг шийдвэрлэдэг.

Хүний болон хувийн этгээдийн эрх, эрх чөлөө ашиг сонирхлыг захиргааны хууль бус, дур зоригийн үйл ажиллагаанаас хамгаалах нь Захиргааны хэргийн шүүхийн тэргүүн зэргийн чиг үүрэг¹⁵, түүнтэй нягт уялдаатай хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны өвөрмөц зарчим, шүүхээс гарах шийдвэрийн төрөл зэрэг нь нэг талын хүсэл зоригийг илэрхийлсэн шийдвэрийг хянахад чиглэгдэж зориулагдсан, харин захиргааны гэрээг талууд уг нөхцөл (шаардлага, хариуцлага зэргийг) зөвшөөрсөн хүсэл зоригоо илэрхийлж байгуулсан Учир Захиргааны хэргийн шүүхийн "дур зоригийн үйл ажиллагааг" хянах үндсэн чиг үүрэгт хамааралгүй. Гэвч одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй захиргааны хэрэг хянан шийдвэрлэх болон бусад хуульд өөрчлөлт оруулах, шинээр зохицуулалт нэмэх байдлаар захиргааны гэрээ, түүнд холбогдох хэрэг, маргааныг захиргааны хэргийн шүүхэд хяргахуулан шийдвэрлүүлэх боломжтой.

Иргэн, хуулийн этгээдийн захиргааны хэргийн шүүхэд хяндан гаргасан нэхэмжлэлийн шаардлага нь дан ганц захиргааны акт (жишээ нь тусгай зөвшөөрөл олгосон) төдийгүй түүний "урьдач нөхцөл" эсхүл "үйлчлэлийг хадгалах нөхцөл" болсон захиргааны гэрээгээр хослуулан зохицуулагдсан үйл ажиллагааг хянуулах тухай бол өнөөгийн хуулийн зохицуулалтаар ч захиргааны хэргийн шүүх цогцоор нь хамтатган шийдвэрлэх нь илүү

¹⁵ Чимид Б. Захиргааны хэргийн шүүхийн тухай мэдэгдэхүүн. УБ: 2004 он. 37 дахь тал

зохиомжтой мэт. Түүнчлэн Захиргааны хэргийн шүүхээр хянагдаж буй маргаан бүхий захиргааны актын хууль зүйн үндэслэлийг хянахад "захиргааны гэрээ" нотлох баримтаар ашиглагдах тохиолдол нилээд элбэг байдаг. Зарим гадаад орны туршлагаас үзвэл нийтийн эрх зүй дэх захиргааны гэрээ захиргааны хэргийн шүүхээр шийдвэрлэгддэг тохиолдол байна. Жишээ нь Латвиын Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нийтийн эрх зүйн гэрээ хуульд харшилсан, зөрчсөн гэсэн үндэслэлээр нэхэмжлэл гаргах эрхтэй байдгийг тодорхойлж, энэ дагуу шүүх үг гэрээг хууль бус болохыг зарласан үгтэйг шийдвэр гаргаж болдог байна¹⁴.

Хэрэв захиргааны гэрээг байгуулсан талууд биш харин өөр гуравдагч этгээд өөрийнх нь эрх ашгийг зөрчсөн гэдэг үндэслэлээр шүүхэд хандах бол аль шүүх хянах вэ? Гуравдагч этгээдийн хувьд тухайн гэрээний тал биш өөрөөр эхлэл гэрээг байгуулах явцад оролцож ашиг сонирхлоо илэрхийлээгүй. Тиймээс нийтийн эрх зүй дэх "захиргааны гэрээ" гуравдагч хөндлөнгийн этгээдийн хувьд "захиргааны акт" мэт үйлчлэлтэй байж болох эсэх нь судлаачаа шаардсан асуудал юм.

Захиргааны гэрээний хэрэглээний боломжит хувилбарууд: Нийтийн эрх зүй дэх захиргааны гэрээ зохицуулалтын хувьд: - шууд зохицуулалттай; - дам зохицуулалттай; - захиргааны акттай хосолмол; - захиргааны актын урьдач нөхцөл болсон; - захиргааны актын үйлчлэлийг хадгалах эсхүл үр дагавар болсон гэх мэт; субъектийн хувьд: захиргаа-иргэн; захиргаа-захиргаа; эрх шилжүүлэн авсан этгээд-иргэн гэсэн төрлүүдээр нийтийн харилцаанд хэрэглэгдэх боломжтой юм.

-Нийтийн захиргааны эрх бүхий байгууллагаас хуулиар оноосон эрх, үүргээ төрийн бус байгууллагад шилжүүлэхдээ хийж байгаа "гэрээний хэлбэр" байна. Үүнд, төрийн өмчит хуулийн этгээдийн удирдах үйл ажиллагаа, үзүүлж байгаа тусламж, үйлчилгээг удирдлага, гүйцэтгэлийн гэрээгээр гүйцэтгүүлнэ. Улсын захиалгатай шинжлэх ухаан, технологийн төслийг санхүүжүүлэх, төслийн үр дүнг үнэлэх эрх бүхий Шинжлэх ухаан, технологийн

сан нь улсын захиалгатай эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлыг санхүүжүүлэх талаар төрийн захиргааны төв байгууллагатай гэрээ байгуулна¹⁵. Хэрэглэгчийн эрхийг хамгаалахтай холбогдсон асуудлаар хууль тогтоомжийн бэлэглэлийг шалгах, мэргэжлийн хяналтын байгууллагатай хамтран үзлэг шалгалт явуулах, мэдээлэл, сурталчилгаа хийх, сургалт зохион байгуулах зэрэг үйл ажиллагааг хэрэглэгчийн эрхийг хамгаалах төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлнэ¹⁶.

-Үйлчилгээ нь нийтэд хэрэгцээ, шаардлагатай боловч хяналтгүй бол эргээд олон нийтэд илүү хохиролтой байж болох аж ахуйн үйл ажиллагааны хэлбэрүүдийг тусгай зөвшөөрөл өгөх замаар хуулийн этгээдүүдэд олгодог. Энэ тусгай зөвшөөрөл олгох үйлдлийн хэлбэр нь захиргааны акт болно, харин олгосон эрхийг хадгалах нөхцөлийг тодорхойлсон эрх зүйн үр дагавар бүхий захиргааны гэрээний төрөл байна. Газрыг эзэмшиж эрх олгосон шийдвэр, радио давтамж ашиглах тусгай зөвшөөрөл, дээд боловсрол олгох сургалтын үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл зэргийг дагалдан "гэрээ" байгуулагддаг.

"Эрчим хүч дулаанаар хангах чиг үүрэг бүхий байгууллагуудыг Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар "нийтийн захиргааны байгууллага" мөн болохыг тодорхойлсон. Эдгээр байгууллагуудын үндсэн үйл ажиллагаа нь цахилгаан, дулаанаар хангах ажиллагаа юм. Тиймээс энэ төрлийн гэрээ нь (цахилгаан үтээхэд хэрэглэгчтэй гэрээ байгуулдаг) нийтийн захиргааны байгууллага чиг үүргээ биелүүлэх зорилгоор бусдадтай хийж буй сонгодог захиргааны гэрээ байж болох юм.

Эцэст нь захиргаагаар батлагдсан тохиолдолд хүчин төгөлдөр болдог (эрх зүйн үр дагавар үүсгэдэг) гэрээний төрөл байна. Иргэний хуулийн 189 дүгээр зүйлд энэ талаар "нэгэм, хувь хүний ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор зарим төрлийн гэрээг гагцхүү төрийн эрх бүхий байгууллагаас олгосон тусгай зөвшөөргийн үндсэн дээр байгуулж болно" хэмээн зохицуулжээ. Эдгээр

гэрээнд "захиргаа" шууд оролцогч биш боловч тухайн гэрээнүүд нь захиргаагаар багалагдсан тохиолдолд эрх зүйн хувьд хүчинтэй болж буй нь гэрээ **агуулааргаа нийтэд хамааралтай ашиг сонирхлыг хөндсөн шинжтэй байдаг** илэрхийлж байна. Жишээ нь, манай улсын ихээхэн хэмжээний ашигт малтмалын нөөцтэй орд газрын (Оюу толгой гэх мэт) ашиглалтын лицензийг эзэмшигч лицэнээс өөр хувь этгээдэд шилжүүлэхээр тохиролцож хуульд заасны дагуу гэрээ хийсэн байна. Энэ гэрээгээр тохиролцож байгаа нөхцөл нь Монгол Улсын хувьд (улсыг төлөөлөн нийтийн эрх ашгийг хэрэгжүүлж буй захиргаанд) нийт иргэний эрх ашигт шууд хамааралтай байна. Шууд утгаараа нийтийн эрх зүй дэх захиргааны гэрээнд хамаарахгүй боловч үг гэрээг тодорхойлох үндсэн гол шинжийг агуулсан учир "захиргааны гэрээ"-ний "тусгай" төрөл болох магадлалтай.

Тиймээс хуулиар захиргааны хувлэсэн чиг үүргийг иргэд хооронд байгуулсан гэрээгээр зохицуулах боломж бий юу? гэсэн асуултын хувьд бараг боломжгүй хэмээн хариулсан болно.

Ашигт малтмал ашиглах лиценз эзэмшигч болон гадаадын хөрөнгө оруулагчтай¹⁷ байгуулах тогтвортой байдлын гэрээ, хувьчилсан эд хөрөнгийн шинэ өмчлөгчтэй байгуулах эд хөрөнгө хувьчилсан тухай гэрээ, төрийн өмчит хуулийн этгээдийг удирдах үйл ажиллагааг хувийн өмчит хуулийн этгээд, хувь хүнээр гүйцэтгүүлэх гэрээ, нийгмийн салбарт үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээдийн удирдах үйл ажиллагааг төрийн өмчийн оролцоогүй хуулийн этгээд, хувь хүнээр гүйцэтгүүлэх гэрээ, төрлөсө нийгмийн салбарт үзүүлдэг тусламж, үйлчилгээг төрийн өмчийн оролцоогүй хуулийн этгээд, хувь хүнээр гүйцэтгүүлэх гэрээ, газрын устуй холбогдсон үйл ажиллагаа явуулах талаар өөрийн болон гадаадын иргэнтэй байгуулах гэрээ, төсвийн байгууллагын ерөнхий менежертэй байгуулах үр дүнгийн гэрээ гэх мэт хууль, эрх зүйгээр зохицуулагдсан захиргааны гэрээний хэрэглэгдэх боломжит төрлүүд байна.

◆ ◆ ◆

¹⁴ VIth Common Seminar on Industrial Property, Dusseldorf, 19-20 March, 2004, Katarzyna Karcz, Patpol, Poland.

¹⁵ Шинжлэх ухаан, технологийн тухай хууль. 1998 он. 11 дүгээр зүйлийн 5-д

¹⁶ Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль. 2003 он. 16 дугаар зүйлийн 1.3-т

¹⁷ Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль. 1993 он. 19 дүгээр зүйлд

ШИНЭЭР ИЛЭРСЭН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүйд "шинээр илэрсэн нөхцөл байдал" гэсэн ойлголт байдаг. Шинээр илэрсэн нөхцөл байдал нь хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийг хянан үзэх үндэслэл болдог. Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг дахин хянах нь Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бие даасан үе шат юм¹.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар шинээр илэрсэн нөхцөл байдлыг тогтоох бөгөөд энэхүү нөхцөл байдал нь Иргэний хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэрийг хүчингүй болгон дахин шийдвэрлэх, улмаар иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг өөрчлөх, дуусгавар болгох зэрэг үр дагаврыг бий болгож болно. Иргэний хэргийн оролцогчдын эрх, үүрэг үүсэх, өөрчлөгдөх, дуусгавар болоход шууд нөлөөлж буй нөхцөл байдал буюу үйл баримтуудыг шинээр илэрсэн нөхцөл байдал гэдэг байна.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 179-182 дугаар зүйлүүдэд "шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг дахин хянах үндэслэл, уг үндэслэлээр шийдвэрийг дахин хянуулах хүсэлт гаргах, түүнийг хянах журам, мөн биелэгдсэн шийдвэрийг цуцлах" тухай тус тус зохицуулжээ.

Шүүхийн практикт сүүлийн үед шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг дахин хянуулах тухай хүсэлт гаргах явдал нэмэгдэх хандлагатай байна.

Монгол Улсын дээд шүүх сүүлийн хоёр жилд шинээр илэрсэн нөхцөл байдлыг тогтоолох тухай 44 хүсэлт, Нийслэлийн шүүх 25 хүсэлтийг тус тус хянан хэлэлцэв.

Энэ байдал нь шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг дахин хянах үйл ажиллагааг хуульд заасан журмын



Улсын дээд шүүхийн шүүгч
А.ДОРЖГОТОВ

дагуу практикт зөв төлөвшүүлэх нь шүүхийн шийдвэр хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх явдлыг хангах зарчмын ач холбогдолтой болохыг харуулж байна.

Иймд шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг дахин хянах талаар Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн холбогдох заалтыг зөв хэрэглэхэд анхаарвал зохих зарим асуудлыг төвч өгүүлэв.

1. ШИНЭЭР ИЛЭРСЭН НӨХЦӨЛ БАЙДЛЫН УЛМААС ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙГ ХЯНАХ ҮНДЭСЛЭЛ

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 179 дүгээр зүйлд шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг дахин хянах үндэслэлийг заажээ. Энд заасны дагуу шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянаж болох "хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр" гэдэгт сум буюу сум дундын, дүүргийн шүүхийн шийдвэр, аймаг, нийслэлийн шүүхийн магадлал, Улсын дээд шүүхийн тогтоолыг хамаруулан ойлгодог. Мөн шүүхийн шийдвэрийн нэгэн адил хэрэгждэг хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн

шүүгчийн захирамж хамаарна.

Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянаж болох шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон байх ёстой. Шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болох гэдэг нь дараах байдлаар тодорхойлогдоно. Үүнд:

а) Анхан шатны шүүхийн шийдвэрийг хэргийн зохигч (түүний төлөөлөгч буюу өмгөөлөгч) гардан авснаас хойш 14 хоногийн дотор давж заалдах гомдол гаргаагүйн улмаас шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болно.

б) Зохигчоос давж заалдах гомдол гаргасан бөгөөд давж заалдах шатны шүүх гомдлын дагуу хэргийг хянан шийдвэрлэж, дараах байдлаар магадлал гаргасан:

-Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 167 дугаар зүйлийн 167.1.1-д зааснаар давж заалдах гомдлыг хүлээн авах боломжгүй буюу үндэслэлгүй бол гомдлыг хангахгүй орхиж, шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээсэн;

-Мөн зүйлийн 167.1.2-т зааснаар анхан шатны шүүхийн шийдвэрт нэмэлт, өөрчлөлт оруулсан;

-Мөн зүйлийн 167.1.3-т зааснаар анхан шатны шүүхийн шийдвэрийн зарим хэсгийг хүчингүй болгож, бусад хэсгийг хэвээр үлдээсэн буюу өөрчилсөн бөгөөд эдгээр магадлалд хяналтын журмаар гомдол гаргаагүй тохиолдолд шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болно.

в) Давж заалдах шатны шүүхийн магадлалд хяналтын журмаар гомдол гаргасан тохиолдолд уг гомдлыг хяналтын шатны шүүх хянаад Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 176 дугаар зүйлийн 176.2.1-176.2.4 дахь заалт, 176¹ дүгээр зүйлд заасны дагуу:

-шийдвэр, магадлалыг хэвээр үлдээж, гомдлыг хангахгүй орхисон,

¹ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй. Тусгай анги. УБ; 2006 он /МУИС. Хууль зүйн сургууль/

-шийдвэр, магадлалд нэмэлт өөрчлөлт оруулсан,

-магадлалыг бүхэлд нь буюу зарим хэсгийг хүчингүй болгож, шийдвэрийг хэвээр үлдээсэн, өөрчилсөн тохиолдолд шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болно.

Эдгээрээс гадна шүүхийн шийдвэр болон магадлалыг хүчингүй болгож, хэргийг буюу нэхэмжлэлийг хэргэсхгүй болгосон хүчин төгөлдөр магадлал, тогтоол болон Улсын дээд шүүхийн тогтоолыг хуулийн хүчин төгөлдөр болсон шийдвэрт хамааруулан шинээр илэрсэн нөхцөл байдалын улмаас дахин хянаж болдог.

Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянах нэг үндэслэл нь шүүхийн шийдвэр гарах үед хэргийн оролцогчид мэдээгүй буюу мэдэх боломжгүй нотлох баримт илэрсэн байх явдал юм. Хэргийн оролцогчид мэдээгүй буюу мэдэх боломжгүй нотлох баримт гэдэг ойлголтын гол шинжүүд нь:

-хэргийг шүүх шийдвэрлэх явцад бодит байдалд байсан боловч хэргийн оролцогч тухайн нөхцөл байдлыг мэдээгүй буюу мэдэх боломжгүй байсан тул уг байдлыг нотлох баримтыг шүүхэд гаргаж өгөөгүй, түүнчлэн түүнийг гаргуулах, бүрдүүлэх талаар шүүхэд хүсэлт гаргаагүй байдаг.

-шинэ нөхцөл байдал тогтоосон нотлох баримт шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсны дараа илэрч мэдэгдсэн байна.

-энэ нотлох баримт нь хэргийг шийдвэрлэхэд ач холбогдолтой, шүүхийн шийдвэрийн үндэслэл болсон нотлох баримтыг үгүйсгэсэн, шийдвэр хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх зарчмыг хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай тул хэргийг анхан шатны журмаар дахин хянан шийдвэрлэхэд хүргэдэг байна.

Харин энэ ойлголт нь хэрэгт авагдаагүй, "шинэ нотлох баримт"-аас ялгаатай.

Анхан шатны шүүхээр хэргийг хянан шийдвэрлэх үед тухайн нотлох баримтын талаар зохицж мэдэж байсан буюу мэдэх бололцоотой байсан боловч

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 25, 38 дугаар зүйлд заасны дагуу нотлох баримтаа өөрөө гаргаж өгөх, цуглуулах, түүнийг бүрдүүлэх тухай шүүхэд хүсэлт гаргах эрх болон үүргээ хэрэгжүүлээгүйн улмаас шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсны дараа нөхөн гаргасан тохиолдолд шинэ нөхцөл байдал илэрсэн гэж үзэхгүй.

Түүнчлэн шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсноос хойш тухайн үйл баримтын талаар шинээр бий болсон нотлох баримт нь шинээр илэрсэн нөхцөл байдал илэрсэн гэж үзэх үндэслэл болохгүй.

Шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсны дараа дээр дурдсан хэрэгт авагдаагүй шинэ нотлох баримт гаргаж ирүүлсэн, зохиогчийн хүсэлтээр шүүх нотлох баримтыг бүрдүүлээгүй, шүүх нотлох баримтыг хуульд заасан журмын дагуу үнэлээгүй буюу түүнийг буруу үнэлсэн, хууль буруу хэрэглэсэн зэрэг нь шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг дахин хянах үндэслэл болж чаддаггүй.

Энэ нь "нотлох баримт"-ын талаар зохицуулсан хуулийн заалт /иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 37-51, 66, 1/-тай нягт холбоотойгоор харьцуулан үзэж, эрх зүйн үнэлэлт өгч, шийдвэрлэх асуудал юм.

Тухайлбал, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 38 дугаар зүйлд зааснаар хэргийн нэхэмжлэгч, хариуцагч гуравдагч этгээд /тэдгээрийн өмгөөлөгч, төлөөлөгч/ шаардлага ба тагталзлын үндэслэл болж байгаа байдлын талаар нотлох баримтаа өөрөө гаргаж өгөх үүрэгтэй. Өөрт байхгүй нотлох баримтаа цуглуулах үүргийг мөн хүлээдэг. Түүнийг өөрөө олж авах, цуглуулах боломжгүй бол шүүхэд хүсэлт гаргаснаар шүүх бүрдүүлэнэ. Энд зохигчид, гуравдагч этгээдийн мэдэж байгаа болон мэдвэл зохих /мэдэх боломжтой/ буйх л нотлох баримт хамаатай юм.

Иргэний хэргийг шийдвэрлэх ач холбогдолтой бүх нотлох баримтыг зөвхөн анхан шатны шүүхэд гаргаж өгөх үүрэгтэй

бөгөөд энэ нь шүүхийн шийдвэр хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх нөхцөлийг бүрдүүлнэ. Шүүх шийдвэрээ анхан шатны шүүх хуралдаанаар хэлэлцэгдсэн нотлох баримтын үндсэн дээр гаргана².

Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиглагааг удаашруулж цаг хожих, шүүхийн шийдвэр магадлалыг хүчингүй болгох зорилгоор хэргийн оролцогчдоос мэдэх ёстой байсан нотлох баримтыг давж заалдах болон хяналтын шатны шүүхэд гаргах боломжгүй байхаар зохицуулжээ. Хуулийн 165 дугаар зүйлийн 165.1.5-д "давж заалдах гомдлын үндэслэлд анхан шатны шүүхээр шийдвэрлэгдээгүй шинэ нотлох баримтыг заах эрхгүй" байхаар зохицуулжээ.

Харин шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болоогүй, шүүхийн шийдвэрийг давж заалдах, хяналтын шатанд гомдол гаргах явцад мэдэх боломжгүй байсан нотлох баримт илэрвэл хэрхэн шийдвэрлэх нь практикийн ач холбогдолтой юм. Миний бодиход энэ асуудал давж заалдах болон хяналтын шатны шүүхэд гаргасан гомдлын хамт шийдвэрлэгдэх боломжтой.

Шүүхийн шийдвэр гарах үндэслэл болсон нотлох баримт хуурамч байсан бол шүүхийн шийдвэрийг хянах бас нэгэн үндэслэл болно.

"Нотлох баримт хуурамч байсан" гэдэг ойлголтыг дараах шинжүүдээр тодорхойлж болно.

-хуурамч нотлох баримт нь шүүхийн шийдвэрийн үндэслэл болсон нотлох баримт байна. Хэрэгт авагдсан боловч шүүхийн шийдвэрийн үндэслэл болоогүй нотлох баримт энд хамааралгүй юм.

-Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 37 дугаар зүйлд заасан нотлох баримтын төрлүүд болох гэрчийн мэдүүлэг худал, шинжээчийн дүгнэлт хууль бус, орчуулга ташаа байсан, эд мөрийн баримт болон бичгийн нотлох баримтыг хуурамчаар бүрдүүлсэн болох нь хуульд заасан журмын дагуу шалгагдан тогтоогдсон байна.

² Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 116 дугаар зүйл

-дээрх байдлаар нотлох баримт хуурамч болох нь шүүхийн хүчин төгөлдөр шийтгэх тогтоолоор тогтоогдсон буюу гэм буруутай этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх шүүхийн шийтгэх тогтоол хуулийн хүчин төгөлдөр болсон байх ёстой.

Дээрх байдлын талаар хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явагдаж байгаа, эрүүгийн хэрэг үүсгэгдсэн зэрэг нь "нотлох баримт хуурамч байсан"-ыг шууд тогтоох үндэслэл болж чадахгүй юм.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.4, 38.5-д "хэргийн оролцогч хуурамч нотлох баримт гаргах буюу түүнийг хууль бус аргаар цуглуулахыг хориглоно" гэжээ. Улмаар нотлох баримтыг гаргах, цуглуулах талаар хуульд заасан журмыг зөрчсөн бол тэдгээр нь нотлох чадвараа алдах бөгөөд шүүхийн шийдвэрийн үндэслэл болохгүй гэж заасан байдаг.

Иймээс шүүхийн шийдвэр гаргах үндэслэл болсон нотлох баримт хуурамч болох нь тогтоогдвол шүүхийн шийдвэрийг шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянуулах тухай хэсэлтийг хангах үндэслэл болно.

Шүүхийн шийдвэрийн үндэслэл болсон нотлох баримт хуурамч болох нь тогтоогдсон гэдэг хуулийн заалтыг хэрхэн тайлбарлаж ойлгох нь шүүхийн практикт чухал ач холбогдолтой юм. Хуурамч нотлох баримт гаргах, бүрдүүлэх явдал нь эрүүгийн гэмт хэрэг болно. Тиймээс хуурамч нотлох баримт болох шүүхийн хүчин төгөлдөр шийтгэх тогтоолоор тогтоогдсон байх ёстой.

Дээд шүүхийн 1998 оны 318 дугаар тогтоолд энэ ойлголтыг тайлбарлахдаа "шүүхийн шийдвэрийн үндэслэл болсон гэрчийн мөдүүлэг, шинжээчийн дүгнэлт хуурамч байсан, орчуулга ташаа байсан, эд мөрийн баримт болон бичмэл нотлох баримтыг хуурамчар бүрдүүлсэн болох нь зохих журмын дагуу шалгагдан тогтоогдож, гэм буруутай этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн шийтгэх тогтоол гарч, хүчин төгөлдөр болсон байна" гэжээ.

Давшрамд дурьдахад эрх зүйт төр, хууль дээдлэх ёс төлөвшсөн

улс оронд шүүхэд худал мэдүүлэх, нотлох баримтыг хуурамчаар бүрдүүлэх нь байж болохгүй зүйл гэж үздэг. Ийм тохиолдол гарсан бол эрх зүйн хийгээд ёс зүйн хариуцлага хүлээлгэдэг байна.

Манайд иргэн, хуулийн этгээдээс үнэн зөв нотлох баримт гаргах, цуглуулах, талаарх хариуцлагыг цаашид эрс дээшлүүлэх шаардлага бий болсны тэмдэглэх нь зүйтэй юм.

Зарим тохиолдолд шинээр илэрсэн нөхцөл байдал тогтоолгохын тулд янз бүрийн баримт цуглуулах хүсэлт гаргах явдал ажиглагддаг.

Жишээ нь: Иргэн "Б" бусдаас зээлийн гэрээгээр авсан мөнгөө тоолж аваагүй, түүнийг гардан авсан гэх баримтгүй тул төлөхгүй. Зээлийн уг гэрээ хүчин төгөлдөр бус гэж марагдаж, Шүүх түүнийг зээлийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй гэж үзэж талбөр гаргуулжээ. "Б" нь шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсны дараа дараах үндэслэлээр шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянуулах тухай хүсэлт гаргажээ. Үүнд: 1. нэхэмжлэл гаргах хөөн хэлэлцэх хуцацаа өнгөрсний дараа нэхэмжлэл гаргасан байхад шүүх хүлээн авч шийдвэрлэсэн нь хууль зөрчсөн байна. 2. Өмнө байгуулсан зээл, хүүг 2002 оны Иргэний шинэ хууль гарсны дараа "нөхөн гэрээ" гэгчийг нэхэмжлэгч шаардаж байгуулсан нь хүү тооцох хууль зүйн үндэслэлгүй. 3. Нийслэлийн прокурорын газрын хяналтын прокурор, санхүүгийн зохицуулах хорооны бичигт нэхэмжлэгч "Д" нь мөнгө нэхэмжлэх эрхгүй болох нь тогтоогдсон гэжээ. Монгол Улсын дээд шүүхийн 2007 оны И/37 дугаар тогтоолд <<шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр, магадлал, тогтоолын үндэслэл хуульд нийцэхгүй байгаа болон бүх шатны шүүх Иргэний хуулийг буруу тайлбарлаж хэргийг үндэслэлгүй шийдвэрлэсэн гэсэн агуулгатай хариуцагч "Б" шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг дахин хянуулах хүсэлт нь Иргэний хэрэг шүүхэд

хянан шийдвэрлэх тухай хуулийн 179 дүгээр зүйлийн 179.1-д заасан 3 үндэслэлийн алинд ч хамааралгүй байх тул түүний хүсэлтийг шүүх хангахаас татгалзах нь зүйтэй байна. Түүнчлэн шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хэрэг хянуулах тухай хариуцагч "Б" хүсэлтэд хавсарган ирүүлсэн Нийслэлийн прокурорын газрын 2005 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 1531 тоот харуу мэдэгдэх хуудас, Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн 4/712 тоот албан бичиг зэрэг баримтууд нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 179 дүгээр зүйлийн 179.1-д заасан үндэслэлүүдийн алинд нь ч хамаарахгүй байгаагаас гадна уг баримтаар тодорхойлогдох нөхцөл байдлууд нь шүүхийн үндэслэлд хамааралгүй байна. Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг дахин хянуулах тухай хариуцагчийн хүсэлтэд хавсарган ирүүлсэн өөр нэг баримт болох прокурор болон нэхэмжлэгчид зээлийн төлбөрт мөнгө хүлээсэн өссөн 7 баримт, мөн эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгох тогтоол зэрэг нь хавтаст хэргийн 38, 60, 61, 63, 65 дугаар хуудсанд авгагдсан бөгөөд бүх шатны шүүхээр хэлэлцэгдэн, шүүх нээлт зохих үнэлэлт өссөн тул эдгээр баримтыг шинэ баримт гэж үзэх үндэслэлгүй>> гэж заагаад хүсэлтийг хангахаас татгалзжээ.

Хариуцагч "Б" дахин шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянуулах тухай хүсэлтдээ: Тухайн мөнгийг надад хүлээлгэн өгсөн гэж нэхэмжлэх нь шүүхэд нотолж чадаагүй байгаа. Зээлийн гэрээ байгуулах хүртэл тухайн мөнгийг надад бэлнээр хүлээлгэж өгөөгүй гэдгийн 09 тоот нотариатчийн гаргаж өгсөн бичгийн нотлох баримтаар нотлогдоно. Иймээс тухайн мөнгийн гэрээг аваагүй учир зээлийн гэрээнд 4 дэх заалтыг зориудаар оруулсан. Энэ нь Иргэний хуулийн 282 дугаар зүйлийн 282.4-т зааснаар уг зээлийн гэрээг байгуулсанд тооцох үндэслэл болохгүй. Тухайн зээлийн гэрээ

байгуулахдаа барьцааны гэрээг байгуулагч мөртлөө миний үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээг барьцааныг Монгол нотариатчдын танхимын сахилгын зөвлөл авч хэлэлцээд 09 тоот нотариатчийн үйлдэл нь ноцтой зөрчил байсныг тогтоосон. Түүнээс гадна Сонгинохайрхан дүүргийн шүүх 2007 оны 9 дүгээр сарын 5-ны өдөр 855 дугаартай шийдвэр гаргаж, 2002 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн зээлийн гэрээг гэрчилсэн нотариатын үйлдлийг хүчингүй болгосон. Иймд дээр дурдсан үндэслэлийг шинээр илэрсэн нөхцөл байдалд тооцож, шийдвэр, магадлал, Улсын Дээд шүүхийн 2005 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 431 дүгээр тогтоолыг хүчингүй болгож өгнө үү гэжээ.

Энэ хүсэлтдээ Монголын нотариатчдын танхимын дэргэдэх сахилгын зөвлөлийн хурлаар хэлэлцээд "нотариатч "Д" нь 2002 оноос 12 дугаар сарын 27-ны өдөр иргэн "Д", "Б" нарын хооронд байгуулсан зээлийн гэрээг гэрчлэхдээ зээлдүүлсэн гэх 20700 ам.долларыг бэлнээр "Б"-д хүлээлгэн өгөөгүй байхад зээлийн гэрээг хүчин төгөлдөр хэмээн гэрчилж, барьцааны гэрээг хавсралтаар байгуулаагүй мөртлөө зээлийн гэрээнд үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээг барьцаалсан нь ноцтой зөрчил юм. Зээлийн гэрээний 4 дэх заалтад зээлдүүлэгчээс зээлдэгч мөнгийг бодитойгоор гардуулсан өдрөөс хүчин төгөлдөр болно гэж заасан байхад 20700 ам.долларыг "Б" нь хүлээн авсан баримтыг зээлийн гэрээнд хавсаргаагүй тул хэчин төгөлдөр бус хэлцэл болно" гэжээ.

Сонгинохайрхан дүүргийн шүүх 2007 оны 9 дүгээр сарын 5-ны өдрийн 855 дугаар шийдвэрээр Монгол Улсын Нотариатын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.1-д зааснаар нотариатч "Д"-ийн 2002 он 12 дугаар сарын 27-ны өдрийн иргэн "Б", "Д" нарын хооронд байгуулсан зээлийн гэрээг гэрчилсэн нотариатын үйлдлийг хүчингүйд тооцжээ.

Монгол Улсын дээд шүүх
2007 оны 56 дугаар тогтоолд

<<Хариуцагч "Б", түүний өмгөөлөгч нараас Монголын нотариатчдын танхимын дэргэдэх Сахилгын зөвлөлийн 2007 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн 59 дүгээр албан бичиг, Сонгинохайрхан дүүргийн тойргийн 09 дүгээр нотариатч Б.Д-гийн 2007 оны 8 дугаар сарын 14-ний өдрийн баримт, Сонгинохайрхан дүүргийн шүүхийн 2007 оны 9 дүгээр сарын 5-ны өдрийн 855 дугаар шийдвэрийг шинээр илэрсэн нөхцөл байдлын талаарх баримт гэж шүүхэд ирүүлсэн.

Дээр дурдсан баримтууд нь Ирээнэй хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 179 дүгээр зүйлд заасан үндэслэлд хамаарахгүй байх тул шинээр илэрсэн нөхцөл байдлыг тогтоосон баримт гэж үзэх үндэслэлгүй байна гэсэн дүгнэлт хийж түүний хүсэлтийг хангахаас татгалзжээ.

Энэ мэтээр шинэ нотлох баримтад тогтоологхоор хууль зүйн үндэслэлгүй бичиг баримт бүрдүүлэх, дахин дахин хүсэлт гаргах явдал нэмэгдэх хандлагатай болжээ.

Шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдааны оролцогч, хэрэг хянан шийдвэрлэх үед гаргасан үйлдэл /эс үйлдэхгүй/ эрүүгийн гэмт хэрэг болох нь шүүхийн хуулийн хүчин төгөлдөр шийтгэх тогтоолоор тогтоогдсон бол шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянах үндэслэл болдог. Энэ нь: а) шүүгч, б) шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, в) гэрч, шинжээч, орчуулагч, хэлмэрч, i) хэргийн оролцогч зэрэг шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдааны оролцогчийн хууль бус үйлдэл /эс үйлдэхгүй/-тэй холбоотой юм.

Харин энэ тайлбарт хөөн хэлэлцэх хугацаа өнгөрсөн, өршөөл үзүүлсэн зэргээс гэм буруутай

этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэлгүй болсон бол тэдний гэм буруутай үйлдлийг мөрдөн байцаалтаар тогтоосноор шинэ нөхцөл байдал илэрсэн гэж үзэж болно гэсэн байдаг.

Хуулийн заалтын агуулгаас үзвэл, шүүгч, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, гэрч, шинжээч, орчуулагч, хэлмэрч, хэргийн оролцогчийн хэрэг хянан шийдвэрлэх үед гаргасан хууль бус үйлдэл /эс үйлдэхгүй/ эрүүгийн гэмт хэрэг болох нь шүүхийн хүчин төгөлдөр шийтгэх тогтоолоор тогтоогдсон тохиолдолд шүүхийн шийдвэрийг шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас дахин хянах үндэслэл болохоор зохицуулжээ.

Энэ нь "нотлох баримт хуурамч байсан" гэсэн ойлголтын шинж тэмдгийг адил агуулдагсаас гадна шүүх хуралдааны оролцогч болон тэдгээрийн үйл ажиллагаатай шууд холбоотой байж болно.

Тухайн хэргийг хянан шийдвэрлэхэд дээрх субъектуудын явуулсан үйл ажиллагаа, үйлдэл /эс үйлдэхгүй/ хууль бус байсны улмаас шүүхийн шийдвэр хууль зүйн үндэслэлгүй, буруу гарсан, эсхүл уг үйл ажиллагаа ийнхүү хууль бус шийдвэр гарахад нөлөөлсөн болох нь тогтоогдсон буюу гэм буруутай этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн шүүхийн шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болсон явдал шинээр илэрсэн нөхцөл байдалд тооцох үндэслэл болно.

Шүүхийн шийдвэр гарах үндэслэл болсон шүүхийн шийтгэх тогтоол буюу шийдвэр, эсхүл төр, захиргааны болон бусад байгууллагын шийдвэр хууль бус байсны улмаас хүчингүй болсон явдал нь шүүхийн хуулийн хүчин төгөлдөр шийдвэрийг дахин хянах үндэслэл болдог.

Шүүхийн шийдвэр хууль бус байсан гэдэгт доорх байдлыг

Энэ ойлголтыг Дээд шүүх тайлбарлахдаа

"Шүүгч, зохигч, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, гэрч, шинжээч, орчуулагч, хэргийн бусад оролцогчийн тухайн хэргийг хянан шийдвэрлэхтэй холбоотой ажиллагаа үйлдэл, эс үйлдэл хууль бус байсны улмаас хууль бус үндэслэлгүй шийдвэр гаргасан нь тогтоогдож, тэдэнд эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн шийтгэх тогтоол, хүчин төгөлдөр болсныг тус тус хамааруулан ойлгоно" гэжээ.

ойлгоно.

а) Иргэний хэргийн талаарх шүүхийн шийдвэр гарах үндэслэл болсон шүүхийн шийтгэх тогтоол хууль бус байсны улмаас дээд шатны шүүхийн шийдвэрээр хүчингүй болсон байна.

б) Иргэний хэргийн талаарх шүүхийн шийдвэр гарах үндэслэл болсон иргэний болон захиргааны хэргийн шийдвэрээс гадна шүүхийн тогтоол, шийтгэвэр, шүүгчийн захирамж зэрэг нь хууль бус байсны улмаас дээд шатны шүүхийн шийдвэрээр хүчингүй болсон байна.


Төр, захиргааны шийдвэр хууль бус байсан гэдэгт төрийн захиргааны байгууллага болон тэдгээрийн албан тушаалтны аливаа шийдвэр, үйл ажиллагааг шүүхийн, эсхүл дээд шатны байгууллагын, эсхүл өөрийн шийдвэрээр хууль бус байсан гэдгийг тогтоож, хүчингүй болгосон байхыг ойлгоно.

Бусад байгууллага гэдэгт

төрийн захиргааны байгууллагаас бусад буюу орон нутгийн өөрөө удирдах байгууллага /иргэдийн хурал, түүний тэргүүлэгчид/, төрийн бус байгууллага, аливаа хороо, комисс, аж ахуйн нэгж, хуулийн этгээд болон хуулийн этгээдийн эрхгүй байгууллага, тэдгээрийн албан тушаалтан зэргийг хамааруулан ойлгож болох юм.

Хууль бус байсны улмаас хүчингүй болсон төр, захиргааны болон бусад байгууллагын шийдвэр нь тухайн иргэний хэргийн шүүхийн шийдвэр гаргах үндэслэл нотолгоо болсон байна. Иргэний хэрэгт нотлох баримтаар авагдсан боловч шийдвэрийн үндэслэл болоогүй байгууллагын шийдвэр хүчингүй болох нь иргэний хэргийг шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас дахин хянах үндэслэл болохгүй юм.

Дээр өгүүлсэн хууль бус байсны улмаас хүчингүй болсон шийдвэр гэсэн ойлголтын хамаарлыг хүснэгтээр үзүүлбэл:



Дээрх үндэслэлээр шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянах шалгуур нь:

а) Эдгээр шийдвэр нь хүчингүй болсон байна. Уг шийдвэрийг хүчингүй болгох эрх бүхий этгээд хуульд заасан журам, үндэслэлээр хүчингүй болгосон байна.

б) Тухайн шийдвэр хүчингүй болох үндэслэл нь "хууль бус байсан" байна. Уг шийдвэр цаг үеийн шаардлага, нөхцөл байдал өөрчлөгдсөн зэрэг шалтгаанаар хүчингүй болсон явдал үүнд хамаарахгүй юм.

в) Хууль бус байсны улмаас хүчингүй болсон шийдвэр нь хянуулах тухай хүсэлт гаргаж байгаа шүүхийн шийдвэрийн үндэслэл нотолгоо болсон байх учиртайг анхаарах нь зүйтэй.

2. ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙГ ХЯНУУЛАХ ТУХАЙ ХҮСЭЛТ ГАРГАХ

Шүүхийн шийдвэрийг шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянуулах тухай хүсэлтийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 180 дугаар зүйлд заасны дагуу гаргана. Мөн хуулийн 179 дүгээр зүйлд заасан үндэслэл бий болсон тохиолдолд хэргийн оролцогчид хүчин төгөлдөр болсон шүүхийн шийдвэрийг дахин хянуулах хүсэлт гаргах боломж бий болдог.

Шүүхийн шийдвэрийг шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянуулах тухай хүсэлт гаргах журам нь дараах байдлаар тодорхойлогдоно. Үүнд:

а) хүсэлтийг шинээр илэрсэн нөхцөл байдал бий болсныг мэдсэн эсхүл мэдэх боломжтой байсан өдрөөс хойш 30 хоногийн дотор шүүхэд гаргана.

б) тухайн хэргийн нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээд нь шүүхэд хүсэлт гаргах эрхтэй бөгөөд тэдгээр нь төлөөлөгч, өмгөөлөгчөөрөө дамжуулан шийдвэрийг хянуулах тухай хүсэлтээ гаргаж болно.

в) уг шийдвэрт давж заалдах гомдол гаргаагүйн улмаас шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон бол хүсэлтийг анхан шатны шүүхэд гаргана.

г) шүүхийн шийдвэрт гарсан

давж заалдах гомдпоор аймаг, нийслэлийн шүүх хэргийг хянан хэлэлцэж, магадлал гаргасан бол хүсэлтийг тухайн аймаг, нийслэлийн шүүхэд гаргана.

д) шүүхийн шийдвэр, магадлалд гарсан хяналтын гомдпоор хяналтын шатны шүүх хэргийг хянан хэлэлцэж, тогтоол гаргасан бол хүсэлтийг Улсын дээд шүүхэд гаргана. Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянуулах хүсэлт гаргах эдгээр журмыг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 180 дугаар зүйлийн 180.1-д "тухайн шатны шүүхэд гаргана" хэмээн томъёолжээ.

е) шийдвэрийг хянуулах хүсэлтийг тухайн хэргийг шийдвэрлэсэн анхан шатны шүүх хүлээн авч, хэргийн хамт зохих шүүхэд хүргүүлнэ.

ж) хүсэлтийг заавал бичгийн хэлбэрээр гаргах ба түүндээ шинээр илэрсэн нөхцөл байдлыг нотлох баримтын эхийг эсхүл нотариатаар гэрчлүүлсэн хуулбарыг хавсаргах ёстой.

Мөн хүсэлтийг ямар шүүхэд гаргаж байгаа, хүсэлт гаргаж буй этгээдийн нэр, хаяг, албан тушаал, хуулийн этгээдийн оршин байгаа газар, аль шүүхийн ямар шийдвэрийг хянуулах хүсэлтэй байгаа хийгээд шинээр илэрсэн нөхцөл байдал, түүний мэдсэн хугацаа зэргийг заасан байх шаардлагатай юм. Хүсэлтийг бичгээр гаргаж, түүнд шинээр илэрсэн нөхцөл байдлын талаарх баримтыг хавсаргана. Хүсэлт гаргаж байгаа хэргийн зохигч, гуравдагч этгээд /тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч/ нь шийдвэрийг хянуулах тухай хүсэлт гаргах журмыг чандлан сахих ёстой. Ингэхгүйгээс үндэслэл муутай хүсэлт гаргах явдал нэлээд гарч байна.

Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянуулах тухай хүсэлт гаргасан этгээд шүүх хуралдаан эхлэхээс өмнө хүсэлтээсээ татгалзах эрхтэй. Энэ тохиолдолд шүүх түүнийг хүсэлт гаргаагүйд тооцдог.

3. ХҮСЭЛТИЙГ ШИЙДВЭРЛЭХ

Шүүхийн шийдвэрийг шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас

хянуулах тухай хүсэлтийг шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэнэ.

Шүүх хуралдаанаар уг хүсэлтийг шийдвэрлэхдээ дараах зүйлийг хянах шаардлагатай. Үүнд:

а) шүүхийн шийдвэрийг хянах үндэслэл, нөхцөл байдал шинээр илэрсэн болохыг мэдсэнээс хойш 30 хоногийн дотор хүсэлт гаргасан эсэхийг шалгана;

б) хүсэлтийг эрх бүхий этгээд буюу зохигч, гуравдагч этгээд гаргасан эсэх, төлөөлөгч, өмгөөлөгчийн гаргасан хүсэлт зохигч, гуравдагч этгээдийн хүсэл зоригт үндэслэсэн эсэхийг хянаж;

в) хүсэлтэд заасан үндэслэл, түүнд хавсарган ирүүлсэн баримт нь шинээр илэрсэн нөхцөл байдалд тооцогдох боломжтой эсэх, шүүхийн шийдвэрийг дахин хянах тухай Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 179 дүгээр зүйлд заасан үндэслэл байгаа эсэхийг нарийвчлан авч үзнэ.

г) хүсэлтийн үндэслэл, түүнд хавсаргасан баримт шүүхийн шийдвэр болон үндэслэлд хэрхэн нөлөөлөх эсэхийг тогтооно;

д) дээр дурдсан зүйлүүдэд тулгуурлан шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хэргийг дахин хянан шийдвэрлэх хууль ёсны үндэслэл байгаа эсэхийг шийдвэрлэнэ.

Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг дахин хянах бүрэлдэхүүнд зөвхөн анхан шатны шүүхийн шийдвэр гаргахад оролцсон шүүгч орж болохгүй. Давж заалдах болон хяналтын шатны шүүхийн шүүх бүрэлдэхүүнд орсон шүүгч, мөн анхан шатны шүүхийн шийдвэр гаргахад оролцоогүй боловч хэрэг хянан шийдвэрлэх бусад ажиллагаанд оролцсон шүүгч хуулийн энэ хязгаарлалтад хамаарахгүй юм.

Хүсэлтийг хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд хүсэлт гаргагч оролцохыг хүссэн тохиолдолд шүүх хуралдаан болох товыг түүнд тухайн шүүх заавал мэдэгдэх үүрэгтэй байдаг. Харин хүсэлт гаргасан этгээд шүүх хуралдааны товыг мэдсэн боловч хүрэлцэн ирээгүй бол түүний оролцоогүйгээр хүсэлтийг хянан хэлэлцэнэ

шийдвэрлэхдээ саад болдоггүй билээ.

Шүүх хуралдаанаар хянан хэлэлцээд хүсэлтийг хангах эсхүл хангахаас татгалзах тухай тогтоол гаргадаг.

Хүсэлтийг хянан шийдвэрлэх ажиллагааны нэг онцлог нь хэргийг хянан хэлэлцэхгүй. Зөвхөн шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянуулах тухай хүсэлтийг хянан шийдвэрлэнэ. Хүсэлтэд хавсаргасан шинээр илэрсэн нөхцөл байдлын талаарх баримтын хүрээнд хянадаг.

Шинээр илэрсэн нөхцөл байдал тогтоогдоогүй, шинэ нотлох баримт нь түүнийг баталж чадаагүй, хэргийг дахин хянах хууль ёсны үндэслэл тогтоогдохгүй бол хүсэлтийг хангахаас татгалзах тухай тогтоол гаргана.

Хэрэв шүүх шинээр илэрсэн нөхцөл байдлыг тогтоосон нөхцөлд шүүхийн шийдвэр, магадлал, тогтоол (шүүхийн шийдвэрийн адил хэрэгжих захирамж)-ыг тус тус хүчингүй болгон, хэргийг ердийн журмаар хянан шийдвэрлүүлэхээр анхан шатны шүүхэд хүргүүлнэ. Хэрэв анхан шатны шүүх шинээр илэрсэн нөхцөл байдалд тооцсон бол анхны /өмнөх/ хүчин төгөлдөр шийдвэрээ хүчингүй болгон тухайн шүүх хэргийг ердийн журмаар хянан шийдвэрлэнэ. Энэ тухай тогтоолдоо заана.

Харин хэргийг "ердийн журмаар хянан шийдвэрлэнэ" гэдэг нь хэргийг дахин хянан шийдвэрлэхдээ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу хэргийг анх удаа хянан шийдвэрлэхтэй адил журам баримтлахыг хэлнэ.

Түүнчлэн хүсэлтийг тухайн хэргийг шийдвэрлэсэн анхан шатны шүүхэд өгнө. Анхан шатны шүүх нь хэргийг бусад оролцогчид мэдэгдэн, тэдгээрийг хүсвэл тайлбарыг гаргуулан хавсаргаж байх нь зүйтэй байдаг. Энэ нь иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны шүүхийн өмнө эрх тэгш байх зарчмыг хангахтай холбоотой юм. Түүнчлэн хүсэлт гаргагч болон хэргийн бусад оролцогч шинээр илэрсэн нөхцөл байдлыг тогтоох шүүх хуралдаанд оролцсон тохиолдолд хүсэлт, түүнд хавсаргасан баримтын талаар тайлбарлах түүнийг хэрхэн үзэж

байгаа тухай хариу тайлбар гаргах эрхтэй байх нь хүсэлтийг үндэслэл бүхий шийдвэрлэх нэгэн нөхцөл болдог.

Хүсэлтийг хангаж шийдвэрлэсэн тохиолдолд шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хүчингүй болгоно. Энэ тохиолдолд **биелэгдсэн шийдвэрийг цуцлах** тухай асуудал зайлшгүй тавигдана. Иймээс шүүхийн шийдвэрийн биелэлтийг цуцлах тухай асуудлыг тухайн хэргийг өмнө хянан шийдвэрлэсэн шүүхээр шийдвэрлүүлэхээр шилжүүлнэ.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 182 дугаар зүйлийн 182.1/

Хянан анхан шатны шүүх, шүүхийн шийдвэрийн биелэлтийг цуцлах боловч уг маргааныг дахин шийдвэрлэх ажиллагааны явцад шаардлагатай гэж үзвэл зохигчийн хүсэлтэд үндэслэн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасан журмын дагуу шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ авч болох юм. Учир нь маргааныг эцэслэн шийдвэрлээгүй, бас холбогдох эд хөрөнгө устаж, үрэгдэхээс хамгаалах хэрэгцээ шаардлага байж болдог.

4. ШҮҮХИЙН ПРАКТИКИЙН ЗАРИМ АСУУДАЛ

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 179 дүгээр зүйлийн 179.1-д “үндэслэл байвал шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянан үзэж болно” гэсэн заалтыг зөв ойлгож хэрэглэх ёстой юм. Энэ заалтаас үзвэл “зөвхөн үндэслэл байвал хянан үзэж болно”, “үндэслэл” байхгүй бол хянан үзэхгүй гэж ойлгохоор байгаа юм. Хуулийн ойм зохицуулалт өмнө нь мөрдөж байсан процессын хуулиудад байсан юм. Тиймээс шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянуулах тухай хүсэлтийг шийдвэрлэх ажиллагаа, шүүхийн практик хоёр янзаар хэрэгжиж иржээ. Үүнд: а) хүсэлтийг шүүх хянан үзээд үндэслэлгүй гэж үзсэн тохиолдолд хүсэлт гаргасан этгээдэд хариу

өгөдөг байжээ. б) Монгол Улсын дээд шүүхийн “шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг дахин хянах тухай Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим зүйл, заалт, хэсгийг тайлбарлах тухай” 1998 оны 318 дугаар тогтоол гарснаар хүсэлтийг шүүх хуралдаанаар хянан хэлэлцэний үндсэн дээр шийдвэрлэж байхаар тогтоожээ.

Мөн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийг хэрэглэсэн шүүхийн практикт “хүсэлт” “үндэслэлтэй” байвал шүүх хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэнэ. Хэрэв “үндэслэлгүй” гэж үзвэл шүүгч хариу өгөх ёстой гэж үзэх хүмүүс байсны улмаас хүсэлтийг хүлээн авсан шүүгч хариу өгч байсан тохиолдол бий билээ.

Гэвч дээр дурдсан “болно” гэдэг томъёоллыг хуулийн 181 дүгээр зүйлийн 181.1-д “шүүхийн шийдвэрийг шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянуулах тухай хүсэлтийг энэ хуульд заасан журмын дагуу тухайн шатны шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэнэ” гэсэн заалттай харьцуулан үзвээс хүсэлтийг шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэж байх нь зүйтэй юм.

Шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолыг шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас дахин хянах уу гэсэн асуулт бий. Энд жишээ дурдъя.

“ХААН” банк, “ЭТ” компаниас зээл, хүүгийн төлбөр 105,6 сая төгрөг нэхэмжилсэн. Тэрээр тус компанитай уулзалт зохион байгуулж, нэхэмжлэл, зээлийн төлбөрийн талаар гарсан маргааныг эв зүйгээр хэлэлцэн тохиролцоооор харилцан тохиролцсон тул зээлийн нэхэмжлэлээсээ татгалзсан тухай шүүхэд мэдэгдсэн тул Баянгол дүүргийн шүүхийн шүүгчийн захирамж /2005 оны 779/-аар нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсаныг баталжээ.

Гэтэл тус банкнаас шүүхэд гаргасан нэхэмжлэлдээ “бид зээлийн гэрээг дахин нэмж байгуулахаар эвлэрч барьцаанд барилга тавуулсан юм. Энэ барилга нь бусдын өр төлбөрт битүүмжилсэн гэдгийг бид мэдээгүй, мэдэх боломжгүй байсан тул 2005 оны 779 дүгээр захирамжийг дахин хянаж

шинээр илэрсэн нөхцөл байдалд тооцож өгнө үү” гэсэн хүсэлт гаргажээ. Баянгол дүүргийн шүүх 2005 оны 176 дугаар тогтоолоор “банк шүүхийн шийдвэрийг 2005 оны 7 дугаар сарын 14-нд гардан авч хүсэлтээ 2005 оны 8 дугаар сарын 19-нд гаргасан тул нөхцөл байдлыг мэдсэнээс хойш хүндэтгэн үзэх шалтгаангүй 30 хоногийн хугацаа хэтэрсэн” гэсэн үндэслэл зааж, хүсэлтийг хангахгүй орхижээ.

Хэдийгээр хуульд “хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр /анхан шатны шүүхийн шийдвэр/ магадлал, тогтоол” хэмээн тодорхой заасан боловч маргааныг эцэслэн шийдвэрлэсэн шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолыг шүүхийн шийдвэртэй адилтган үзэж хянан хэлэлцэнийг буруутгах үндэслэлгүй гэж үзнэ.

Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянуулах тухай хүсэлтийг хангасан болон хангахгүй орхисон шүүхийн тогтоолд гомдол гаргаж болох уу гэдэг асуудал байдаг. Энд давж заалдах шатны болон хяналтын шатны шүүхэд гомдол гаргахгүй байх, гаргасан гомдлыг хүлээн авч хэлэлцэхгүй байх практик нэгэнт тогтсон гэж хэлж болно. Энэ нь шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг дахин хянуулах хүсэлтийг шийдвэрлэхдээ тухайн шүүх бүрэлдэхүүн хэргийг хянан хэлэлцдэггүйтэй холбоотой юм. Шүүх зөвхөн хүсэлтэд заасан үндэслэл шинээр илэрсэн нөхцөл байдал мөн эсэхийг хянан хэлэлцдэг.

Дээр дурдсан т а й холбоотойгоор шинээр илэрсэн нөхцөл байдлын тухай, хүсэлтийг хангасан болон хангахаас татгалзсан шүүхийн тогтоол гаргах, түүнийг хүчингүй болгон өөрчлөх боломж бий юу гэдэг асуулт тавигдана. Шүүхийн практикт тогтоолд гомдол гарган өөрчлөлт оруулсан тохиолдол байдаг.

Жишээ нь: Баянгол дүүргийн шүүхийн 2005 оны 176 дугаар тогтоолд (дээр дурдсан) “ХААН” банк гомдол гаргасан байх юм. Баянгол дүүргийн шүүх гомдлыг хянан хэлэлцэж 2005 оны 245 дугаар тогтоолоор гомдлыг хангахгүй орхижээ.

Энд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 171 дүгээр зүйлийн 171.1.1-д заасныг удирдлага болгожээ. Түүнчлэн Хэнтий аймгийн шүүхэд шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг дахин хянасан хэрэгээс шийгээ өвчл.

"Д", "Г" нар 2004 оны 5 дугаар сарын 22-ны 14 цагт хэрийн цастай халтргаатай замд машинаараа хоорондоо шүргэлцсэн хэрэг гэрчээ. Улмаар сумын замын цагдаагийн байцаагч "Б" 2004 оны 8 дугаар сарын 19-ний өдөр мэдээлэлд үндэслэн "хэрэг учралын газар нөхөн үзлэг хийсэн тэмдэглэл" бичиж, "зам тээврийн осол тогтоосон акт" үйлджээ. Энэ актад үндэслэн анхан шатны шүүхийн шийдвэр гарч, улмаар дөвж заалдах шатны шүүх хянаад шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээжээ. Үүний дараа 2004 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр замын цагдаагийн гзрээс шинжээч томилон шинжээч дүгнэлт гаргахдаа "ослын газарт нөхөн үзлэг хийсэн материалд зөвдсөн нотлох баримтаар ослын шалтгаан нөхцөлийг тогтооход хангалтгүй, дэслэгч "Б"-гийн зам тээврийн осолд гэрээсэн дүгнэлт буруу тавигдсан гэжээ. Хэнтий аймгийн шүүх "Д"-гийн гаргасан шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хэргийг хянуулах тухай хүсэлтийг хянан хэлэлцээд 2005 оны 1 дүгээр тогтоолоор шүүхийн шийдвэр, магадлалыг тус тус хүчингүй болгож "Г"-ийн нэхэмжлэлтэй иргэний хэргийг хэрэгээс хувируулан болгожээ.

Энэ тогтоол илэрхийл

алдаатай хууль зөрчсөн байна. Тийм учраас тус шүүх хүсэлтийг дахин хэлэлцэж 2006 оны 4 дүгээр сарын 6-ны өдрийн 1 дүгээр тогтоолоор хэргийн оролцогчийн хүсэлтийг үндэслэн "шинээр илэрсэн нөхцөл байдла" тооцон "Д"-ийн хүсэлтийг хангаж, хэргийг ердийн журмаар шийдвэрлэх нь зүйтэй гэж үзжээ.

Энд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 124 дүгээр зүйлийн 124.1 дэх заалтыг удирдлага болгосон байдаг.

Дээр дурдсан хоёр жишээнээс үзэхэд шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянаад гаргасан шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжид Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 170 дугаар зүйлд заасан журмын дагуу гомдол гаргах, улмаар 124 дүгээр зүйлд заасны дагуу шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж илт үндэслэл муутай гарсан бол түүнийг хүчингүй болгох буюу өөрчилж болох юм гэж үзнэ.

5. ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ШААРДЛАГА

Гадаадын өндөр хөгжилтэй зарим улс оронд манай хуульд заасан "шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг дахин хянах ажиллагааны тухай ойлголцоход нэлээд бэрхшээлтэй байдаг билээ. Учир нь иргэний хэргийн зохиц оролцогчид нотлох баримтаа өөрөө гаргана, өөрөө цуглуулна. Маргаан анхан шатны шүүхэд үнэн зөв, үндэслэл бүхий шийдвэрлүүлэхэд бүх анхаарлаа

тавина, Эрх зүйн үйлчилгээ, туслалцаа авна. Өөрөө өөрөөснөө шалтгаалах бүхийг хийнэ.

Энэ бүхэн нь зохигч, хэргийн оролцогчийн хувийн хариуцлагын асуудал байдаг.

Шүүхэд хуурамч нотлох баримт гаргаж болохгүй. Шүүхэд худал мэдүүлбэл том асуудал, хариуцлагад унана. Шүүхийн өмнө мэдүүлэх нь бурхны өмнө шударгаар мэдүүлэхтэй агаар нэгэн. Иймээс шинэ нөхцөл байдал илрэх нь тун ховор.

Хэрэв шинэ нөхцөл байдал илэрвэл зөвхөн анхан шатны шүүх авч үзнэ. Өмнөх шүүхийн шийдвэрээс өөрөөр шийдвэрлэж болно. Хүсэлтийг хэрэгтэй нь хамт шийднэ. Энэ нь шинэ нөхцөл байдалд үндэслэсэн ердийн шийдвэр байна.

Түүнийг хуульд заасан журмын дагуу давж заалдах буюу хянуулж болно. Өмнө нь гарсан шийдвэр, магадлал, тогтоолыг хөндөх хүчингүй болгох шаардлага ч байхгүй. Учир нь тухайн нөхцөл байдалдаа зөв байсан.

Ийм үзэл санаа өмнө нь яригдсан боловч уламжлалт ойлголт, арга барил үүнд саад болж байгаа билээ.

Иймээс шинэ илэрсэн нөхцөл байдлыг тогтоолох хүсэлтийг анхан шатны шүүхэд авч хянан хэлэлцэж хэрэв шинэ нөхцөл байдал тогтоогдвол хэргийг дахин шууд шийдвэрлэх, улмаар шийдвэрийг нь ердийн журмаар давж заалдах, хянах боломжтой байхаар хуулийн зохицуулалтыг өөрчлөх нь зүйтэй мэт санагдана.

Энэ нь бас цаг хугацаа, үр ашгийг зардлыг хэмнэх, шүүхийн илүү хэргүүг зарим ажиллагааг багасгахад ач холбогдолтой гэж үзнэ.



ШҮҮХИЙН ЖИШИГ БА ЗАНШИЛ

Зарим бичигдээгүй хууль бүх бичмэл хуулиас хатуу
Сенека

Судалгааны ажлын энэ хэсэгтээ миний бие заншлын эрх зүйг түүхэн талаас нь бус өнөөгийн олон улсын эрх зүй болон монголын эрх зүйн тогтолцоонд заншлыг хэрхэн авч үзэж буйг судалж, заншил болон шүүхийн жишиг хэрхэн харилцан хамаарч буйг дүгнэсэнээ тогилуулах болно.

Энэхүү судалгааны ажил доорх хэсгээс бүрдэнэ.

1. Заншлын эрх зүйн тулгуур ойлголт, хэлбэр, тодорхойлолтын тухай,

2. Заншлын эрх зүйг дотоодын эрх зүйн тогтолцоонд улс орнууд хэрхэн авч үзсэн тухай,

3. Заншлын эрх зүйн илрэн гарах хэлбэр нь Монгол Улсын шүүхийн жишиг болох тухай,

4. Дүгнэлт.

1. Заншлын эрх зүйн тулгуур ойлголт, хэлбэр, тодорхойлолтын тухай

Эрх зүйн эх сурвалжуудын харилцан хамаарлыг авч үзэхэд нэн түрүүнд заншлын эрх зүйн тухай асуудал хөндөгддөг.

Заншлын эрх зүй гэдэг нь удаа дараа уламжлагдан хэрэглэгдсэн ба засаг төрөөс зөвшөөрсний үр дүнд нийгэмд бүрэлдэн тогтсон зан үйлийн журмын (заншлын) нийлбэр цогц юм¹.

Хуулийг төрөлжүүлэх системчлэл нь тодорхой бус нутгийн заншлыг нутгийн хуульчид ажмаар нэгтгэн бичих ажлын үр дүнд бий болсон юм. Эдгээр заншлыг нийтээр хүлээн зөвшөөрсөн ба нийгмийн



ХЗҮТ-ийн Олон улсын эрх зүйн секторын эрдэм шинжилгээний ажилтан
Б.ГҮНБИЛЭГ

гишүүдийн харилцааг зохицуулах хууль зүйн хүчин чадалтай байв.

Заншлыг хүмүүс хүлээн зөвшөөрч, нийтээр дагаж мөрдөж байгаа нь ямар нэг эзэн хаан, эсвэл эрх мэдэлт субъектын шахаж шаардсанаас айсан буюу албадсаны үр дүн биш бөгөөд олон нийтэд тэр зохицуулалт үгүйлэгдсэн, нийгэмд тэр заншил бий болох урьдач нөхцөл буюу хэрэгцээ аль хэдийн бий болсон учраас хүмүүст таалагдаж өөр хоорондынхоо харилцаанд зохицуулалт болгон хэрэглэж байгаа юм.²

Лон Фүллерийн бичсэнээр занширал тогтоосон эрх, үүргийн харилцан хамаарал нь нэгдүгээрт, эрх зүйн харилцаанд оролцогч талуудын сайн дурын үндсэн дээр хүлээн зөвшөөрөгдөх, хоёрдугаарт, талууд тэгш эрхтэй

байх, гуравдугаарт, хэнд ч, ямар ч үед тохиолдож болохоор, өөрөөр хэлбэл, өнөөдөр ч иү харилцаанд орсноор чамд хохиролтой байж болох ч, маргааш чамд ашигтай байх шударга ёсны зарчимд тулгуурласан байдаг³.

Заншил нь улс хоорондын, улсын, бүсийн, хотын, гудамжны, гэр бүлийн, өрхийн гэх мэтээр маш олон янзын хэлбэртэй байж болно. Гэвч ямар заншил нь чухам албан ёсоор хууль зүйн хүчин чадалтай вэ гэдэг нь шийдэх ёстой асуудлын нэг юм.

Заншлын эрх зүй нь улс хоорондын харилцаанд өргөнөөр мөрдөгдөх ба тэдний практикаас бүрдэнэ. Улс орнууд тухайн заншлыг хууль зүйн хувьд хүчин чадалтай хэмээн итгэж байх үед оршдог⁴. Зарим тодорхойлолтод зөвхөн олон улсын гэрээнд заншлын хэм хэмжээг хоёрдогч эх сурвалж болгох маягаар хэрэглэдэг гэж бичсэн байна⁵.

Олон улсын харилцаанд заншлын эрх зүй нь нэлээд багагүй үүрэг гүйцэтгэдэг⁶. Олон Улсын шүүхийн дүрэмд "хууль мэт хүлээн зөвшөөрөгдсөн туршлагын нотлоог заншил гэнэ"⁷ гэжээ. Америкийн Нэгдсэн Улсын хувьд "Хууль зүйн үүргээ шударгаар биелүүлэх зорилгоор улс гүрнүүдийн дагаж мөрдөж буй нийтлэг тогтвортой практикийг Олон Улсын Заншлын эрх зүй гэнэ"⁸ гэж томъёолжээ.

Олон улсын заншил нь өөртөө улсын туршлага ба *opinio juris* гэсэн хоёр элементийг агуулдаг байна⁹. Улсын туршлага гэдэг тодорхой болсон үйл явдлын давтамж бол

¹ Нарангэрэл С. Эрх зүйн эх толь бичиг. УБ; 2007 он. 201 дэх тал.

² Bruce Benson's The Enterprise of Law. Extracted by Mark Sulowski, The Enterprise of Law: Justice Without the State by Bruce Benson. pp 12-15 <http://jim.com/custom.htm>-аас ишлэв. (хамгийн сүүлд 2005 оны 12 сарын 11-нд зочилсон).

³ Bruce Benson's The Enterprise of Law. Extracted by Mark Sulowski, The Enterprise of Law: Justice Without the State by Bruce Benson. pp 12-15 <http://jim.com/custom.htm>-аас ишлэв. (хамгийн сүүлд 2005 оны 12 сарын 11-нд зочилсон).

⁴ http://www.saskscshools.ca/curr_content/law30/international/internationalvocab/vocab.html-аас ишлэв. (хамгийн сүүлд 2005 оны 12 сарын 11-нд зочилсон).

⁵ <http://www.hfenberg.com/it/theory/intlawdefinitions.html>-аас ишлэв. (хамгийн сүүлд 2005 оны 12 сарын 11-нд зочилсон).

⁶ Нарангэрэл С. Эрх зүйн эх толь бичиг. УБ; 2007 он. 201 дэх тал.

⁷ Олон улсын Шүүхийн дүрэм, 38(1)(b)

⁸ Restatement (Third) of the Foreign Relations Law of the United States, Article 102(2) (ALI 1987)

⁹ North Sea Continental Shelf (FRG/Den.;FRG/Neth.), 1969 ICJ Rep. 3, 44 (Feb. 20)

*opinio juris*¹⁰ гэдэг нь хуулийн тухай санал, үзэл гэж хэлж болно.

Х. Виктор Кондэгийн тодорхойлсноор *opinio juris* буюу хуулийн тухай санал гэдэг нь тухайн улсын олон улсын тавцан дээр олон улсын эрх зүйн дагуу хүлээсэн үүргээ үйлцэтгэж байна гэсэн үзлээр үйлдсэн үйлдлийн сэтгэл зүйн элемент юм. Энэ нь хүндэтгэл үзүүлэх, хэрэгцээ, зохистой гэсэн үндэслэлтэй холбоогүй ба олон улсын заншлын эрх зүйн нэгээхэн хэсэг бөгөөд хүний эрхийн эрх зүйн хэм хэмжээний нэгэн төрөл, субъектив шинжтэй элемент байдаг¹¹.

Олон улсын түвшинд улс хоорондын дипломат буюу хүчирхийллийн аль ч харилцааны дүнд үүссэн хэм хэмжээг олон улсын заншил буюу заншлын эрх зүй гэнэ. Олон улсын заншлыг улс орнууд шаардлагатай бол олон улсын гэрээ байгуулан өөрчилж болох боловч зарим заншлыг өөрчилж болохгүй. Жишээ нь, боолчлол, геноцидыг хориглох зэрэг хүний эрхийн хэм хэмжээ агуулсан зарим заншил өөрчлөгдөх буюу шинэчлэгдэх боломжгүй юм. Олон улсын гэрээгүүд урьд өмнө үйлчилж байсан заншуудыг аль болох төрөлжүүлэн эмхэтгэхийг зорьдог¹².

Олон улсын заншлын эрх зүйн судалгаагаар мэргэшсэн профессор Д'Амато¹³:

"Олон улсын эрх зүйчид байр сууриа хамгаалахын тулд бараг тааралдсан бүх эх сурвалжаа эрх зүйн эх сурвалжид тооцож боллоо. Энэ байдлыг шүүмжлэгчид төдий л үл ойлгож, хоосон гоё үг мэт хүлээн авч байна... Олон улсын эрх зүйчээс бусад салбарт ажиллаж буй бидний хамтран зүтгэгчид хууль, шүүхийн жишигт үндэслэн үйл ажиллагаагаа явуулдаг. Заншил гэдэг бол тэдний хувьд маш хачин, этгээд зүйл мэт харягддаг..."¹⁴

гэж хэлсэн байдаг. Түүний хэлснээс үзэхэд олон улсын эрх зүйн бүх харилцааг гэрээгээр зохицуулж чаддаггүй ба ихэнх тохиолдолд олон улсын заншлын эрх зүй зохицуулалтын хэрэгсэл болдгийг харж болно. Мөн олон улсын эрх зүйчид өөрийн байр суурийг хамгаалахын тулд төдий л олон нийтэд хүлээн зөвшөөрөгдөөгүй номлол, зарчмуудыг заншлын эрх зүй мэтээр батлахыг оролддог аж.

Олон улсын заншлын талаар тогтсон зарим ойлголт байх ч, зарим тохиолдолд түүнтэй санал нийлэхгүй явдлууд гардаг. Тийм учраас олон улсын заншил нь зарим нэг тохиолдолд энх тайван тогтоох арга хэрэгсэл, эс бөгөөс дайн, дажны эхлэл болдог байна.

Заншлын эрх зүйн тухай тодорхойлолтуудыг ерөнхийд нь нэгтгэн дүгнэвэл объектын талаасаа практик, байнгын давтамжтай байх ёстой бол субъектын талаасаа түүний хүчин чадлыг нь хүлээн зөвшөөрсөн итгэл байх ёстой юм. Өөрөөр хэлбэл, Олон Улсын шүүхийн дүрэмд заасан нөхцлүүд заншлыг тодорхойлох ерөнхий нөхцлүүдийг эмхэтгэн тодорхойлжээ гэж хэлж болно.

Нэгэн гудамжны заншлын тухай жишээ авъя¹⁵. Нэгэн гудамжны эцэст замын уулзвар байж гэнэ. Уулзварын нэг талд өндөр ургасан төм мод байх ба модон дээр ЗОФС гэсэн үгийг хэн нэгэн сийлсэн аж. Тэр дүүргийн хүмүүс тээврийн хэрэгслээр зорчихдоо энэ модны дэргэд заавал зогсож, хөндлөн замаар явж байгаа тэргийг өнгөрөөдөг байлаа. Харин хөндлөн замаар явж байгаа жолооч модны цаана жолооч хүлээж байгаа гэдэгт итгэдэг байв. Улмаар энэ заншил нь олон жилийн нүүр үзэж, тухайн дүүргийн хүмүүс бүгд мэддэг болжээ. Гэтэл нэг удаа тухайн дүүрэгт амьдардаг нэг жолооч модны дэргэд зогсолгүй

үрэгш хөдлөхөд хөндлөн замаар явж байсан тээврийн хэрэгсэлд мөргүүлж гэнэ. Хөндлөн замаар явж байсан тэргэний жолооч нь энэ дүүрэгт амьдардаггүй байжээ. Ингээд тэд шүүхээр асуудлаа шийдвэрлүүлэхээр хандаж гэнэ. Харин шүүх мөргүүлсэн тэргэний жолоочийн буруу хэмээн тогтоож, мөргөсөн тэргэний жолоочийн хохирлыг барагдуулахаар шийдвэрлэв. Учир нь мөргүүлсэн тэргэний жолооч тэр дүүрэгт амьдардаг, мөн тэр модны дэргэд зогсдог заншилтайг бас мэддэг төдийгүй, шүүгчийн:

"Та өөрөө хөндлөн замаар явахдаа модны цаана машин хуваар байгаа гэдэгт итгэдэг байсан уу? гэсэн асуулдаг:

"Итгэлгүй яах вэ, манай дүүргийнхэн тэнд зогсдог шүү дээ хэмээн хариулсан байна. Иймээс шүүх хэдийгээр тухайн модон дээр сийлсэн ЗОФС хэмээх сийлбэр нь замын цагдаагийн газраас хүлээн зөвшөөрөгдөж, батлагдсан стандартад нийцээгүй байсан ч заншлын хэм хэмжээ зөрчсөн хэмээн мөргүүлсэн жолоочийг буруутгажээ.

Заншил эрх зүйн эх сурвалж болохын тулд төрийн болоод албадлагын механизмээр хангагдсан байх ёстой. Шүүх заншлыг эх сурвалж болгон хэрэглэж, шийдвэр гарахад энэ нь төрийн албадлагын механизмээр хангагдаж байна гэсэн үг. Нөгөө талаас заншлаа зөрчсөн тохиолдолд олон улсын түвшинд болоод хувь иргэдийн хоорондын харилцаанд нэр хүндээ алдаж, дараагийн удаад тухайн харилцаанд оролцох эрхгүй болох зэрэг нь заншлыг хууль зүйн хувьд хүчин чадлтай болгож өгдөг.

Жишиг хэм хэмжээ ба заншлын хэм хэмжээний хоорондын ялгаа, төсөөний талаар хуульчид, иргэд

¹⁰ *Opinio iuris* [*opinio iuris sine necessitate*; эрх буюу үүргээ мэдэх]. Олон улсын заншлын эрх зүйд хаммаар *terminus technicus* (мэргэжлийн үг); олон улсын эрх зүйн этгээдүүдийн тодорхой асуудал, хэргүүд дээр туулж өнгөрөөсөн туршлагауд нь заавал дагаж мөрдөх хүчин чадалтай болж хувирсан хэмээх итгэл. Эрх зүйн толь. Р. Батхүүгийн тайлбар.

<http://asulit.net/erhkhziitoli.html>-аас ишлэв. (хамгийн сүүлд 2005 оны 12 сарын 11-нд зочилсон).

¹¹ Х. Виктор Кондэ, Хүний эрхийн олон улсын нэр томъёоны гарын авлага, Улаанбаатар 2002, х. 118.

¹² http://en.wikipedia.org/wiki/Customary_law-аас ишлэв. (хамгийн сүүлд 2005 оны 12 сарын 11-нд зочилсон).

¹³ Норфестерийн Их Сургуулийн профессор. 1988 оны 4 сарын 22-нд болсон "Олон Улсын Заншлын эрх зүйн онол" сэдэв семинарт удирдагчаар оролцсон.

¹⁴ THE THEORY OF CUSTOMARY INTERNATIONAL LAW, 82 American Society of International Law Proceedings 242 (1988) (Code A88) p 1.

¹⁵ Энэхүү жишээг Walter Slinnet Armstrong, Word meaning in Legal Interpretation, San Diego Law Review, What is Legal Interpretation? Vol 142, p 474, -ээс санаа аван заншлын тохиолдол болгон өөрчлөн ишлэв.

орон янзын төсөөлөлтэй байдаг. Зарим нэг нь энэ хоёр бараг ижил зүйл гэдэг бол зарим нь хоёр өөр туйл руу завгалах жишээтэй. Эдгээр

Үүдэсэл	Жишээ хам хэмжээ	Заншлын хам хэмжээ
1.Хууль зүйн фактын хувьд	Шүүх тогтоож, өөрчилж, хүчингүй болгох эрхтэй.	Жишээг бодвол удаан хугацаанд үйлчилдэг. Үүсэхдээ хүмүүс хоорондын харилцаанаас урган гардаг. Хэрэглэгдэх давтамжийн хувьд их.
2.Хүчин чадвал, хэрэглэх хэрэгний хувьд	Маргаан гарсан тохиолдолд л шүүх хэрэглэнэ. Тухайн төсөөтэй хэрэгт л шүүх өөрийн дотоод итгэлд үндэслэн хэрэглэхээр сонговол хүчинтэй.	Статутын нэгэн адил нийтлэг харилцааг зохицуулж, хүмүүсийн өдөр тутмын зан байдлыг зохицуулж байдаг. Илүү нийтлэг харилцааг зохицуулдаг.

2.Заншлын эрх зүйг дотоодын эрх зүйн тогтолцоонд улс орнууд хэрхэн авч үзсэн тухай

Заншлын эрх зүй нь эрх зүйн анхдагч түүхэн хэлбэр бөгөөд орчин үед хөгжилтэй улсад заншлын эрх зүй онц ач холбогдолгүй болжээ¹⁶. Гэсэн хэдий ч нийгмийн харилцаа өргөн баялаг учраас заншлын эрх зүйн орон зай улс бүрийн тогтолцоонд оршсоор байна.

Заншлын эрх зүй, жишиг эрх зүй хоёр нэгэн тогтолцоонд аль алиныгаа нөхөн үйлчилж бондгийг Нигер улсын эрх зүйн тогтолцооноос харах боломжтой юм.

Нигер нь Британийн колони байсан ба газар нутгийн хувьд Нэгдсэн вант улсаас гурав дахин том. Британийн колони байсан улсууд дундаа том газар нутагтай, хүн ам их суурьшсан улсад тооцогддог байжээ. Хэдийгээр Английн хууль, дүрэм Нигерт голлох байр суурь эзэлж байсан боловч, орон нутагт заншлын эрх зүй хүчтэй нөлөөтэй байсан учраас британчууд заншлыг хуулийн нэгэн адил хэрэглэхийг орон нутгийн шүүхүүдэд зөвшөөрсөн байна. Гэхдээ тэрхүү заншил нь колони эзэмшигч улсад хөр нөлөөгүй, мөн түүний хуульд харшлахгүй байхыг онцгойлон заажээ¹⁷.

1960 онд тусгаар тогтнолоо олсон Нигер улс өөрийн эрх зүйн тогтолцоог английн эрх зүй болон өөрийн улсын заншлын эрх зүй дээр тулгуурлан хөгжүүлж эхэлсэн байна. Гэвч хөгжлийн явцад буюу сүүлийн дөмөө жилд заншлын эрх зүйн байр суурь багасч, заншил нь бичмэл хуулийн хэлбэрт шилжиж байгаа боловч зарим нэг бичигдээгүй заншил өнөөг хүртэл хүчин төгөлдөр үйлчилсээр байна. Тухайлбал, Нигерт гэр бүл болоход эмэгтэй нь

нь хоёр давтамж, хэрэглээний хувьд төсөөтэй мэт боловч өргөн хүрээгээр авч үзвэл ялгаа гарна.

эрэгтэйдээ инж өгөх ёстой бөгөөд хэрэв сэлсэн тохиолдолд шинэ нөхөр буюу эмэгтэйн эцэг тэр инжийг авах эрхтэй байдаг байна. Энэхүү харилцааг ямар ч хууль зохицуулаагүй бөгөөд харин энэ заншлыг шүүх хүлээн зөвшөөрч, өөрийн шийдвэрт эх сурвалж болгон хэрэглэдэг аж.

Тэгэхээр эндээс заншил нь шүүхийн жишгийн хэлбэрт шилжин хуулийн хүчин чадлаа хадгалсан байгааг харж болно. Тухайлбал, заншил нь цаг ирэх тусам эх сурвалжийн бичигдээгүй хэлбэрээ алдаж бичмэл хууль, шүүхийн жишгийн хэлбэрт шилжиж байна.

Өөр нэг анхаарах ёстой зүйл бол Мусульманы хуулийн Британийн колонилогичид заншлын эрх зүйтэй нэгэн адил зүйл гэж авч үзсэн ба Нигерт тогтсон заншил нь мусульманы шашны нөлөөнд үзсэн гэж үздэг аж. Тэгэхээр Нигерийн жишээ нь дээр аваад үзэхээр шашны сургаал, заншил, шүүхийн жишиг (эсвэл бичмэл хууль) гэх мэт эрх зүйн эх сурвалжууд нэгэн цэгт давхцаж, бүх гурван хэлбэрээ нэг хэлбэрээр илэрхийлж болж байгаа юм. Иймд германы эрдэмтэн Р.Вольфрумын хэлснээр эрх зүйг, тэр дундаа харьцуулсан эрх зүйг судлахдаа бүгдийг төгс хэлбэрээ олсон, ангилагдан системчлэгдсэн хэмээн үзэж, бүгдийг тэгээс эхэлж болохгүй гэдэг нь батлагдаж байна.

Үйл хэрэгтээ хэвшиж заншсан дүрэм, жаягийг гарцаагүй үнэн буюу алдаа мадаггүй дүрэм гэж үзэж болохгүй¹⁸. Гиймээс тогтож заншсан бүхнийг улс гүрнүүд заншил хэмээн авч үзэхээсээ илүүтэй тухайн улсын шүүх уг заншлыг хэрхэн авч үзсэнийг илүүтэйгээр үнэлдэг.

АНУ, Нэгдсэн вант улс, ХБНГУ-ын хувьд заншлын эрх

зүйг эх сурвалж болгон ашиглаж байгаа бөгөөд энэ нь шүүхийн шийдвэрээр илрэн гардаг гэдэгтэй санал нийлдэг. Харин Японы хувьд эдгээр орноос илүү заншлын эрх зүйн зохицуулалттай. Тухайлбал, гэр бүлийн эрх зүй Японы заншлын эрх зүйд ихээхэн тулгуурласан байдаг. Энэ нь ханрэйгээр илрэн гардаг.

Монгол Улсын хувьд заншлын эрх зүйг тодорхойлсон тодорхойлолт байхгүй байна. Мөн 1924 оноос хойш гарсан Үндсэн хуулиудад заншлын тухай зохицуулалт, үг үсэг байхгүй гардаг.

3.Заншлын эрх зүйн илрэн гарах хэлбэр нь Монгол Улсын шүүхийн жишиг болох тухай

Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй нийт эрх зүйн актын 101-д нь "заншил"-ын тухай зохицуулалт байгаа бөгөөд эдгээрт нийт 195 зүйлд заншлын тухай өгүүлсэн байна. Эдгээрийг задалж үзвэл:

- 23 хуулийн 40 зүйлд,
- 21 УИХ-ын тогтоолын 43 зүйлд,
- 29 Засгийн газрын тогтоолын 65 зүйлд,
- 5 Ерөнхийлөгчийн зарлигийн 7 зүйлд гэх мэт.

Заншлын эрх зүйн зохицуулалт бүхий хуулиуд:

1. Арбитрын тухай хууль,
2. Байгаль орчныг хамгаалах тухай хууль,
3. Барааны тэмдэг газар зүйн заалтын тухай хууль,
4. Биеийн тамир спортын тухай хууль,
5. Боловсролын тухай хууль,
6. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль,
7. Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль,
8. Гэр бүлийн тухай хууль,
9. Далай ашиглах тухай хууль,
10. Дипломат албаны тухай хууль,
11. Засгийн газрын тусгай сангийн тухай хууль,
12. Захирааны хармуцлагын тухай хууль,
13. Иргэний хууль,
14. Монгол Улсын засгийн газрын тухай хууль,
15. Монгол Улсын Их хурлын тухай хууль,
16. Монгол Улсын Хилийн тухай хууль,
17. Олон нийтийн радио, телевизийн тухай хууль,
18. Соёлын тухай хууль,

¹⁶ Нарангэрэл, С. Эрх зүйн эх толь бичиг. УБ: 2007 он. 201 дэх тал.

¹⁷ The future of customary law in Africa, Symposium-Colloque Amsterdam 1955, Leiden 1956, p 42.

¹⁸ CARDINAL RULES OF LEGAL INTERPRETATION, by Edward Beal, LONDON: Law Publishers and Booksellers 1896, p 31.

19. Соёлын өвийг хамгаалах тухай хууль.
20. Тор, сүм хийдийн харилцааны тухай хууль.
21. Харьяатын тухай хууль.
22. Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль
23. Үндэсний Их баяр наадмын тухай хууль.

Улсын дээд шүүхийн 1990 оны Шүүхийн өөрчлөлт шинэчлэлтийн үндсэн чиглэлийг багтах тухай 89 дүгээр тогтоолд "2.Шүүх ял ногуулахдаа гэм буруутай этгээдийн үйлдэл, эс үйлдэл нь нийгмийн ёс суртахууны хэмжээ, үндэсний зан заншилд хэрхэн нийцэж байгааг харгалзан үзэж байна" гэжээ. Энэ тогтоол нь эрүүгийн эрх зүйн харилцааг зохицуулж байгаа тул Эрүүгийн хуулийг тайлбарласан зөвлөмжийн шинжтэйгээр үйлчилдэг гэж үзэж болох юм. Гэсэн хэдий ч хууль зүйн хүчин чадлын хувьд хэрэглэж, эсэх нь уг тогтоолын батлагдсан хугацаа, Эрүүгийн хуулийг Дээд шүүх тайлбарласан байдал зэргээс улбааж тодорхойгүй байна.

БНМАУ-ын Анхдугаар Үндсэн хууль батлагдсанаас хойших эрх зүйн актуудад "заншил" үг тодорхойлсон зүйл судлаачдын явцад илэрсэнгүй. Гагцхүү Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн Төрийн дүрэмийн 1.4-т зааснаар "Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбарыг Дээд шүүх гаргах" чиг үрэгтэй учир дээрх 23 хуульд заасан "заншил"-ыг шүүх тайлбарлан, тодорхойлох ёстой болж байна. Иймээс заншлын илрэн гарах хэлбэр нь Монгол Улсын хувьд шүүхийн шийдвэр болох юм.

Дээрх 23 хуулиас хамгийн ихээр хэрэглэгддэг Иргэний хуульд заасан заншлын эрх зүйн зохицуулалтуудыг авч үзвэл:

...196.1.7.ажил хэргийн хүрээнд тогтсон заншил ёсоор санал гаргагч талыг хүлээн зөвшөөрнө гэж үзээд санал хүлээн авагч тал нь саналд дурдсанаас өөр нөхцөлөөр гэрээ байгуулахаар харц илгээсэн тохиолдолд санал гаргагч татгалзсан тухайгаа нэн даруй мэдэгддэг...

198.3.Гэрээний зарим үг хэлэлцгийг нутгийн онцлогоос шалтгаалан өөр өөр агуулгаар тайлбарлаж болохоор байвал гэрээ байгуулсан талуудын оршин суугаа газарт хэрэглэж заншсан агуулгаар, талууд нь өөр өөр газар оршин суудаг бол гэрээ байгуулах саналыг хүлээн зөвшөөрсөн талын оршин суугаа газарт хэрэглэж заншсан агуулгаар тайлбарлана...

449.3.Аккредитивийн төлбөр тооцоог гүйцэтгэхэд олон улсад хэрэглэгддэг нийтлэг зохицуулалт,

ажил хэргийн хүрээнд тогтсон заншлыг баримтална...

450.2.Инкассийн төлбөр тооцоог гүйцэтгэхэд хууль, олон улсад хэрэглэгддэг нийтлэг зохицуулалт, ажил хэргийн хүрээнд тогтсон заншлыг баримтална...

457.17.Энэ хуулиар зохицуулаагүй банкны баталгаатай холбогдсон бусад харилцааг олон улсын хэмжээнд хэрэглэдэг нийтлэг зохицуулалт, ажил хэргийн хүрээнд тогтсон заншлаар зохицуулна...

540.1.Шаардлагатай бол шүүх иргэний хэрэг, маргаан шийдвэрлэх буюу иргэний эрх зүйн бусад харилцааг зохицуулахад Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд харшлагагүй гадаад улсын хууль, эрх зүйн болон олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн заншлын хэм хэмжээг хэрэглэж болно.

Үндэсний Их Баяр наадмын тухай хуулийн хүрээнд заншлын эрх зүйгээр хэрхэн зохицуулалт хийснийг авч үзье.

Улсын Их Баяр наадмын тухай хуулийн 10.2-т "Бөх, харваач нь сэргээш хэрэглэхийг хориглоно. Уяач моринд сэргээш өгөхийг хориглоно. Улсын баяр наадмын шөвгийн 16-д үлдсэн бөх, эхний 3 байр эзэлсэн харваач, айрагдсан бүх моринд сэргээш шинжилгээнд заавал оруулна", 10.9-д "Энэ хуулийн 10.2-т заасан шинжилгээнд орохгүй бол сэргээш хэрэглэсэнд тооцно", 14.3-т "Бөх, харваач сэргээш хэрэглэсэн, моринд сэргээш хэрэглэсэн нь тогтоогдвол тухайн баяр, наадамд олгосон цол, байрыг хасна".

2006 оны наадмаар улсын заан Д.Рагчаа, Б.Эрхэмбаяр нараас сэргээш илэрсэн. Харин улсын аварга А. Сүхбат, улсын харцага Элбэг нар сэргээшийн шинжилгээнд орох шаардлагыг биелүүлээгүй байна.

Д.Рагчаа, Б.Эрхэмбаяр хоёр А шинжилгээнд илэрсэн сэргээшийг үл хэн зөвшөөрөлгүй БНСУ-д байрлах Олон Улсын олимпын хорооноос магадлан итгэмжлэгдсэн допингийн төвд хандаж, В шинжилгээг мөн хийлгэжээ. Харин нь сэргээш илэрсэн гэж гарсан байна. Ингээд Баяр наадмыг зохион байгуулах комиссийн дүгнэлтээр эдгээр бөхийн цол, чимгийг хураах шийдвэр гарч, хуулийн дагуу Ерөнхийлөгчид өргөн барихад бэлэн болоход Д.Рагчаа, Б.Эрхэмбаяр нар Захиргааны хэргийн шүүхэд хандаж, хэргээ шийдвэрлүүлжээ. Захиргааны хэргийн шүүх 2007 оны 1 дүгээр сарын 5-ны өдрийн 06, 2007 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн

81 тоот шийдвэрээрээ допингийн А шинжилгээг эрх бүхий субъект аваагүй байгаа тул уг шийдвэрийг хүчингүй болгосон байна. Энд В шинжилгээг өрөөс үнэлж дүгнээгүй юм.

Хэрэв Захиргааны хэргийн шүүх В шинжилгээг үнэлсэн бол уг сэргээш хэрэглэсэн хоёр бохийн цолыг хуулийн дагуу хураах байлаа. Үндэсний Их Баяр наадмын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1-д зааснаар "Баяр наадмыг уламжлалт эс заншилд тулгуурлан улс орон даяар тэмдэглэн өнгөрүүлэх ажлыг Үндэсний Их Баяр наадмыг зохион байгуулах хороо, аймэг, сумын хойроо хариуцна" гэжээ. Энд яригдаж байгаа "ес заншил" гэдэгт:

1. Үндэсний заншил
2. Олон улсын заншил орох юм.

Ямар тохиолдолд олон улсын заншилд тулгуурлах вэ гэдэг асуудал гарна. Үндэсний эс заншлаар зохицуулагдаагүй шинээр үүссэн харилцаанд олон улсын заншлын хэм хэмжээг хэрэглэнэ. Сэргээш нь үндэсний эс заншлаар зохицуулагдаагүй учраас олон улсын заншлыг харах болж байгаа юм.

Олон улсын спортын заншилд сэргээш илэрсэн тамирчин медаль, байраа хураагдахад түүний дараа орсон тамирчин дээш нөхөж, уг медаль, байрыг авдаг. Иймээс заншлын эрх зүйн дагуу Д.Рагчаа, Б.Эрхэмбаяр, А.Сүхбат, Г.Элбэг нарт унасан бөхчүүд дээш ахин байр эзлэх боломжтой байгаа юм.

Дүгнэлт

Дотоодын эрх зүйд заншлын хэрэглээ улам бүр багасч байгаа хэдий ч эрх зүйн зохицуулалтын өөрийнх нь мөн чанар үгүйсгэгдээгүй харин улам хөгжин нэрийсч, хэлбэрийн хувьд дүрэм, журам, хууль, шүүхийн жишиг, номлол болон эрх зүйн харилцааг зохицуулахаг, заавал биелэгдэх хүчин чадалтай хэм хэмжээ болон тогтож байгаа юм. Тэр дундаа шүүхийн жишиг нь шинээр үүсэн бий болж буй заншлын эрх зүйн шууд хэлбэр бөгөөд цагаас цагт аривинч баяжиж байна. Тухайлбал, шүүхийн жишиг нь хуулиар зохицуулагдаагүй буюу хууль баримтлан зохицуулахад шударга ёсонд үл нийцэх тухайн харилцааг шинэ заншил бий болгон зохицуулж буй эрх зүйн хэм хэмжээ юм.

ХҮҮХДИЙН ГЭМТ ХЭРГИЙГ ШҮҮН ТАСЛАХ АЖИЛЛАГААНД ГАРЧ БУЙ ХҮНДРЭЛ БЭРХШЭЭЛ, ЦААШИД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

Нийслэлийн дүүргийн анхан шатны шүүхүүд 2005-2007 оны хагас жилийн байдлаар нийт 6067 хэрэг янхан шийдвэрлэж, 8642 хүнд ял шийтгэсний 10.6 хувь буюу 920 нь насанд хүрээгүй хүмүүс байлаа. Эдгээр 920 хүүхдэд ногдуулсан эрүүгийн ял шийтгэлийг судалж үзвэл, нийт 920 хүүхдийн 836-д нь хорих ял шийтгэж, үүнээс 178 хүүхдийн хорих ялыг насанд хүрээгүйчүүдийн хорих ангид биечлэн эдлүүлж, 588 хүүхдэд хорих ял ногдуулсан шийтгэх тогтоол биелүүлэхийг 6 сараас 2 жил хүртэл хугацаагаар хойшуулж, 70 хүүхдэд ногдуулсан хорих ялыг биечлэн эдлүүлэхийг түдгэлзүүлэн зэвсэж, хянан харгалзсан бөгөөд 37 хүүхдийг баривчлаж, 32 хүүхдийг албадан ажил хийлгэх, 15 хүүхдийг торгох ялаар тус тус шийтгэж, хөнгөн буюу хүндэтгэр гэмт хэрэг анх удаа үйлдсэн насанд хүрээгүй этгээдэд ял ногдуулахгүй байх нь зохистой гэж шүүхээс дүгнэлт хийж, нийт 25 хүүхдэд хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авч, 6 сараас 1 жил хүртэл хугацаагаар засарч хүмүүжихийг даалгаж, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, сурган хүмүүжүүлэгч, ойрын төрөл садангийн хүний хяналтад өгсөн байна.

Насанд хүрээгүй 920 хүний гэмт хэргийг ангиллаар нь авч үзвэл:

- Хөнгөн гэмт хэрэгт 49 буюу 5.3хувь,
- Хүндэтгэр гэмт хэрэгт 643 буюу 69.8 хувь,
- Хүнд гэмт хэрэгт 200 буюу 21.7 хувь,
- Онц хүнд гэмт хэрэгт 28 буюу 3 хувь.

Нийт шийтгүүлэгчийн 692 буюу 75.2 хувь нь хөнгөн ба хүндэтгэр гэмт хэрэг үйлдсэн, 228 буюу 24.7 хувь нь хүнд ба онц хүнд гэмт хэрэг үйлдсэн байна.

Насанд хүрээгүй хүмүүс гол төлөв бусдын эд зүйлийг хулгайлах,



Нийслэлийн шүүхийн
Эрүүгийн хэргийн
танхимын тэргүүн
Б.САРАНТУЯА

булаах, дээрэмдэх, танхайрах, хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэргүүдийг үйлдэж ял шийтгүүлсэн байна.

Нийт ял шийтгүүлсэн хүний 24,6 хувь буюу 227 нь 14-16 насны, 75,3 хувь буюу 693 нь 16-18 насны хүүхдүүд байх бөгөөд тэдний

гэмт хэрэг үйлдсэн болон хувийн байдлыг судалж үзвэл, бусдад уруу татагдсан 45, архи согтууруулах ундаа хэрэглэсэн, мансуурсан үедээ гэмт хэрэг үйлдсэн 33, ажил, сургуульгүй 248, хагас, бүтэн өнчин 102, нэн ядуу, эмзэг өрхийн 23 хүүхэд байна.

Гэмт хэрэг үйлдсэн насанд хүрээгүй хүнд холбогдох хэргийг шүүхүүд зөв шийдвэрлэж, оновчтой ял шийтгэж байгаа учир хорихоос өөр төрлийн хөнгөн ял шийтгүүлсэн хүүхдүүд хяналтын хугацаанд дахин гэмт хэрэг үйлдэх нь харьцангуй цөөн байна.

Анхан шатны шүүхээс насанд хүрээгүй хүмүүст ногдуулсан биечлэн эдлэх хорих ялыг давж заалдах шатны шүүх болон хяналтын шатны шүүхээс хорихоос өөр төрлийн ял болгон өөрчилсөн хувь хэмжээ маш бага байгаагаас үзэхэд анхан шатны шүүхүүдийн насанд хүрээгүй хүмүүст ногдуулж буй ял шийтгэлийн байдал тохирсон байна гэж үзэхээр байна.

Харин Улсын дээд шүүхийн хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдаанаас насанд

Судалгаа-1

Он	Шийдвэрлэсэн бүх хэрэг	Ял шийтгүүлсэн нийт хүн	Насанд хүрээгүй бгд	Эмэгтэй		Торгох	Албадан ажил хийлгэх	Баривч-лах		Хорих		Тогтоол биелүүлэхийг хүмүүжүүлэгчид албадлагын арга хэмжээ өгсөн					
				14-16	16-18			Бүгд	Насанд хүрээгүй	Бүгд	Насанд хүрээгүй		Бүгд	Насанд хүрээгүй			
															Бүгд	Насанд хүрээгүй	
2005 он	2786	3979	424	36	114	310	331	9	155	14	539	22	2932	379	66	287	9
2006 он	2035	2821	278	22	71	207	255	2	120	12	313	6	2116	258	65	158	7
2007 оны хагас жил	1246	1842	218	8	42	176	141	4	111	6	239	9	1339	199	47	143	9
Бүгд	6067	8642	920	66	227	693	727	15	386	32	1091	37	6387	836	178	588	25

хүрээгүй хүмүүсийн үйлдсэн гэмт хэргийн нийгмийн хор аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруутай этгээдийн хувийн байдал, гэмт хэрэг үйлдэхэд идэвхтэй оролцож, гардан гүйцэтгэсэн этгээдүүдэд хорих ял ногдуулсан шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан нь буруу.

Мөн Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 376 дугаар зүйлд заасан насанд хүрээгүй этгээдэд хорих ял ногдуулсан тогтоол биелүүлэхийг хойшлуулж асуудлыг хүүхдийн болон цагдаагийн байгууллагын хамтран гаргасан хүсэлт ирээгүй байхад шийдвэрлэж шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан нь буруу гэх мэт үндэслэлээр шийтгэх тогтоолууд хүчингүй болж насанд хүрээгүй хүмүүсийн хорих ялыг биелчлэн эдлүүлэхэд хүрсэн байна. Насанд хүрээгүй хүмүүсийн хэргийг шийдвэрлэхэд хэд хэдэн боршлол учирч байна.

Насанд хүрээгүй хүмүүсийн хэргийг шалгах явцад хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, прокурорын шатанд Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 42 дугаар бүлэгт заасан "Насанд хүрээгүй этгээдийн үйлдсэн гэмт хэрэгт Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулах Тусгай журам"-ыг зөрчих, хэргийг маш удаан, урт хугацаагаар шалгаснаас насанд хүрээгүй хүмүүс нь 18 насанд хүрч хөнгөлөлт эдэлж чадахгүйд хүрэх, насанд хүрээгүй шүүгдэгчийн ургийн овог, эцгийн нэр, өөрийн нэр, төрсөн он, сар, өдөр, нас, хүйс, насанд хүрээгүй хүүхдийн амьдралын нөхцөл байдал ба хүмүүжил, гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлсөн шалтгаан нөхцөл, насанд хүрсэн хатгагч ба бусад хамтран оролцогч байсан эсэхийг шалгалгүй орхигдуулдаг, хариуцлагыг хөнгөрүүлэх, хүндрүүлэх нөхцөл байдлыг тогтоолгүйгээр хэргийг шүүхэд шилжүүлдэг.

Анхан шатны шүүхүүд насанд хүрээгүй хүмүүст холбогдох хэргийг хянан шийдвэрлэхдээ Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг ноцтой зөрчих, Эрүүгийн хуулийг буруу хэрэглэх, ял шийтгэлийг оновчтой зөв ногдуулж чадахгүй байх, эрүүгийн хариуцлага хүлээлгэх насанд хүрээгүй этгээдийг эрүүгийн хариуцлагад татаж ял шийтгэл ногдуулах гэх мэтийн алдаа зөрчил

гаргасан байна.

2007 онд Эрүүгийн байцаан шийтгэх хуульд орсон нэмэлт, өөрчлөлтөөр насанд хүрээгүй хүмүүсийн урьдчилан цагдан хорих хугацааг эгнээгосгон, мөн энэ төрлийн хэргийг хаалттай шийдвэрлэх, өмгөөлөгч нь хүссэн тохиолдолд байцаалтыг дүрс бичлэгээр бэхжүүлж авах гэх мэтийн зэрэг сайн заалт орсон боловч насанд хүрээгүй хүмүүсийн хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэхийг хориглох, 16 нас хүрсэн л бол мэдүүлэг өгөхөөс татгалзах буюу зайлсхийх, санаатайгаар худал мэдүүлэг өгөх хариуцлага хүлээлгэхээр хууль сацуулж гарын үсэг зуруулах зэрэг заалт орсон нь анхаарал татаж байна.

Цаашид насанд хүрээгүй этгээдийн амьдралын нөхцөл байдал, хүмүүжил, үйлдсэн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хувийн байдал, гэмт хэргийн шалтгаан нөхцөл, хохирлын хэр хэмжээ, учруулсан хор уршгийн шинж чанар, гэмт хэрэгт оролцсон оролцоо, хариуцлагыг хөнгөрүүлэх болон хүндрүүлэх нөхцөл байдал, нийгмээс тусгаарлахгүйгээр хүмүүжүүлэх боломжтой эсэх зэрэг тал бүрээс нь дүгнэлт өгч, гэм бурууд нь тохирсон мэдрэмжтэй, ялгамжтай ял шийтгэл ногдуулах шаардлагатай.

-Хэргийг үндэслэлгүйгээр мөрдөн байцаалтанд олон дахин буцааж хугацаа алдах явдлыг зогсоох.

-Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд насанд хүрээгүй хүмүүсийн хэргийг маш хурдан шалгаж шүүхэд шилжүүлж байх, үндэстэй, үндэсгүй шалтгаанаар хэргийг түдгэлзүүлсэн нэртэйгээр удаан хугацаагаар дарагдуулах явдлыг таслан зогсоох.

-Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасан насанд хүрээгүй этгээдийн үйлдсэн гэмт хэрэгт Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулах тусгай журмыг ягштал баримталж, насанд хүрээгүй хүмүүсийн хэргийн мөрдөн байцаалтад эцэг, эх, сурган хүмүүжүүлэгч, хууль ёсны төлөөлөгчийг заавал оролцуулах, тэдэнд хэргийн

материалыг танилцуулахдаа хуулийн шаардлагыг хангах. Насанд хүрээгүй хүмүүс нь сэтгэцийн өвчингүй боловч ухаан санаа нь гүйцэд хөгжөөгүй улмаас өөрийнхөө үйлдлийн холбогдлыг бүрэн гүйцэд ойлгож байгаа эсэхэд эргэлзээ төрвөл шинжээч томилж дүгнэлт гаргуулж байх.

-Хүнд (5-аас дээш жил хорих ялтай), онц хүнд (10-аас дээш жил хорих ялтай) гэмт хэрэг үйлдсэн насанд хүрээгүй хүмүүст олоогийн дагаж мөрдөж байгаа Эрүүгийн хуулиар хорих ял шийтгэл ногдуулж, уг ялыг биелчлэн эдлүүлэхэд дэндүү хүнд тусч байгааг анхаарч насанд хүрээгүй хүмүүст хорих ял биелчлэн эдлүүлэх тохиолдолд Эрүүгийн хуульд заасан хорих ялын доод хэмжээг доош татаж ногдуулж болох заалтыг Эрүүгийн хуульд оруулах.

-Дөнгөж 18 насанд хүрсэн, амьдралд хөлөө олоогүй хүмүүс насанд хүрээгүй хүмүүстэй хамт бүлэг гэмт хэрэг шийтгүүлэхдээ насанд хүрээгүйчүүдэд хорих ял ногдуулсан шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулж байхад 18 насанд хүрсэн этгээдийг олон жилээр шоронд эгнээг байна. Иймд хорих ял ногдуулсан шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулах тухай Эрүүгийн хуулийн 62 дугаар зүйлийн "насанд хүрээгүй" гэснийг "20 насанд хүрээгүй" гэж өөрчилж, 20 хүртэл насны залуучуудад хорих ял ногдуулсан шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулдаг болгох.

-Гэмт хэрэг үйлдсэн насанд хүрээгүй хүмүүсийн хэргийн талаарх мэдээллийг төрийн бус байгууллагуудад өгч байх.

-Төрийн бус байгууллагууд цагдаагийн байгууллагуудтай хамтарч, насанд хүрээгүй хүмүүсийг хүмүүжүүлэх хүсэлтийг шүүхэд бичгээр гаргаж өгч, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 376 дугаар зүйлээр хүлээсэн үүргээ биелүүлж байх шаардлагатай байна.



КРИМИНАЛИСТИКИЙН ЭКСПЕРТИЗИЙН АНГИЛЛЫН ОНОЛ, ПРАКТИКИЙН ЗАРИМ АСУУДАЛ

Нийслэлийн цагдаагийн газрын Эрэлч нохойн алба, Үнэрийн лабораторийн эрхлэгч, цагдаагийн дэд хурандаа, докторант **Б.ЖАРГАЛСАЙХАН**

Дэлхий дахин даяаршиж, шинжлэх ухааны үйлдвэрлэлийн технологи эрчимтэй хөгжихийн хэрээр шинжлэх ухааны мэдлэг ялгарах ба нэгдэх процесст чанарын өөрчлөлт гарч, криминалистикийн экспертиз хийгдэж буй материал, хийц, бодисын зүйлийн төрөл, хэмжээ өсч, манайхын уламжлалт "тусгай шинжилгээ" хэмээх ангиллын хүрээнээс хэдийн даваад хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчид экспертизийн нэр, ангиллыг зөв тодорхойлоход хүндрэлтэй болж эхэлжээ. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчид экспертиз хийлгэх тухай тогтоолд экспертизийн төрлийг зөв тодорхойлон, экспертийн эзэмшсэн тусгай мэдлэгийн хүрээнд багтаан хийлгэж байх нь нотолгооны өндөр ач холбогдолтой. Экспертизийн төрлийг зөв тодорхойж, экспертийн эзэмшсэн тусгай мэдлэгийн хүрээнд багтаах асуудалд манайд криминалистикийн экспертизийг ангилж буй байдал сөрөг нөлөө үзүүлж болзошгүй нь сүүлийн үед ажиглагдах боллоо. Үйлдвэрлэлийн технологийн өндөр хөгжлийг даган криминалистикийн экспертиз хийлгэхээр ирүүлж буй объектын төрөл, тоо өсөх болсон нь бидний уламжлалт ангиллыг шинэчлэх асуудлыг зүй ёсоор шаардаж байна. Учир нь, манайхын баримталж заншсанаар криминалистикийн экспертиз:

1. Криминалистикийн,
2. Эмнэлгийн болон сэтгэгч-бие бялдрын,
3. Инженер-техникийн,
4. Инженер-тээврийн,
5. Инженер технологийн,
6. Эдийн засгийн,
7. Биологийн,
8. Экологийн,
9. Хөдөө аж ахуйн,

10. Урлагийн зүйлийн¹ гэж ангилдаг бид мэднэ.

Сүүлийн үед дэлхий нийтэд, ялангуяа хойд хөршид хийгдэж буй криминалистикийн экспертизийн чиг хандлагыг үзвэл түүнийг дотор нь ангилан мөр судлалын; баллистикийн; бичгийн хэв судлалын; бичиг баримтад хийх техникийн; дүр зургийн; зохиогчийг тогтоох; дүрс, дуу авианы; гэрэл зургийн техникийн; тээсэлгээний техникийн; устгаж зассан дугаарын; материал, хийц, бодисын зүйлд хийх криминалистикийн гэж төрөлжүүлдэг.

Үүн дотроо өөрчлөлтөд бага өртөж байгаа бусад төрлийг орхиж зөвхөн криминалистикийн экспертизийн шинэ төрөл болох **материал, хийц, бодисын зүйлд хийх криминалистикийн экспертизийг** хэрхэн ангилж буйг авч үзье. Энэ төрлийн экспертизийг шинэчлэгдэж буй объектоор нь төрөлжүүлэн:

- у т а с л а г - ш и р х э г л э г материалын;
- нефтийн бүтээгдэхүүн болон шатах-тослох материалын;
- лак-будгийн зүйл болон лак-будгийн давхрагад хийх;
- полимер хийцийн;
- төмөр болон хайлш хийцийн;
- шил, шаазан, силикат материалын;
- наркотик болон эмийн зүйлийн;
- хүчтэй үйлчлэх болон хорт бодисын;
- спиртний найрлага бүхий шингэрийн хэмээн ангилалд оруулжээ.

Манайд криминалистикийн экспертизийг ингэж ангилахгүй байгаагаас материал, хийц, бодисын зүйлд хийх криминалистикийн экспертизийг байгалийн шинжлэх ухааны хими, физик, биологийн

гэсэн гурван лабораторит, буруу тодорхойлсон экспертизийн төрлөөр, тус тусдаа бие даасан аргачлалаар хийлгэж байна.

Юуны өмнө экспертизийн нэр томъёог зөв оноох асуудал хөндөгдөнө. Манайд нэршиж заншсан "шүүхийн шинжилгээ" гэдэг нэр томъёо нь оросын эрүүгийн эрх зүйн "судебные экспертизы" хэмээх нэр томъёоны махчилсан орчуулга бөгөөд "шүүхийн" гэдэг энэ үг "хууль зүйн" гэсэн санаагаар ойлгогдож өгдөггүй. Англи хэлний "forensic examination", орос хэлний "судебная экспертиза" хэмээх энэхүү ухагдахуун нь тухайн хэлэндээ "хууль зүйн" гэсэн санаагаар хэрэглэгддэг. "Forensic" гэдэг үгийг англи хэлний тайлбар толиос үзвэл "used to discover information about a crime by scientifically examining the objects or substances that are involved in the crime"² буюу "гэмт хэрэгт холбогдолтой объект, зүйлд шинжлэх ухаанлаг судалгаа явуулж гэмт хэргийн тухай мэдээллийг олж илрүүлэх" гэсэн байгаа нь дээрх үгийг зөвхөн шүүн таслах ажиллагааны бус криминалистик буюу хууль зүйд тэр чигт нь хамаарах болохыг харуулж байна.

"Криминалистик" хэмээх үгийг латин хэлний "crimin" - гэмт хэрэг, "criminalis" – гэмт гэдэг үгнээс гаралтай, гэмт хэрэгтэй холбоотой бүх зүйлийг хэлдэг үг, Орос, Герман мэтийн улсад энэ нэрээрээ, барууны улс орон "forensic science" гэдэг нэрээр, Япон мэтийн зарим улсад "police science" гэж нэрлэгддэг. Тэгэхээр "forensic" гэдэг үгийг оросууд заримдаа криминалистик гэж гадаад үгнээс үүссэн нэрээр нь, заримдаа эх хэлээрээ, "судебный" гэж авчмаадаг байгааг манайхан анзааралгүйгээр хоёр өөрөөр орчуулавд, буруу ойлголт төрүүлээд байгаа хэрэг.

¹ Белкин Р.С., Аверьянова Т.В. Криминалистическое обеспечение деятельности криминальной милиции и органов предварительного расследования. М., "Новый Юрист", 1997. с.160-161

² Митричев В.С. Криминалистическая экспертиза материалов, веществ и изделий. Саратов, 1980

³ Cambridge international dictionary of English. CAMBRIDGE UNIVERSITY PRESS, 1995. p.549

Хими, физик, биологийн аргаар хийгдэж буй криминаликтикийн экспертиз нь энэ шинжлэх ухааны гаргаж боловсруулсан аргачлалаар, хууль зүйн ашиг сонирхлын дагуу, гэмт хэрэгтэй холбогдолтойгоор хийгдэж буй тул бүгдгүй нь "криминаликтикийн шинжилгээ" хэмээн ерөнхий нэрээр нэрлэдэг.

Мөн "шүүхийн" гэдэг үгийг англи хэл рүү эргэж орчуулан "court", эсвэл "trial", шүүхийн шинжилгээг "court/ trial/ examination", "Шүүхийн шинжилгээний үндэсний төв"-ийг "The national centre of the court expertises", шүүх эмнэлгийг "court medicine" гэвэл англиар ярьдаг гадаадынханд бидний ойлгуулах гэсэн ухагдахуунаараа буухгүй. Иймээс "шүүхийн шинжилгээ" гэсэн нэр томъёог цаашд эх хэлнийх нь илэрхийлж буй утгаар "криминаликтикийн экспертиз" гэж, "шүүх эмнэлэг" гэсэн нэр томъёог "анагаах ухааны криминаликтик" гэж занших нь зүйтэй.

Манай Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйд "шинжилгээ" хэмээх ухагдахуунаар авч үзэж буй гэр зүйл нь шинжилгээ буюу "экспертиз", түүнийг хийж гүйцэтгэж буй мэргэжилтэн нь шинжээч биш эксперт байх ёстой. Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйд экспертизийг "шинжилгээ" гэж авч үздэг нь буруу¹. Учир нь оросоор "исследование", англиар "research" хэмээх үг нь монгол хэлнээ буулгавал судалгаа гэсэнтэй утга дүйх үг. Энэ үгээс үүссэн "исследователь", "researcher" хэмээх үгийг монгол хэлнээ "судлаач" гэж буулгавал зохилтой г манайхан шинжээч хэмээн орчуулдаг. Харин оросын "экспертиза" хэмээх үг нь английн "examination" хэмээх үгтэй утга дүйгдийг манайхан мөн шинжилгээ хэмээн орчуулдаг. Экспертиз хэмээх энэхүү үг нь латин хэлний "expertus" буюу "туршлага" гэсэн үгээс үүссэлтэй франц хэлний "expertise" гэсэн үг бөгөөд орос хэлэнд тэр хэвээрээ хэрэглэгдсэн байдаг². Тиймээс судлаач биш, эксперт буюу шинжлэх ухааны тусгай мэдлэгийг гаргууд эзэмшсэн, мэргэжилтний тэр мэдлэгийг

Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйд ашиглахыг судалгаа г биш, шинжилгээ г биш, экспертиз хэмээн нэрлэж заншмаар байна. Шинжлэх ухааны мэдлэг ялгарах процессын үр дүнд хүн төрөлхөнд байсан философи хэмээх цорын ганц шинжлэх ухаанаас өнөөдрийн бүх шинжлэх ухаан төрөн гарсан нь үнэний адил криминаликтик маань задарч Энэтхэг улсад "fingerprint science" буюу гарын мөрний шинжлэх ухаан³, ОХУ-д Гаалийн криминаликтик, Хилийн криминаликтик, Гүйцэтгэх ажлын криминаликтик, Анагаах ухааны криминаликтик, Өмгөөллийн криминаликтик зэрэг салбар үүсэн хөгжиж буйг эрдэмтэн судлаачид хүлээн зөвшөөрөөд⁴ байгаа билээ. Криминаликтикийн экспертизийн онол арга зүйн үндсийг боловсруулдаг экспертологийг хэмээх шинжлэх ухаан мөн л криминаликтикаас төрөн гарсан.

Шүүхийн шинжилгээний үндэсний төв гэдгийг "The national forensics centre" гэвэл зөв орчуулга болох болов уу. Учир нь "forensics" гэдэг үгийг мөн тайлбараас харвал хэрэв утгайг бөгөөд гэмт хэрэгтэй холбоотой болит мэдээлэлд хийх шинжлэх ухаанлаг судалгаа, нөгөө нь "forensics is also the place where physical information about a crime is tested scientifically" буюу "түнчлэн гэмт хэргийн тухай биет мэдээлэлд шинжлэх ухаанлаг судалгаа явуулдаг байгууллага" гэжээ. Харин одоо англиар "The national centre of the forensic examination" гэж байгаа нэр нь "Шүүхийн" биш "Криминаликтикийн экспертизийн үндэсний төв" гэж орчуулагдана.

Шүүхийн шинжилгээний үндэсний төвд хийгдэж буй экспертизийн байдлыг үзвэл материал, хийц, бодисын зүйлд хийх криминаликтикийн экспертизийг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчид хими, физик, биологийн экспертизээр ихэвчлэн шийдүүлж байна. Энэ нь шинжлэх ухааны эдгээр салбарын дээрх төрлийн экспертизийн арга тус тусдаа, криминаликтикийн экспертизийн нэгдмэл аргачлал боловсрогдоогүй байгатай шууд холбоотой.

Материал, хийц, бодисын

зүйлд хийх криминаликтикийн экспертизийн төрлийг зөв тодорхойлох нь экспертизийн эзэмшсэн тусгай мэдлэгийн хүрээг зөв тодорхойлж экспертизийн байгууллагыг сонгохоос эхлэлтэй. Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 158 дагуур зүйлд зааснаар "шинжилгээг шинжилгээний байгууллагаар хийлгэх журмын" дагуу криминаликтикийн экспертизийг Шүүхийн шинжилгээний үндэсний төв хийж байна. Гэтэл энэ төвийн техник хангамж, экспертүүдийн эзэмшсэн тусгай мэдлэгийн хүрээ нь дээр дурдсан хими, физик, биологийн зарим төрлийн экспертиз хийхээс цааш хэтрэхгүй байгаа. Криминаликтикийн экспертизийг хийх чадамж бүхий өөр нэг газар нь Цагдаагийн академийн Криминаликтикийн тэнхим мөн боловч тэнд мөн техник хангамж муу, багш нараар нь экспертиз хийлгэдэггүйгээс энэ тухай хуульд мэддэггүй гэхэд хилсдэхгүй. Гэтэл дэлхийн практикаас үзвэл түүх, соёлын дурсгалт зүйлийн харьяаллыг тодорхойлох, хүний организмн талаарх элдэв нотолгоо, маргаантайн улмаас давтан хийгдэж буй экспертизийн маргаан таслах сүүлчийн шат нь их сургуулиуд байдгийг бид бүхэн мэднэ.

Криминаликтикийн экспертиз хийлгэхээр чадамж бүхий байгууллагыг сонгохдоо материал, бодисын шинж, гарал үүсэл болон экспертэд тавих асуулын хүрээг үндэслэл болгох ёстой. Экспертиз хийгдэж буй зүйлийн шинж, ерөнхий гарал үүслийг мөрдөн байцаагч, хэрэг бүртгэгч хэргийн болсон байдал болон мэргэжилтэнтэй зөвлөлдсөний үндсэн дээр чиглүүлэн тогтоох бөгөөд экспертизийн ангилал нь түүний төрлийг тогтоолд зөвхөн. Экспертиз хийлгэх тогтоолд зөвхөн ангиллыг дурдах нь хангалттай бөгөөд экспертиз явуулахад шаардлагатай арга, аргачлалыг экспертүүд өөрсдөө сонгох нь зүйтэй.

Органик бус гарал үүсэлтэй материал, бодисын зүйлд тэдгээрийн уу болох, бэтэц

¹ Хурцгэрэл, Ж. Криминаликтик. УБ, 2002. 1 боть, 75 дахь тал

² Жаргалсайхан, Б. Эрүүгийн байцаан шийтгэх хууль дахь криминаликтикийн хэл болон монгол хэлзүйн зарим асуудал. Хууль дээдх ёс. 2007. № 3 (18). 36-44 дахь тал

³ Sanki K. Chatterjee & Richard V. Hazare. Finger print or Dactyloscopy and Ridgeoscopy. Calcutta. 1988.

⁴ Зорин, Г.А. Теоретические основы криминалистики. Минск., 2000

⁵ Винберг А. И. Магальская Н. Т. Судебная экспертиология (Общетеоретические и методологические основы проблемы судебных экспертиз). М., 1979.

найрлагыг тодорхойлуулахаар криминаликтикийн экспертизийг нэлээд элбэг хийлгэдэг. Материал, хийц, бодисын зүйлд хийх криминаликтикийн экспертиз нь уламжлалт мөр судлал, бичиг баримт, галт зэвсгийн зэрэг экспертизийн хүрээнд хийгдэх болно.

Материал, хийц, бодисын зүйлд хийх криминаликтикийн экспертизийн зорилго нь материал, хийц, бодисын зүйлийн үйлдвэрлэх, ашиглах, зөөвөрлөх явцад бий болсон адилтгалын онцлог шинжээр тэдгээрийн гарал үүсэл, бүлгийн харьяаллыг тогтоох, ангилах, гэмт хэрэг үйлдэгдсэнтэй холбоотойгоор тухайн материал, хийц, бодисын зүйл үүсч бий болсон буюу устаж арга болсон шинж, тэдгээрт гарсан өөрчлөлт, зөөвөрлөх үед өөр бусад зүйлтэй харилцан үйлчилсэнээс үүсч бий болсон онцлог шинж зэргийг тогтоох явдал юм. Энэ төрлийн экспертизийн өвөрмөц онцлог нь хэргийн бодит үнэнийг тогтоохоор програмчлагдсан экспертизийн аргачлал, экспертиз хийгдэх буй объектын хэмжээ, давтан хийх экспертизэд дээжээс авч хоцрох шаардлага, гаргаж авсан баримтын криминаликтикийн үнэмлэх /мэдээллийн синтез үнэлгээ/ зэрэг юм⁹.

Материал, хийц, бодисын зүйлд хийх криминаликтикийн экспертизийн агуулга нь хэргийн бодит үнэнийг тогтоохоор материал, хийц, бодисын зүйл, тэдгээрийн үлдэгдэл, бичиг зэсэгт хийх, криминаликтикийн аргачлалд үндэслэгдсэн тусгай судалгаа бөгөөд криминаликтикийн шинжлэх ухааны тусгай мэдлэгийг ашиглан тогтоож буй энэ бодит баримт нь энэ төрлийн экспертизийн зүйл болж өгнө.

Экспертизийн объект болон зүйлийг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн асуулт тодорхойлж өгөх бөгөөд шаардлагатай гэж үзвэл үүнийг эксперт санаачилгаараа нэмэн өргөжүүлж болно¹⁰.

Хүний организмсын гаралтай шүлс, хөлс, нулимс, шээс, өтгөн, хаг, хулхи мэтийн ялгадас;

түүнчлэн цус, үрийн шингэн, арьс, хумс, эрхтний хэсэг зэргээг анагаах ухааны криминаликтикийн экспертиз хийгддэг. Энэ ангиллын экспертиз нь дотроо төрөлжин хуваагдадаг бөгөөд бодисын зүйлд хийх экспертиз нь анагаах ухааны криминаликтикийн эд мөрийн баримтын¹¹ экспертийн тусгай мэдлэгийн хүрээнд хамаарах хийгээд бодисын зүйлд хийх анагаах ухааны криминаликтикийн экспертизийн хэд хэдэн төрөл байдаг¹² /биологи, гистологи, хими-хор судлалын, физик-техникин аргуудыг хавсарч хэрэглэх/.

Эд мөрийн баримтад хийх анагаах ухааны криминаликтикийн экспертиз нь эс адилтгах шинжтэй нэлээд асуудлыг шийдэж өгдөг нь объектуудын гарал үүслийг тогтоох, тэдгээрийн төрөл, хүйс, биеийн ямар эрхтнийх болохыг тодорхойлон харьцуулах экспертиз хийх зэрэг юм.

Ерөнхий биологи, молекулын генетик, анагаах ухааны криминаликтикийн өнөөгийн хөгжилд энэ хамтаар тусгай мэдлэгийн хүрээнд хамаарах адилтгалын зорилгыг улам нарийвчлан зааглаж өгч байна.

Английн эрдэмтэн А.Жеффрисийн удирдлагаар 1985 онд хүний ДНХ-ийн давтагдашгүй хувилбарын анализ дээр үндэслэсэн "Генийн дактилокопи" хэмээн нэрлэсэн арга гаргаж боловсруулсан нь энэ чиглэлд гарсан асар том ололт байлаа. Цаашид ДНХ-полимеразын гинжин урвалыг ашиглан генетикийн бодисыг "хувилах", ДНХ-ийн молекулыг олшруулах болжмж нээгдсэн. Полимеразын гинжин урсгал нь ДНХ-ийн өчүүхэн жижиг хэсгээр ч, бүтцийн өөрчлөлтөд орсон үгүйг үл харгалзан, хэчнээн хугацааны дараа ч шинжилгээ хийн тогтоох боломж олгожээ.

Сүүлийн үед генийн төрөл судлалын¹³ /генотипоскопия/ аргыг ашиглан экспертиз явуулж байна. Биологийн объект тодорхой хүнээс гарал үүсэлтэйг тогтоох, эсвэл бүлгийн харьяаллыг тогтоож өгдөг

байсан биохимийн экспертизээс ялгаатай нь энэ экспертизээр хүнийг тухайлан тогтоох /нэг өвдөн эсний ихрүүдээс бусад тохиолдолд/ боломжтой бөгөөд ДНХ агуулсан биологийн ямар ч материалын өчүүхэн хэсэг нь экспертиз хийхэд хангалттай. Энэ арга нь адилтгалын асуудлыг шийдвэрлэхээс гадна садан төрлийн холбоо, хүйсийг тогтоох зэрэгт ашиглагдаж байна¹⁴. Английн Манчестэр хотын ойролцоо аугуйгас олдсон эртний хүний арга ясны соёоны угаас авсан генетикийн экспертизээр уг арга яс нь одоогоос 9000 жилийн өмнө амьдарч, нүүдлийн аж ахуй эрхэлж, жимс голдуу хүнсээр хооллодог, 20 орчим насны эрэгтэй хүнийх болохыг тогтоогоод уг хотын иргэдийг генетикийн дээж өгөхийг уриалахад мөн хотын дунд сургуулийн нэгэн багшийн өвөг дээдсийнх мөн болохыг тогтоосон баримт, дэлхийд шуугиан тариад байгаа Чингэсийн ген, МЭӨ YII зууны орчимд оршин тогтнож байгаад сураг тасарсан эртний домогт Амазон бүсгүйн шарлаас авсан генетикийн дээж Өмнөговийн хоньчин охиноос илэрсэн¹⁵ зэрэг баримт олон бий.

Анагаах ухааны шинжтэй зарим асуултад хариулахын тулд анагаах ухааны криминаликтикийн эксперт эмч нар тусгай мэдлэгийнхээ хүрээнд хүний биеийн дотор, эсвэл бие дээр хэрэгжсэн ул мөр нь илэрт тогтоогдсон гадны биетэд /галт зэвсгийн үйлчлэл, дарь, хор болон төмөрлөгийн зүйл г.м/ экспертиз хийдэг.

Энд одорлогийн экспертизийг¹⁶ ч мөн дурдууштай. Амьтан, ургамал, эрдэслэг гаралтай материаллаг объектуудаас байнга тооцон ялгарч буй тухайн биетийн бичил хэсэг-молекулын шинжийг үнэр гэх бөгөөд хүний үнэрийн худьд биологийн бусад объектын адил генетикээр програмчлагдсан, дахин давтагдашгүй, харьцангуй тогтвортой шинжтэй билээ.

Үнэрийн шинжийг агуулж байхын тулд объект үнэр хуулан авагчийн үнэрийн анализаторт

⁹ Маланьина Н.И. Криминалистическое исследование материалов, веществ и изделий как отрасль криминалистической техники. //Пособие совершенствования предварительного следствия: Сборник статей. СПб, 1992. Вып. 71.

¹⁰ Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 162.3

¹¹ Селиванов Н.А. Вещественные доказательства. М., 1971.

¹² Попов В.Л. Судебно-медицинская экспертиза: Справочник. СПб, 1997.

¹³ Комаровский Ю. А. Применение молекулярно-генетических методов в судебно-медицинской экспертизе. СПб, 1998.

¹⁴ Стенова Т. В и др. Работа со следами биологического происхождения на месте происшествия. М., 1992.

¹⁵ Б. Болдсайхан, Гаймашмит Амазон-Монгол бүсгүйчүүд. Өдрийн сонин. 2007.07.03. № 154 /2606/. 7 дугаар нүүр.

¹⁶ Одорлогийн тухай материалыг үүнийг бичигч "Хууль зүйн мэдээ" сонини 2007 оны 19; 21-22 дугаарт хэвлүүлсэн "Үүн, тэрний мөн чанар" өгүүлэлээ ашиглас.

/энэ нь хүн, амьтны үнэрлэх эрхтэн буюу эсвэл хэрэгсэл төхөөрөмжийн авуур байж болно/ мэдрэгддэг байх ёстой. Ийнхүү мэдрэгдэх нь материаллаг шинжтэй бөгөөд ямар ч тохиолдолд мөр үүсгэгч ба хүлээн авагч объектууд оролцсон байх ёстой. Трасологийн өрөнхий ойлголтоор "харилцан үйлчлэлийн үр дүнд материаллаг объектын гадаад бүтцийн шинж тэмдэг тусгал хэлбэрээр нөгөө объектын гадаргууд дүрслэгдэхийг хэлнэ"¹⁷ гэсэн тусгал мөрний тодорхойлолт нь үнэрийн мөрөнд ч хамаатай. Учир нь хоёр объект харилцан үйлчилснээр нэг объектын гадна бүтцийг тодорхойлж буй элементийн нэг болох үнэр нь нөгөө объектод шингэн үлдэж байгаа хэрэг. Мөн онолоор мөр гэж "гэмт хэрэг үйлдэгдсэнтэй холбогдон хүрээлэн буй орчимд үүсэх бий болж байгаа аливаа бодит өөрчлөлтүүдийг хэлэх ба энэ нь эд зүйлийн байр солигдсон, байсан эд зүйл алга болсон, эсвэл шинээр бий болсон, эдгээр эд зүйлд ганц чанарын өөрчлөлт зэрэг шинжүүдээр илэрдэг"¹⁸. Тусгал мөртийг адилхан шугааман хэмжигдэхүүнч чухам эрт онцлог шинжийн нэг нь үнэр мөн бөгөөд найрлага дахь молекулын бүтэц, тоон үзүүлэлтээр тодорхойлогдож хүрээлэн буй орчны агаарын найрлагад орсон үнэр хэлбэрээр илэрдэг. Хурц үнэртэй зүйл /гоо сайхны бүтээгдэхүүн, бензин, будаг г. м/ хүнд шууд мэдрэгддэг ч, гүлгэн болон гарын мөр мэтийн зүйлээс хүн үнэрийг мэдрэдэггүй нь агаарын найрлага дахь үнэрт бодисын молекулын хэмжээг бидний үнэрлэх эрхтний авуурууд хүлээн авч чадахгүй байгаагай шууд холбоотой. Харин үнэр задлагч зохих хэрэгсэл төхөөрөмжийн тусламжтайгаар, үнэр бүхий ямар ч материаллаг биетээр адилтгал явуулах боломжтой.

Үнэрийг хүлээн авч мэдрэх нь үнэр үүсгэгч объектын физик шинжээс хамаараад зогсохгүй биологийн илчлэгчийн хувийн онцлог, зориулалтын ольфакторик¹⁹ хэрэгсэл төхөөрөмжийн техник үзүүлэлт, түүнчлэн үнэрт бодисын мэдрэгдэх доод хэмжээээс хамаараад.

Үнэрт бодисын мэдрэгдэх доод хэмжээ 1 шоо см агаарт

агуулагдах үнэрийн молекулын тоогоор тодорхойлогдох бөгөөд агаарын найрлага дахь үнэрийн молекулын тоо түүнээс цөөн байвал үнэр мэдрэгдэхгүй гэсэн үг. Хүн болон амьтан, хорхой шавьж, загас, нохой зэргийн үнэр мэдрэх доод хэмжээнд хийсэн судалгааны дүнгээс тэдний үнэр мэдрэх чадвар хоорондоо хэчнээн их ялгаатай болохыг харж болно. Жирийн хүн 1000 орчим үнэрийг ялгаж чаддаг бөгөөд нохой хүнээс ойролцоогоор 800 000 дахин илүү мэдрдэг бол түүнийг тусгайлан сургавал энэ нь бүр ч нэмэгдэг байна.

Иймээс хойд хөршүүд маань албаны нохойг ашигласан кинологийн²⁰ одорлогийн экспертизийг эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаандаа экспертиз дүгнэлт гаргах түвшинд ашиглаж байна. Харин урд хөрш болон барууны орнууд ольфакторик одорлогийн шинжилгээг эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд болон шинжлэх ухаан техникийн бусад салбарт түлхүү ашиглаж "Хувь хүнийг адилтгах биологийн хуудасны жагсаалтад үнэр шинээр нэмэгдсэн тул гарын мөр, ДНХ-ийн экспертиз хийх шаардлагагүй боллоо. Хятадын цагдаагийнхан сэжигтэн этгээдийг адилтгахад үнэрийн санг ашиглаж эхлэсэн бөгөөд Нанжин дахь Цагдаагийн нохойн судалгааны төвийн ажилтнуудын нотолж байгаагаар гэмт хэргийг шийдвэрлэхэд гол үүргийг үнэр гүйцэтгэх бөгөөд энэ нь хэчнээн архаг туршлагатай гэмт хэрэгтэн этгээд ч хэргийн газраас үнэрээ авч явж чаддаггүйтэй холбоотой"²¹ хэмээх болжээ.

Үнэрийн мөр нь мөн чанар, түүнтэй ажиллах арга барил, техник хэрэгслээрээ уламжлалт мөрнөөс эрс ялгаатай, криминалистикийн техник зүйн цоо шинэ төрлийн мөр билээ. Чухам энэ ялгаа, түүнтэй ажиллах илрүүлэх, бэхжүүлэх, тусгаарлах, битүүмжлэх, ашиглах/ аргачлал, технологи, техник хэрэгсэл, шаардлагатай төхөөрөмж боловсрогдоогүй байсан тул үнэрийн мөрийг саяхан болтол мөр судлалын бие даасан зүйл болгон судалж байсангүй. Харин одоо үнэрийн мөрийг нотлох баримт болгон ашиглаж хэрэгсэл төхөөрөмж бүрдсэн байна гэж хэлэх үндэс

бүрджээ.

Үнэрийн мөр үүсэх механизм нь тусгал мөр болон эд зүйл-үл мөр үүсэх механизмээс мөр үүсгэгч объектын агрегат төлөвөөр ялгагддаг. Тиймээс үнэрийн мөр нь түүнтэй ажиллах өвөрмөц онцлог бүхий арга барил, аргачлал, технологи, хэрэгсэл төхөөрөмжийг шаарддаг.

Криминалистикт үнэрийг дараах шинжээр тодорхойлж болно. Үүнд:

- мөр үүсэх механизмын тасралтгүй үргэлжлэх шинж. Трасологийн мөр үүсгэгч бусад объектод харьцуулбал үнэрийн мөрийг хүлээн авагч объект нь хүрээлэн буй орчны тодорхой нөхцөлд мөрөө тасралтгүй үргэлжлүүлэн үүсгээдэг байдаг. Иймээс үнэрийн мөрийг илрүүлэх нь түүнийг үүсгэгч объектын үнэрт бодисын хэмжээ, мөр хүлээн авагчид үлдсэн үнэрийн концентраци, хүрээлэн буй орчны нөхцлөөс хамаарна.

-мөрний бутэц, дотоод нэдрлэгийн хөдөлгөөнт шинж. Үнэрийн молекулууд хоорондоо холбоогүй, хүрээлэн буй орчны агаар болон өөр хоорондоо байнга холигдон шингэж байдаг. Агаар дахь үнэрийн мөрийн концентраци нь мөр хүлээн аваад зөөвөрлөгч объект болж хувирсан үүсгэгчийн орчимд илүү өтгөн байдаг тул үүнтэй уялдан мөрийг чухам тэндээ тусгаарлан авах шаардлагатай. Хязгаарлагмал, вакум орчимд үнэрийн мөр концентрацийн хувьд хаанаа ч адилхан, жигд найрлагатай байдаг.

-мөрний сарнимтгай шинж. Үнэрийн мөр нь битүү сав болон задгай агаарт сарних, эсвэл бөөгнөрөх шинжийг агуулдаг. Иймээс найрлага нь өөрчлөгдөж өтгөрөх буюу шингэрч байдаг байна. Үнэрийн мөрний хөдөлгөөнийг хурд, чиглэл нь агаарын урсгалас хамаарна. Иймээс үнэрийн мөрийн найрлага нь мөр үүсгэгчийн орчимд ямагт өтгөн байна.

-хуваагадмалтгай шинж. Үнэрийн мөрийг хэсэг бүр нь адил чанарын үзүүлэлттэй хэд хэдэн хэсэгт хувааж болно. Энэ нь үнэрийн нэг эр сурвалжаас нэгэн зэрэг буюу хэсэг хугацааны дараа хэд хэдийг хувиалан авах боломжтой гэсэн үг бөгөөд тэдгээрт агуулагдах үнэрийн моддээлэл нь адилхан байдаг. Иймээс үнэр үүсгэгчийг шууд тусгаарлан авах боломжгүй бол дараа дараагийн шинжилгээнд зориулан хэд хэдэн хувийг түүнээс авч болно. Санд авч битүүмжлэсэн

¹⁷ Бат-Эрдэнэ Б. Криминалистик. УБ, 2003 он. 42 дөх тал

¹⁸ Жаралсалхайн Б. Криминалистикийн техник. УБ, 1998 он. 49 дөх тал

¹⁹ Olfactus—үнэр эзсэн латин үгнээс гаралтай

²⁰ Кинос— нохой эзсэн Грек үгнээс гаралтай

²¹ <http://www.pinktentacle.com/2006/03/chinas-body-odor-databank-sniffs-out-crime/>

үзэрийн мөрийг ч ийм маягаар, адил найрлагатай хэд хэдэн хувь болгон олшруулж болно. Битүүмжилсэн үнэр нь харьцангуй тогтвортой шинжийг агуулж удаан хугацаагаар өөрчлөгддөггүй. Шаардлагатай үед битүүмжилсэн үнэрийг зөөвөрлөж болно. Санд буюу шинжилгээнд ирүүлэхээр сэжигтэн этгээд, хохиоргчдын хувцас, алчуур зэргийг битүүмжлэн ирүүлж бас болно.

Нийслэлийн цагдаагийн газрын Эрэлч нохойн албаны Үнэрийн лабораторит үнэрийн дээрхи шинжид туршилт хийгдэж эхлээд байна.

Хүний организмн гаралтай эдгээр экспертизийг Шүүхийн шинжилгээний үндэсний төв хийх бүрэн чадалтай байх ёстой.

Амьтны болон ургамлын гаралтай цус, ус, ялгадас, шавьж, үр тариа, шороонцор, ургамлын зүйл материаллаг объектуудад криминалистикийн биологийн экспертиз хийгддэг. Энэ чиглэлд амьтан судлалын, ургамал судлалын гэсэн хоёр төрлийн экспертиз хийх бөгөөд экспертизийн зүйл нь амьтны болон ургамлын гаралтай объектын бүлгийн харьяаллыг биологийн ангиллын дагуу гарал үүсэл, төрөл хэлбэрээр нь болон амьдралын /ургасан/ нөхцлийн тогтоох явдал юм. Түүнээс гадна биологийн экспертизийн хүрээнд ургамал, амьтны биологийн шинжээр нь адилтгал хийгддэг.

Ургамал, амьтны тусгал мөрөөр хийх экспертиз нь криминалистикийн экспертүүдийн тусгай мэдлэгийн хүрээнд ордог хэдий ч биологийн экспертизтэй хамтарсан экспертиз хийгдэж бас болно.

Энэ төрлийн объектуудад одорологийн, ялангуяа, ольфакторик одорологийн экспертиз хийх боломжтой.

Ургамал, амьтны гаралтай бодисын зүйл нь боловсрогдож, хэлбэрээ өөрчлөн хувирсан хэлбэрээ тохиолдох ба байгаа хэлбэрээрээ /ноосон давауу, ясны цавуу, ургамлын ширхэглэг материал, давирхай зэрэг/ материал, хийц, бодисын зүйлийн экспертизийн объект болдог. Энэ төрлийн экспертиз Шүүхийн шинжилгээний үндэсний төвд одоогоор хийгдэхгүй байна.

Бүтээгдэхүүний стандарт хэм хэмжээг зөв мөрдсөн эсэх, үйлдвэрлэсэн техникийн нөхцөл,

хадгалалтын горим, үйлдвэрлэгчийг тогтоох зэрэг асуудлын хүрээнд криминалистикийн бараа судлалын экспертиз хийгддэг. Энэ экспертизийг хүнсний болон хүнсний бус бараа гэсэн хоёр төрөлд хийнэ. Зүй нь Шүүхийн шинжилгээний үндэсний төвийн бүтцэд байх шаардлагатай ч манайд огт хийгдэхгүй байгаа экспертизийн төрөл энэ.

Иймээс дээрх төрлийн экспертизийг экспертизийн бус байгууллагаар хийлгэхээс өөр сонголт байхгүй ба ингэхдээ тухайн байгууллагын мэргэжлийн чиглэл, экспертийн эзэмшсэн тусгай мэдлэгийн хүрээнд анхаарлаа хандуулах нь зүйтэй.

Энэ нь материал, хийц, бодисын зүйлд хийх криминалистикийн экспертизэд ч хамаарах ба сүүлийн үед энэ чиглэлд хийгдэж буй экспертизийн цаашдын хандлага нь нэг төрлийн салбар шинжлэх ухааны явцуу мэдлэгийн хүрээнд биш, шинжлэх ухааны үндэслэл нь өөр өөр олон аргыг нэгтгэсэн хамтарсан экспертизэд нэгдэх төлөвтэй байна.

Экспертэд тавигдсан асуудлыг шийдвэрлэхэд өөр өөр төрлийн тусгай мэдлэг эзэмшсэн экспертүүдийг ерөнхий синтээээр шинжилгээнийхээ үр дүнд хамтарсан ерөнхий дүгнэлт гаргуулахаар хамтарсан экспертизийг хийлгэх бөгөөд эксперт тус бүр өөрийн гаргасан дүгнэлтийг хариуцаад зогсохгүй хамтарсан дүгнэлтийнхээ ч хариуцлагыг хүлээ тул дүгнэлтийн үндэс болдог синтэзийн хэсэг нь хамтарсан экспертизийн заавал хийгдэх үе нь болдог. Экспертийн эзэмшсэн тусгай мэдлэгийн хүрээ нь хамтарсан экспертизийн синтэ дүгнэлтэд оролцох боломжгүй бол тэрээр энэ экспертизэд оролцохоос татгалзана. Учир нь энэ экспертизээр гарах ерөнхий дүгнэлтийн хариуцлагыг түүнд оролцсон бүх эксперт хүлээдэг. Энэ тохиолдолд болон экспертизийн үр дүнд хүрсэн дүгнэлт зөрүүтэй байгаа тохиолдолд эксперт өөрийн эзэмшсэн тусгай мэдлэгийн хүрээнд, тусдаа дүгнэлт гаргах үүрэгтэй.

Орчин үеийн шинжлэх ухааны хөгжлийн чиг хандлага нь тус тусдаа битүүлэг олон салбарын аргачлалууд нэгдэн хамтдаа ашиглагдах чигтэй

байгааг дээр хэлсэн бөгөөд энэ нь криминалистикийн экспертизийн тухайд ч мөн адил. Материал, хийц, бодисын зүйлд хийх хамтарсан экспертизийн тухайд бусад хамтарсан экспертизийг бодвол илүү давуу, өвөрмөц талтай. Учир нь ийм төрлийн экспертизийн үед бие биенийхээ дутууг дүүргэсэн шинжлэх ухааны өөр өөр аргыг ашигладаг. Нэг адил объектод тус тусдаа экспертиз хийх нь экспертүүд ердөө л гаваар төдий бодлоор хязгаарлагдаж, нэгдмэл дүгнэлтэд шаардлагатай хувийн онцлог шинжүүдийн нийлбэр дүнг гаргаж чаддаггүй болохыг практик харуулсан. Шинжлэгдэж буй объектын хувийн онцлог шинжүүдийн нийлбэр дүнг гаргах боломжгүй тул экспертүүд эсрэг дүгнэлтэд хүрч байсан жишээ ч байдаг²². Энэ нь хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтыг хүндрэлд оруулж экспертизийг давтан хийлгэхэд хүргэдэг. Харин хамтарсан экспертизийн үед бол төрөл бүрийн шинжлэх ухааны аргаар тогтоосон судалгааны баримтад нэгдсэн синтэз хийснээр экспертэд тавигдсан асуулыг шийдвэрлэх бүрэн дүгнэлтэд хүрэх хангалттай үндэслэл гаргаж авах буюу эсвэл судалгааны дүнд гаргаж авсан өөр өөр төрлийн мэдлэгийг хамгийн ихээр ашиглах боломжоор хангагддаг.

Материал, хийц, бодисын зүйлд хийх криминалистикийн экспертизийг судалгаанд шаардлагатай шинжлэх ухааны мэдлэгийн салбараар нь нэг төрлийн шинжлэх ухааны болон хэд хэдэн төрлийн шинжлэх ухааны хамтарсан экспертиз гэж ангилж болно.

Нэг төрлийн шинжлэх ухааны хамтарсан экспертизийг нэг шинжлэх ухааны тусгай мэдлэгийн хүрээнд, өөр өөр чиглэлд бэлтгэгдсэн экспертүүд хамтарсан аргаар хийнэ. Жишээлбэл, Экспертэд "И-гийн цамцан дээр үүссэн урагдалт нь хэргийн газраас ирүүлсэн хутгаар үүссэн эсэх?" гэсэн асуулт тавигдаж, Экспертиз хийсэн мөр судлалын эксперт уг урагдалт мөн хутгаар үүссэн байж болох гэсэн дүгнэлт гаргажээ (даавуучны материал нь сунадаг, уян эдлэл байсан тул шууд дүгнэлт өгөх боломж байсангүй). Харин материал, хийцийн чиглэлд бэлтгэгдсэн эксперт хутганы ирэн дээрээс хоёр ширхэг бичиг утаслаг ширхэглэг зүйлийн ирүүлэлт


²² Колдин В. Я и др. Экспертная криминалистическая идентификация. Вып. 1. Теоретич. основы. М., 1996. с.24

түүний бүтэц, өнгө зэрэг нь экспертизад ирүүлсэн цамцных мөн болохыг тогтоосон байна. Даавууны зүсэгдсэн урагдалт, урэнхайн хэмжээ, урагдалт орчмын будагдсан өнгө, хутгамы ирний хэмжээ, ирэн дээр илэрсэн бичил утас, түүний харьяалал, бичил утасны тохиолдох магадлалын тоон үзүүлэлт, онцлог шинж давхцаж байгаа зэрэг комплекс аргыг хэрэглэсний үр дүнд экспертизад ирүүлсэн цамцны урагдалт

мөн хутгаар үүссэн болохыг тогтоож өгчээ²³.

Хэд хэдэн төрлийн шинжлэх ухааны хамтарсан экспертизийн явцад өөр өөр төрлийн мэргэжилтэй экспертүүд тус бүрийн шинжлэх ухааны тусгай мэдлэгийг нэгтгэн тавигдсан асуудлыг шийддэг. Экспертизийг төвлөрсөн нэг буюу өөр өөр байгууллагаар хийлгэж болох бөгөөд тухайн байдлаас

Хамгааран эксперт хийлгэх тухай тогтоолоо гаргана. Тогтоолд тухайн мэргэжлийн хүрээг тодорхойлж өгөх ба анагаах ухааны криминалистика-криминаликтикийн, криминалистика-автотехникийн, криминалистика-бараа судлалын, криминалистика-тэсрэх бодисын гэх мэтчилэн тодорхойлж өгнө.



²³ Вандер М. Б. Криминалистическая экспертиза материалов, вещеста и изделий. Санкт-Петербург., 2001. с.20

ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖИЛД ИРГЭДИЙГ ТАТАН ОРОЛЦУУЛАХ ЗАРИМ АСУУДАЛ

Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үргийг иргэнийхээ өмнө хариуцна¹ гэж заажээ.

Төр, засгийн бодлого шийдвэрийн нэг чухал бүрэлдэхүүн хэсэг бол ард иргэдийнхээ амгалан тайван аж төрөх нөхцөл бололцоог хангах, гэмт хэргэ зөрчилтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах явдал билээ.

Өнөөдөр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил зөвхөн төр засаг, хууль яналтын байгууллагын үүрэг төдий бус төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн үрэг, бүх нийтийн үйлс болон чухлаар тавигдаж байна.

Монгол Улсын Засгийн газраас:

1. Хүн ялангуяа хүүхэд эмэгтэдийг бэлгийн мөлчлөгийн зорилгоор ашиглахаас хамгаалах үндэсний хөтөлбөр 2006-2014 он, 2005 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн Засгийн газрын 234 тоот тогтоол,

2. Архидан согтуурахаас сэргийлэх, хяналт тавих үндэсний хөтөлбөр 2003 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн УИХ-ын 46 тоот тогтоол,

3. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр,

4. Малын хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үндэсний хөтөлбөр,

5. Хар тамхи, мансуурах, донтох эмгэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх үндэсний хөтөлбөр,

6. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үндэсний хөтөлбөр,

7. Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр,

8. Нийслэлийн хэмжээнд



Нийслэлийн цагдаагийн газрын Олон нийтийн харилцааны хэлтсийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тасгийн ахлах байцаагч, цагдаагийн хошууч, магистрант
Л.ЦЭРЭНЖАМ

нийгмийн дэг журмыг бэхжүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх 2005-2008 онд хэрэгжүүлэх хөтөлбөр,

9. Цахим цагдаа дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна. Энэ нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд чухал нөлөөтэй арга хэмжээ болж байна.

Цагдаагийн байгууллага нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг хэрэгжүүлэхдээ Үндсэн хууль, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Цагдаагийн байгууллагын тухай хууль, Цагдаагийн байгууллагын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын заавар, холбогдох бусад хууль тогтоомжийг мөрдөж, хууль дээдлэх, хүний эрх, эрх чөлөө, нэр төрийг хүндэтгэх, олон нийтийн хүчинд түшиглэх, иргэдэд туслах, хамтарч ажиллах, цагдаагийн албад, алба хаагчийн оролцоо, нэгдмэл ажиллагааг хангах зарчимд тулгуурлан ажиллана.

Нийгмийн хөгжлийн явцтай ялдан цагдаагийн байгууллага нь гэмт хэргэ зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журам хамгаалах үүрэгэ байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийнхээ дэмжлэг туслацгаанд тулгуурлан хэрэгжүүлэх бодлого чиглэл барьж, гадаад орнуудын цагдаагийн байгууллагын ажлын арга туршлагыг судлан, үйл ажиллагаандаа хэрэгжүүлж байна.

Ер нь гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажиллагааны уламжлалыг авч үзвэл тодорхой цаг үед онцлог үйл ажиллагаанд хамаарагдаж байсан юм.

1939 оноос нийслэл хотод нийгмийн хэв журам сахиулах үйл ажиллагааг эрчимжүүлж, нийгмийн дэг журам тогтооходоо иргэд олон нийтийн хүчийг өргөн ашиглаж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хэв журын зөрчлөөс хамгаалахад Цагдан сэргийлэх байгууллагаас хууль сурталчлах ажлыг өргөжүүлж байжээ.²

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэдийг татан оролцуулах ажиллагааны хэлбэр янз бүр байсан бөгөөд тэр нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг дээшлүүлэхэд чухал нөлөө үзүүлдэг байсан байна.

Заримаас нь дурдвал:

Цагдан сэргийлэх газар нь ард иргэдийг нийгмийн дэг журам тогтооход ажилд татан оруулах зорилгоор 1939 онд клуб байгуулж, сайн дурын уран сайханчидтай болсноор өөрийн уран сайхны тоглолтоор олон түмний өөртөө татаж, урлагийн тоглолт, шог нэвтрүүлэг бүхий програмаар төвийн радио нэвтрүүлэг долоо хоног бүр хийдэг болсон зэргээс клубын сайн дурын уран сайханчдын тоо өсч, 1940 оны үед клубын нэр төр дээшилж, 1941 онд Цагдан сэргийлэхэд туслах бригад буй болоход сайн дурын

¹ Монгол Улсын Үндсэн хууль 2 дугаар бүлэг 19 дүгээр зүйлийн 1 дүгээр заалт

² Думбурай А. Монгол төрийн цагдаагийн уламжлал, түүхэн хөгжил, 1999 он, 1 дэвтэр, 130 дахь тал

уран сайханчид цагдан сэргийлэхэд туслах бригадын гишүүд болж, нийгмийн хэв журам сахиулах ажлыг биечлэн хийх болсон түүхтэй.

1970-1980 онд Цагдан сэргийлэх байгууллагад туслах хүчин нь энгээндээ 40 гаруй мянган гишүүнтэй 15000 гаруй отряд ажиллаж жилд дунджаар 1102355 хүн цагийн эргүүл хийж 300 орчим эрүүгийн гэмт хэргээ, 15000 гаруй зөрчил илрүүлж, 12000 хүн даан авч, хүмүүжүүлж байжээ.³

Төрөөс "Хуулиар тогтоосон хэв журмыг сахин хамгаалахын хувьд иргэд бүр өөрийгөө нэг ёсондоо ардын цагдаа гэж үздэг байх ёстой" гэсэн үзэл баримтлал дэвшүүлж байсан нь иргэдийн идэвхи санаачилга, үүргийг дээшлүүлэхэд нөлөөлж байсан юм.

1990-ээд оноос эрх зүйн шинэтгэл хийгдэж Цагдаагийн байгууллага тухайн үед төрийн захиргааны төв байгууллага байж, шинэ бүтэц, зохион байгуулалт, зорилго чиглэл, үйл ажиллагааны арга тактик буй болж, цагдаагийн хэрэгтээ шаардлага өндөржсөн юм. Тухайн үед цагдаагийн байгууллагыг бэхжүүлэх талаар ч багагүй арга хэмжээ авч иржээ. Хэдийгээр шинэчлэлтийн цочирдол үүсч, эмх замбараагүй байдал газар авч байсан ч шинэ Үндсэн хуулийн хэрэгжилтээс эхлэн иргэд эмх замбараагүй, дэг журам, сахилга батгүй байдлыг тэвчишгүй болж, нийгмийн шинэчлэлтийн явцад сөрөг нөлөө үзүүлэх /гэмт хэргэ зөрчил ихэссэн гэх мэт /үзэгдлүүдийг багасгахын тулд гэмт хэргэ зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд онцгой анхаарч эхэлсэн байна.

1997 онд Монгол Улсын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль батлагдсанаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд бүх шатны төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн эрх, үүргийг тодорхойлон зааж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд байгууллага, иргэдийг татан оролцуулах гол хэлбэр бол нийгмийн хэв журам хамгаалах олон нийтийн байцаагч,

урамшилт болон нийтийн эргүүл, жижүүр ажиллуулахаар эрх зүйн орчныг нь хуульчилж өгсөн нь одоо мөрдөгдөн хэрэгжиж байна.⁴

Цагдаагийн ерөнхий газраас дэвшүүлсэн "Нийгмийн хэв журам хамгаалах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэдийн оролцоог нэмэгдүүлэн, тэдний амгалан тайван байдлыг хангахад ахиц гаргах",⁵ "Гэмт хэргэ, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын үр дүнг дээшлүүлэх" зорилтыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан, гэмт хэрэгтэй тэмцэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд, /Манай улсын хүн амын тал хувь нь суурьшсан нийслэл хотын хэмжээнд хийсэн судалгаа дүгнэлтэд тулгуурлав./ хүн ам ихээр төвлөрсөн нийслэл хотын эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдал хүндэрч байгаа өнөө үед ард иргэдийн амгалан тайван амьдрах нөхцөл бололцоог бүрдүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд оролцож байгаа олон нийтийн байцаагч, урамшилт эргүүл, жижүүрүүдийн өмнө тулгарч байгаа бэрхшээлийг сөнсөх, тэдний ажлыг дэмжих, мэргэжлийн удирдлагаар хангахад чухам ямар ажил шаардлагатай байгааг хамтран санал солилцож, нэгдсэн ойлголтод хүрч, тодорхой асуудлуудыг шийдвэрлэх зорилгоор Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Нийслэлийн цагдаагийн газар, Монголын сууц өмчлөгчдийн холбооны дээд зөвлөл хамтран "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд цагдаагийн байгууллага, олон нийтийн байцаагч, урамшилт эргүүл, жижүүрүүдийн хамтын ажиллагааг сайжруулахад анхаарах зарим асуудал" нэгдсэн зөвлөгөөн зохион байгуулсан нь ач холбогдолтой болсон юм.

Нийгмийн дэг журмыг хангах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд идэвхи зүтгэл санаачилгатай оролцож ирсэн зарим байгууллага, иргэнийг шанаж урамшуулсан юм. Жишээлбэл, Баянзүрх дүүргийн 18 дугаар хороо "Мандах-2" СӨХ-ны гүйцэтгэх захирал Ц.Цэрэнбадам /Хариуцсан

байруудынхаа орцны жижүүрийг сайн удирдан зохион байгуулж, хэсгийн байцаагч, цагдаатайгаа нягт холбоотой ажиллаж, иргэдээс гомдол саналгүй, хариуцсан байр, оронд нь гэмт хэргэ, зөрчил гараагүй/, Хан-Уул дүүргийн 12 дугаар хорооны Нийгмийн хэв журам хамгаалах олон нийтийн байцаагч П.Даваа /Удаа дараа мал хулгайлах гэмт хэргийг илрүүлсэн/, Сонгинохайрхан дүүргийн 3 дугаар хорооны урамшилт эргүүл П.Явуухүү /Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэнийг үүргийг сайн биелүүлж, урамшилт эргүүлээр тогтвортой ажиллаж байгаа/ нарыг Нийслэлийн цагдаагийн газрын өргөмжлөл үнэ бүхий зүйлээр тус тус шагнаж урамшуулсан юм.

Нийслэлийн хэмжээнд байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд татан оролцуулах зорилгоор мэдээлэл, сурталчилгааг өргөжүүлж ажилласнаар Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийг сурталчлах өдөрлөг, уулзалт, уралдаан тэмцээн 88, сургалт 140 удаа тус тус зохиож, хийсэн ажил болон урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг, мэдээлэл телевизээр 453, төвийн болон FM радиогоор 233, хэвлэлээр 151 удаа өгч ажилласан нь урьдчилан сэргийлэх ажилд иргэд, байгууллагыг татан оролцуулах, тэдний идэвхи санаачилгыг өргүүлэхэд зохих үр нөлөө үзүүлж байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд хэвлэл мэдээллийн болон аж ахуйн нэгж, байгууллага, олон нийтийн байцаагчийн оролцоог нэмэгдүүлэх, нийгмийн дэг журмыг бэхжүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх, аридан согуурах явдлыг бууруулах чиглэлээр болзолт уралдааныг Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлөөс 2007 оны 3 дугаар сарын 15-ны өдөр хэртээ 10 дугаар сарын 10-ны өдөр хүртэл зохиосон нь үр дүнтэй ажил болов.

2007 оны эхний 10 сарын байдлаар нийслэлийн хэмжээнд нийгмийн хэв журам хамгаалах олон

³ Мөн тэнд, 122 дахь тал

⁴ Мөн тэнд, 124 дэх тал

⁵ Монгол Улсын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 12 дугаар зүйл

⁶ Цагдаагийн ерөнхий газар, Мэдээлэл, сургалт, арга зүйн Цагдаа сэтгүүл 2006, №1

нийтийн байцаагч 128, урамшилт эргүүл 571, жижүүр 1531 ажиллаж, хэсгийн байцаагчдын зүгээс тэдний мэргэжлийн удирдлагаар ханган 281 удаа хамтарсан арга хэмжээ зохион байгуулав.

Мөн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх асуудлаар нийслэл, дүүргийн төр захиргааны байгууллагад 231 санал оруулж шийдвэрлүүлсэнээс гадна Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хуулийн биелэлтийг давхардсан тоогоор 19804 байгууллага, аж ахуйн нэгжийг хамруулан шалгаж, гэмт хэргийн шалтгаан нөхцлийг арилгуулахаар 10855 албан мэдэгдэл өгч дутагдлыг засуулан 8701-д нь хариу авч, нийтийн эргүүлд давхардсан тоогоор 8875 аж ахуйн нэгж, байгууллагыг ажиллуулсныг урд оны мөн үетэй харьцуулахад 12,8 хувиар, 140900 иргэдийг нийтийн эргүүлд ажиллуулсан нь 25,7 хувиар тус тус өссөн нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд оролцох иргэдийн оролцоо нэмэгдэж байна.⁷

Баянзүрх, Багахангай дүүрэгт Засаг даргын захирамжаар дүүргийнхээ нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлдэг байгууллага, аж ахуйн нэгжийг хуваарьт оруулан "Машинт эргүүл", Баянгол, Сүхбаатар, Чингэлтэй дүүргүүд тогтмол тодорхой графикайн дагуу "Оюутны эргүүл", Сүхбаатар, Баянгол дүүргийн Цагдаагийн хэлтэс өөрийн дүүргийн нутаг дэвсгэрт оршин суудаг цагдаагийн байгууллагаас чөлөөнд гарсан ахмадуудыг оролцуулан "Ахмадын эргүүл", гэрэлтүүлэг муутай харахуй орчинд, ялангуяа гэр хороололд иргэдийн нийтийн эргүүдийг хэсгийн ахлагч, ахмадууд, оршин суугчдын оролцоо дэмжлэгтэйгээр зохион байгуулж, тогтмол ажиллуулсны үр дүнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн оролцоо нэмэгдсээр байна.

Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх урьдчилан сэргийлэх чиглэлээр Хан-Уул дүүргийн 12

дугаар хорооны нутаг дэвсгэрт мал бүхий иргэдийн үүсгэл санаачилгаар 2005 онд байгуулагдсан "Малчин холбоо" нь төрийн бус байгууллага болоод байна. Мөн Багахангай дүүрэгт 2006 оны 3 дугаар сарын 25-нд анх өвөр хороонд "Малчин холбоо" байгуулагдан, "Морин эргүүл" өнөөдрийг хүртэл ажиллаж байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зохих үр дүнгээ өгөх нэг ажил бол урамшилт жижүүр ажиллуулах явдал бөгөөд өнөөдөр нийслэлийн хэмжээнд 350 СӨХ, 1531 орчны жижүүртэй гэрээ байгуулан ажиллаж байна.

2007 оны эхний 10 сард улсын хэмжээнд гэр, орон сууцанд үйлдэгдсэн хэрэг 10,4 хувиар буурсан байна.⁸

Дээрх арга хэмжээг үргэлжлүүлэн орон сууц, байр, оронд гэмт хэрэг үйлдүүлэхгүй байх асуудлыг нэлээд анхаарч байна.

Орчны жижүүр нь иргэд, оршин суугчдыг аюулгүй, амар тайван амьдрах нөхцлийг бүрдүүлэхэд онцгой үүрэгтэйгээс гадна гэмт хэрэг, ялангуяа орон байрны хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд нөлөө үзүүлэх үүрэгтэй. 2006 оны эхний 10 сарын байдлаар оронд 150 гэмт хэрэг үйлдэгдсэнийг урд оны мөн үетэй харьцуулахад 9 нэгжээр буюу 5,6 хувиар буурсан. 2007 оны эхний 10 сард оронд 94 гэмт хэрэг үйлдэгдсэнийг урд оны мөн үетэй харьцуулахад 56 нэгжээр буюу 37,3 хувиар буурсан нь орчны жижүүр ажиллуулсны үр дүн харагдаж байгаа болно.⁹

Гэхдээ нийслэлийн хэмжээнд ажиллаж буй нийт орчны жижүүрийн 70 орчим хувь нь хөдөө орон нутгаас ирсэн бичиг баримтгүй, орон гэргүй иргэд байдаг.

Сууц өмчлөгчдийн холбоод жижүүрүүдийг сонгож судлах, тэдний ажлын хариуцлага, сахилгад тавих хяналт сул байснаас орчны жижүүрүүд өөрсдөө гэмт хэрэг үйлдэх явдал 2006 онд цөөнгүй гарсан. Тухайлбал:

- 2006 оны 3 дугаар сарын 22-ны өдөр Баянзүрх дүүргийн 16 дугаар хороо 70 дугаар байрны 3 дугаар орчны жижүүр 51 настай эрэгтэй Монголын Ганбат бусдын бие махбодид хүндэвтэр гэмтэл учруулсан.

- 2006 оны 1 дүгээр сарын 24-ний өдөр Баянгол дүүргийн 12 дугаар хороо 15 дугаар байрны 1 дүгээр орчны жижүүр 40 настай эмэгтэй Жамсрангийн Энхтуяа бусдын эд зүйлийг хулгайлсан.

- 2005 оны 12 дугаар сарын 12-ны өдөр Чингэлтэй дүүргийн 12 дугаар хороо Булгийн задгайн 1024 тоотод оршин суудаг /орчны жижүүр хийж байсан/ гэмт хэрэг үйлдэж олсон эд хөрөнгө гэдгийг мэдсээр байж борлуулсан¹⁰ гэх мэт.

2007 онд орчны жижүүрүүдээс гэмт хэрэгт холбогдсон хүн байхгүй болно.

Нийслэлийн зургаан дүүргийн 500 иргэнээс тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа Сууц өмчлөгчдийн холбоод, Сууц өмчлөгчдийн хамтын үйл ажиллагааны талаар болон орчны жижүүрүүдийн үүрэг хариуцлагын талаар иргэдийн санал бодлыг судлах, тэднээс бодит боддг өгсөн үнэлэлтийг авах, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээнд шаардлагатай мэдээллийг бүрдүүлэх зорилгоор 25 асуулгатай санал асуулга явуулж, тандалт ярилцлага хийж дүгнэхэд орчны сууцны байшингуудад орчны байнгын жижүүр ажиллуулснаар орон байрны хулгай буурахад нөлөөлдөж чадаж байна уу? гэсэн асуулгад 60,4 хувь нь орчны байнгын жижүүрийг ажиллуулах нь зүйтэй, орон байрны хулгай буурахад нөлөөлдөж чадаж байна, 65,6 хувь нь ажил үүрэг нь чанартай хариуцлагатай байх нөхцөлд ажиллуулж болно гэж хариуцжээ. Орчны цэвэрлэгээ гэрэлтүүлгийн талаар асуухад 34,4 хувь нь цэвэрхэн гэрэл гэгээтэй, 40 хувь нь цэвэрлэгээ тааруу, гэрэл гэгээтэй, 25,6 хувь нь бохир харанхуй байдаг гэж хариуцжээ.¹¹ Мөн Монгол Улсын Гэмт хэргээс

⁷ Нийслэлийн цагдаагийн газрын Олон нийтийн харилцааны хэлтэсэн нэгдсэн мэдээ /2007 оны эхний 10 сар/

⁸ Улсын хэмжээнд 2007 оны эхний 10 сард бүртгэгдсэн гэмт хэргийн статистик мэдээ

⁹ Нийслэлийн хэмжээнд 2005, 2006, 2007 онд оронд үйлдэгдсэн гэмт хэргийн статистик мэдээ

¹⁰ 2006 онд орчны жижүүрээс үйлдсэн гэмт хэргийн судалгаа

¹¹ 2007 оны 05 дугаар сарын 20-ны өдрөөс 31-ний өдрүүдэд хийсэн санал асуулгын дүн

урьдчилан сэргийлэх тухай хууль болон бусад хууль тогтоомжийг сурталчлах, иргэдийн хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг татан оролцуулах, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг иргэдэд ойртуулах зорилгоор "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил-бүх нийтийн үйлс" өдөрлөгийн үеэр 600 гаруй иргэний дунд санал асуулга явуулж дүгнэсэн.¹² Цаашид санал асуулгыг олон чиглэл, оновчтой хэлбэрээр тодорхой асуудлуудаар тасралтгүй явуулж, иргэдийн санал бодлыг сонсож, нэгтгэн дүгнэж ажиллах нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэд олон нийтийг татан оролцуулж бүгд нэг хэлбэр төдийгүй цагдаа олон нийтийн хамтын ажиллагаа өргөжиж болно.

Өнөөдөр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын чухал хөшүүрэг болсон нийгмийн хэв журам хамгаалах олон нийтийн байцаагчдыг ажиллуулах явдал хэвшэмэл нэг загвар орж, үр дүн гарахгүй байна. Тухайлбал:

-Бодит байдал дээр олон нийтийн байцаагчдыг хороодын Засаг дарга нар судалж өдөр тутмын удирдлагаар хангаж, тэднийг нийгмийн хэв журам хамгаалах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд бус төрийн захиргааны ажилд түлхүү татан оролцуулах явдал нийтлэг байна.

-Олон нийтийн байцаагчид нь хэсгийн байцаагчдын хувьд шадар туслах, хамтран ажиллагч байж өдөр тутмын мэргэжлийн удирдлагаар хангагдан, мэдээллээр хангадаг, ялангуяа урамшилт болон нийтийн эргүүл, жижүүрийг зохион байгуулж, хяналт тавин, удирдаж ажиллуулдаг байх ёстой. Гэтэл ихэнх хороонд энэ үйл ажиллагаа хэрэгжихгүй байна

-Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуульд олон нийтийн байцаагчдын урамшууллыг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас олгохоор заасан боловч уг хуулийн хэрэгжилт муу, урамшууллын тасалдуулах, улирал,

хагас жилээр бөөн олгох, нөхөн олгохгүй хохироох явдал ч үрд олд гарч байсан. Энэ нь тэдний ажилдаа урам, идэвхи санаачилгад муугаар нөлөөлж байна.

Иймд тэдний урамшлын асуудлыг шийдвэрлэх, эрх зүйн ажлын бүрдүүлэхтэй холбогдсон судалгаа гарган, танилцуулга бичиж, Цагдаагийн ерөнхий газар, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Хууль зүй, дотоод хэргийн яаманд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай Монгол Улсын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санал хүргүүлсэн юм.

Уг төсөлд дараах байдлаар тусгагдан болно.

Тухайлбал, "Хэв журын урамшилт эргүүл, жижүүр болон нийгмийн хэв журам хамгаалах олон нийтийн байцаагчаар ажиллуулах хүний тоо, урамшууллын хэмжээг иргэдийн Төлөөлөгчдийн хурал жил тутам тогтооно"¹³ гэснийг хуулийн 12 дугаар зүйлд "Иргэдийг нийтийн эргүүлд гаргах, хэв журын урамшилттай эргүүл, жижүүр болон нийгмийн хэв журам хамгаалах олон нийтийн байцаагчаар ажиллуулах журам болон тэдгээрийн урамшлын хэмжээг Засгийн газар тогтоож байхаар шинэчлэгдсэн. Олон нийтийн байцаагчийг таних тэмдэг, үнэмлэхтэй болгохоор тусгасан. Ингэснээр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажиллагаанд оролцох иргэдийн оролцоо улам нэмэгдэнэ гэж үзэж байна. Олон нийтийн байцаагч, урамшилт эргүүл, жижүүрийн үйл ажиллагааны эрх зүйн орчин сайжирна.

16 дугаар зүйлд урамшилт эргүүл, жижүүр, олон нийтийн байцаагчийг цагдаагийн байгууллагын өдөр тутмын шууд удирдлагад ажиллуулж байхаар тусгасан. Ингэснээр цагдаа, иргэдийн хамтын ажлын уялдаа сайжрах боломж нээгдэнэ. Олон нийтийн байцаагч нар нийгмийн хэв журам хамгаалахад өдөр тутам цагдаагийн ажилтнуудтай хүч хамтран ажиллах боломж нэмэгдэнэ.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардал нь тухайн жилд

шүүхийн шийдвэр биелүүлэх, замын хөдөлгөөний болон хэв журын зөрчлийг арилгах чиглэлээр улсын орлого болсон, торхож ял болж төсөвт тушаасан мөнгөний 40 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг дараагийн жилийн орон нутгийн төсвөөс санхүүжүүлдэг¹⁴ юм. Энэхүү зардал нь аймаг, нийслэлийн хэмжээнд бүрэн тооцогдож төсөвлөгддөггүй, төсөвт тусгасан хөрөнгийг аймаг, нийслэлийн Санхүүгийн хэлтэс, Сангийн яаманд төсвийн төсөл хянах явцад үндэслэлгүйгээр хасах, батлагдсан хөрөнгийг Засаг дарга, түүний Тамгын газрын үзэмжээр тухай бүр бүрэн гаргахгүй байх зэрэг ноцтой зөрчил гарсаар байна. Улсын хэмжээний зохицуулах зөвлөл нь сүүлийн 10 жилд энэхүү зардлыг хуваарилах, хяналт тавих, зохицуулах ямар ч эрх мэдэлгүй явж ирсэн нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үр дүнд дээшлүүлэхэд сөргөөр нөлөөлж ирсэн. Иймд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг Хууль зүй, дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний төсвийн багцад төвлөрүүлэн батлуулж, Зөвлөлөөр хэлэрцүүлж, эрүүгийн болон хэв журын нөхцөл байдлыг нь харгалзан орон нутагт хуваарилан санхүүжүүлж, хяналт тавьдаг болохоор төсөлд тусгагдсан, Зөвлөлөөс хуваарилсан хөрөнгийг зарцуулах асуудлыг аймаг, нийслэлийн салбар Зөвлөл өөрсдөө шийдвэрлэх, мөн аймаг, нийслэл, сум, дүүрэг нь өөрийн төсвөөс нэмэлт зардал гаргаж болохоор тус тус тусгагдсан байна.

Энэ мэтчилэнгээр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын нөлөөлөл, одоогийн төлөв байдлыг олон жишээ баримтаар дурдаж болох боловч хамгийн гол нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд ямар арга хөшүүргийг хэрэглээл зүйтэй вэ гэсэн асуудлыг доорх хэдэн зүйлээр илэрхийлж байна.

1. Өнөөдөр нийгмийн хэв журам хамгаалах олон нийтийн байцаагчдад олгож байгаа урамшууллын хэмжээ нэмэгдээд

¹² 2007 оны 6 дугаар сарын 28-ны өдөр Эрх чөлөөний талбайд зохион явуулсан өдөрлөгийн үеэр авсан санал асуулгын дүн

¹³ Монгол Улсын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3 дэх заалт

¹⁴ Монгол Улсын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх заалт

сар бүрийн 25.0 мянган төгрөгийг улирвэл нэг удаа бөөнд нь олгож /урамшилт эргүүлд албан ёсоор 3000 төгрөг олгодог гэх боловч зөвхөн Хан-Уул дүүрэгт л хэрэгжиж байна./ байна. Энэ нь өнөөгийн нөхцөлд тэдний гүйцэтгэсэн үйл ажиллагаа, ажиллах идэвхи санаачилгад нь хэрхэн нийцэж хөшүүрэг болох вэ гэдгийг бодолцох нь зүйтэй.

2. Эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдал хүндэрсэн хороо, хэсэгт олон нийтийн байцаагч, урамшилт эргүүлийн тоо, тэдний урамшууллыг нэмэгдүүлэх асуудлыг /олон нийтийн байцаагчийг орон тооны ажилтан болгож, урамшууллыг цалин болгох, ингэхдээ хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тогтоолгох/ холбогдох шатны байгууллагад танилцуулан шийдвэрлүүлэх, мөрдөгдөж буй хууль, дүрэм, журам, зааварт өөрчлөлт оруулах.

3. Монголын сууц өмчлөгчдийн холбоодын дээд зөвлөл, салбар зөвлөлүүд, Цагдаагийн хэлтэс хамтарч сууц өмчлөгчдийн холбоодын үйл ажиллагааг жигдрүүлж, орц, байрны жижүүрүүдийг шилж сонгох, тэдний хариуцлагыг сайжруулах, гудамж, талбайд хувийн утсаар /цагаан/ иргэдэд үйлчилдэг хүмүүсийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд татан оролцуулах.

4. Хэсгийн байцаагч, олон нийтийн байцаагчдын ажиллах нөхцлийг сайжруулж, телефон утас, богино долгионы станц, тусгай хэргэслээр хангаж цагдаагийн бичил хэсгүүдийг /кабон/ хороо, хэсгүүдэд шинээр буй болгож ажиллуулах.

5. Иргэдэд үйлчилдэг таксины жолооч нартай тодорхой гэрээ хийж, тэдэнд урамшил олгох замаар гэмт хэрэг, зөрчлийн талаар мэдээлэл авах ажиллагааг хэрэгжүүлэх.

6. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэдийн оролцоог өргөжүүлэх чиглэлээр санаачилга, үр бүтээлтэй ажиллаж байгаа /Иргэдийн хурал, Засаг дарга, цагдаагийн ажилтан, байгууллага, аж ахуйн нэгж, иргэд/ хүмүүс, байгууллагыг шагнаж урамшуулах.

7. Төр засгийн бодлогоор нийслэл хотыг камержуулах, гэрэлтүүлэх ажлыг өнөөгийн шаардлагад нийцүүлэн хийх.

Дээр дурдагдсан ажлыг оновчтой зөв зохион байгуулж бодитой хэрэгжүүлэх нөхцлийг бүрдүүлж өгөх нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын чанар, үр нөлөөг дээшлүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

Цагдаагийн байгууллагын хуулиар хүлээсэн нэг үүрэг нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил бөгөөд энэ ажлыг зохих ёсоор зохион байгуулж чадвал үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэх,

шалгаж шийдвэрлэхээс харьцангуй хямд өртөгтэй, үр дүнтэй байх болно.

Өнөөгийн практикт гэмт хэргийг үйлдэгдсэний дараа эзэн холбогдогчдыг илрүүлэхээр ихээхэн хүч хөдөлмөр, цаг хугацаа, хөрөнгө зарж байна. Энэ байдалд дүгнэлт хийж, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуульд тусгагдсан цагдаагийн байгууллагад хамаарах заалт бүрийг хэрэгжүүлэх талаар бодитой ажил зохиохын зэрэгцээ гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд нутгийн захиргаа, хууль сахиулах болон төрийн бус байгууллагууд, иргэд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх талаар санал, санаачилга гарган ажиллах хэрэгтэй байна.

Оросын нэрт эрдэмтэн академик В.Н. Кудряцевийн бичсэнээр

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил нь:

- Нийгэм, эдийн засгийн хүрээнд,
- Улс төр, эдийн засгийн хүрээнд,
- Ес суртахуун, соёлын хүрээнд,

- Олон улсын түвшингийн¹⁵ гэж хуваан үзэж байгаа нь урьдчилан сэргийлэх ажил ямар өргөн хүрээг хамарч байгааг харуулж байна



¹⁵ Организация деятельности органов внутренних дел по предупреждению преступлений, Москва, 2000.

МАНСУУРУУЛАГЧ ОЛСНЫ УРГАМЛЫН ХУУЛЬ БУС ХЭРЭГЛЭЭТЭЙ ХОЛБООТОЙ ЗАРИМ АСУУДАЛ

Өнөөдөр дэлхий нийтийн өмнө тулгамдаж буй асуудлуудын нэгд мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэг, мансууруулах бодисын хууль бус эргэлт, түүнээс нийгэм, эдийн засагт үзүүлж буй хор уршиг голлох байр суурийг эзлэх болоод байгаа.

Манай орны хувьд мансууруулах бодисын хууль бус хэрэглээгээр тогтсон уламжлал байхгүй хэдий ч хөрш зэргэлдээх орны иргэдийн тодорхой хүрээллээс уламжлал илэрч байхыг үгүйсгэхийн аргагүй. Тухайлбал, өнгөрсөн зууны үед хятад худалдаачдын мансууруулах бодистой холбоотой хэрэг, явдал гарч байсан нь түүхийн хуудаснаа тэмдэглэгдэн үлдсэн байна.

Социалист системийн үед хар тамхи, мансууруулах бодистой холбоотой аливаа асуудал нь хаалттай сэдвийн нэг байсан төдийгүй, энэ талаарх мэдээлэл туйлын хомс байжээ.

Глобалчлалын өнөө үед дэлхий улс орнуудын соёлын нөлөө манай оронд тусч үүнийг даган сөрөг үзэгдлүүд илт нэвтэрч байгаа нь нууц биш. Ялангуяа аливаа шинэ зүйлд соргоогоор хандаж залуучууд мансууруулах бодисын хууль бус эргэлтэнд орж хууль бусаар хадгалах, хэрэглэх газар зохион байгуулах заримдаа өөрсдийн гараар түүх, боловсруулал бэлтгэх зэрэг идэвхтэй үйлдлүүдийг хэрэгжүүлж эхэлсэн нь бүртгэгдсэн гэмт хэргийн тоон үзүүлэлт болон энэ төрлийн гэмт хэрэгтэй дагнан тэмцэж буй цагдаагийн байгууллагын дүн мэдээнд илэрлээ олж байна.

Монгол хүмүүс олноор гадаад улс орон руу чөлөөтэй аялах, суралцах, бизнес эрхлэх зэргээр явах, гадаадын иргэд Монгол Улсад аялан жуулчлах болсон нь мансууруулах бодисын хууль бус эргэлт тодорхой хэмжээгээр нөлөөлж байгаа цаашлаад хөрш зэргэлдээ хиллэх хоёр том гүрэн



"Их Засаг" их сургуулийн магистрант
С.ХАШ-ЭРДЭНЭ

маань энэхүү хууль бус эргэлт, хэрэглээний томоохон зах зээл болон тодорхойлогдож байгаатай шууд холбоотой гэж дүгнэж байна.

Монголын өнөөгийн нийгэмд хар тамхи, мансууруулах бодис хэрэглэх явдал өсөх хандлагатай хэмээн олон нийтийн дунд яригдаж байгаа боловч энэ талаар хийгдсэн тодорхой судалгаа, мэдээ баримт төрийн болон төрийн бус байгууллагын хүрээнд дутагдалтай бөгөөд энэ төрийн мэдээлэл нуугдмал байдлаар оршоор байна.

Төр бодлогоо тодорхойлж "Хар тамхи, мансууралтай тэмцэх үндэсний хөтөлбөр", "Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтэнд хяналт тавих" тухай Монгол Улсын хуулийг батлан гаргаж энэ төрлийн гэмт хор хөнөөлийг ард иргэдэд ойлгуулах, урхилан сэргийлэх асуудлаар зохицуулалтын арга хэмжээ авах урьдчилсан нөхцлийг бий болгож байгаа хэдий ч өнөөгийн нөхцөл байдлыг бүрэн мэдрэгдэхээр судалгаа, шинжилгээний тогтворжсон үйл ажиллагаа байхгүй, төрийн бодлого шийдвэр бодит байдлаар хэрэгжихгүй, цаасан дээр буудаг ажил болж байгааг судалгааны явцад мэдрэгдэж байна.

Иймээс энэ үзэгдэлд чиглэгдсэн эрдэм шинжилгээ, судалгааны ажил харьцангуй бага, судалгааны үйл ажиллагааны хүрээ хязгаарлагдмал, ашиглах материалууд гадаад хэлээр ихэвчлэн нийтлэгддэг, хууль зүйн ухааны чиглэлээр судалгаа явуулж буй судлаачдын сонирхлыг татахгүй байгаа нөхцөл байдлуудад үндэслэн мансууруулагч олсны ургамлын хууль бус хэрэглээтэй тэмцэх асуудалд өөрийн судалгааг чиглүүлж энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагаа, хүрээг өргөжүүлэх шаардлага байгааг тодорхойлж байна.

Мансууруулагч олсны ургамлын тодорхойлолт

Орчин үед дэлхий дахины хэмжээнд нууцаар үйлдвэрлэгдэн, тараагдаж, хэрэглэгдэж буй гол мансууруулагч бодис, бүтээгдэхүүн, тэдгээрийн түүхий эдийн талаар доорх байдлаар дурдъя.

Дэлхийн улс орнуудад төдийгүй Монгол Улсад хүрээгээ тэлж, нийгэм, гэр бүл, хувь хүний амьдралд асар их хор нөлөөтэй, олон сая хүний амьдралын хөгжил, хөдөлмөр, хүн-нийгмийн түстэй, дэвшлээс тусгаарлаж буй аюулт үзэгдэл бол мансууруулагч олсны ургамал, түүний хууль бус хэрэглээтэй холбоотой асуудал болж байна.

Дэвшилтэд хүмүүс, үндэстэн, улс орон бүрийн төр, засаг, Нэгдсэн үндэстний байгууллага, Дэлхийн хамтын нийгэмлэгийн үндсэн бодлого, үйл ажиллагаанд мансууруулагч ургамал болон мансууралтай тууштай тэмцэж, хүн төрөлхтөний ирээдүйг хамгаалах асуудал тулгуур зорилт болон тавигддаг. Энэхүү зорилтод Асуудал Монгол Улсын төрийн бодлогын хэмжээнд хуульчлагдсан хэдий ч баримт бичгийн хүрээгээр хязгаарлагдаад байна гэсэн үнэлэлтийг судлаачийн зүгээс гаргаж байгаа юм.

Энэхүү судалгааны ажилтай холбогдон хавсрагдаж буй үйл ажиллагаа, материалууд нь тодорхой хэмжээгээр нууцлалын хүрээгээр язгаарлагдах учиртай гэдэг дүгнэлтийг хийж байгаа. Учир нь судалгатай холбоотой мэдээлэл нь нэг талаас урьдчилан сэргийлэх ач холбогдолтой, нөгөө талаас энэ төрлийн гэмт үйлдэлд мэдээллийн чанартайгаар ашиглагдах боломжийг үгүйсгэхийн аргагүй.

Гэвч өнөөдрийн нээлттэй нийгмийн үед хор нөлөөллийг урьдчилан сэргийлэх чиглэлээр дэлгэн тавьж энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх шаардлага ямар түвшинд тавигдаж байгаа нөхцөл байдлыг хууль тогтоо болон хэрэгжүүлэгч байгуулага, түүний алба хаагчдад хүргүүлэх үүднээс доорх судалгааны материалуудтай холбогдох учиртай.

Дэлхийд хамгийн их хэмжээгээр бэлтгэгдэж, хамгийн өргөн хэрэглэгдэж байгаа мансуурлагч бол Олонсы ургамлын гаралтай мансууруулагч бүтээгдэхүүнүүд байна.

Олонсы мансууруулагч бүтээгдэхүүнүүд (ОМБ) нийт мансууруулагчийн 50 гаруй хувийг эзлэх бөгөөд 147 гаруй сая хүн хэрэглэдэг мэдээ байна.

Олонсы мансууруулагч бүтээгдэхүүнүүд хамгийн өргөн дэлгэрсэн, хэрэглээ нь залуу үеийнхний илүү хамаарсан байдгийн шалтгааныг өргөн хүрээгээр тодорхойлохд:

- Олонсы ургамал дэлхийн олон улс оронд өргөн тархсан ба түүхий эдийн нөөц арвинтай;

- Уг ургамлаас мансууруулагч бүтээгдэхүүн бэлтгэх технологи нь хялбар, олон тооны хувь хүн бэлтгэх боломжтой;

- Олонсы мансууруулагч бүтээгдэхүүнийг зараах олон тооны хувь хүн оролцдог онцлогтой;

- Зах зээлд харьцангуй хямд үнэ өртөгтэй байдаг зэрэгтэй холбон тайлбарладаг.

Мансууруулагчийн үйлдвэрлэл нь нууцаар явагддаг учир үйлдвэрлэлийн бодит хэмжээг үнэн зөвөөр тогтоох боломжгүй бөгөөд олон улсын практикт бүтээгдэхүүний төрөл, тэдгээрийн хэмжээг хураагдсан байдлаар нь үндэлдэг.

Олонсы ургамлын гол мансууруулагч үйлчилгээтэй

бодисууд нь байгалийн нэгдлийн каннабиноидын анги бүлэгт хамаарах Л-⁹ ⁸ ⁴-тетрагидроканнабинол (ТГК), каннабидиол (КБД), каннабинол (КБН) зэрэг бөгөөд мансуурах зорилгоор эдгээр бодисыг дангаар нь бус харин эдгээрийг агуулсан бүтээгдэхүүн хэлбэрээр (гашиш, марихуан, гашишийн давирхай болон гашишийн тос зэрэг) хэрэглэнэ².

Хар тамхи, кок, амфетаминь мансууруулагч бодисууд нь байгалийн нэгдлийн алкалоидын бүлэгт хамаарах бодисууд байдаг бөгөөд эдгээр нь гол төлөв цэвэршүүлсэн байдлаар хэрэглэгддэг онцлогтой.

Бодисыг агуулсан хэлбэрүүдийг тодорхойлоход:

- Марихуан** гэдэг олсны ургамалд 0,5-5 хувь ТГК агуулагдах бөгөөд эм ургамлыг дангаар нь тарималжуулж түүнээс бэлтгэсэн марихуанд ТГК-ийн хэмжээ 7-14 хувь агуулагдаж байна³.

- Гашиш** агуулагдах ТГК-ийн хэмжээ 2-8 хувь, зарим тохиолдолд 10-20 хувь-д хүрнэ⁴.

- Гашишийн тосонд** 50 хувиас илүү ТГК агуулагдаг.

НҮБ-ын Мансууруулах бодис хянах олон улсын хөтөлбөрөөс гаргасан мэдээгээр нийтдээ 140 сая гаруй хүн буюу дэлхийн хүн амын 2,5 хувь нь олсны ургамлын гаралтай мансууруулах бодисыг хэрэглэдэг нь амфетаминь төрлийн бодисуудыг хэрэглэдэг-0,5 хувь, кокаины төрлийн бодис хэрэглэгч-0,3 хувь, намууны төрлийн бодис хэрэглэн мансуурдаг-0,2 хувьтай харьцуулбал ихээхэн өндөр үзүүлэлт бөгөөд энэ тоо улам өссөөр байгаа юм⁵.

Энэ нь гашиш, кокаинаас 3 дахин, героиноос 30 дахин их, марихуан нь кокаинаас 10 дахин, героиноос 100 дахин их хэмжээтэй хэрэглэгдэж байгааг харуулж байна.

Олонсы төрлийн мансууруулах бодисийг дэлхийн олон улс оронд ихээр хэрэглэдэг нь тодорхой болсон бөгөөд НҮБ-ын Мансууруулах бодис хянах олон улсын хөтөлбөрийн мэдээлснээр⁶ 1990-1996 онд нийт 183 улс орон, бус нутагт марихуан болон гашишийг ямар нэгэн байдлаар илрүүлж хураан авсан байна гэсэн бодит статистик тоо баримтыг мэдээллийн хэрэгслээр цацаж

байгаад манай орон анхааралдаа авах шаардлагатай юм.

Учир нь Монгол Улсад олсны төрлийн ургамал байгальд тархан ургах, энэхүү ургамлыг түүх, бэлтгэх, боловсруулах хууль бус үйлдлийг мансуургагчид хэдийн хэрэглээд эхэлсэн, мансууруулагч олсны газар нутгийн тархацыг Та биднээс илүүтэйгээр судалгаа чиглүүлэх шаардлагатай байгаа юм.

Жишээ татахад, Хил хамгаалах ерөнхий газар Сэлэнэ аймгийн Алтанбулаг боомтын орчимд тархцатай мансууруулагч олсныг 2003 онд шатааж устгасан байна.

Хэнтэй аймгийн нэгэн суманд нэр бүхий иргэд хашаан дахь цэцгийн мандалдаа мансууруулах төрлийн ургамлыг тарьсны хууль хэрэгжүүлэгч байгууллагын ажилтнууд илрүүлж байсан.

Ингээд олон улсад оршин тогтсон нөхцөл байдлыг өөрийн оронд үүсэн бий болж буй нөхцөл байдлыг холбож тайлбарласан судалгааг дэлгэхэд, олсны мансууруулагч бүтээгдэхүүнийг эхлэн хэрэглэгчийн насны хязгаар нь бусад төрлийн мансууруулах бодисыг хэрэглэгчидтэй харьцуулбал нэлээд залуу байгаа бөгөөд энэ тоо Испанид 17 нас, АНУ-д 16 нас, Францад 16 нас, Австралид 17,5 наснаас эхлэж байна. Австрали, АНУ, Европийн холбооны улсад мансууруулагч бодис хэрэглэгчийн ихэнх хувийг 20-25 насны залуучууд эзэлдэг.

Хөрш зэргэлдээ ОХУ-д 2,5 сая хүн хар тамхи байгаа хэрэглэгдээс 76%-ийг нь 25 хүртэлх насны залуучууд эзлэх бөгөөд эдгээр улс орон дахь марихуаны хэрэглээ нь бусад орны адил өндөр байна.

Судалгаанаас үзэхэд өмнө зүгийн орнуудад 20-40 хүртэлх насны эргэлтүүдийн 60 хүртэл хувь нь гашишийн мансууралд автагдсан байдаг. Ялангуяа, архийг хориглосон, лалын шашны орнуудад энэ төрлийн мансуурал элбэг тохиолддог.

Манай орны тухайд мансууралчдын насны хязгаар нь 18-29 насны хооронд хйбэлбээж байгааг цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн гэмт хэргүүдэд харьцуулж гаргалаа.

Орчин үед хар тамхи.

¹ ² ³ UNODC-аас эрхлэн гаргадаг "Дэлхийн хар тамхины хууль бус эргэлтийн чиг хандлага" эмхтгэлийн орчуулгаас.

⁴ Ботаникийн хүрээлэнгийн ургамал судлалын ботаникийн тодорхойлолт.

⁵ ⁶ UNODC-аас эрхлэн гаргадаг "Дэлхийн хар тамхины хууль бус эргэлтийн чиг хандлага" эмхтгэлийн орчуулгаас.

мансууруулах бодисыг хууль бусаар тээвэрлэх, наймаалах, хэрэглэх явдал нь зохион байгуулалттай гэмт хэргийн суурь дэвсгэр болж өргөжсөөр байгааг өнөөгийн дэлхийн халуун цэгүүд бодитойгоор харуулж байна.

Хар тамхи, мансууруулах бодис хүн амын эрүүл мэнд, амь бие, үндэсний генийн фонд буюу хүний удамшил зүй, улс орны үндэсний аюулгүй байдалд нөхөж бэршгүй хохирол учруулахаас гадна эрүүгийн ноцтой гэмт хэргэ үйлдэх томоохон шалтгаан нь болдог ч тохиолдол бий.

1980-аад оны үед дэлхий дэхинд мансууруулах бодисын асуудал тодорхой бус нутгаар хязгаарлагдаж байсан бол 1990-ээд оноос хойш дэлхийн 100 гаруй орны зах зээлд үйлдвэрлэн боловсруулах, худалдаалах мафийн томоохон сүлжээүүдтэй болоод байна.

Мансуурах дон нь бохир мөнгөтэй болох гол аргын нэг болох бөгөөд үүнийг хэрэгжүүлэхийн тулд зохион байгуулалттай дээрэмчид санаанд оромгүй янз бүрийн аргаар олон улсын хэмжээнд мансууруулах бодисыг худалдаалж сая саяар нь мөнгө олж байна.

АНУ-ын судлаачдын тооцоолсноор мансууруулах бодисоос хордож нас барагчдын тоо улам ихэссээр байгаа бөгөөд тэдгээрийн 25 хувь нь 15-19 насны залуучууд байгаа аж.

Хар тамхи, мансууруулах бодисын эсрэг дэлхийн янз бүрийн улс оронд улс төр, нийгэм, эдийн засгийн байлдаас шалтгаалан төрөл бүрийн арга хэмжээ авч тэмцдэг.

Олон улсын мансууруулагчид хяналт тавих байгууллагын төв нь Австрийн Вена хотод тогтмол үйл ажиллагаагаа явуулж байна.

Мансууруулагчийн эсрэг тэмцэл 1925 оны Олон улсын Женевийн конвенцээс эхлэн улс орон бүрд идэвхтэй өрнөж одоогоор Дэлхийн хамтын нийгэмлэгийн бүх улсад төр нийгмийн бодлого болон хэрэгжиж байна. Энэ хурацаанд олон арван мянган га талбайд мансууруулагч олсны ургамлыг шатааж, олон сая долларын бүтээгдэхүүнүүдийг хурааж устгасаар байна.

Олсны мансууруулагчийн олон улсын зах зээлийн үнэ, ханш

Цуглуулсан баримтаас үзвэл каннабисын төрлийн бүтээгдэхүүнийг худалдаалах зах зээл нь төвлөрсөн бус зохион байгуулалтай, өөрөөр хэлбэл ханган нийлүүлэх болон худалдан авах талаас маш олон тооны хүн оролцдог оос зах зээлд аливаа гэмт хэргийн нөлөө багатайн дээр үнийг доод хэмжээнд байгаж олон тооны хэрэглэгчийг татах боломжтойгоос гадна хэрэглэх хэлбэр нь бусад төрлийн мансууруулагч бодистой харьцуулахад харьцангуй энгийн хялбархан байдаг нь хэрэглэгчийн тоо нэмэгдэх шалтгаан болдог байна.

1995-1996 оны байдлаар хөгжсөн орнуудад олсны ургамлыг худалдаалах дундаж үнэ ойролцоогоор 1 грамм нь 12.5\$ байдаг нь үүнтэй тэнцэх хэмжээний героины үнийн дөнгөж 6 хувь, кокаины 8 хувь юм¹.

Харин хөгжиж байгаа орнуудад худалдах үнэ хамаагүй доогуур бөгөөд дундаж үнэ ойролцоогоор 1 грамм нь 1 \$ байдаг нь үүнтэй тэнцэх хэмжээний героин, кокаины үнийн ердөө 2 хувь болно².

Мансууруулагч олсны ургамлын год үйлдвэрлэгч орнууд болох Зүүн өмнөд Ази (Бангладеш, Энэтхэг, Шри Ланк, Таиланд), Африк (Гана, Малави, Намиби, Өмнөд Африк)-д 1 грамм нь 0.1 \$-оос ч доогуур үнээр буюу бөөний үнээр худалдаалагддаг ажээ. Төв Америк, Карибын орнуудад 1 грамм нь 10\$ хүрэхгүй үнээр худалдаалагддаг.

Манай орны хувьд 2003 оны албан бус судалгаагаар канабисын үнэлгээг тодорхойлоход грамм хэмжээгээр бус шүдэнзний хайрцаг, янжуур тамхины хайрцаг, гялгар төр, уут зэргээр хэмжээг тогтоож үнэ ханш нь 1ширхэг шүдэнзний хайрцагтай олсны ургамал нь 10000-15000 төгрөг буюу мансууруулагч олсны боловсруулсан байдалаараа харилцан адилгүй байдалаар үнэлгээ тогтож байна.

Тодруулбал, манай орны хувьд олсны ургамлын зах зээлийн үнэ хараахан бүрэлдэн тогтоогүй хэдий ч өнөөдөр зарагдаж байгаа үнэлгээг харьцуулахад хөгжиж байгаа орнууд дахь үнэлгээтэй ойролцоо байгааг судалгааны дүн илтгэж байна.

Дээрх нөхцөл байдлыг нэгтгэн судлаачийн зүгээс доорх дүгнэхэд:

- Монгол орны хувьд мансууруулагч олс нь эзрэг болон таримал хэлбэрээр тодорхой газар нутгуудаар тархсан байгаа.

- Ботаникийн хүрээлэнгийн ургамал судлаач, ботаникчдын зүгээс сүүлийн 10 жилд мансууруулагч олсны ургамлын тархац, байршлын судалгааг хийжээгүй. Итхуйн байгууллагын төсөв, санхүүнд тусгагдаагүй байдагтай нэг талаас холбоотой.

- Орон нутгийн хууль хяналтын болон ургамал судлаачдад мансууруулагч олсны ургамлын тархац, байдлыг нарийвчлан тодорхойлоход мансууруулагч олсны судалгаа хийгээгүй.

- Мансууруулагч олсны ургамлын тодорхойлолт, шинж чанар, тархац, байршил зэрэг дэлгэрэнгүй мэдээлэл хууль хяналтын байгууллагын алба хаагчид хүрээгүй буюу товчоор тодорхойлоход мансууруулагч олсны ургамалтай тэмцэх нөхцөл байдал тогтворжоогүй.

- Мансууруулагч олсны ургамлын хор нөлөөлөл, энэ төрлийн гэмт хэргийн нөхцөл байдалд хууль хяналтын байгууллага үнэлэлт, дүгнэлтийг үр дүнд хүрэхгүй байдлаар хийгүй байгаатай шууд уялдаж байна.

Цаашид боловсруулсан хэрэгжүүлэх өргөн хүрээний ажлын саналууд:

1. Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтэй тэмцэж байсан үндэсний хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх, хөтөлбөрийн хүрээнд мансууруулагч олсны тархац, байршил, хууль бус хэрэглээтэй холбоотой асуудлыг мэргэжлийн байгууллагуудын хүрээнд албан ёсоор судалж нөхцөл байдлаа үнэн зөвөөр тодорхойлох.

2. Мансуурагч этгээдүүдэд мансууруулагч олсны ургамал, түүний хууль бус хэрэглээтэй холбоотой мэдээллийн өргөн сүлжээ байдагтай нэгэн адил хууль хяналтын байгууллага, түүний алба хаагчид мэдээллээр хангаж энэ төрлийн хууль бус эргэлтэй нэгэн зэрэг тэмцэл хийж эхлэх.

3. Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 192-195 зүйлүүдийг хэрэглэх талаар дээд шүүхийн тайлбар гаргах зэрэг болно.

^{1,2} UNODC ИҮБ-ын Хар тамхи, гэмт хэргийн асуудал эрхлэх алба-наас гаргасан мэдээгээр

ЭД ХӨРӨНГИЙН ХОХИРОЛ, ТҮҮНИЙГ НОТЛОХ АЖИЛЛАГАА

Эд хөрөнгийн хохирлын тухай ойлголт, ангилал

Гэмт хэргийн улмаас эд хөрөнгөд учирсан хохирлыг эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны үед зөв тогтоон шийдвэрлэж, хуулийн этгээд хувь хүний эд хөрөнгийн болон өмчлөх эрхийг хамгаалан хангах талаар өнөөгийн мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийн заалтыг нэг мөр хэрэгжүүлэн ажиллах нь хуульч бидний өмнө тавигдаж байгаа эрхэм зорилгуудын нэг нь билээ.

Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах байгууллага, прокурор, шүүх нь гэмт хэргийн улмаас хуулийн этгээд, хувь хүнд учирсан эд хөрөнгийн хохирлыг хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүн таслах ажиллагааны явцад бүрэн шалгах, бодит хохирлын хэмжээг үнэн зөв тогтоож, уг хэргийг шүүн хэлэлцэх шүүх хуралдаанаар хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг нэг мөр хамтад нь шийдвэрлэж байх нь чухал юм.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д "гэмт хэргийн улмаас нэр төр, алдар хүнд, санаа сэтгэл, бие эрхтэн, **эд хөрөнгийн** талаар хохирол хүлээсэн этгээдийг хохирогч гэнэ" гэж, 43 дугаар зүйлийн 43.1-д "гэмт хэргийн улмаас учирсан **эд хөрөнгийн** болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн, түүнийгээ нөхөн төлүүлэх буюу сэргээлгэхээр шаардлага тавьж байгаа иргэн, хуулийн этгээдийг иргэний нэхэмжлэгч гэнэ" гэж тодорхойлсон байдаг.

Эндээс дүгнэлт хийж үзвэл хохирогч, иргэний нэхэмжлэгч хоёрын гол ялгаа нь **хохирогч** хэдийгээр хохирсон байдаг ч заавал хохирлоо төлүүлэхээр шаардлага гаргах өлбөгүй, өөрөөр хэлбэл хохирол гаргуулах хэмжээнд хүртэл хохироогүй /ишээ нь гэмт этгээд эд зүйлийг нь дээрэмдэхээр довтолголт хохирогч өөрийгөө хамгаалаад эд зүйлээ алдаагүй/, эсхүл хэдийгээр эд хөрөнгийн хохирол хүлээсэн ч түүнийгээ төрөл судан, найз нөхдийн харилцаатайн улмаас болон бусад шалтгаанаар гэмт этгээдээс хохирлоо төлүүлэхээс татгалзсан байдаг бол харин **иргэний нэхэмжлэгч** нь хохирол хүлээсэн, уг хохирлоо



Улсын ерөнхий прокурорын
газрын хяналтын прокурор,
хууль зүйн магистр
Х.БАТЧИМӨГ

нөхөн төлүүлэх буюу сэргээлгэхээр хүсэлт буюу шаардлага гаргасан байх ёстой.

Эндээс гол нь хохирогч хохирлоо төлүүлэхээр хүсэл зоригоо илэрхийлсэн шаардлага тавьснаар иргэний нэхэмжлэгч болно гэсэн санааг гаргаж харуулахыг зорив.

Гэтэл одоогийн практикт хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор нь энэ ялгааг ойлгохгүйгээр хохирсон этгээдийг хохирогчоор тогтоох тогтоолыг, иргэний нэхэмжлэгчээр тогтоох тогтоолтой нь хамт үйлдэж байгаа /нэг хуудсанд хоёуланг нь багтааж хэвлэсэн хэвлэмэл маягтай байдаг/ нь буруу юм.

Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нь хохирогчид эрх, үүргийг нь сайтар танилцуулж хохирол учирсныг хохирогч өлбөгөө хэрхэн нотлох, хууль зүйн дагуу баримтуудаа яч буудуулвал зохих талаар зөвлөгөө өгч байх хэрэгтэй. Иргэний нэхэмжлэгчээр тогтоох асуудлыг байцаалтын дараа шийдвэрлэж байх нь зүйтэй юм. Учир нь хохирогч хохирлоо шууд нэхэмжлэхгүй ч байж болох бөгөөд хэзээ нэхэмжилж байна тэр үед нь иргэний нэхэмжлэгчээр тогтоож байх нь хуулийн шаардлагад нийцнэ.

Магадгүй хохирогч иргэний нэхэмжлэлээсээ татгалзаж болох

бөгөөд энэ тохиолдолд байцаалтад тодорхой тусгасны үндсэн дээр иргэний нэхэмжлэгчээр тогтоох тогтоол үйлдэх ёстой. Учир нь иргэний нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсан тохиолдолд шүүх шийдвэртээ заавал энэ талаар тусгадаг тул татгалзсан тохиолдолд иргэний нэхэмжлэгчээр тогтоолгүй оржи болохгүйг анхаарах хэрэгтэй.

Гэмт хэргийн улмаас учирсан эд хөрөнгийн хохирлын үнийг эрх бүхий байгууллага, мэргэжлийн хүмүүсийн үнэлгээнд /шинжээчийн дүгнэлт/ тулгуурлаж нарийвчлан тогтоолгүйгээр зөвхөн хохирогч, иргэний нэхэмжлэгч нарын үнэлсэн үнэлгээг үндэслэн тогтоодог практик нэгэнт тогтжээ.

Гэтэл үнэлгээг хэрхэн зөв тогтоох нь хууль зүйн хэрхэн ач холбогдолтой болох талаас нь авч үзэх шаардлагатай байна.

Эрүүгийн хуульд:

-хохирол

-хүнд хор уршиг

-бусад хүнд хор уршиг

-гэм хор гэх зэргээр тодорхой

хэмжээний **хохирол** шаардсан хэргүүдээс гэмт хэргийн зүйлчилэл нь шууд нөлөөлөхөөр байна. Эдгээр нэр томъёонуд нь дотроо бүгд эд хөрөнгийн хохирлыг багтаасан байдаг.

Хохирол: Эрүүгийн хуулийн тусгай ангид зааснаар хохирол гэдэг нэр томъёо нь үргэлж тодорхой хэмжээ шаардсан байдаг. Тухайлбал, Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 29 дүгээр зүйлд хохирлын хэмжээг бага бус, эцэж, их, онц их хэмжээ гэж тодорхойлсон байдаг.

Улсын дэд шүүхийн 1997 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 473 дугаар тогтоолд "тэм хор учруулснаас үүсэх үүргийн зүйл (объект) нь бусдын амь нас, эрүүл мэндийг бусниулсан, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг доромжилсон, гутаасан, **эд хөрөнгийг гэмтээсэн, устгасан** зэрэг үйлдлийн эцэст учирсан хохирол байна. Хохирол мөнгөн илэрхийлээгээр тодорхойлогддог" гэж тайлбарлажээ.

"**Хүнд хор уршиг**" болон "**бусад хүнд хор уршиг**"; Эрүүгийн хуулиар хамгаалагдсан тодорхой эрх ашигт халдсан нийгэмд аюултай

үйлдэл, эс үйлдэхүйн улмаас эрүүгийн хуульд гэмт хэргийн заавал байх шинж болгон заасан бодит ур дагавар (өөрчлөлт)-ыг **хор уршиг** гэнэ¹.

Хор уршиг нь гэмт хэргийн бүрэлдэхүүний объектив талын нэг үндсэн элемент болдог. Хор уршиггүй гэмт хэрэг гэж байдаггүй боловч тусгай ангид заасан бүх гэмт хэрэгт хор уршиггүй гэмт хэрэг байдаг. Учир нь хэлбэрийн бүрэлдэхүүнтэй гэмт хэрэгт үйлдэл, эс үйлдэхүй гэмт хэрэг мөнсэхийг тогтооход учруулсан хор уршигийг материаллаг хэлбэрээр үнэлэх шаардлагагүй байдаг. Харин материаллаг бүрэлдэхүүнтэй хэргийн хувьд бодитойгоор учирсан буюу учирч болох хор уршиг нь гэмт хэргийн бүрэлдэхүүнтэй эсэхийг үнэлэх шалгуур нь болдог байна.

Улсын дээд шүүхийн 2003 оны 7 дугаар сарын 9-ний өдөр гаргасан “Эрүүгийн хуулийн “хор уршиг”, “гэм хор” гэсэн заалтыг зөв хэрэглэх тухай” зөвлөмжид зааснаар хор уршигийг хүний амь нас, эрүүл мэндэд учирсан хор уршиг, эд хөрөнгөд учирсан хор уршиг, эдийн бус гэж гурав хуваасан байна.

Түүнчлэн Эрүүгийн хуулийн тусгай ангид “хүнд хор уршиг”, “бусад хүнд хор уршиг” шаардсан нийт 36 хэргийг зүйл тус бүрээр нь тайлбарласан бөгөөд хүнд хор уршигт эд хөрөнгөд тодорхой хэмжээний хохирол учирсныг багтаасан байна. Тухайлбал, Эрүүгийн хуулийн 153 дугаар зүйлийн 153.2-ыг буюу бусдын эд хөрөнгийг санаатайгаар устгах гэмт хэргийг галдан шатаах буюу нийтэд аюултай аргаар үйлдсэнээс бусад хүнд хор уршиг учирсан гэдгийг “хүний биед хүнд, хүндэвэр гэмтэл учирсан, хохирогч орон гэргий эсхүл ажлын байргүй болсон, амьжиргааныхаа эх үүсвэрээс салсан, эд хөрөнгөд нь их буюу онц их хэмжээний хохирол учирсан байхыг ойлгоно” гэжээ.

Эрүүгийн хуульд хэдийгээр “хүнд хор уршиг”, “бусад хүнд хор уршиг” гэж ялгаатай тусгасан боловч зүйл, хэсгүүдэд дүнгэлт хийж үзэхэд хууль тогтоочч ч ялгаа, заагийг нь гаргалгүйгээр зохицуулсан зохицуулалтууд нэлээд байна. Жишээлбэл, Эрүүгийн хуулийн 108 дугаар зүйл /Хүн хулгайлах/, 112 дугаар зүйлд /хүн барьцаалах/ заасан гэмт хэргүүд нь хоорондоо зөвхөн объектив талын үйлдээрээ л ялгагддаг бөгөөд объект, субъект,

субъектив тал нь адилхан хэрэг байхад 108 дугаар зүйлийн 108.3-т “энэ хэргийн улмаас хүнд хор уршиг учирсан” гэж, 112 дугаар зүйлийн 112.3-т “бусад хүнд хор уршиг учирсан” гэж ялгаатай мэтээр хуульчилсан нь буруу байна.

Нэгэнт нэг үгээр биш хоёр өөр үгээр хуульчилсан тул “хүнд хор уршиг” гэдэгт хүний амь нас хохирсныг оруулж болохоор, харин “бусад хүнд хор уршиг” гэдэгт хүний амь нас хохирсноос бусад хүнд гэмтэл учрах, ураг зулбах, эд хөрөнгөд их хэмжээний хохирол учирсан зэргийг хамруулж болохоор байна.

Дээрх зөвлөмжид ч ялгаагүй мэтээр хольж бичсэн байх тул цаашид хуульчид үүнийг нэг мөр ойлгож хэрэглэх хэрэгтэй. Түүнчлэн цаашид Улсын дээд шүүхээс ялгаа, заагийг нь гаргасан тайлбар гаргах шаардлагатай гэж үзэж байна.

Гэм хор: Гэм хор нь хохирлоос өргөн ойлголт юм. Зарим судлаач хохирлыг гэм хорын мөнгөн илэрхийлэл гэж үздэг. Гэвч энэ нь буруу ойлголт бөгөөд гэм хор бүр мөнгөн илэрхийлэгдэхгүй².

Гэм хор нь их өргөн хүрээтэй ойлголт бөгөөд гэм хорын илрэх хэлбэр нь хор уршиг, хохирол юм.

Эд хөрөнгийн хохирлын ангилал:

1. Эд хөрөнгийн хохирол нь хэргийн зүйлчлэлтэй зайлшгүй холбоотой ойлголт бөгөөд хэргийн зүйлчлэлд нөлөөлж байгаа эсэхээс нь шалтгаалаад:

1. **Зүйлчлэлд нөлөөлөхөөр хохирол**

2. **Зүйлчлэлд нөлөөлөхөөргүй хохирол** гэж хоёр ангилж болох юм.

Дээр дурьдсанчилан хохирол, хүнд хор уршиг, бусад хүнд хор уршиг зэрэг нь дотроо эд хөрөнгийн хохирлыг багтаасан ойлголт юм.

Эрүүгийн хуульд эд хөрөнгийн хохирлоос хамаарч зүйлчлэлд нөлөөлөх тусгай ангид заагдсан 125 хэрэг байна. Тэгэхээр хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд эд хөрөнгийн хохирлыг зөв, хууль хүний үндэслэлтэй тогтоохын нэг ач холбогдол нь хэргийн зүйлчлэлтийг зөв тогтоох, улмаар гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай этгээдийн үйлдэлд нь тохирсон ял шийтгэл ногдуулах явдал юм.

Хэргийн зүйлчлэлд нөлөөлдөө хохирол гэдэгт Эрүүгийн хуулийн

тусгай ангид заасан гэмт хэргийн бүрэлдэхүүнд учруулсан хохирлоос нь шалтгаалж гэмт хэрэгт тооцож эсэх, мөн хүндэрүүлэх бүрэлдэхүүнд хамааруулдаг хэргүүдийг оруулж болох юм. Жишээ нь, Б нь иргэн Л-ийн 6 сая төгрөгийн үнэтэй манан хоёртгийг хулгайлсан бол энэ нь Эрүүгийн хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-д заасан “үлэмж” хэмжээний хохиролд хамаарах бөгөөд энэ гэмт хэргийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 145 дугаар зүйлийн 145.2 дахь хэсэгт зааснаар зүйлчлэх хууль зүйн үндэслэл бий болж байна. Хохирогчийн цорын ганц эд хөрөнгөд хохирол учирч болох бөгөөд энэ тохиолдолд эд хөрөнгийн хохирлыг мөргөн бодит үнэлгээгээр тогтоож зүйлчлэх ёстой. Харин үнэ, цэцэгтэй, цорын ганц эд хөрөнгөд хохирол учирсны хувьд эдийн хохирлоос гадна, эдийн бус хохирлыг давхар нэхэмжилж болно. Эдийн бус хохирлыг давхар нэхэмжилж байгаа нь хэргийн зүйлчлэлд нөлөөлөхгүй гэдгийг анхаарах хэрэгтэй.

Харин **хэргийн зүйлчлэлд нөлөөлдөггүй хохирол** гэдэгт гэмт хэргийг үйлдэх явцад эд хөрөнгөд их, бага хэмжээний хохирол учруулснаас нь хамаарахгүйгээр гэмт хэргийн бүрэлдэхүүний өөр шинжээр нь зүйлчилдэг хэргүүдийг хамааруулж болох юм. Жишээлбэл, А нь зэвсэг хэрэглэн танхайрах явцад иргэн Б-гийн машиныг хутгаар зурах, дугуйнуудыг хагалах зэргээр эд хөрөнгөд нь хохирол учруулсан боловч дээрх үйлдэл нь Эрүүгийн хуулийн 181 дүгээр зүйлийн 181.3 дахь хэсгийн буюу зэвсэг хэрэглэж танхайрсан гэмт хэргийн бүрэлдэхүүнийг агуулсан байх бөгөөд энэ тохиолдолд иргэн Б-гийн эд хөрөнгөд хэчнээн төгрөгийн хохирол учруулсан нь зүйлчлэлд огт нөлөөлөхгүй байна.

2. Учрах байдлаар нь:

1. **Шууд хохирол,**

2. **Шууд бус дагалдах,**

Шууд хохирол гэдэгт нь товчоор хэлбэл гэмт хэргийн халдлагын улмаас эд хөрөнгө алдагдсан, эвдэрсэн, гэмтсэнээс болж учирсан хохирол байна.

Шууд бус хохирол тухайн эд хөрөнгийн эвдрэлийг засах, сэргээх, шинээр сольж хийхтэй холбоотойгоор гарсан зарлдууд хамаарна.

Авто солон гэмт хэргийн улмаас

¹ Жацан С. Эрдэнэбат, Г. Эрдэнэбулган, Ж. Гэмт хэргийн тухай Эрүүгийн эрх зүйн тулгуур ойлголт. УБ: 2005 он. 19 дэх тал

² Брангинский М.И., Витрянский В.В. Договорное право общее положение. Москва. 1998 он. с.540

³ Иргэний хуулийн 84 дүгээр зүйлийн 84.2. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. 2002 он. №7

хохилогчийн машины зүүн талын хаалга эвдэрч, салхины шил хагарсан, толь хугарсан зэрэг эвдэрд гарсан байхад толь, салхины шил шинээр хийж, хаалгыг сэргээн засуулж, будуулж байгаа нь шууд хохирол, харин засвар хийсний зардал нь шууд бус хохирол юм.

3. Эд хөрөнгийг хохиорлын хэлбэрээр нь:

1. Эд юмд учирсан хохиорол,

2. Оюуны үнэт зүйлд учирсан хохиорол,

3. Эрхэд учирсан хохиорол.

Хөрөнгө гэдгийг Иргэний хуулийн 83 дугаар зүйлийн 83.1-д "Аливаа этгээд нь хууль хархорилгоогүй, нийтээр хүлээн зөвшөөрсөн сан зургаархууны хэм хэмжээнд харшлахгүйгээр эдийн баялаг болох эд юм болон эдийн бус баялаг болох оюуны үнэт зүйл, эрхийг олж авч болох бөгөөд энэ тохилдолд дээрх баялаг нь хөрөнгө болно" гэж тодорхойлжээ.

Эд юм - бодит, нүдээр үзэгдэж харагдах эд зүйл бөгөөд хохиорогчийн хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгийг¹ хэлэх ба түүнд учирсан хохиорлыг эд хөрөнгөд учирсан хохиорол гэж ойлгоно.

Оюуны зүйл - хохиорогчийн оюуны бүтээл үйл ажиллагаагаар бүтээгдсэн утга зохиол, урлагийн бүтээл, шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загвар зэрэг нь оюуны зүйлд хамаарах бөгөөд эдгээрт учирсан хохиорлыг оюуны зүйлд учирсан хохиорол гэж үзнэ.

"Шинэ бүтээл" гэж байгалийн хуульд тунгуурлансдаж үндэслэлийг нь тодорхойлсон, үйлдвэрлэх арга ажиллагаа болон бүтээгдэхүүнд хамаарах, шинэ бүтээлийн түвшин агуулсан шинэ шийдлийг;

"Бүтээгдэхүүний загвар" гэж бүтээгдэхүүний гадаад хэлбэр, хийцэд хамаарах гоёл чимэглэл, өнгө, өнгөний хослол агуулсан, шинээр зохион бүтээсэн, өвөрмөц шийдлийг;

"Ашигтай загвар" гэж үйлдвэрлэлийн багаж, хэрэгсэл, аргад хамаарах, үйлдвэрлэлд ашиглах боломжтой техникийн шинэ шийдлийг тус тус ойлгоно⁴.

Эрх - гэмт хэргийн улмаас хохиорогчийн эдлэх онцгой эрх тухайлбал, газар өмчлөх эрх, лиценз, патент, банкин дахь хадгаламж, эрх зэмшигчийн эрх зэрэгт хууль бусаар халдсны улмаас учирсан хохиорлыг ойлгоно.

"Эрх зэмшигч" гэж утга зохиол, урлагийн бүтээлтэй холбоотойгоор үүсэх зохиогчийн бүтээл ашиглах онцгой эрхийг эдлэх хувь хүн, хуулийн этгээдийг⁵;

"Патент" гэж тухайн шийдэл нь шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар болохыг тодорхойлж, зохиогч нь тодорхой хугацаанд түүнийг өмчлөх онцгой эрхтэй болохыг хүлээн зөвшөөрч, төрийн эрх бүхий байгууллагаас олгож байгаа баримт бичиг юм.

Эд хөрөнгийн хохиорлыг нотлох ажиллагаа

Гэмт хэргийн улмаас учирсан хохиорлын хэмжээ нь хэргийн зүйлчлэлд ихээхэн нөлөөлдөг тул хэрэг үйлдсэн өдрийн зах зээлийн ханшаар хохиорлын хэмжээг тогтоож байх нь зүйтэй⁶.

Эрүүгийн байцан шийтгэх хуулийн 80 дугаар зүйлийн 80.1.5-д "гэмт хэргийн улмаас учирсан хохиорлын шинж чанар, эрх хэмжээ"-г нотолсон байхыг заасан байдаг.

Шинж чанар гэдэг нь физик, химийн талын ойлголт бөгөөд хийсэн материал, түүний орц, хэмжээ, найрлага, өнгө, үнэр, амт, галд тэсвэртэй эсэх, уян хатан, зөөлөн, хатуу байдал, эдэлсэн хугацаа, элэгдэл, ховордог, хадгалалт, гэмтсэн гэмтэл, эвдрэл зэрэг эд зүйлийн бүхий л шинж тэмдэг багтсан байна.

Шинж чанарыг сайтар тогтоосны үндсэн дээрээс хохиорлын эрх хэмжээг тогтоох нь зайлшгүй юм.

Эрх хэмжээ гэдэг нь тооны үзүүлэлт бөгөөд тухайн эд зүйлийн үнэлэгдэж байгаа үнэ, өртгийг хэлнэ. Үнэ өртгийг зөв тогтоох нь эрүүгийн гэмт хэргийн зүйлчлэлийг зөв хийхээс гадна хохиорогчид учирсан хохиорлыг бодитоор нөхөн төлүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

Одоогийн практикт эд хөрөнгийн хохиорлын хэмжээг тогтооходоо:

1. Шинжээчийн дүгнэлт (Криминалистикийн шинжилгээний, шүүх эмнэлэгийн, Аудитын, нягтлан бодох бүртгэлийн гэх мэт),
2. Эд зүйлийн үнэлгээний комисс,
3. Татвар, гаалийн байцаагчийн акт,
4. Мэргэжлийн хяналтын байцаагчийн акт,

5. Талууд харилцан тохиролцох,

6. Зардлын баримтаар тогтоох,

7. Байгууллагын дансанд тусгагдан үнэлээ,

8. Даатгалын үнэлгээ зэргийг нотлогдоны эх сурвалж болгож байгаа болно.

Шинжээчийн дүгнэлт: Шинжээч гэдэг нь хэрэгт ач холбогдолтой баримтын талаар нарийн мэргэжлийн буюу тусгай мэдлэг шаардсан дүгнэлт гаргуулж шинжлүүлэхээр эрүүгийн байцан шийтгэх ажиллагааг хэрэгжүүлэгчдээс томилсон хэрэгт хувийн сонирхолгүй хөндлөнгийн этгээд бөгөөд шинжээчийн дүгнэлт гэдэг нь шинжлэх ухаан, техник, урлаг, соёлын нарийн мэргэжил бүхий хүн хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүхийн тогтоол, шүүхийн захиралжийн дагуу хийсэн нотлох баримтын эх сурвалж болж чадауцгүй үзлэг, шинжилгээний эцсийн үр дүн юм.

Улсын Их Хурлын 1998 оны 18 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр"-ийн 44 дүгээр заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 63 тоот тушаалаар

- Эрүүл мэндийн яамны харьяа "Шүүх эмнэлгийн магадлах төв",

- Сангийн сайдын дэргэдэх "Шүүх нягтлан бодох бүртгэлийн магадлах төв",

- Цагдаагийн өрөнхий газрын дэргэдэх "Шинжилгээний хүрээлэн" зэргийг тус тус нэгтгэн Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд "Шүүхийн шинжилгээний үндэсний төв"-ийг байгуулжээ.

Тус төвийн Шүүх нягтлан бодох бүртгэлийн магадлах төвчөө нь шүүх, цагдаагийн мөрдөн байцаах болон хэрэг бүртгэх алба зэрэг хууль сахиулах байгууллагаас ирүүлсэн тогтоол, захирамжийн дагуу ач ахуйн нэгж, байгууллага, иргэдэд холбогдох өмчийн болон татварын холбогдолтой хэргийн талаарх маргаантай асуудалд магадлагаа хийж дүгнэлт гаргах үндсэн үүрэгтэйгээр ажилладаг бөгөөд өнөөдрийн байдлаар тус төвчөөнд товчооны дарга нэг, магадлагч дөрөв гэсэн орн тоотой, аймгуудын Засаг даргын Тамгын газрын дэргэд Шүүх нягтлан бодох бүртгэлийн орн тооны бус магадлах

¹ Патентын тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн 3.1.1, 3.1.2, 3.1.3 дахь заалт
² Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай /Шинэчилсэн найруулга/ хуулийн 3.1.2 дахь заалт
³ Патентын тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн 3.1.4 дэх заалт
⁴ Улсын дээд шүүхийн 2002 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн 3 дугаар тогтоолод

комисс ажиллаж байдаг юм байна.

Эд зүйлийн үнэлгээний комисс

Одоогийн байдалар үнэлгээний комиссууд нь аймагт аймгийн Засаг даргын Тамгын газрын дэргэдэх үнэ тогтоох комисс, нийслэлд дүүргийн Засаг даргын Тамгын газрын дэргэдэх болон Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дэргэдэх Үнэ тогтоох комисс гэсэн зохион байгуулалттайгаар үйл ажиллагаагаа явуулж байгаа юм байна. Гишүүдийг судалж үзвэл орон тооны бус бөгөөд Үйлдвэрлэл, үйлчилгээний хэлтэс, Төрийн сангийн хэлтсийн ажилтнуудаас голдуу гишүүдийг томьхон бөгөөд даргаар нь. Хууль зүйн хэлтсийн дарга, ажилтан ажилладаг нийтлэг жишиг тогтсон байдаг юм байна.

Зам, тээврийн ослын хэргүүдэд машины эвдрэл, гэмтлийн үнэлгээг одоогоор Сангийн яамнаас зөвшөөрөл авсан 18 хувийн компани тогтоож байна.

Харин мал алдагдсан хэргүүдэд малын үнэлгээг сумын Засаг даргын тодорхойлолтоор тогтоодог нийтлэг жишиг тогтжээ.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 79 дүгээр зүйлийн 79.2-т "хэргийг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий баримт сэлт, мэдээлэл нь гэрч, хохирогч, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн мэдүүлэг, шинжээчийн дүгнэлт, мэдүүлэг, эд мөрийн баримт, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүх хуралдааны тэмдэглэл болон бусад баримтаар тогтоогдоно" гэжээ. Өөрөөр хэлбэл, Эрүүгийн байцаан шийтгэх хуульд эд зүйлийн үнэлгээг эд зүйлийн үнэлгээний комисс хийнэ гэсэн зохицуулалт байдаггүй бөгөөд байх ч шаардлагагүй юм. Эд зүйлийн үнэлгээний комисс нь хуучин социализмын үед байсан бөгөөд энэ үеэс хойш шинээр хууль батлагдсан, мөн хуульд хэд хэдэн удаа нэмэлт өөрчлөлт орсон байхад хуучин тогтолцоог хэрэгжүүлсээр байгаад дүгнэлт хийх шаардлагатай байна. Эд зүйлийн үнэлгээг хуультай нийцүүлэн шинжээч хийж, шинжээчийн дүгнэлт гаргах ёстой.

Гэтэл одоо үнэлгээ тогтоож байгаа комисс нь ямар байдалаар, ямар хугацааны зах зээлийн ханшаар үнэлгээ тогтоогдож нь ойгомжгүй, ямар аргачиллаар хэрхэн үнэлгээ тогтоогдож нь тодорхойгүй зөвхөн хийсвэрээр үнэлдэг байна. Ялангуяа эд зүйл нь алдагдсан, олдоогүй тохиолдолд бүр ч хийсвэрээр үнэлдэг болох нь хэнд ч тодорхой билээ. Учир нь хууль сануулж гарын үсэг

зуруулаагүй, хариуцлага-тооцох механизм байхгүй, тодорхой эрх, үүрэг хүлээдэггүй тул үнэлгээнд зүгээр л уязмжээрээ үнэлдэг практик манайд хэвшсээр олон жилийн нуур үзэж байна. Хуульчид бид цаашдаа ингэж хуулиасаа хоцрогдсон, хуульд байхгүй аргаар эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулж болохгүй бөгөөд үүнийг өөрчилж хууль зүйн дагуу болгох цаг үе нэгэнт иржээ.

Үүнийг засахад тийм ч хэцүү биш бөгөөд дээр дурдсанаар Шүүхийн шинжилгээний үндэсний төвийн Шүүх нягтлан бодох бүртгэлийн магадлах товчоо нь шүүх, прокурор, цагдаагийн мөрдөн байцаах болон хэрэг бүртгэх алба зэрэг хуулийн байгууллагуудаас ирүүлсэн тогтоол, захирамжийн дагуу аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд холбогдох өмчийн болон татварын холбогдолтой хэргийн талаарх маргаантай асуудалд магадлагаа хийж дүгнэлт гаргах үндсэн үүрэгтэйгээр ажилладаг бөгөөд нэгэнт байгаа тус товчоонд эв хөрөнгийг үнэлэх чиг үүргийг өгөхөд болохгүй гэх газаргүй гэж бодож байна.

Түүнчлэн хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч нь эд хөрөнгө үнэлгээг хийлгэхэдээ шинжээчийн нэр заасан шинжээч томилгох тухай тогтоол үйлдэж, хууль санаулдаг практикийг хуульд нийцүүлэн хийж хэвхий шаардлагатай байна.

Эд зүйлийн үнэлгээг зөв тогтоохын хууль зүйн ач холбогдол нь хэр их болох талаар бид дээр дурдсан билээ.

Гэмт хэргийн зүйлчлэл, цаашилбал хүний хувь заяаг бүрэн шийдвэрлэж чадах энэ том үйл ажиллагааг хуульчид бид зөвхөн хуульдаа нийцүүлэн хийх хэрэгтэй бөгөөд хэрвээ зөв гольдролд нь оруулахгүй бол цаана нь хүний эрх, эрх чөлөө хохирсон байх болно гэдэг нь тодорхой билээ.

Татаар, гаалийн байцаагчийн акт болон мэрэгжлийн хяналтын байцаагчийн акт

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 79 дүгээр зүйлийн 79.2-т "хэргийг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий баримт сэлт, мэдээлэл нь гэрч, хохирогч, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн мэдүүлэг, шинжээчийн дүгнэлт, мэдүүлэг, эд мөрийн баримт, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүх хуралдааны тэмдэглэл болон бусад баримтаар тогтоогдоно" гэжээ.

Гэтэл татаар, гаалийн байцаагчийн акт, мэрэгжлийн хяналтын байцаагчийн акт зэрэг нь

хууль сануулсны үндсэн дээр үнэн зөв гаргах үүрэг хүлээсэн шинжээчийн дүгнэлт бий бөгөөд дангаараа ноголж баримт болохгүй. Эдгээр нь мөн хуулийн 166 дугаар зүйлийн 166.1.2-т "гэмт хэрэг гарсан талаар аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан мэдээлсэн" мэдээлэл юм.

Татварын байцаагчийн акт, мэрэгжлийн хяналтын байцаагчийн акт зэрэг нь эдгээр байгууллагын эрх бүхий албан тушаалтнуудаас төрийн байгууллагын чиг үүргээ хэрэгжүүлэх явцааа шалгалт хийсний үйлдлийг илрүүлж улмаар эрх бүхий байгууллагаар шалгуулахаар өгч байгаа мэдээлэл юм. Өөрөөр хэлбэл, эдгээр байгууллага нь энэ тохиолдолд хөндлөнгийн байр суурьтай байж чадахгүй байдаг.

Тиймээс эдгээр актыг үндэслэн хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч шинжээч томилгох тогтоол үйлдэж шинжилгээний байгууллагаар дүгнэлт гаргуулахаар холбогдох баримтуудыг шилжүүлэх нь зүйтэй бөгөөд ингэж байх хүний эрх бүрэн хангагдах болно.

Талууд харилцан тохиролцох:

Эд хөрөнгийн хохирлын хэмжээг тогтооход талууд харилцан тохиролцоо ойлголт байж болохгүй бөгөөд харин хохирол нөхөн төлүүлэх асуудалд талууд хохирлын хэмжээг харилцан тохиролцоо замаар тогтоож, улмаар хохирлоо төлүүлж болдог. Эд хөрөнгийн хохирлыг тогтоох нь гэмт хэргийн зүйлчлэлд асар их нөлөөтэй бөгөөд хохирлын хэмжээг ялгамжтай тогтоох нь хүн бүр шүүхийн өмнө эрх тэгш байх зарчимтай харшлах тул хохирлын хэмжээг гагцхүү бодитоор тогтоох шаардлагатай.

Зардлын баримтаар тогтоох:

Эд хөрөнгийн хохирол учирсан зарим тохиолдолд зардлын баримтаар хохирлыг тооцож нөхөн төлүүлж болно. Тухайлбал, зам, тээврийн ослын гэмт хэргийн улмаас автомашины эд анги, салбэгүүд нөхөн сэргээгдэх боломжгүйгээр эвдэрсэн тохиолдолд хохирогч шинээр авахын тулд зардлын баримт бүрдүүлэх шаардлага гарна. Мөн шинээр гар утас худалдаж аваад хуягайд алдсан бол худалдаж авсан баримтаар нь үнэлгээ тогтоож болдог бөгөөд энэ тохиолдолд заавал үнэлгээг хийлгэх шаардлагагүй юм.

Байгууллагын дансанд тусгаарсан үнэлгээ:

Аж ахуйн нэгж, байгууллагын эд хөрөнгөд учирсан хохирлын үнэлгээг тогтоох бас нэг арга нь байгууллагын

нь дансанд хэрхэн үнэлэгдэж байгаагаа нь үнэлгээ хийж явдал юм. Гэхдээ энд анхаарах нэг асуудал бол аж ахуйн нэгж, байгууллага нь эд хөрөнгийн үнэлгээгээ жил бүр шинэчлэн тогтоосон эсэхийг анхаарах хэрэгтэй. Тэр үнэлгээ нь эд хөрөнгийн элэгдэл, хорголд зэрэгт үндэслэгдсэн байх ёстой. Хэрвээ үнэлгээгээ шинэчлээгүй бол түүнийг шууд эд хөрөнгийн үнэлгээ гэж авч болохгүй. Учир нь гэмт хэргийн хохирлыг зах зээлийн үнэлгээгээр хийх нь зүйтэй.

Даатгалын үнэлгээ:

Хохирогч эд хөрөнгөө даатгуулсан тохиолдолд даатгалын сангаас хохирлоо нөхөн төлүүлэх боломжтой байдаг. Энэ тохиолдолд даатгалын баримтаар Үнэлгээг тогтоож болдог.

Хохирлыг нөхөн төлүүлэх ажиллагаа

Хохирлыг нөхөн төлүүлэх ажиллагаа нь хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд сэжигтэн, яллагдагчийн хувьд сайн дурын шинжтэй байдаг. Өөрөөр хэлбэл энэ шатанд түүний хувьд гэм буруутай нь нотлогдоогүй байдаг тул хэрвээ сэжигтэн, яллагдагч гэм буруугаа ухамсарласан болон хохирогчийг энэрч өрөвдсөн сэтгэлээр сайн дураараа хохирол төлж болдог.

Шүүхийн шийдвэр гарахаас өмнө хохирлыг сайн дураараа төлсний хууль зүйн үр дагавар нь:

- гэмт хэрэг үйлдэж учруулсан хохирлоо сайн дураараа нөхөн төлсөн буюу гэм хорьж нөхөн төлсөн бол ял шийтгэлийг хөнгөрүүлэх нөхцөл байдалд тооцохор⁴,

- хүндэтвэр гэмт хэрэг үйлдэж анх удаа хорих ял шийтгүүлсэн этгээд учруулсан хохирлоо нөхөн төлсөн буюу гэм хорьж арилгасан тохиолдолд түүнд оноосон хорих ялыг тэнсэж болохор⁵,

- хөнгөн гэмт хэрэг үйлдсэн этгээд учруулсан хохирлоо бүрэн төлсөн буюу гэм хорьж арилгасан бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлж болохор⁶,

- хорих ялаар шийтгүүлж,

ялынхаа тодорхой хувийг эдэлсэн этгээд учруулсан хохирлоо нөхөн төлсөн буюу гэм хорьж арилгасан бол түүнийг ял эдлэхээс хугацаанаас нь өмнө тэнсэн суллаж болох¹¹ зэрэг болно.

Сэжигтэн, яллагдагч нар хохирлыг сайн дураараа нөхөн төлөхөөс гадна хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчаас хохирлыг нөхөн төлүүлэхээр хуульд заасан арга хэмжээг авсан байх шаардлагатай. Үүнд:

- эд хөрөнгө барьцаалах (сэжигтэн, яллагдагч нь дуудсан цагт саадгүй ирж байх үүргийг өөрөө хүлээж, өөрийнхөө эд хөрөнгийг барьцаалсан бол),

- эд хөрөнгө захиран зарцуулах эрхийг хязгаарлах,

- аж ахуйн нэгж, байгууллага, иргэний эд зүйл, эд хөрөнгө, мөнгө агуулсан байр савыг битүүмжлэх зэрэг ажиллагаа хамаарна.

Өнөөгийн практикт хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчаас энхүү ажиллагаануудыг хангалттай хийж гүйцэтгэхгүй байгаа. Ихэвчлэн онц дуулиантай, хохирол ихтэй хэргүүдэд л хийж байгаа нь нууц биш юм.

Түүнчлэн иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагчийг тухай бүрд нь тогтоохгүй орхих, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч нарын болон иргэний хариуцагчийн хөрөнгийг олж илрүүлэн, шаардлагатай үед цаг алдалгүй битүүмжлэн нэхэмжлэлийг хангаж арга хэмжээ авахгүй байх зөрчлүүд байсаар байна.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын үнийг нарийвчлан тогтоолгүйгээр зөвхөн хохирогч, иргэний нэхэмжлэгч нарын үнэлсэн үнийг үндэслэн үнийг тогтоох, иргэний нэхэмжлэгч шүүх хуралдаан хүртэл эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны аль ч үе шатанд иргэний нэхэмжлэл гаргах эрхтэй болохыг тайлбарлан өгөхгүй орхигдуулах, нотлох баримтын шаардлага хангахгүй материалыг хэрэгт үдэх зэрэг дутагдал гарсаар байгаа билээ.

2005 онд улсын хэмжээгээр анхан шатны шүүхээр 6966 хэргийн 10153 шүүгдэгч ял шийтгүүлжээ.

Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд 241 хэргийн 335 сэжигтэн, яллагдагчийн хөрөнгийн байдал, төлбөрийн чадвартайг тогтоох ажиллагаа хийгдсэн байна. Энэ нь нийт шүүхээр шийтгүүлсэн шүүгдэгчийн тоотой харьцуулбал 3.3 хувийг, нийт шүүхээр шийдвэрлэгдсэн 6966 хэргээс 241 хэрэгт сэжигтэн, яллагдагчийн хөрөнгийн байдлыг тогтоосон нь 3.4 хувьтай гэсэн тоо гарсан нь хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд хохирол нөхөн төлүүлэх хуульд заасан арга хэмжээ болон торгуулийн ялын биелэгдэх байдлыг тогтоож байх хуулийн заалтуудын хэрэгжилт туйлын хангалтгүй байна гэсэн дүгнэлтэд хүргэлээ¹².

Харин хэргийг шүүх хуралдаанаар хянан хэлэлцээд гарсан шийдвэр нь заавал биелэгдэх шинжтэй албадлага болж хувирдаг.

Шүүх хохирлыг төлүүлэхдээ гэм хор учруулахаас өмнөх байдлаас нь сэргээх /адил нэр, төрөл, чанарын эд хөрөнгө өгөх, гэмтсэн эд хөрөнгийг засах зэргээр/ буюу учирсан хохирлыг мөнгөөр төлүүлэхээр¹³ шийтгэх тогтоолдоо тусгана.

Эд хөрөнгийн хохирлыг нөхөн төлүүлж байгаа шүүхийн практикт эд хөрөнгийн хохирлыг төлүүлэхэд шийтгэх тогтоолдоо дурдахдаа хуулийн зүйл, заалтыг тодорхой дурдахгүй байх, шүүгдэгчийн гэм буруугаас тэдний хэмжээний хохирол учирсан, хэр нь ямар баримтаар нотлогдож байгааг тодорхой заахгүй байх, шүүх хуралдаанд иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, гуравдагч этгээд, хамтран хариуцагчийг татан оролцуулдаггүй явдал давтан гарч байна¹⁴.

Гэмт хэргийн улмаас хохирсон хүн хохирсон чигээрээ үлдэх нь тэдний нийгэмд буюу ялангуяа хуулийн байгууллагад хандах хандлагад сөргөөр нөлөөлдөг. Хуулийн амжилтууд хохирогчийн сэтгэл зүйн ойгодоогүй, мэдлэг дутагдсан болон мэдрэмжтэй бус хандлагууд нь дээр дурдсан сөргө нөлөөлүүдийг ихэсгэж байна.¹⁵

⁴ Монгол Улсын Эрүүгийн хуулийн 55 дугаар зүйлийн 55.1.2, 55.1.3, 55.1.55.1.10 дахь заалт

⁵ Монгол Улсын Эрүүгийн хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1 дэх заалт

⁶ Монгол Улсын Эрүүгийн хуулийн 70 дугаар зүйлийн 70.1, 71 дүгээр зүйлийн 71.1

⁷ Монгол Улсын Эрүүгийн хуулийн 74 дүгээр зүйлийн 74.1 дэх заалт

⁸ 2006 онд Улсын Ерөнхий прокурорын газраас "Торгуулийн ялын биелэлт"-ийн талаар хийсэн судалгааны илтгэх хуудаснаас

⁹ Иргэний хуулийн 510 дугаар зүйлийн 510.1 дэх заалт

¹⁰ Даваадорж.Г. "Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлж байгаа шүүхийн практик" сэдэвт магистрийн дипломнын амжилт. 2003 он. 10 дахь тал

¹¹ Эрх зүйн шинэтгэл-2002 он. № 3

комисс ажиллаж байдаг юм байна.

Эд зүйлийн үнэлгээний комисс

Одоогийн байдалар үнэлгээний комиссууд нь аймагт аймгийн Засаг даргын Тамгын газрын дэргэдэх үнэ тогтоох комисс, нийслэлд дүүргийн Засаг даргын Тамгын газрын дэргэдэх болон Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дэргэдэх Үнэ тогтоох комисс гэсэн зохион байгуулалттайгаар үйл ажиллагаагаа явуулж байгаа юм байна. Гишүүдийг судалж үзвэл орон тооны бус бөгөөд Үйлдвэрлэл, үйлчилгээний хэлтэс, Төрийн сангийн хэлтсийн ажилтнуудаас голдуу гишүүдийг томлох бөгөөд даргаар нь Хууль зүйн хэлтсийн дарга, ажилтан ажилладаг нийтлэг жишиг тогтсон байдаг юм байна.

Зам, тээврийн ослын хэргүүдэд машины эвдрэл, гэмтлийн үнэлгээг одоогоор Сангийн яамнаас зөвшөөрөл авсан 18 хувийн компани тогтоох байна.

Харин мал алдагдсан хэргүүдэд малын үнэлгээг сумын Засаг даргын тодорхойлолтоор тогтоодог нийтлэг жишиг тогтожээ.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 79 дүгээр зүйлийн 79.2-т "хэргийг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий баримт сэлт, мэдээлэл нь гэрч, хохирогч, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн мэдүүлэг, шинжээчийн дүгнэлт, мэдүүлэг, эд мөрийн баримт, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүх хуралдааны тэмдэглэл болон бусад баримтаар тогтоогдоно" гэжээ. Өөрөөр хэлбэл, Эрүүгийн байцаан шийтгэх хуульд эд зүйлийн үнэлгээг эд зүйлийн үнэлгээний комисс хийнэ гэсэн зохицуулалт байдаггүй бөгөөд байх ч шаардлагагүй юм. Эд зүйлийн үнэлгээний комисс нь хуучин социализмын үед байсан бөгөөд энэ үеэс хойш шинээр хууль батлагдсан, мөн хуульд хэд хэдэн удаа нэмэлт өөрчлөлт орсон байхад хуучин тогтоогоогч хэрэгжүүлсээр байгаа дүгнэлт хийх шаардлагатай байна. Эд зүйлийн үнэлгээг хуультай нийцүүлэн шинжээч хийж, шинжээчийн дүгнэлт гаргах ёстой.

Гэтэл одоо үнэлгээ тогтоож байгаа комисс нь ямар байлаар, ямар хуцаахыг зах зээлийн ханшаар үнэлгээ тогтоодог нь ойлгомжгүй, ямар аргачиллаар хэрхэн үнэлгээ тогтоодог нь тодорхойгүй зөвхөн хийсвэрээр үнэлдэг байна. Ялангуяа эд зүйл нь алдагдсан, олдоогүй тохиолдолд бүр ч хийсвэрээр үнэлдэг болох нь хэнд ч тодорхой бэлэг. Учир нь хууль сануулж гарын үсэг

зуруулаагүй, хариуцлага тооцох механизм байхгүй, тодорхой эрх, үүхэг хүлээдэггүй тул үнэлгээнд зүгээр л үзэмжээрээ үнэлдэг практик манайд хэвшсээр олон жилийн нүүр үзэж байна. Хуульчид бид цаашдаа ингэж хуулиасаа хоцрогдсон, хуульд байхгүй аргаар эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулж болохгүй бөгөөд үүнийг өөрчилж хууль зүйн дагуу болгох цаг үе нэгэнт иржээ.

Үүнийг засахад тийм ч хэцүү бид бөгөөд дээр дурдсанаар Шүүхийн шинжилгээний үндэсний төвийн Шүүх нягтлан бодох бүртгэлийн магадлах товчоо нь шүүх, прокурор, цагдаагийн мөрдөн байцаах болон хэрэг бүртгэх алба зэрэг хуулийн байгууллагуудаас ирүүлсэн тогтоол, захирамжийн дагуу ач ахуйн нэгж, байгууллага, иргэдэд холбогдох өмчийн болон татварын холбогдолтой хэргийн талаарх маргаантай асуудалд магадлагаа хийж дүгнэлт гаргах үндсэн үүрэгтэйгээр ажилладаг бөгөөд нэгэнт байгаа тус товчоонд эд хөргөнийг үнэлэх чиг үүргийг өгөхөд болохгүй гэх газаргүй гэж бодож байна.

Түүнчлэн хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч нь эд хөргөнд үнэлгээг хийлгүүлэхэд шинжээчийн нэр засаан шинжээч томилж тухай тогтоол үйлдэж, хууль сануулдаг практикийг хуульд нийцүүлэн хийж хэвхэши шаардлагатай байна.

Эд зүйлийн үнэлгээг зөв тогтоохын хууль зүйн ач холбогдол нь хэр их болох талаар бид дээр дурдсан билээ.

Гэмт хэргийн зүйлчлэл, цаашилбал хүний хувь заяаг бүрэн шийдвэрлэж чадах энэ том үйл ажиллагааг хуульчид бид зөвхөн хуульдаа нийцүүлэн хийх хэрэгтэй бөгөөд хэрвээ зөв гольдролд нь оруулахгүй бол цаана нь хүний эрх, эрх чөлөө хохирсоор байх болно гэдэг нь тодорхой билээ.

Татвар, гаалийн байцаагчийн акт болон мэргэжлийн хяналтын байцаагчийн акт

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 79 дүгээр зүйлийн 79.2-т "хэргийг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий баримт сэлт, мэдээлэл нь гэрч, хохирогч, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн мэдүүлэг, шинжээчийн дүгнэлт, мэдүүлэг, эд мөрийн баримт, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүх хуралдааны тэмдэглэл болон бусад баримтаар тогтоогдоно" гэжээ.

Гэтэл татвар, гаалийн байцаагчийн акт, мэргэжлийн хяналтын байцаагчийн акт зэрэг нь

хууль сануулсны үндсэн дээр үнэн зөв гаргах үүрэг хүлээсэн шинжээчийн дүгнэлт бий бөгөөд дагараа нотлох баримт болохгүй. Эдгээр нь мөн хуулийн 166 дугаар зүйлийн 166.1.2-т "гэмт хэрэг гарсан талаар ач ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан мэдээлсэн" мэдээлэл юм.

Татварын байцаагчийн акт, мэргэжлийн хяналтын байцаагчийн акт зэрэг нь эдгээр байгууллагын эрх бүхий албан тушаалтнуудаас төрийн байгууллагын чиг үүргээ хэрэгжүүлэх явцада шалгалт хийсний үйлдлийг илрүүлж улмаар эрх бүхий байгууллагаар шалгуулахаар өгч байгаа мэдээлэл юм. Өөрөөр хэлбэл, эдгээр байгууллага нь энэ тохиолдолд хөндлөнгүйн байр суурьтай байж чадахгүй байдаг.

Тиймээс эдгээр акты үндэслэн хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч шинжээч томилж тогтоол үйлдэж шинжилгээний байгууллагаар дүгнэлт гаргуулахаар холбогдох баримтуудыг шилжүүлэх нь зүйтэй бөгөөд ингэж байж хүний эрх бүрэн хангагдах болно.

Талууд харилцан тохиролцох

Эд хөрөнгийн хохирлын хэмжээг тогтоодог талууд харилцан тохиролцох ойлголт байж болохгүй бөгөөд харин хохирол нөхөн төлүүлэх асуудалд талууд хохирлын хэмжээг харилцан тохиролцох замаар тогтоож, улимаар хохирлол төлүүлж болдог. Эд хөрөнгийн хохирлыг тогтоох нь гэмт хэргийн зүйлчлэлд асар их нөлөөтэй бөгөөд хохирлын хэмжээг ялгамжтай тогтоох нь хүн бүр шүүхийн өмнө эрх тэгш байх зарчимтай харшлах тул хохирлын хэмжээг гагцхүү бодитоор тогтоох шаардлагатай.

Зардлын баримтаар тогтоох

Эд хөрөнгийн хохирол учирсан зарим тохиолдолд зардлын баримтаар хохирлыг тооцож нөхөн төлүүлж болно. Тухайлбал, зам, тээврийн ослын гэмт хэргийн улмаас автомашины эд анги, салбегүүд нөхөн сэргээгдэх боломжгүйгээр эвдрэсэн тохиолдолд хохирогч шинээр авахын гулд зардлын баримт бүрдүүлэх шаардлага гарна. Мөн шинээр гар утас худалдаж аваад хугалд алдсан бол худалдаж авсан баримтаар энэ үнэлгээг тогтоож болдог бөгөөд энэ тохиолдолд заавал үнэлгээ хийлгэх шаардлагатай юм.

Байгууллагын дансанд тусгагдсан үнэлгээ

Ач ахуйн нэгж, байгууллагын эд хөрөнгөд учирсан хохирлын үнэлгээг тогтоох бас нэг арга нь байгууллаагын

нь дансанд хэрхэн үнэлэгдэж байгаагаар нь үнэлгээ хийх явдал юм. Гэхдээ энд анхаарах нэг асуудал бол аж ахуйн нэгж, байгууллага нь эд хөрөнгийн үнэлгээгээ жил бүр шинэчлэн тогтоосон эсэхийг анхаарах хэрэгтэй. Тэр үнэлгээ нь эд хөрөнгийн элэгдэл, хоргодол зэрэгт үндэслэгдсэн байх ёстой. Хэрвээ үнэлгээгээ шинэчлээгүй бол түүнийг шууд эд хөрөнгийн үнэлгээ гэж авч болохгүй. Учир нь гэмт хэргийн хохирлыг зах зээлийн үнэлгээгээр хийх нь зүйтэй.

Даатгалын үнэлгээ:

Хохирогч эд хөрөнгөө даатгуулсан тохиолдолд даатгалын сангаас хохирлоо нөхөн төлүүлэх боломжтой байдаг. Энэ тохиолдолд даатгалын баримтаар Үнэлгээг тогтоож болдог.

Хохирлыг нөхөн төлүүлэх ажиллагаа

Хохирлыг нөхөн төлүүлэх ажиллагаа нь хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд сэжигтэн, яллагдагчийн хувьд сайн дурын шинжтэй байдаг. Өөрөөр хэлбэл энэ шатанд түүний хувьд гэм буруутай нь нотлогдоогүй байдаг тул хэрэгээ сэжигтэн, яллагдагч гэм буруугаа ухамсарласан болон хохирогчийг энэрч өөрсдөн сэтгэлээр сайн дураараа хохирол төлж болдог.

Шүүхийн шийдвэр гарахаас өмнө хохирлыг сайн дураараа төлсний хууль зүйн үр дагавар нь:

- гэмт хэрэг үйлдэж учруулсан хохирлоо сайн дураараа нөхөн төлсөн буюу гэм хорьн нөхөн төлсөн бол ял шийтгэлийг хөнгөрүүлэх нөхцөл байдал тооцооноор⁶,

- хүндэтгэр гэмт хэрэг үйлдэж анх удаа хорих ял шийтгүүлсэн этгээд учруулсан хохирлоо нөхөн төлсөн буюу гэм хорьг арилгасан тохиолдолд түүнд оноосон хорих ялыг тэнсэж болохоор⁸,

- хөнгөн гэмт хэрэг үйлдсэн этгээд учруулсан хохирлоо бүрэн төлсөн буюу гэм хорьг арилгасан бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлж болохоор⁹,

- хорих ялаар шийтгүүлж,

ялынхаа тодорхой хувийг эдэлсэн этгээд учруулсан хохирлоо нөхөн төлсөн буюу гэм хорьг арилгасан бол түүнийг ял эдлэхээс хугацаанаас нь өмнө тэнсэн суллаж болох¹¹ зэрэг болно.

Сэжигтэн, яллагдагч нар хохирлыг сайн дураараа нөхөн төлөхөөс гадна хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчаас хохирлыг нөхөн төлүүлэхээр хуульд заасан арга хэмжээг авсан байх шаардлагатай. Үүнд:

- эд хөрөнгө барьцаалал (сэжигтэн, яллагдагч нь дуудсан цагт саадгүй ирж байх үүргийг өөрөө хүлээж, өөрийнхөө эд хөрөнгийг барьцаалсан бол),

- эд хөрөнгө захиран зарцуулах эрхийг хязгаарлах,

- аж ахуйн нэгж, байгууллага, иргэний эд зүйл, эд хөрөнгө, мөнгө агуулсан байр савыг битүүмжлэх зэрэг ажиллагаа хамаарна.

Өнөөгийн практикт хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчаас эхнүү ажиллагаануудыг хангалттай хийж гүйцэтгэхгүй байгаа, Ихэвчлэн онц дуулиантай, хохирол иктэй хэргүүдэд л хийж байгаа нь нууц биш юм.

Түүнчлэн иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагчийг тухай бүрд нь тогтоохгүй орхих, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч нарын болон иргэний хариуцагчийн хөрөнгийг олж илрүүлэн, шаардлагатай үед цаг алдалгүй битүүмжлэн нэхэмжлэлийг хангах арга хэмжээ авахгүй байх зөрчлүүд байсаар байна.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын үнийг нарийвчлан тогтоолгүйгээр зөвхөн хохирогч, иргэний нэхэмжлэгч нарын үнэлсэн үнийг үндэслэн үнийг тогтоох, иргэний нэхэмжлэгч шүүх хуралдаан хүртэл эрүүгийн байцан шийтгэх ажиллагааны аль ч үе шатанд иргэний нэхэмжлэл гаргах эрхтэй болохыг тайлбарлан өгөхгүй орхигдуулах, нотлох баримтын шаардлага хангахгүй материалыг хэргээ үдэх зэрэг дутагдал гарсаар байгаа билээ.

2005 онд улсын хэмжээгээр анхан шатны шүүхээр 6966 хэргийн 10153 шүүгдэгч ял шийтгүүлжээ.

Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд 241 хэргийн 335 сэжигтэн, яллагдагчийн хөрөнгийн байдал, төлбөрийн чадвартай тогтоох ажиллагаа хийгдсэн байна. Энэ нь нийт шүүхээр шийтгүүлсэн шүүгдэгчийн тоотой харьцуулбал 3.3 хувийг, нийт шүүхээр шийдвэрлэгдсэн 6966 хэргээс 241 хэрэгт сэжигтэн, яллагдагчийн хөрөнгийн байдлыг тогтоосон нь 3.4 хувьтай гэсэн тоо гарсан нь хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд хохирол нөхөн төлүүлэх хуульд заасан арга хэмжээ болон торгуулийн ялын биелэгдэх байдлыг тогтоож байх хуулийн заалтуудыг хэрэгжилт туйлын хангалтгүй байна гэсэн дүгнэлтэд хүргэлээ¹².

Харин хэргийг шүүх хуралдаанаар хянан хэлэлцээд гарсан шийдвэр нь заавал биелэгдэх шинжтэй албадлага болж хувирдаг.

Шүүх хохирлыг төлүүлэхдээ гэм хор учруулахаас өмнөх байхад нь сэргээх /адил нэр, төрөл, чанарын эд хөрөнгө өгөх, гэмтсэн эд хөрөнгийг засах зэргээр/ буюу учирсан хохирлыг мөнгөөр төлүүлэхээр¹³ шийтгэх тогтоолдоо тусгана.

Эд хөрөнгийн хохирлыг нөхөн төлүүлж байгаа шүүхийн практикт эд хөрөнгийн хохирлыг төлүүлэхэд шийтгэх тогтоолдоо дурдахдаа хуулийн зүйл, заалтыг тодорхой дурдахгүй байх, шүүгдэгчийн гэм буруугаас хэдий хэмжээний хохирол учирсан, тэр нь ямар баримтаар нотлогдож байгааг тодорхой заахгүй байх, шүүх хуралдаанд иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, гурвавдагч этгээд, хамтран хариуцагчийг татан оролцуулдаггүй явдал давтан гарч байна¹⁴.

Гэмт хэргийн улмаас хохирсон хүн хохирсон чигээрээ үлдэх нь тэдний нийгэмд буюу ялангуяа хуулийн байгууллагад хандах хандлагад сөргөөр нөлөөлдөг. Хуулийн амилтнууд хохирогчийн сэтгэл зүй ойлгогдоггүй, мэдлэг дутагдсан болон мэдрэмжтэй бус хандлагууд нь дээр дурдсан сөргө нөлөөлүүдийг ихэсгэж байна.¹⁵

⁶ Монгол Улсын Эрүүгийн хуулийн 55 дугаар зүйлийн 55.1.2, 55.1.3, 55.1.55.1.10 дахь заалт

⁷ Монгол Улсын Эрүүгийн хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1 дэх заалт

⁸ Монгол Улсын Эрүүгийн хуулийн 70 дугаар зүйлийн 70.1, 71 дүгээр зүйлийн 71.1

⁹ Монгол Улсын Эрүүгийн хуулийн 74 дүгээр зүйлийн 74.1 дэх заалт

¹⁰ 2006 онд Улсын Ерөнхий прокурорын газраас "Торгуулийн ялын биелэлт"-ийн талаар хийсэн судалгааны илтгэх хуудаснаас

¹¹ Иргэний хуулийн 510 дугаар зүйлийн 510.1 дэх заалт

¹² Даваадорж.Г. "Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлж байгаа шүүхийн практик" сэдэвт магистрийн дипломын

ажил. 2003 он. 10 дахь тал

¹³ Эрх зүйн шинэтгэл-2002 он. № 3

Гэр бүлийн тухай хуулийн 25.1-д заасны дагуу "Хүүхэд гэр бүлийн дотор тэгш эрх эдэлнэ" гэж заасны дагуу анхан шатны шүүхээр гэрлэлт цуцлуулахад хамтад нь гэр бүлийн хамтран өмчлөх эд хөрөнгийг цугт нь шийдвэрлэсэн байгаа бөгөөд үүний 25 шийдвэрээр маргаантай эд хөрөнгийг цэгц, эх, хүүхдэд тэнцүү хуваасан нь энэ заалт бодитой хэрэгжиж байгаагийн нэгэн илрэл юм.

Нийт гэрлэлт цуцлахтай холбоотой маргааны хүүхдийн насны байдлыг харгалзан үзвэл 305 буюу 36.5 хувь нь 1-3 насны буюу бага насны хүүхэдтэй байна.

Гэр бүлийн тухай хуульд "Гэрлэгчид... хүүхдээ хэний асрамжид үлдээх, түүнийг болон хөдөлмөрийн чадваргүй эхнэр, нөхрөө тэжээн тэтгэх, хамтран өмчлөх дундын эд хөрөнгө хуваах тухайгаа тохиролцож болно" гэж заасан нь талууд гэрээгээр үг харилцааг зохицуулж болох буюу Иргэний хуульд заасан гэрлэгчдийн эд хөрөнгийн эрхийн гэрээ байгуулж болно гэсэн заалтыг баталгаажуулсан байна.

Анхан шатны шүүхээр шийдвэрлэсэн хэрэгт гэрлэгчид эд хөрөнгийн эрхээ гэрээгээр зохицуулсан тохиолдол нэг ч гараагүй байна.

Харин 2007 онд зарим дүүргийн шүүхээр шийдвэрлэсэн гэр бүлийн маргаанд гэрлэгчид эд хөрөнгийн гэрээг байгуулсан байгаа нь гэрлэгчдийн дунд эд хөрөнгийн гэрээ ямар ач холбогдолтой болохыг анхаарч буйн нэгэн илрэл юм.

Давж заалдах шатны шүүхийн 17 магадлалын 9 /53 хувь/ нь гэрлэлт цуцлуулахтай хамт хамтран өмчлөх дундын эд хөрөнгө хуваахыг хүссэн маргаантай асуудал байна.

Давж заалдах шатны шүүхийн магадлалаар анхан шатны шүүхийн шийдвэрийг:

Анхан шатны шүүхэд буцаасан 9 (52.8 хувь),

Анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр баталсан 4 (23.6 хувь),

Анхан шатны шүүхийн шийдвэрийг өөрчилсөн 1 (5.9 хувь) /Гэр бүлийн тухай хуулийн 40.1.1, 40.1.2 гэж/.

Анхан шатны шүүхийн шийдвэрийг хэрэгсэхгүй болгосон 3

(17.7 хувь) байна.

Энд хамтран амьдрагсдын талаар цухас авч үзэх хэрэгтэй болов уу. Иргэний хэргийн 32 буюу 0.57 хувийг хамтран амьдралтай байсныг тогтоолохыг хүссэн нэхэмжлэл эзэлж байгаа нь тэдний хувьд нэг хууль ёсны ашиг сонирхолтой, хууль ёсны үр дагавартай байсан учраас шүүхэд хандсан болов уу гэсэн дүгнэлтэд хүргэж байна.

Хамтран амьдрагсдын дунд эд хөрөнгийн харилцаатай холбоотой маргаан гарвал хууль ёсны гэр бүл биш гэсэн шалтгаанаар нэхэмжлэлийн шаардлагыг биелүүлэхгүй биш харин Иргэний хуулийн дундын өмчийн ерөнхий зохицуулалтыг баримтлан шийдэх нь зохимжтой. Иймээс хамтран амьдрагсад гэрлэлтээ хууль ёсны болгох, эд хөрөнгийн гэрээг байгуулах шаардлага урган гарч байна.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль батлагдсан гарснаас хойш хүчирхийлэл үйлдэгчийн эрхийг хязгаарлах арга хэмжээ нийт 30 хүнд авсан бөгөөд үүний 5 буюу 16.6 хувьд нь хамтран өмчлөх дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулахыг хориглосон байна.

Гэрлэгчдийн эд хөрөнгийн маргааныг шийдвэрлэхдээ Иргэний хуулийн 129 дүгээр зүйлийн 129.4 ".... гэр бүлийн гишүүнд ногдох эд хөрөнгийн хэсгийг тодорхойлохдоо гэр бүлийн хамтран өмчлөх дундын эд хөрөнгө бий болоход оруулсан түүний хөдөлмөрийн оролцоо, хөрөнгийн хэмжээг харгалзан багасгах, эсхүл олгохгүй байхаар шүүх шийдвэрлэж болно" гэсэн заалтыг баримтлан шийдвэрлэсэн шийдвэр байхгүй нь энэхүү зүйл хэрэглэх шаардлага гарахгүй байна уу эсвэл хэрэглэж чадахгүй байна уу гэсэн асуулт гарч ирж болох юм. Эдгээрээс дүгнэвэл:

1. Гэр бүлийн тухай хуулийн зорилт гэсэн 1 дүгээр зүйлд "Гэр бүлийн тухай хууль тогтоомжийн зорилт нь" гэж заагаагүй харин "энэ хуулийн зорилт нь...." гэж заасан учраас гэр бүлийн гишүүдийн эд хөрөнгийн харилцааг Иргэний хуулиар бус Гэр бүлийн тухай хуулиар бүхэлд нь зохицуулах, одоо Иргэний хуульд байгаа гэр

бүлийн хөрөнгийн эрхийн тухай зохицуулалтыг бүхэлд нь Гэр бүлийн тухай хуульд оруулах шаардлагатай юм.

2. Гэр бүлийн тухай хуульд гэр бүлийн эд хөрөнгийн харилцааны зохицуулалт гэж заасан мөртлөө Иргэний хуульд гэр бүлийн хөрөнгийн эрх гэж оруулсан нь хуулийн нэр томъёог жигдрүүлэх шаардлагатайг харуулж байна. Иргэний хуульд заасан гэр бүлийн хөрөнгийн эрх гэдгийг гэр бүлийн эд хөрөнгийн эрхийн харилцаа гэж өөрчлөн найруулах нь зүйтэй болов уу.

3. Иргэний хуулийн 125 дугаар зүйлийн 125.1 дэх хэсэгт "гэр бүлийн хөрөнгө нь гэрлэгчдийн, гэр бүлийн бусад гишүүний хөрөнгөөс бүрдэнэ" гэж заасан. Энд гэр бүлийн бусад гишүүн гэдэгт хэн орох ёстой вэ? гэсэн асуулт гарч байна. Өөрөөр хэлбэл, гэр бүлийн бусад гишүүн гэдэгт ийм этгээд орно гэж Иргэний хууль хийгээд Гэр бүлийн тухай хуульд заагаагүй. Гэр бүлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх хэсэгт гэр бүлийн гишүүн гэдгийг тодорхойлж-өгснөөс бус гэр бүлийн бусад гишүүн гэсэн томъёоллыг оруулаагүй. Иймд гэр бүлийн гишүүн, гэр бүлийн бусад гишүүн гэдэг ойлголтууд нь ижил ойлголт мөн эсэх, хэрэв тийм бол тэдэргийг хууль тогтоомжид нэг нэр томъёогоор оруулж жигдрүүлэх нь зүйтэй юм. Хэрэв алгаатай бол тэд гэр бүлийн эрх зүйн эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус харилцаанд чухам ямар эрх эзлж, үүрэг хүлээх талаар нарийвчлан заах нь чухал.

4. 2004 онд батлагдсан Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2-д "Энэ хуулийн зохицуулалтад гэрлэлтээ хуульд заасны дагуу төрийн эрх бүхий байгууллагад бүртгүүлээгүй боловч хамтын амьдралтай байгаа хүмүүс, түүнчлэн Гэр бүлийн тухай хуульд заасны дагуу хүүхдийг гэр бүлдээ авч хүмүүжүүлсний, эсхүл асран хамгаалагч, харгалзан дэмжиж тогтоосны үр дүнд тухайн иргэний асрамжид байгаа этгээд нэгэн адил хамаарна" гэж заасан хамтран амьдрагсдын харилцааг зохицуулсан цорын ганц эх сурвалж гэж үзэж болохоор байна.

Ийм учраас Иргэний

амьдрахтай холбогдсон харилцааг зохицуулсан зохих зүйл, заалтыг холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлтөөр оруулах шаардлагатай байна.

5. Төрөөс "Эх, хүүхдэд тэтгэмж олгох, хүүхэд, гэр бүлд мөнгөн тусламж үзүүлэх тухай" хууль батлагдсан нь хамтран амьдрагчид болон гэрлэлтээ бүртгүүлээгүй гэр бүлийг төрийн эрх бүхий байгууллагад бүртгүүлэх арга хэмжээ авсан эрх зүйн ач холбогдол бүхий ажиллагаа юм.

6. "Эх, хүүхдэд тэтгэмж олгох, хүүхэд, гэр бүлд мөнгөн тусламж үзүүлэх тухай" хуулийн 9 дүгээр зүйлд хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагын талаар заасан. Энэ зүйлд "хуурамч баримт бичиг бүрдүүлэх, худал мэдээлэх зэргээр энэ хуульд заасан тэтгэмж, тусламж тогтоолгосон гэм буруутай этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол улсын байцаагч 10.000-50.000 төгрөгөөр торгону" гэж заажээ. Торгох мөнгөн дүнг хөдөлмөрийн хөлсний дорд хэмжээгээр хэмжих хэрэгтэй болов уу.

Гэтэл энд Гэр бүлийн тухай

хуульд заасны дагуу гэрлэгчид нь тэгш эрх, сайн дурын үндсэн дээр гэрлэлгүй зөвхөн төрөөс олгож буй нэг удаагийн тусламж авах зорилгоор гэр бүл болоод уг тусламжийг авсныхаа дараа гэрлэлтээ цуцлуулах тохиолдол гарч болохыг үгүйсгэх аргагүй юм. Энэ тохиолдолд нөгөө тэтгэмж, тусламж нь нийгэмд үүргээ гүйцэтгэж чадахгүйд хүрэх талтайг анхаарах хэрэгтэй юм. Өөрөөр хэлбэл, төр өгч чадсан бол тухайн гэрлэгчдийн аль нэг нь Гэр бүлийн тухай хуульд заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд эргээд тэднээс авч чаддаг байх ёстой болов уу.

"Хуурамч баримт бичиг бүрдүүлэх, худал мэдээлэх зэргээр" уг хуульд заасан тэтгэмж, тусламж тогтоолгосон тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэж болохоор байна. Гэтэл Эрүүгийн хуульд яг энэ тохиолдлын зүйлчлэлийг тусгаагүй байгаа билээ. Иймд энэ тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэх ямар ч боломжгүй байгаа тул уг хуульд заасан "...эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол" гэсэн хэсгийг хасах эсхүл энэ талаар Эрүүгийн

хуульд нэмэлт зохицуулалт оруулах шаардлагатай юм.

7. Иргэний хуулийн 129.3, 129.4-д заасныг нэг мөр ойлгох талаар Улсын дээд шүүхээс тайлбар гаргах шаардлагатай байна.

8. Шүүхээс гэрлэгчдэд хамтран өмчлөх дундын эд хөрөнгийг өмчлөх эрхийг бусдад шилжүүлэх, худалдах, бэлэглэх, захиран зарцуулахыг хориглох урьдчилсан арга хэмжээг авч байх нь "гэрлэгчид нь гэр бүлийн дотор тэгш эрх эдэлж, адил үүрэг хүлээнэ" гэсэн заалт бодитой хэрэгжихийн үндэс, мөн Иргэний хуульд заасан өмчлөгчийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах ач тустай.

9. Хамтран амьдрагсад болон шинээр гэр бүл болж буй хүмүүст гэрлэгчдийн эд хөрөнгийн ойлгуулах ач холбогдол, үр нөлөөг ойлгуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

10. Хүүхдэд тогтоосон тэтгэлэг болон хамтран өмчлөх эд хөрөнгийг тэнцүү хуваасан хөрөнгийг тухайн хүүхдэд хүрч байгаа эсэх, хэрхэн үр дүнтэй захиран зарцуулж байгаад хяналт тавих механизмг бүрдүүлэх.

МОНГОЛ УЛСЫН ИРГЭНИЙН ХУУЛИЙН ТАЙЛБАР (Ерөнхий анги)

ХЭВЛЭГДЭН ГАРЛАА

5 ШИРХГИЙГ ХУДАЛДАН АВБАЛ

ШИРХГИЙГ БЭЛЭГ

НЭГ БҮРИЙН
ҮНЭ: **25000** ТОГРОГ

УТАС: 317494, 319144
ФАКС: 315735, 315789

**ХУУЛЬ ЗҮЙН
ҮНДЭСНИЙ ТӨВ**

СЭТГЭЛ САНААНЫ ГЭМ ХОРЫН ТУХАЙ ОЙЛГОЛТ БУЮУ ГҮТГЭЛЭГ, НЭР ТӨР ГУТААХ АСУУДЛЫН ТАЛААРХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Аливаа улсын улс төр, нийгэм, эдийн засаг дахь өөрчлөлт, шинэчлэл нь эцсийн дүндээ хууль болон эрх зүйн бусад актаар дамжин илрэлээ олдог билээ. Хууль бол нийгмийг хөдөлгөгч хүч. Харин тэрхүү хөдөлгөгч хүчийг залан жолоодох эсэх тухайн нийгмийн эд эс болсон хүн. Энэ үүднээс нь авч үзвэл эрх зүйт төрийн мөн чанар нь хүнийхээ эрх, эрх чөлөөг хэрхэн баталгаажуулан хамгаалсанаас ихээхэн хамааралтай гэж хэлэх байна.

1992 онд батлагдсан Монгол Улсын шинэ Үндсэн Хуульд хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг ард түмний өмнө тавигдсан эрхэм зорилго хэмээн тунхагласан. Энэ утгаараа эрх зүйт төрийн хамгийн гол зарчим бол хүний эрх, эрх чөлөөг өндөр түвшинд хангах явдал юм гэдгийг бүх нийтээр хүлээн зөвшөөрсөн явдал юм.

Олон улсын эрх зүйн хэм хэмжээнд Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Иргэний болон улс төрийн эрхийн тухай Пакт зэрэг буюу товчхондоо олон улсын Хүний эрхийн Биллд хүний үндсэн эрх, эрх чөлөөг хангахын зайлшгүй шаардлагыг заасан байдаг. Монгол Улсын Үндсэн хуульд хүний хувийн амьдрал, эрүүл мэнд, нэр төр, алдар хүндийг хүний үндсэн эрх, эрх чөлөөний нэг бүрэлдэхүүн хэсэг хэмээн тодорхойлж хамгаалахаар заасан байна. Эрх зүйт төрийн чухал зорилтуудын нэг бол иргэнийхээ зөрчигдсөн эрхийг аль болох шуурхай, шударга байдлаар сэргээх, учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх механизмыг боловсронгуй болгон хэрэгжүүлэх явдал юм.

Иймээс өнөө цаг үед тулгамдсан асуудлын нэг болоод байгаа хүний сэтгэл санааны материаллаг бус гэм хор буюу нэр төр гутаах, гүтгэх гэмт хэрэг



Хууль зүй, дотоод хэргийн яамны мэргэжилтэн
Ш.ҮНЭНТӨГС

үйлдэх явдал, түүнийг арилгах, нөхөн төлүүлэх эрх зүйн харилцааны талаар цогцоор нь авч үзэх шаардлага гарч байна.

Сэтгэл санааны гэм хорын тухай ойлголт, хууль тогтоомжид тусгагдсан байдал

Нийгмийн харилцаа улам бүр өргөжин, хөгжин дэвжихийн хэрээр бидний өдөр тутмын амьдралд санаа сэтгэл зовох, шаналах болон элдэв зовиур амсах зэрэг явдал ихээхэн тохиолддог. Ийнхүү ямар нэг байдлаар эрх нь зөрчигдсөний улмаас хүний материаллаг бус оюун санааны хүрээнд гарч байгаа сөрөг өөрчлөлт, үр дагавар, материаллаг бус баялаг нь учирч буй гэм хорыг арилгах механизмыг оновчтой бүрдүүлэх, хуулийн хүрээнд зөв зохицуулалт хийх шаардлагатай байдаг.

Монгол Улсын Үндсэн хуульд хүний эрх, нэр төр, алдар хүндийг хуулиар тогтоон хамгаалахаар заасан бөгөөд мөн иргэд нь хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхолыг нь хүндэтгэхээр хуульчилсан нь уг харилцаа Үндсэн хуулийн зохицуулалтын объект

болж, Иргэний хууль, Эрүүгийн хууль болон холбогдох бусад хуулиар зохицуулагдаж байна.

Энэ утгаараа тус асуудал нь хүний эрх, эрх чөлөөтэй холбогдох туйлын их анхаарал татаж байгаа асуудал хэдий ч одоогоор энэ талаар манайд цөөхөн хэдэн судлаачийг эс тооцвол өөр төдийлөн нухацтай судалсан, хууль тогтоомжид нарийвчлан тусгасан зүйл бага гэж хэлж болох байна.

Энэ талаар доктор С.Нарангэрэл "Гэм хор гэж иргэний эрх зүйд иргэний субьектив эрх буюу баялгийг багасгах, устгахыг хэлнэ. Хууль зүйн нэм зохиол, шүүхийн практикт "хохирол" гэсэн нэр төмбөг хэрэглэдэг. Гэм хор ба хохирол гэсэн нэр төмбөг нь хоорондоо яг нийцдэггүй. Гэм хор нь нэлээд өргөн хүрээтэй ухагдахуун бөгөөд эд хөрөнгийн ба эд хөрөнгийн бус гэж хуваагдана. Эд хөрөнгийн гэм хор гэдэгт үнэлгээний хэлбэр бүхий эрх зүйн зөрчлийн материаллаг /эдийн засгийн/ үр дагаварыг ойлгоно. Эд хөрөнгийн гэм хорын мөнгөн үнэлгээг хохирол гэж нэрлэнэ. Эд хөрөнгийн бус буюу ёс суртахууны гэм хор гэж бусад этгээдийн хууль бус үйлдлийн /жишээ нь гутаасан мэдээ сэлт тараах замаар хувийн алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг доройтуулах, хувийн амьдралд хөндлөнгөөс оролцох зэрг/ улмаас учирсан зэд суртахууны ба бие махбодийн зүдвүр шаналал" гэж тодорхойлсон байна.

Харин доктор Д.Наранчимэг: Гэм хор нь иргэний эрх зүйн хариуцлага үүсэх нэг нөхцөл мөн. Гэм хор нь субьектын амин хувийн эрх болон эд хөрөнгийн эрхийг зөрчсөн явдлаар илэрдэг гээд гэм хорыг материаллаг ба материаллаг бус гэж ангилсан байна. Материаллаг бус гэм хорыг дотор нь: - хүний амьн нас хохироосон, - хүний эрүүл мэндийг сарниулсан, -хүний нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан гэж ангилалт хийжээ".

¹ Нарангэрэл С. Эрх зүйн эх толь бичиг. УБ; 2007 он

² Наранчимэг Д. Иргэний эрх зүйн үндсэн асуудал. УБ; 1999 он

Мөн доктор Т.Мөнхжаргал Хохирол бол хариуцлага хүлээлгэх гэж нөхцөл юм. Иргэний хууль болон бусад хууль тогтоомжид хохирол эд хөрөнгийн ба эд хөрөнгийн бус шинжтэй болохыг заасан, мөн тэр нь эрх зөрчигчийн ямар нэг үйлдлээр үүсч, ямар нэг хэлбэрээр илрэх байдлыг ойлгоно. Үүрэг гүйцэтгүүлэгчээс гарсан зардал, эд хөрөнгийн зардал буюу гэмтэл, үүрэг хүлээгч үүргээ гүйцэтгэсэн бол үүрэг гүйцэтгүүлэгчид орох байсан орлогыг хохиролд тооцно³ гэж эд хөрөнгийн хохирлыг тодорхойлсон. Харин бусдын нэр, төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ тараасан явдал нь⁴ эд хөрөнгийн бус хохирол гэж тодорхойлсон байна⁵.

Түүнчлэн Монгол Улсын Иргэний хуулийн тайлбарт: "Хохирол гэж хэл ярианы хэвшсэн нийтлэг утгаар хэн нэгэн этгээд ямар нэг үйлдлийн үр дүнд өөрийн амьжиргааны зүйлээр, тухайлбал, эрүүл мэнд, өмч хөрөнгө, нэр төр, алдар хүнд, эсхүл чадвар чадвахиараа хохирол амсахыг ойлгодог. Эрх зүйн нөхөн арилгахуйц хэмээн үзэж болох гэм хор, хохирлын үрээд өмч, эд хөрөнгийн холбогдолтой, өмч, эд хөрөнгийн холбогдолгүй хэмээн ангилж үзнэ. Эдийн бус гэм хор учирсан гэж үзвэл уг гэм хорыг гагцхүү эдийн бус хэлбэрээр буюу уг мэдээг няцаалгах, мөнгөн хэлбэрээр нөхөн төлүүлж болдог"⁶, гэж тус тус тодорхойлсон байна.

Мөн оросын иргэний эрх зүйн чиглэлээрх бүтээлд "Гэм хор гэдэг нь аливаа эд хөрөнгийн эрх эсхүл материаллаг бус баялагт халдсан болон зөрчигдсөн байдлыг ойлгоно. Эд хөрөнгийн бус хохирлыг – бие махбодийн хохирол, "ёс суртахууны хохирол гэж хуваадаг"⁷ гэсэн байдаг. Мөн манай Хууль зүйн тайлбар толинд Гэм хор гэдэг нь бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, эд хөрөнгийн бус ашиг сонирхолд учирсан хохирол⁸ гэж тодорхойлсон байдаг.

Японы эрх зүйн тайлбарт Гэм хор буюу сэтгэл санааны хохирол гэж зөрчил гаргасан, гэм буруутай этгээдийг шийтгэх зорилгоор гомдол гаргагчид шууд учирсан хохирлоос илүү хэмжээний мөнгөн төлбөр олгох шийдвэрийг шүүхээс гаргахыг хэлнэ"⁹ гэсэн байдаг.

Гэм хор гэж англиар - hart, оросоор – вред, учерб, германаар – schaden, nachteil, verletzung, verletzen гэж хэлдэг¹⁰.

Дээр дурдсан тодорхойлолтуудаас харахад гэм хор, хохирол гэдэг ойлголтууд нь агуулгын хувьд давхцаж байгаа нь харагдаж байна. Харин хууль тогтоомжид энэ талаар тусгасан байдлыг авч үзвэл:

1. Иргэний эрх зүйн харилцааны хүрээнд

Хүчин төгөлдөр мөрдөгдөж буй 2002 онд батлагдсан Иргэний хуулийн 227 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт "үүрэг гүйцэтгүүлэгчээс гарсан зардал, эд хөрөнгийн алдагдал буюу гэмтэл, үүрэг гүйцэтгэгч үүргээ гүйцэтгэсэн бол үүрэг гүйцэтгүүлэгчид зайлшгүй орох байсан орлогыг хохиролд тооцно" гэснээс үзэхэд хохирол гэдэгт хохирлоос зөрчигдсөн эрхээ сэргээхэд буюу эрх зөрчигдөөс өмнөх байдалд эргүүлж оруулахад шаардагдах зардал болон эрх зөрчигдсөний улмаас алдсан орлогыг тодорхойлсон гэж болох байна.

Харин Иргэний хуулийн 497- 514 дүгээр зүйлд гэм хор учруулснаас үүсэх үүргийн хариуцааг зохицуулсан байдаг. Хуулинд "гэм хор" гэсэн ойлголыг тодорхойлж өгөөгүй байгаа боловч гэм хор учруулснаас үүсэх үүрэг нь өөрөө гэрээний бус үүрэгт хамаарах учир гэм хор учирсан явдал нь талуудын хоорондын гэрээний бус харилцаанаас үүсэн гарсан эд хөрөнгийн болоод эд хөрөнгийн бус эрх зөрчигдсөний үр дагавар гэж ойлгож болно.

Тэгэхээр гэм хор, хохирол гэсэн ойлголтуудыг яг ижил

ойлголт гэж авч үзэх нь тийм ч оновчтой биш байна. Гэвч 2002 онд батлагдсан Иргэний хуулинд энэ ялгааг нилээд тод гаргаж өгсөн гэж болох бөгөөд уг хуулийн 227 дугаар зүйлийн 4 дахь хэсэгт зааснаас харахад хохирол бол гэрээний үүргээ биелүүлээгүйгээс нөгөө талд учирсан материаллаг зардал, олох байсан орлого юм. Харин уг хуулийн 228-229 дугаар зүйлд гэм хорыг арилгах ерөнхий нөхцөл, жуурийг тогтоосон бөгөөд өмнөх хуулийн ойлголтоос ялгагдах онцлог нь гэм хор арилгах үүрэг нь талууд хоорондоо гэрээний болон гэрээний бус харилцаанд байгаагаас үл хамааран үүсэхээр заажээ. Мөн хуулийн 230 дугаар зүйлд эдийн бус гэм хорыг арилгах талаар заасан бөгөөд Эдийн бус гэм хорыг зөвхөн хуульд тусгайлан заасан тохиолдолд мөнгөн хэлбэрээр нөхөн төлүүлж болох тухай заасан байна.

Иймээс Иргэний хуулийн заалтууд болон дээрх судлаачдын тодорхойлолтоос харахад гэм хор гэсэн ойлголт нь хохирол гэсэн ойлголтоос илүү өргөн утгатай бөгөөд түүнийг өөртөө багтаасан ойлголт гэж болох байна. Өөрөөр хэлбэл гэм хор нь **шууд материаллаг хохирол болон эдийн бус гэм хор буюу сэтгэл санааны эрх хор** гэсэн төрөлд хувааж болох юм.

Энэхүү ойлголтоор авч үзвэл хүнд учирсан эдийн бус буюу сэтгэл санааны гэм хорыг арилгах, нөхөн төлүүлэх эрх зүйн зохицуулалтын талаар тоймлох шаардлага урган гарч байна. Тухайлбал, Иргэний хуулийн 511 дүгээр зүйлд эдийн бус гэм хорыг арилгах тохиолдол, арга замыг зааж өгсөн. Уг зүйлийн 1 дэх хэсэгт "Бусдын нэр, төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ тараасан этгээд түүнийгээ бодит байдалд нийцж байгааг нотолж чадахгүй бол эд хөрөнгийн гэм хорыг арилгасныг үл харгалзан эдийн бус гэм хорыг мөнгөн болон бусад хэлбэрээр арилгах үүрэг хүлээн" гэж заасан байна. Өөрөөр хэлбэл, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ тараасан, хувийн нууцтай хамааралтай мэдээг өөрийн нь зөвшөөрөлгүй тараасан, өлдвээр дүрсэлж нийтэлсэн, улмаар олон нийтэд үзүүлсэн тохиолдолд

³ Иргэний хуулийн 227 дүгээр зүйл

⁴ Иргэний хуулийн 21 дүгээр зүйл

⁵ Мөнхжаргал Т. Иргэний эрх зүй, УБ, 1997 он

⁶ Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар, Ерөнхий анги, УБ, 2005 он

⁷ Гражданское право Том 3., М., 2000

⁸ Хууль зүйн тайлбар толь, УБ, 2003 он

⁹ http://en.wikipedia.org/wiki/japanese_law

¹⁰ Амарсанаа Ж. Олон улсын эрх зүйн толь, УБ, 2004 он

учирсан эдийн бус гэм хорыг нөхөн төлүүлж болохоор хуульчилсан, мөн гэм хорын даатгалыг шинээр оруулсан нь өмнөх зохицуулалтаас илүү нарийвчилсан шинжтэй болсон.

Нөгөөтэйгүүр энд анхаарах татаж буй зүйл бол Иргэний хуулинд Эдийн бус гэм хор гэдэгт яг юуг оруулж тооцох вэ гэдгийг шууд тодорхой зааж өгөөгүй байгаа асуудал юм. Гэхдээ уг хуулийн 511.1-д зааснаар бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан гэх тохиолдлыг эдийн бус гэм хор буюу сэтгэл санааны гэм хор гэсэн ойлголтын бүрэлдэхүүн хэсэгт хамруулан үзэх бололцоотой гэж үзэж болох байна.

Түүнчлэн эдийн бус буюу сэтгэл санааны гэм хорыг нөхөн төлүүлэх талаар манай хууль тогтоомжинд тодорхой зааж өгөөгүй бөгөөд Иргэний хуулийн 511 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт "эдийн бус гэм хорыг арилгах хэрэгсэл, хүрээ, хохирогчийн сэтгэл санаанд учирсан үр дагавар зэргийг хэргалзан нэхэмжлэгчийн шаардлагын хүрээнд мөнгөөр тооцож тогтоох болон бусад аргаар няцаалт хийхийг үүрэг болгоно" гэж заасан нь хууль зүйн практикт уг зохицуулалтыг янз бүрээр тайлбарлах, ойлгож шийдвэрлэх тодорхойгүй байдлыг үүсгэх хандлага байна.

Үүнээс үндэслэн үзэхэд сэтгэл санааны гэм хорыг манайд гэм хорын тусгайлсан төрөл болгохгүй байгаа бөгөөд харин эдийн бус гэм хорыг нөхөн төлүүлэхэд хэргалзан үзэх шалгуур гэж хуульчилсан нь ажиглагдаж байна. Нөгөөтэйгүүр энэ нь эдийн бус хохирлод чухам яг юу хамааруулан ойлгох талаар тодорхойлоогүй нь эдийн бус буюу сэтгэл санааны гэм хорын ойлголтын талаар маргаантай асуудлыг үүсгэж болзошгүй байна. Тухайлбал, хүний нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан эдийн бус гэм хороос гадна хүний амь нас хохирсоноос, хүний эрүүл мэндийг сэрниулсанаас хүнд үзэх сэтгэл санааны хохирол буюу үр дагаварын талаар хэрхэн зохицуулах талаар иргэний хуулинд тодорхой тусгаагаагүй нь учир дутагдалтай юм. Энэ нь манай

шүүхийн практик ч ийм жишээг явж байгаагаар харж болно.

Тухайлбал, Улсын дээд шүүхээс 1999-2004 оны хооронд хийсэн судалгаанаас харахад шүүхэд хандсан сэтгэл санааны гэм хорыг нөхөн төлүүлэх талаарх нэхэмжлэлүүдийн 35.5 хувь нь нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд гутаагдсан гэж үзэж гэм хорын хохиролыг мөнгөн хэлбэрээр гаргуулахыг илэрхийлсэн, 68.5 хувь нь нэр төрөө сэргээлгэх, зарлуулах хийлгэх, уучлалт уийлгэх тус тус шаардан нэхэмжлэл гаргасан байна. Нэхэмжлэгчдийн шаардлагыг судлан үзэхэд нэр төрөө сэргээлгэхийг хүссэн 50 хувь, ажил хэргийн нэр хүндээ сэргээлгэхийг 23.7 хувь, сэтгэл санааны хохиролоо арилгуулахыг 14.4 хувь, эрүүл мэндээр хохирсон гэх 9.2 хувь, олох ёстой орлогоод сэтгэл санааны улмаас нөлөөлсөн гэх 2.7 хувь эзлэсэн байна.

Түүнчлэн Монголын Нээлттэй Нийгэм Хүрээлэнгийн захиалагчар нийслэлийн 6 дүүргийн шүүхэд 3 жилийн байдлаар бидний хийсэн судалгаанаас¹¹ харахад сэтгэл санааны гэм хортой холбогдуулан гаргасан нэхэмжлэлийн дагуу хэрэгүүдийн шийдвэрлэсэн байдал нь эдийн бус буюу сэтгэл санааны гэм хорын хохиролыг тооцох асуудал нь зөвхөн Иргэний хуулийн 511.1-д заасны дагуу хүний нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан гэх байдлаар л хязгаарлагдах хандлага байгаа нь харагдаж байлаа.

Мөн хүний нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасныг шүүхээс хэрэг хянан тхэлцээд төгтөөсөн атал, тухайн хүнд өмнөх хохирол учраагүй гэж дүгнэж, энэ талаар нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон зөрүүтэй шийдвэрүүд олон тавьа гаргасан байдаг.

2. Эрүүгийн эрх зүйн харилцааны хүрээнд:

Иргэний эрх зүйн харилцаанд дээрх байдлаар зохицуулалт хийгдсэн байдаг бол Эрүүгийн эрх зүйн харилцаанд тухайн асуудал нь гэмт хэргийн бүрэлдэхүүнтэйд тооцогдон тусгайлан зохицуулагдаж байна.

Хүчин төгөлдөр мөрдөгдөж

буй 2002 онд батлагдсан Эрүүгийн хуульд "Гутгах" гэмт хэргийг Хүний эрх, эрх чөлөө, алдар хүнд, нэр төрийн эсрэг гэмт хэрэг гэсэн бүлэгт хамааруулан 111 дүгээр зүйл болгон тусгасан байдаг бөгөөд мөн уг хуулийн 110 дугаар зүйлээр бусдын нэр төр, алдар хүндийг олон нийтийн өмнө, эсхүл хэвлэл, мэдээллийн хэрэгслээр доромжилсон эсэх асуудлыг хуульчилан зохицуулах байдаг.

Гутгах, доромжлох хоёрын аль нь материаллаг бус хохирол учруулдаг боловч бүрэлдэхүүнээр ялгаатай. Гүтгэлийн бүрэлдэхүүн нь бодит байдал үл нийцсэн гэсэн ойлголт байдаг. Харин доромжлолын хувьд заавал бодит байдлад нийцсэн, тохирсон нь чухал биш, хамгийн гол нь ямар хэлбэрээр илэрхийлсэн нь чухал байдаг. Аливаа хүний тухай хэвлэлээр шүүмжлэхдээ звгүй, тэвгүй байдлаар илэрхийлсэн байвал тэр нь доромжлол болдог.

Гутгах гэмт хэрэг нь хүний

нэр төр, алдар хүндийг гутаасан

худал мэдээт амаар, бичгээр,

элдэ дүрс бичлэг, хуураг болон

хэвлэл мэдээллийн хэрэгслээр

тараасан байхыг тодорхойлсон

байна. Энэ нь уг хүний нийгэмд

үнэлэгдэх зүй ёсны бодит үнэлгээд

доройтуулан, гажуудуулсан

ойлголтыг олон нийтэд тараахад

чилгээгдсэн мэдээлэл байх бөгөөд

тарааж байгаа мэдээ нь уг хүний

зан төлөв, үйл ажиллагааны

үнэн бодит байдлад нийцэхгүй

байхыг ойлгоно. Энэ гэмт хэргийн

онцлог шинж нь бусдын нэр төр,

алдар хүндийг гутаах зорилгоор

илт худал гүжирдлэг тарааснаар

тодорхойлогддог.

Гүтгэлэг нь тухайн хүнд эдийн

бус буюу сэтгэл санааны хохирол

учруулдаг. Гүтгэлийн бүрэлдэхүүн

нь бодит байдлад үл нийцсэн

мэдээлэл тарааж, түгээрээ хүний

нэр төр, алдар хүндийг гутаасан

гэсэн ойлголт болдог тухай дээр

егүүлсэн.

Иймээс уг гэмт хэрэг нь хүний

нэр төр, алдар хүндийг гутаах гэсэн

шууд санаатай, сэдэлт нь өш хонзон

сангах, үзэн ядах, атаархах явдал

байдаг. Гүтгэлгээр заавал олон

хүнд тараасан байхыг шаардахгүй

зөвхөн анхны хүнд мэдээлсэнээр

төгсдөг нь тус эрх зүйн харилцааны

¹¹ Ш.Унэгтсэг нар., Legal aid for media project. МНХ., УБ

онцлог юм.

Уг гэмт хэргийн хохирогч нь аливаа хүн тэр ч байтугай бага насны, хэрэг хариуцах чадваргүй түүнчлэн нас барсан хүмүүс ч байж болно. Объектив тал нь илт худал гүтгэлгээ тараасан идэвхтэй үйлдлээр илрэлгэ бөгөөд гүтгэлгээ нь хохирогчийг гутаасан шинжийг агуулж, нэр хүндийг нь басамжилсан мэдээ сэлт орно. Харин эдгээр гутаасан мэдээ сэлт нь үйл баримтад үндэслэсэн байх бөгөөд эргэцүүлсэн бодлын байдлаар илрэх ёсгүй. Бас нэг онцлог нь энэ гэмт хэргийн субъект нь 16 насанд хүрсэн этгээд байдаг.

Харин бусдын нэр төр, алдар хүндийг гутаах агуулгатай гүтгэлгийг бодит байдалд нийдэхгүй, буруу ташаа дүгнэлт хийснээс бол тараасан гэж үзвэл эрүүгийн хариуцлагаас чөлөөлөгдөх боломжтой байна. Өөрөөр хэлбэл, таарсан мэдээ сэлт нь худал боловч уг хүнийг гутаагагүй байвал гүтгэх гэмт хэрэгт тооцдоггүй. Мөн тараасан мэдээ нь хүний нэр төр, алдар хүндийг гутаахаар мэдээлэл агуулсан боловч бодит байдалд тухайн хүний зан төлөв, үйл ажиллагаанд илэрсэн зүйл байсан бол гүтгэлгээ гэж үзэж эрүүгийн хариуцлага хүлээлгэж болохгүй гэж үздэг. Хэрэв тухайн этгээд тараасан мэдээ сэлтээ бодит байдалд нийцсэн үнэн бодитой гэж итгэлтэй байсан боловч үнэн хэрэг дээрээ худал байвал гүтгэсэн гэмт хэрэг эрх зүйн хариуцлага хүлээлгэж байх боломжтой.

Нөгөөтэйгүүр гүтгэх гэмт хэргийн хамгийн аюултай төрөл нь хүнд, онц хүнд гэмт хэрэгт холбогдуулан яллаулахад чиглэн гүтгэсэн явдал байдаг. Энэ төрлийн гэмт хэргийг зориуд, худал мэдээлэх гэмт хэрэгээс ялгаж явдал зайлшгүй чухал юм. Зориуд худал мэдээлэхэд гэм буруутай этгээдийн санаа нь хохирогчийг эрүүгийн хариуцлагад татуулах, харин гүтгэхэд хохирогчийн нэр төр, алдар хүндийг гутаахад чиглэгддэг байна. Жишээлбэл, Хэдхэн жилийн өмнө манай нэгэн төрийн өндөр албан тушаалтныг эрүүгийн онц хүнд гэмт хэрэгт

гүтгэн, харамсалтайгаар нэр төрийг нь хохироосон явдал гарч байсан билээ. Уг асуудалд цагдаа, прокурор, шүүхийн байгууллагууд хэрхэн хандаж, хүлээн авч, шийдвэрлэж байсан нь манай хууль зүйн практикт томоохон кейс болсон. Учир нь нэг асуудалд хэдэн өөр янзаар хандаж, тайлбарлаж болох хуулийн гэрч байгаа болохыг илэрхийлсэн зүйл болсон.

Гэхдээ гүтгэх гэмт хэрэг үйлдсэн эсэх талаар хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явагдаж, прокурорын хяналтын дагуу эрүүгийн журмаар шүүхэд хандаад гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй гэж үзвэл дараа нь иргэний эрх зүйн журмаар эдийн бус гэм хорыг арилгуулахаар хохирогч шүүхэд хандаж болох байна.

Нэр, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийн талаарх ойлголт, арга зам

Бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан зөрчил гаргасан этгээдэд хүлээлгэх хариуцлагын ихэнх тохиолдолд нь Иргэний эрх зүйн чиглэлээр хариуцлага ногдуулж байгаа нь удаа дараагийн судалгаа, шүүхийн практикаас харагдаж байна¹².

Он	1991	1992	1993	1994	1995	1996	1997	1998	1999	2000	2001	Нийт хэрэг
Хэрэг												
Иргэний хэрэг	7	5	5	3	8	13	23	31	30	39	10	174
Эрүүгийн хэрэг									3		1	4
Дүн	7	5	5	3	8	13	23	31	33	39	11	178

Харин шүүхээс хэрэг маргааныг шийдвэрлэх явцад гэм буруутай этгээдэд оноож буй эдийн бус гэм хорыг мөнгөөр нөхөн төлүүлэх хэмжээг тогтоох нийтлэг шалгуур байхгүй байгаа. Энэ нь шүүгч өөрийн итгэл үнэмшилдээ дулдуйдан шийдвэр гаргах боломжтойгоос гадна нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд гэсэн ойлголтууд нь хоорондоо ялгаатай боловч шүүхийн практикт өөрөөр хэлбэл, шүүх, хариуцагч,

нэхэмжлэгч нар эдгээр ойлголтыг төдийлөн анхаарч үздэггүй байна.

Харин гадаад орнуудын хууль зүйн практикт энэ талаар нилээд тодорхой авч үздэг байна. Тухайлбал, европт шүүхийн практик болон хуульчдын дунд эдийн бус буюу сэтгэл санааны гэм хорыг нөхөн төлүүлэхтэй холбоотой бүрдүүлвэр асуудлын нэг болох нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг хэрхэн тодорхойлж ойлгосноос шалтгаалан түүнийг сэргээх, гэм хорыг нь арилгах, нөхөн төлүүлэх аргыг тогтоох боломж бүрддэг.¹³

Юуны түрүүнд Нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан тохиолдолд сэтгэл санааны гэм хорыг нөхөн төлүүлэхээр шаардах эрхтэй этгээдэд хэнийг хамруулах вэ гэсэн асуудал чухал. Үүнд иргэн, хуулийн этгээд, эсхүл зөвхөн ганц иргэнийг хамруулах эсэхээ тодорхойлох ёстой. Иймээс нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд гэсэн ойлголтуудын ялгааг нь мэдэх нь чухал.

Нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийн талаарх онолын тодорхойлолтыг илүү өргөн хүрээнд авч үзсэнээр асуудлын мөн чанарыг тодруулах боломжтой.

Монгол хэлний товч тайлбар толинд¹⁴

- Ес сурталуун- хэвшиж тогтсон зан суртал

- Зан суртал-уламжлан заншиж ирсэн ёс, дүрэм, хүн нийтээр үзэн зөвшөөрсөн дадал заншил

- Зан сурталуун- ямар нэг нийгэмлэгийн шаардлагад тохирсон хүний ааль, авир, дүрэм, төлөв.

- Алдар 1. Нэрийн хүндэтгэл 2. олонд тарсан, дурдсан нэр /алдар хүнд/

¹² Ш.Уянзөг нар., Legal aid for media project, МННХ., УБ

¹³ Голубев М., Нариковой С., "Защита деловой репутации юридических лиц" //Росс.юстиция, 1999

¹⁴ Цэцэгл.Я. Монгол хэлний товч тайлбар толь УБ, 1966 он

3. үнэгүй бөгөөтөл хууран бадруулсан цуурхал

- Нэр алдар-ногдсон үүргээ нэр төртэй биелүүлэх

- Сэтгэл-элдвийг сэтгэх ухааны эрхтэний нь санаа, бодол, дур хүсэл

- Санаа сэтгэл-сэтгэл гэмтний санаа, амаргүй зүйл

- Санаа-бодол, сэтгэж буй зүйл гэсэн тайлбарыг хийсэн байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн нэр томъёоны дөгөөг¹⁵. Нэр төр, алдар хүнд гэдэг бол хамт олон, нийгэм төрөөс хүний хувьд өгсөн үнэлгээ юм. Хувь хүн нь нийгмийн гишүүний хувьд алдар хүндтэй байж нийгэм төрөөс оногдуулсан үүргийг нэр төртэй биелүүлэхийн зэрэгцээ бие хүний тухайд нэр төрөө бодож түүнийг ямагт ариун байлцаж алдраа ямагт цуурайтуулах өс суртахууны хийгээд хууль зүйн ач холбогдол бүхий эрхтэй, үүрэгтэй гэж тайлбарласан байна.

Эрх зүйн мэдлэгийн товч толинд¹⁶: Нэр төр бол бие хүний талаар нийгмийн зүгээс өгч буй тодорхой үнэлэлт бөгөөд түүний нийгмийн бодит шинж юм. Бие хүний нэр төрийг түүний үйл ажиллагаа, үйл хэрэг, үзэл бодлоор тодорхойлон. Алдар хүнд нь бие хүний өөрийн үнэлгээнд илэрхийлэгдэнэ. Энэ үнэлэлт бол бие хүний ухамсар дахь бодит зүйлийн тусгал байдаг ч гэсэн түүнийг тусгайд нь авч үздэг. Иймд нэр төр, алдар хүндийг хооронд нь салгахгүйгээр авч үзэх ёстой. Өнөө үед нийгмийн өс суртахууны зарчим, иргэд байгууллагын нэр төр, алдар хүндийг хамгаалах явдал нийгэм улс төрийн асар их ач холбогдолтой юм. Иргэний хууль тогтоомжоор иргэд байгууллагын нэр төр, алдар хүндийг хамгаална. Иргэд байгууллагын нэр төр, алдар хүндийг гутаасан мэдээ тараасан этгээд түүнийгээ үнэн зөвийг нотлож чадахгүй бол уг мэдээг няцаахыг нэр төр нь гутаагдсан иргэн буюу байгууллага шүүхэд шаардах эрхтэй. Хэрэв дурдсан мэдээг хэвлэлд нийтэлсэн бол зохих

няцаалтыг хэвлэлээр дамжуулан гүйцэтгэнэ. Бусад тохиолдолд няцаалт хийх журмыг шүүх мэдээ тараасан аргыг харгалзан тогтодог.

Хууль зүйн тайлбар толинд¹⁷ Нэр төр гэж хүний нийгэмд эзлэх байр суурь шинж чанар, төлөв байдлыг өс суртахууны талаас нь илэрхийлсэн үнэлэмж буюу нийгэм эрх зүйн категор. Нэр төр нь хүний төрсөн өдрөөсөө эхлэн зөвхөн өөрт нь заяамал ба салшгүй чанар нь нэр төртэй байх явдал бөгөөд түүнийг хэн ч өөрчлөх, хүчингүй болгох эрхгүйгээс гадна бусдад шилжүүлж болдоггүй.

Алдар хүнд бол хүний авьяас чадвар, ертөнцийг үзэх үзэл, нийгмийн учир холбогдолд өгсөн өөрийн дотоод үнэлгээ юм. Алдар хүнд нь санаа сэтгэл зовомтгой, хүмүүсийг өрөөдөж хайрлах сэтгэл, албан тушаал хөөцөлдөх, зусардан бялдуулахыг зөвүүцэх зэрэг зан чанарууд хүчээд ахуй үзэйн хүмүүжилд суурилдаг өөрийн үнэлэлт юм. Хэн сайн мэдэрч шударга ба шударга бус зан үйлийн ялгааг ухамсарлаж чадсан хүн алдар хүндтэй байдаг. Нөгөөтэйгүүр алдар хүнд гэж иргэн, хуулийн этгээд хөдөлмөр, үйлдвэрлэл, авьяас чадвар, ур ухаанаар онцгой амжилт гаргасныг төр, нийгэм, хамт олноос үнэлж өгсөн алдар цол, хэргэм зэрэг өргөмжлөл юм.

Ажил хэргийн нэр хүнд гэж иргэн, хуулийн этгээд тухайн эрхлэж буй байгууллага, аж ахуйгаа үр ашгтай эрхлэн хөтөлж, үйлдвэрлэл, үйлчилгээ, бараа, бүтээгдэхүүнээрээ тодорхой зах зээл, хэрэглэгчийн хэрэгцээг тогтвортой хангаж, тэдний таашаалыг хүлээх нь тухайн иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг үнэлсэн нийгмийн үнэлэмж юм гэж тодорхойлсон байна.

Олон улсын хүний эрхийн нэр томъёоны тайлбар¹⁸ хүний нэр төр, алдар хүнд гэж бүх хүний эрхийн эрх зүй, гүн ухааны үндэс болдог. Хүнд төрсөн цагаас нь заяасан хүний төрлөхийн үнэ цэнэ. Аливаа улс хүний нэр төр,

алдар хүнд, нэр хүндийг хамгаалж, гутаахыг хязгаарласан олон улсын хүний эрхийн стандартыг тогтоож, хүний нэр төр, алдар хүндийг хүндэтгэх зарчмыг хууль тогтоомжоороо баталгаажуулах ёстой. Хүний эрх нь нэр төр, алдар хүндийг хамгаалдаг. Хүний эрхийн суурь нь нэр төр, алдар хүнд бөгөөд тэр нь бусдаас олгодоггүй, үүсгэгдээгүй төрлөх чанартай гэсэн байна.

ОХУ-ын эрх зүйн тайлбар¹⁹ Нэр төр-хүн төрөхөөсөө үхэх хүртлээ өөртөө өгсөн үнэлгээ. Алдар хүнд – нийгэм, олон нийт тэр хүнийг хэрхэн хүлээн авч буйн илрэл. Харин хувь хүнд хандах хандлага нь нэр хүндээр илэрдэг. Ажил хэрэг, бизнестэй холбоотой хэрэглэгддэг ажил хэргийн нэр хүндийг хүн өөрөө буюу эрхлэн буй ажил, албан байдлаар олж авдаг гэсэн байдаг.

Нөгөөтэйгүүр Сэтгүүл зүйн онол арга зүйн хүрээнд²⁰ мэргэжлийн сэтгүүлчийн ёс зүйн зарчимд зааснаар үнэн зөв мэдээллийг шударгаар олж авах, бусдын нэр төрийг хүндэтгэх, худал зүйл мэдээлэх, гүтгэх, үндэслэлгүйгээр буруушаах, аливаа мэдээлэлд хувийн атгаг санаа оруулах, мушгин гуйвуулахыг хориглох, мэдээллийн үнэн зөвийг нотлох явдал хамаардаг байна. Эдгээрээс харахад хүний нэр, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийн талаарх ойлголт, тодорхойлолт, хамгаалалт баталааны хувьд цогц байдлаар хэрэгжидэг олон хүчин зүйлээс хэргэмидг болох нь харагдаж байна.

Дээрх байдлаас үндэслэн дараах дүгнэлтийг хийж болох байна. Нэр төр гэдэг ойлголтыг хуулийн этгээдийн хувьд хэрэглэх боломжгүй бөгөөд хуулийн этгээд нь зохиомлоор бий болгосон бүтэц боломжихоо хувьд өөрийн ухамсар, сэтгэлтэй байх боломжгүй юм. Хуулийн этгээдийн хувьд ажил хэргийн нэр хүндийг нь гутаасан үед л түүнийг сэргээх талаар ярьж болох бөгөөд учир нь

¹⁵ Монгол Улсын Үндсэн хуулийн нэр томъёоны дагалга, УБ

¹⁶ Эрх зүйн мэдлэгийн товч толь, УБ, 1978 он

¹⁷ Хууль зүйн тайлбар толь, УБ, 2003 он

¹⁸ N Victor Conde. A Handbook of international human rights terminology, Nebraska., 1999

¹⁹ Галина Аранова. Нэр төр сэргээх талаарх хууль тогтоомж, европын шүүхийн хууль цааз.

²⁰ Үнэнгэрс.Ш. Монголын хэвлэл мэдээлэл, УБ, 2000 он

хуулийн этгээд гэдэг нь өөрөө ажил хэрэг явуулах 1 зорилготой байгуулагддаг ба түүнд зөвхөн ажил хэрэгч шинж чанар л байж болох юм. Иймээс ажил хэргийн нэр хүндийг хөндсөн гэх зөрчлийн үед 3 төрлийн хариуцлага тооцож болох юм. Үүнд:

- 1/ тараасан мэдээллийг няцаах
- 2/ учирсан хохирлыг нөхөн төлөх /материаллаг хохирол/
- 3/-сэтгэл-санааны-гэм-хорыг нөхөн төлөх явдал юм.

Харин иргэний нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан хэргийн хувьд дээр дурдсан 3 төрлийн хариуцлагыг аль алиныг нь тооцож болох бөгөөд гэхдээ хуулийн этгээдийн хувьд сэтгэл санааны гэм хорыг нөхөн төлүүлэх хариуцлага оноох боломжгүй юм. Хуулийн этгээд өөрийн гэсэн сэтгэл санаа байхгүй, өөрөөр хэлбэл хуулийн этгээд нь сэтгэлийн хөдөлгөөн, бие мах бодийн зовлон шаналал амссан байх боломжгүй. Иймд хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндийг гутаасан тохиолдолд:

- худал мэдээлэлд няцаалт, залруулга хийх, - эд хөрөнгийн хохирлыг нөхөн төлөх гэсэн 2 төрлийн хариуцлагыг тооцож болох байна.

Сэтгэл санааны гэм хорын нөхөн төлбөрийн хууль зүйн үндэслэл

Манай улсын хууль тогтоомжид сэтгэл санааны гэм хорыг нөхөн төлүүлэх талаар шууд заасан заалт байхгүй гэж болох юм. Иргэний хуулийн 9 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт "Иргэний эрхийг эдийн бус гэм хорыг арилгуулах аргаар хамгаална", 497 дугаар зүйлд "Бусдын эрх, амь нас, эрүүл мэнд, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, эд хөрөнгөд хууль бусаар санаатай буюу болгоомжгүй үйлдэл /эс үйлдэл/-ээр гэм хор учруулсан этгээд уг гэм хорыг хариуцан арилгах үүрэгтэй" гэж заасан байна. Эндээс харахад сэтгэл санаанд учруулсан гэм хорын талаар дурдаагүй байна.

Харин уг хуулийн 511 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Бусдын нэр

төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ тараасан этгээд түүнийгээ бодит байдалд нийцэж байгааг нотолж чадахгүй бол материаллаг хохирлыг арилгасныг үл харгалзан эдийн бус гэм хорыг мөнгөн болон бусад хэлбэрээр арилгах үүрэг хүлээн" гэсэн байгаа нь материаллаг хохирлын хажуугаар материаллаг бус хохирлыг нөхөн төлүүлэх бололцоог бүрдүүлсэн гэж болох байна.

Мөн зүйлийн 2 дахь хэсэгт "Эдийн бус гэм хорын хэмжээг мэдээ тараасан хэрэгсэл, тарсан хүрээ, хохирогчийн сэтгэл санаанд учирсан үр дагавар зэргийг харгалзан нэхэмжлэгчийн шаардлагын хүрээнд мөнгөөр тооцож тогтоох"-оор зааснаас үзэхэд сэтгэл санаанд учирсан үр дагавар буюу сэтгэл санааны гэм хор нь эдийн бус гэм хорыг мөнгөн хэлбэрээр нөхөн төлүүлэх нэг үзүүлэлт болж байгаа нь харагдаж байна. Иймд манай хууль тогтоомжид заасны дагуу сэтгэл санааны гэм хорыг эдийн бус гэм хорыг нөхөн төлүүлэх аргаар арилгаж болох үндэслэл байна.

Эдийн бус гэм хор гэдэгт эдийн бус баялаг, хувийн эрх нь зөрчигдсөн байдлыг ойлгож болно. Эдийн бус баялагт амь нас, эрүүл мэнд, нэр төр, алдар хүнд, хувийн амьдралын халдашгүй байдал, хувийн болон гэр бүлийн нууц зэрэг орно. Эдийн бус хувийн эрх гэдэгт оршин суугаа газраа чөлөөтэй сонгох, зохиогчийн эрх, өөрийн нэрийг хэрэглэх эрх зэрэг орно. Эдгээр баялаг, эрхийг эдийн бус гэж тодорхойлох гол шалгуур бол түүнийг бусад этгээдэд дамжуулж болдоггүй, зөвхөн тухайн этгээдэд хамааралтай байдаг онцлогтой юм.

Иргэний хуулийн 497 дугаар зүйлд заасны дагуу өөрөөр хэлбэл эд хөрөнгийн болон эдийн бус эрх нь зөрчигдсөн үед гэм хор нөхөн төлүүлэхээр заасан боловч гэм хорын төрлийг нарийн заагдаж өгөөгүй байна. Эндээс үзвэл үүнд Иргэний хуульд заасан гэм хорын хоёр төрлийн аль алиныг нь ч төлүүлж болохоор ойлгогдож байна. Гэтэл 511 дүгээр зүйлд зааснаас харахад зөвхөн эдийн бус гэм хор

учирсан тохиолдолд сэтгэл санаанд учирсан үр дагаврыг харгалзан үзэх талаар дээр дурдсанчлан заасан байдаг.

Өөрөөр хэлбэл, сэтгэл санааны гэм хор нь эдийн бус гэм хор учирснаас л үүсэх үр дагавар гэж ойлгогдож байна. 511 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт эдийн бус гэм хорыг нөхөн төлүүлэх тохиолдлыг зааж өгсөн байна. Энэ нь бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ тараасан явдал юм. Үүнээс гадна иргэний хуулийн 511.3--т заасны дагуу уг хуулийн 21.4; 21.5, 21.6-д заасан зөрчлүүд буюу хуулиар тогтоосон хувийн нууцад хамааралтай мэдээ тухайн иргэний өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр тарааснаас гэм хор учирсан гэж үзвэл, иргэний дүрсийг гэрэл зураг, кино, дүрс бичлэгийн хальс, хөрөг зураг болон бусад хэлбэрээр өөрийнх нь зөвшөөрөлгүй нийтэлсэн, олон нийтэд үзүүлснээс гэм хор учирсан зэрэг нь мөн эдийн бус гэм хорыг мөнгөөр нөхөн төлүүлэх үндэслэл болох байна.

Нас барсан хүний нэр төр, алдар хүндийг гутаасан тохиолдолд түүнийг нь хэрхэн хамгаалах, эд хөрөнгийн бус эрхийн хэмжээг хэрхэн тогтоох, нэр төр гутааснаас сэтгэл санаанд учирсан үр дагавар гэдэгт юуг ойлгох зэрэг асуудал хууль зүйн зохицуулалтын гадна үлдсэн мэт санагдана.

Бусад тохиолдолд гэм хорыг хэрхэн арилгах талаар Иргэний хуулийн 52 дугаар бүлэгт тодорхой заасан боловч дээр дурдсан тохиолдоос бусдад нь сэтгэл санааны гэм хорыг хэрхэн нөхөн төлүүлэх талаар нарийвчлан заагаагүй байна. Энэ байдлаас шалтгаалан шүүхээс хэргийг шийдвэрлэхдээ тусөвтэй бус, магадгүй өрөвсгөл гэж болохуйц янз бүрээр шийдвэрлэх хандлага байна гэж болох байна. Тухайлбал доорх судалгаанаас харж болох юм²¹.

Нийслэлийн зургаан дугуйрч 1999, 2000, 2001 оны хооронд хармуцагчаас нэхэмжлэсэн мөнгөний дээд, доод, дундаж хэмжээ, мөн нэхэмжлэлийг хангасан шүүхийн шийдвэрийн эд хөрөнгийн бус гэм хорын хэмжээг тогтоосон доод болон дээд, дундаж хэмжээг

²¹ Ш.Унэгтес нар., Legal aid for media project. МНХХ., УБ

хүснэгтээр үзүүлэв.

байдал зэргийг харгалзан үзэх нь зүйтэй юм.

№	Хаанаас тогтоосон /мөнгөн дүн/	доод хэмжээ	дундаж хэмжээ	дээд хэмжээ
1.	Нэхэмжлэгчийн нэхэмжилсэн мөнгөн дүн	100000 төг	2 сая - 30 сая төг	400 сая төг
2.	Шүүхийн шийдвэрээр хариуцагчаас гаргуулахаар тогтоосон мөнгөн дүн	42000 төг	200000-500000 төг	1485000 төг

Мөн зарим тохиолдолд нэхэмжлэгчээс "миний нэр төрийг мөнгөөр үнэлэх аргагүй", эсхүл "хариуцагчийн санхүүгийн боломжийг харгалзан" гэх мэтээр эд хөрөнгийн бус гэм хорын хэмжээг мөнгөөр үнэлээгүй байх бөгөөд зөвхөн нэр төрөө сэргээлгэхээр шүүхэд хандсан тохиолдол ч олон бий.

Харин Эрүүгийн хуулинд гэм буруутай нь тогтоогдвол зохих торгууль ногдуулах, тодорхой хугацаагаар баривчлах, хорих ял ногдуулахаар зохицуулсан байна.

Иргэний эрх зүйд тухайн хүн гэм буруугүй гэдгээ өөрөө нотлох ёстой. Хэрэв нотлож чадахгүй бол гэм буруутайд тооцогдоно. Харин Эрүүгийн эрх зүйд гэм буруутайд үл тооцох зарчим үйлчилдэг. Өөрөөр хэлбэл, бүрэн төгс нотлогдож, шийдвэр гараагүй цагт тухайн хүнийг гэм буруутайд тооцох ёсгүй билээ.

Гэм хорын нөхөн төлбөрийн хэмжээг тодорхойлох асуудал

Мэдээж дээр дурдсан байдлаас гадна шүүхэд нөхөн төлбөрийн хэмжээг объектив байдлаар тодорхойлох тусгай шалгуур байх ёстой. Тодорхой хэрэг бүрийн тухайд шүүгч тухайн хүний зөрчигдсөн баялгийн өрөнхий үнэлгээ, хууль зөрчигчийн гэм буруугийн хэмжээ, эрх зүйн зөрчлийн үр дагаврын хэмжээ, хохирогчийн амьдралын нөхцөл /албан ажлын, гэр бүлийн, ахуйн, материалын, эрүүл мэндийн байдал, нас/, худал мэдээлэл тараагдсан хүрээ, бие эрхтний гэмтлийн хэмжээ, нас барсан хүн болон нэхэмжлэгчийн төрлийн холбоо, талуудын материаллаг

Нөгөөтэйгүүр бас нэг анхаарах томоохон асуудал бол эдийн бус буюу сэтгэл санааны гэм хор учирсан гэх хүн буюу нэхэмжлэл гаргагч маань өөрийн хохирсон гэх үнэлзэгээ мөнгөн хэлбэрээр тооцон нэхэмжлэх, түүнийг нь шүүх хууль хяналтынхан хэрхэн үнэлэн тооцох аргачлал нэн хангалтгүй байгаа болно. Үүнээс шалтгаалан нэхэмжлэл гаргагчид өөрсдийн тооцолсноор буюу хатуухан хэлэхэд хүссэнээрээ нэхэмжлэлийн мөнгөн хэлбэрээ илэрхийлдэг гэхэд хилсдахгүй байна.

1. Дотоодод нөхөн төлбөрийн хэмжээг тодорхойлж буй аргачлал

Манай улсын хувьд эд хөрөнгийн бус гэм хорыг нөхөн төлүүлэх хэмжээг тогтоох асуудлын талаар Улсын Дээд Шүүхийн Иргэний тэнхимаас шинэ Иргэний хууль батлагдахаас өмнө буюу 2000 оны 6 дугаар сарын 25-ны өдөр зөвлөмж²² гаргасан байдаг. Гэхдээ шинэ Иргэний хуультай тусвэстэй хэрэглэгдэх бололцоотой юм.

Тус зөвлөмжид дараах байдлаар эдийн бус гэм хорын хохиролыг нөхөн төлүүлэх аргачлалыг гаргасан байна. Үүнд: "Шүүх эд хөрөнгийн бус гэм хорыг арилгах хэмжээг мэдээ тараасан арга хэрэгсэл, тарсан хүрээ, хохирогчид учирсан сэтгэл санааны үр дагавар зэргийг харгалзана" гэдгийг доорхи утгаар ойлгоно. Хуучин Иргэний хуулийн 392 дугаар зүйл, шинэ Иргэний хуулийн 511 дүгээр зүйл.

А/ Эд хөрөнгийн бус хохирлын үнэлгээг тогтооходоо мэдээ тараасан аргыг харгалзан үзнэ. Мэдээг үгээр илэрхийлэх нь зургаар, фото зургаар, дүрс бичлэгээр, дуу

авиагаар, бичгээр илэрхийлэхээс зарчмын ялгаатай юм.

Б/ Мэдээлэл тараасан хэрэгсэл нь үнэлгээ өгөх бас нэг нөхцөл юм. Энэхүү арга хэрэгсэл гэдэгт шуудан холбооны бүх төрлийн техник хэрэгсэл орохоос гадна приставка, компьютер, факс гэх мэт зүйлс хамаардаг. Утсаар ярих, факс илгээх нь хоёр өөр тул хохирлын үнэлгээг ялгажтай тогтооно.

В/ Эд хөрөнгийн бус хохирлыг үнэлэхдээ мэдээлэл тархсан хүрээ, тодруулбал газар нутгийн байршил, нэвтрүүлэх хэрэгслийн хүчин чадлыг харгалзан үзвэл зохино. Жишээлбэл, мэдээг телевизээр нэвтрүүлэхдээ сум, аймаг, улс дэлхийд дамжуулах, олон захиалагчтай хэвлэлд нийтлэх нь цөөн захиалгчтай сонинд нийтлэхээс ялгаатай болно. Түүнчлэн радиогоор нэвтрүүлсэн бол радио цэгийн тоо, сонсогчийн тоог ч ойролцоогоор тогтоож болох юм.

Г/ Хохирогчид учирсан сэтгэл санааны үр дагавар гэдэгт нийгмийн амьдралд идэвхтэй оролцож чадахгүй болох, ажлаас халагдах, шагнал, урамшлаас хасагдах, гэр бүл захидал харилцаа болон өвчний нууц алдагдах, гэр бүл, эцэг эх, үр хүүхдийн сэтгэл санаанд нөлөөлөх, сэтгэцийн гутралд орох, ажил сургуульдаа явж чадахгүй байх, гудамжинд гарахдаа олон түмнээс ичих зэрэг сэтгэл санааны таагүй байдалд орсон байгаа ойлгоно" гэх зэрэгээр заасан байна.

Уг аргачлалаар доорх байдлаар гаргасан байна:



²² Дээд шүүхийн мэдээлэл. 2001, №1, 40-41 дэх тал

Сэтгэл санааны хөдөлгөөний үнэлэх аргачлал



Мөн уг зөвлөмжид заасны дагуу шүүх эдийн бус гэм хорыг нөхөн төлүүлэхдээ дээрх хуульд заасан нөхцөл байдлаас гадна төлбөр хариуцагчийн цалин, орлого, үндсэн хөрөнө эргэлтийн хөрөнгийн хэмжээ, мэдээ тараасан санаа зорилгыг харгалзан үзэж гэм хорын хэмжээг тогтооно гэсэн байна. Энэхүү зөвлөмж нь шүүхүүдээс иргэдийн эдийн бус гэм хорын хохиролыг нөхөн төлүүлэх, арилгах, сэргээхтэй холбогдсон харилцааг арга зүйн хувьд объектив байдлаар шийдвэрлэх боломжийг бүрдүүлж байна гэж болох байна.

2. Гадаад орнуудад нөхөн төлбөрийн хэмжээг тодорхойлж буй аргачлал

Гадаад орнуудын хууль зүйн практикаас харахад нөхөн төлбөрийн хэмжээг тодорхойлохдоо дараахь шалгуурыг харгалзан үздэг байна.

- Гэм хор учруулагчийн гэм буруугийн хэмжээ,
- хохирол учирсан этгээдийн хувийн онцлогтой холбоотой бие махбодийн болоод ёс суртахууны зовлонгийн /гэм хорын/ хэмжээ,
- Бодит нөхцөл байдал болон хохирогчийн хувийн онцлогийг тусгасан бие махбодийн болоод ёс суртахууны зовлонгийн /гэм хорын/ шинж чанар,
- шударга ёсны шаардлага зэрэг юм.

Гэм хор учруулагчийн гэм хорын хэмжээ, хуулинд гэм буруу хариуцлага хүлээлгэх үндэслэл болно гэж заасан нөхцөлд хэрэглэгдэх бололцоотой.

Зовлонгийн /учирсан гэм хор/ хэмжээ гэдэгт түүний хэр гүнгийг байгааг /жишээлбэл, "сун", "тэсвэрлэмээр", "хүчтэй", "тэсвэрлэшгүй" өвдөлт гэх мэтээр зовлон нь ямархуу түвшинд буюу хэр их гүнгий зовж байгааг тодорхойлол/ ойлгоно. "Дундаж"

хүний хувьд зовлонгийн гүний хэмжээ эд хөрөнгийн бус баялагын төрлөөс болон түүний багассан хэмжээнээс хамаарах ба харин хохирогчийн хувийн онцлог нь энэ зовлонгийн гүнийг ихэсгэх буюу багасгаж болох юм. Иймд "дундаж" хэмжээг анхааралдаа авах /гэм хор/ шаардлагатай бөгөөд хувийн онцлогоос хамаарч өөрчлөгдөх өөрчлөлтөөр шүүх бодит сэтгэл санааны гэм хор болон түүнд тохирсон нөхөн төлбөрийн хэмжээг тогтоож болдог байна.

"Сэтгэл санааны гэм хор" нь хууль бус үйлдлийн нийгмийн үнэлгээг тусгадаг. Иймд нөхөн төлбөрийн хэмжээг тодорхойлохдоо ёс суртахууны болон бие махбодийн зовлонгийн төрөл /шинж чанар биш/, харин эдгээр эд хөрөнгийн бус гэм хор учирсан баялагийн ач холбогдол шинж чанарыг харгалзах нь зүйтэй гэж үздэг. Ихэнх судлаачийн үзэж байгаагаар бодит сэтгэл санааны гэм хорын нөхөн төлбөрийн хэмжээ "байж болохуйц сэтгэл санааны гэм хорын нөхөн төлбөр"-ийн хэмжээнээс дөрөв дахинаас хэтрэхгүй байх нь тодорхой төрлийн эрх зүйн зөрчлийн хувьд нөхөн төлбөрийн дээд түвшинг тогтоох бололцоог бүрдүүлдэг гэж үздэг байна.

Эдгээр асуудлыг шийдвэрлэх аргачлалыг зарим нэгэн эрдэмтэд гаргасан байдаг. Тухайлбал дээр дурдсан бүх төрлийн шалгуурыг тусгасан гэх доорхи аргачлалыг Эрделевскийн томъёо гэдэг байна.

$$D=d^*f(v)^i*c^*(1-f(s))$$

D-бодит сэтгэл санааны гэм хорын хэмжээ
 d-учирч болохуйц сэтгэл санааны гэм хорын хэмжээ
 f(v)-гэм хор учруулагчийн гэм хорын хэмжээ

i-хохирогчийн хувийн онцлогийн коэффициент
 $0 < i < 2$;
 c-гэм хор учирах үеийн анхаарал татахуйц нөхцөл байдал
 $0 < c < 2$
 f(s)-хохирогчийн гэм буруугийн хэмжээ
 $0 < f(s) < 1$

Энэ томъёоллоос харахад бодит сэтгэл санааны гэм хорын нөхөн төлбөрийн дээд хэмжээ учирч болохуйц сэтгэл санааны гэм хорын хэмжээнээс дөрөв дахинаас хэтрэхгүй байхаар харагдаж байна. Энэ томъёоллыг хэрэглэхэд гэм хор учруулагчийн гэм буруугийн хэмжээнд дараахь үнэлгээг хэрэглэж болно гэж үздэг. Үүнд:
 $F(v) = 0.25$ энгийн болгоомжгүй
 $F(v) = 0.75$ бүүдүүлж болгоомжгүй
 $F(v) = 0.75$ шууд бус санаатай
 $F(v) = 1$ шууд санаатай

Мөн гэм хор учруулагчийн эд хөрөнгийн байдал нөхөн төлбөрийн хэмжээг бууруулж болох ба хэрэв санаатай гэм хор учруулсан бол үүнийг харгалзан үздэггүй гээд ийм үед дараахь томъёоллыг хэрэглэж болно гэжээ. Энэ нь.

$$D=d^*f(v)^i*c^*(1-f(s))^p$$

p-гэм хор учруулагчийн эд хөрөнгийн байдал
 $0.5 < p < 1$ г з ж томъёолсон байдгийг анхаарахад илүүдэхгүй бэй ээ.

Түүнчлэн Австрали, Их Британи зэрэг оронд хэн ч нэр төрөө сэргээх нэхэмжлэл гаргаж болно. Гэхдээ шүүхээс дараах үндсэн 4 элементийг хангасан тохиолдолд тухайн гаргаж буй нэхэмжлэлийг хүлээн авдаг байна. Үүнд:

1. бодит байдал нийцээгүй мэдээлэл түүгээсн бол,
2. Нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан бол.

3. Тодорхой байгууллага, хувь хүний нэр зааж, танигдахаар бичсэн, дүрсэлсэн /гэхдээ заавал шууд тусгахгүй байж болно/ бол,

4. Бодит баримт, болсон үйл явдал дээр тулгуурлаагүй бол²³ гэсэн үндэслэлтэй байх ёстой.

Гэхдээ энэ нь цэвэр онолын асуудал бус, хууль зүйн практик ач холбогдол талаасаа анхаарах зүйл юм. Тухайлбал, дээр дурдсан орны сэтгүүлчид дээрх 4 элементийн хууль зүйн үр дагаварыг мэддэг учраас аливаа материал нийтлүүлдээ уг хүрээ, хязгаараас гажихгүйгээр бичиж, нийтэлдэг. Манай хэвлэлийнхэн ч энэ талаар

мэдээлэлтэй байх нь нэн чухал.

Эцэст нь хэлэхэд Улсын дээд шүүхээс гаргасан дээрх зөвлөмжид эдийн бус гэм хорыг тооцоход хэд хэдэн асуудлыг тодруулан зааж өгсөн нь нэлээд дэвшилттэй боловч зарим зүйлийг шинэчлэн найруулсан Иргэний хуульд нийцүүлэх болон илүү тодруулах замаар өөрчлөлт оруулах нь зүйтэй болов уу. Үүнд нэр төр гутаагдсан гэх үндэслэлээр шүүхэд нэхэмжлэл гаргах эрх бүхий этгээдийн хүрээ хязгаарыг тогтоох /хэт алслагдсан гэм хорыг нөхөн төлүүлэхгүй зэрэг/ болон нөхөн төлбөрийн хэмжээг тогтоох аргачлалыг улам

боловсронгуй болгох, гадаад орнуудын туршлагыг судлан нэвтрүүлэх боломжийг судлах, бусад хуульд энэ талаар заасан заалтыг хэрэглэх зэрэг асуудлын зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай.

Түүнчлэн шүүхээс нэр төр гутаах хэрэг маргааныг хянан шийдвэрлэхдээ нэхэмжлэгчид эрүүл мэнд, сэтгэл санааны гутрал бий болсон эсэх, ашиг орлогын тооцоо, гэм хорын хохиролын хэмжээ, үг хэллэгийн тайлбар зэрэг тусгай мэдлэг шаардсан асуудлыг хэрхэн шийдвэрлэх боломжийг нарийвчлан зохицуулах нь зүйтэй байна.



²³ Press law and Practice. Defamation acts, Civil and Criminal actions., UK. 1993

ХАРЬЦУУЛАХ, ЭС ХАРЬЦУУЛАХ ЭРХ ЗҮЙ¹

1. Харьцуулсан эрх зүй хэрхэн хөгжиж байна вэ?

1.1. Өнгөрсөн үеийг нэхэн санахаас

Энэ бол жаахан этгээд мэт боловч манай өнөөгийн хэрэгцээнээс үүссэн сэдэв юм. Өнөөг мэдвээ гэвэл "эхээс нь" бүүр үүслээс нь авч үзвэл арай л углуургатай.

Харьцуулсан эрх зүй судалгааны арга болохын хувьд аль эртний угшилтай. Бүүр МТӨ аугаа их Аристотель Грек, Афины олон хот улс, аймгийн 150-иад Үндсэн хуулийг судалсандаа үндэслэн улс төрийн шинжилгээний зохиолоо бичсэн бол алдарт шинэтгэгч Солон хуулиудаа их Грекийн хотуудын хууль зарлигуудыг судалсны үндсэн дээр гаргасан; Дундад зуунд Англи, хожим Франц, Германд Ромын эрх зүйг судалсны үндсэн дээр заншлын болон хувийн (тусгай) эрх зүйг бүрдүүлэхийг чармайсан; наашлуубал энэ уламжлалыг эх газрын хэмжээнд өгүүлдэг билээ. Бүхэлд нь үзвэл эрх зүйн шинжлэх ухаан бий болсон цагаас харьцуулан судлах арга зэрэгцэн хөгжсөн гэж үздэг. Бас хууль зүйн шинжлэх ухаан бол дэлхийн ууган шинжлэх ухааны нэг гэж хүлээн зөвшөөрдгийг иш үндэс болговол харьцуулсан эрх зүй нэн эртний улбаатайдаг.

1.2. Монголынхоо тухайд цэцэг өөгөдийн үйл хэргийг үгүйсгэж болохгүй

Дэлхийн улсуудын нэгэн адил Монголд ч ийм нөлөө хэзээ хэр туссанг бид лавтай нотлоогүй ч харьцуулсан эрх зүй (арга) дөнгөж л одоо үүсч байгаа биш юм. Бидний мэдэх ойрмогхоноос таслан үзвэл ХХ зууны эхнээс Монголд харьцуулан судлах арга хууль зүйн амьдралын янз бүрийн хүрээ, түвшинд хэрэглэгдэж ирсэн түүхэн баримт элбэг бий. Тоймловол:

Бур Богд хаант засгийн үед (1911-1921) Цэвээн Жамсранов нарын судлаачид дэлхийн олон орны төрийн эрх зүйн харьцуулсан судалгаа хийж байсан; 1920-иад оны эхээр Монголын анхны Үндсэн



ХЗҮТ-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор, профессор, гавьяат хуульч

Б.ЧИМИД

хуулийн төсөл боловсруулагч үндэсний ардчилсан үзэлтнүүдд барууны нэлээд орны Үндсэн хуулийг харьцуулан судалсан зэрэг дорвитой баримт буй:

-Монгол орон социалист чиг баримжаанд шилжсэний дараахнаас Зөвлөлт эрх зүйг үлгэр жишээ болгон үндсэн дээр шинжлэл судлал, практик ажлыг зохиож ирсэн;

-“Социалист байгууллын үе” гэх 1960-аад оноос 80-аад оны эцэс тэрхүү ЭХХТЗ (СЭВ)-ийн гишүүн орнуудын хамтын ажиллагааны цогцолбор хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд хууль тогтоомжийг язгуулан жигдлэх арга хэмжээг засаг төрийн бодлогын түвшинд зохиосон;

-Монгол Улс 1990-ээд оноос ардчилал, зах зээлийн харилцаанд шилжиж эхэлснээр хөгжингүй орнуудын хууль тогтоомж, практикийг жишиг болгох гэсэн албан ёсны хандлага баримталж ирсэн зэрэг нь шинжлэх ухааны өндөр түвшинд биш ч гэсэн эрх зүй, хууль тогтоомжийн харьцуулсан судалгаа үргэлжилж ирснийг харуулна.

Харин цаг цагийн зэргэлтэд “хэт хувьсгалчирхах”, зөвлөлт мангаар “интеграцилах”, өгдөг “даварших” гэхчлэн өрөөсгөлдөж **хошуурснаас өөрийн орны хөгжлийн түүхэн үеүд дэх дотоодын хууль тогтоомжийг харьцуулан**

судалж “хөрсөн дээрээ бууж хөгжихөд” бага анхаарч ирснийг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Эндээс «хууль тогтоомжийг харьцуулах» гэдэг тухайд юу хэлж болох вэ? Хэдийгээр «өөрийн систем дотроо харьцуулалт хийх нь харьцуулсан эрх зүй судлалын зорилго биш»² гэлээ ч нийгмийн өөр өөр байгуулал дамжсан Монгол шиг орны хувьд тэр түүхэн эе бүрийнхээ эрх зүй, түүний эх сурвалж (хуулиуд)-ийг харьцуулан судлах нь чухлыг үгүйсгэж болохгүй. Учир нь өнгөрсөн алдаанаас сургамж авахын сацуу үнэт зүйлийг нь өвлөн залгамжлах, ингэхээр “хөрсөн дээрээ” урган хөгжихөд зайлшгүй хэрэгтэй нь маргаангүй.

Гэтэл өдгөөг хүртэл өөрийн орны эрх зүйг харьцуулсан онол-эрдэм шинжилгээний судалгааг төдийлөн анхаарахгүй, харин бусад орны хууль тогтоомжийг шууд хуулбарлах арга, хандлага зонхилж байгаа нь харьцуулсан эрх зүй судлал жинхэнэ утгаараа хөгжихөд муугаар нөлөөлж байна.

Дээр дурдсан өөрийгээ үгүйсгэх, бусдыг хуулбарлах хоёр хандлагаас үүдэн бид харьцуулсан эрх зүй гэж чухам юуг ойлгож, түүнд онол, арга зүйн ямар үндэс зарчим баримтлах вэ? гэдгийг бодитой, шүүмжлэлтэйгээр эргэн харах цаг болсон. Энэ цагийн “хонхыг дахин дахин дэлдэхэд” “Шихихутга” дээд сургуулийн санаачлагаар энд хийж буй **“Харьцуулсан эрх зүйн онол-практикийн орчин үеийн асуудал”** сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний бага хурал бас нэг шинэ түлхэц өгнө гэж найдаж байна. “Шинэ түлхэц” гэдэг тухайд ойрмогхон үеийн өөрчлөлт шинэтгэлийн явцтай холбон үзэх гэсэн санаа болно.

1.3. Өнөө үеийн өнөө төрх

Хоёр зууны заагаас Монгол Улсад болж буй эрх зүйн шинэтгэлийн хүрээнд харьцуулсан эрх зүй шинжлэх ухааны утгаараа шинэ түвшинд хүрч хөгжих суурь тавигдаж эхэлсэн гэж болно. Сүүлийн жилүүдэд Монгол Улсын Их Сургуулийн Хууль

¹ Харьцуулсан эрх зүйн онол-практикийн орчин үеийн асуудал” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний бага хуралд толилуулсан илтгэл. УБ, 2007 он

² Амарсанаа.Б. “Харьцуулсан эрх зүй судлал”. УБ, 2005 он. 8 дахь тал

зүйн сургууль, Хууль зүйн үндэсний төв, бие даасан судлаачид дангаар болон дотоод, гадаадын төрийн бус байгууллагуудтай хамтран шинжлэх ухааны өгүүлэн буй чиглэлээр онол, арга зүйн болон зохион байгуулалтын дорвитой ажил санаачлах болов.

Манай судлаачид эрх зүйн ерөнхий онол, тодорхой салбарын чиглэлээр харьцуулсан судалгаа хийж эрдэм шинжилгээний ном зохиол нийтлүүлж, олон улсын болон дотоодын эрдэм шинжилгээний хурал зохион байгуулж, судлаач, сонирхогчдын хүчийг нэгтгэх зарим алхам хийж ирснийг дашрамд тэмдэглэж байна.

2003 онд бид нарын санаачлагаар "Монголын харьцуулсан эрх зүйн нийгэмлэг", 2004 оны 1 дүгээр сард академич Ж.Амарсанаагийн санаачилгаар МУИС-ийн Хууль зүйн сургуульд "Харьцуулсан эрх зүй, олон улсын эрх зүй судалгааны төв" байгуулагдсан. Мөн Х.Тэмүүжин нарын залуу судлаачдын хамтлаг энэ чиглэлээр зохих нэгдэл бий болгов. Ханс-Зайделийн сангийн Эрх зүйн боловсрол академи, мөн Улс төрийн боловсрол академи зэрэг харьцуулсан эрх зүйн судлаачаар голчлон сургалт, судалгаа явуулдаг төвүүд бий болов. Монгол хууль зүйн эрдэм шинжилгээний шинэхэн голомт, Хууль зүйн үндэсний төв энэ талаар мэдэгдэхүйц үр дүнтэй ажил хийж байгаа гээд тоймолбол ахиц нэлээд буй.

Академич Ж.Амарсанаа "Хүний эрх, Үндэсний боловч олон улсын харьцуулсан эрх зүй" (УБ., 1990), академич С.Нарангэрэл "Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо" (УБ., 2001), докторант Н.Отгончимэг "Монголын харьцуулсан эрх зүй судлал" (УБ., 2001), докторант Б.Амарсанаа "Харьцуулсан эрх зүй судлал" (УБ., 2005), Б.Гүнбилэг, А.Төмөр "Харьцуулсан эрх зүй" (УБ., 2005), Хууль зүйн үндэсний төв, Дэлхийн банкны Шүүх эрх мэдлийн шинэчлэл төсөл хамтран "Монгол Улсын эрх зүйн хөгжил ба харьцуулсан эрх зүй судлал" гэх мэт нэг сэдэвт зохиол, харьцуулсан нэр томъёоны толиуд, түүнчлэн дотоод, гадаадын олон судлаачийн хамтын цөөнгүй бүтээл нийтлэгдсэн нь энэ чиглэлээр хөгжил урагшиж байгаагийн баримт мөн. Үүнийг хоёр жил гэхэд Хууль зүйн үндэсний төвөөс хууль зүйн сургууль, бусад

байгууллагатай хамтран:

– «Хоёр Солонгос, Монгол Улсын иргэний болон газрын эрх зүйн чиг хандлага» (2006 он);

– «Монгол ба өмнөд, хойд Солонгос улс дахь эрүүгийн болон газар, олон улсын эрх зүйн өөрчлөлт» (2007 он);

– Нагоягийн Их сургуультай хамтран «Үндсэн хуулийн шүүхийн асуудал» зэрэг дотоод, гадаадын олон улсын хурал, семинар зохион байгуулав. Доктор, профессор Т.Доохүү, Ч.Энхбаатар нарын харьцуулсан судалгааны бүтээл "Гадаад орнуудын Үндсэн хуулийн эрх зүй" суралцах (2006) нийтлэгдсэн байна.

Энэ салбарт нэлээд дорвитой үр дүн үлдээсэн хамтын ажиллагааны нэг хэсэг нь Германы Ханс Зайделийн сангийн хөтөлбөрийн захирал, доктор Ц.Сарантуяагийн санаачилгаар тус сангийн дэмжлэгтэйгээр зохион байгуулж ирсэн Монгол-Германы эрдэмтдийн нийтийн эрх зүйн хүрээн дэх харьцуулсан эрх зүйн төсөл-судалгаа Мөн Тус төслийн явцад олон улсын чанартай хэд хэдэн уулзалт, хурал зохион байгуулж, зохих хууль боловсруулж, харьцуулсан судалгааны цувралууд гаргасны дотор "Захиргааны хэргийн шүүх: Монгол дахь шинэтгэл Дэлхийн улсуудын жишиг" (2004 он) хамтын бүтээл нийтлүүлсэн.

Мөн профессор Н.Лүндэндорж нар эрхлэн нийтлүүлсэн АНУ-ын судлаач Кристофер Осакевегийн "Харьцуулсан эрх зүй судлал: Ерөнхий ба тусгай анги" (2005 он) зэрэг гадаад эрдэмтдийн номыг орчуулан гаргасан. Энэ бүхэн "Монголд харьцуулсан эрх зүйн шинжлэх ухаан", бас судалгааны арга хүрээгээ тэлсээр буйг нотлох буй заа.

Ийнхүү хүрсэн твүвшин ахиулан хөгжүүлэхэд хуульч судлаачид энэ талаар онол-арга зүйн нэгдсэн ойлголтдоо хүрсэн, гар нийлсэн байх нь чухал юм.

2. "Харьцуулсан эрх зүй" гэдэг чухам юу, түүний зорилго юунд орших вэ?

2.1. Энэ хавийн өргөн, явцуу хоёр утга

Уг асуудал эртний уламжлалтай ойлголт боловч Монголын эрх зүйн өнөөгийн онол-практикт эргэлзээтэй үзэл бодол

илэрсээр байна. Монголын болон гадаадын судлаачдын бүгээлүүд, мөн хууль тогтоох, хэрэглэх практикаас үзэхэд "харьцуулсан эрх зүй" гэдэг ухагдахууныг наанадаг хоёр утгаар хэрэглэх нь зөв болов уу.

Нэгд, Эрх зүйн шинжлэх ухааны тогтолцоон дахь түүний бие даасан нэгэн салбар, өөрөөр хэлбэл эрх зүйн мэдлэг, соёлын нэг чухал хүрээ мөн.

Энэ ангиллыг тодруулбал «харьцуулсан эрх зүй» ("Сравнительное право-Comparative law) гэдэг нь чухам ямар утга агуулаа, багтаамж, үүрэг, ач холбогдол бүхий ойлголт вэ? Түүнийг бид юунд, ямар зорилгоор "ашиглаж" байна вэ? гэдгийг эрдэм шинжилгээний танин мэдэхүйн үүднээс нягтлан үзэж, чиг баримжаагаа цэцгэтэй тодорхойлж авах нь зайлшгүй чухал. Өдгөө ном зохиолд «харьцуулсан эрх зүй», «харьцуулсан эрх зүй судлал», «эрх зүйн харьцуулсан судлах арга» гэх янз бүрийн томъёолол (нэр) гарган бичдэг. Эдгээр нь яг адил утга, багтаамжтай биш нь ойлгомжтой боловч аль нь ерөнхий (их буюу үндсэн), аль нь түүнээс үүсмэл (тусгай), эсвэл хоорондоо хамааралгүй ойлголтууд юм уу гэдэгт зөв хариу олж байх цааш «хөдлөх» ёстой болов уу.

2.2. Асуудлыг бүүр язгуураас урвуулан үзвэл

Бидний хүрсэн дүгнэлт гэвэл: «Харьцуулсан эрх зүй» гэдэг нь хамгийн ерөнхий (их) ухагдахуун юм. Түүнд «харьцуулсан эрх зүй судлал», «эрх зүйн харьцуулсан судлах арга», бас «хууль тогтоогчийн харьцуулсан судалгаа» гэж ойлголт багтана. Өөрөөр хэлбэл «харьцуулсан эрх зүй» гэдгээс бусад нь үүсмэл гэж болно. Гэтэл цаана нь «эрх зүй» гэдэг суурь буюу язгуур ойлголт бий. Энэ нь биднээс үл хамааран орших эрх зүйн хэм хэмжээний үндсэн нийлбэр цогц, түүнийг тусгаж буй ухамсар, хэрэглэж буй арга, тэргүүтний тогтолцоо гэх бодит үзэгдлийг илэрхийлдэг. Энэ утгаар «зохицуулах зүйл», «зохицуулалт» энэ тэр гэж ярьцгаавдаг. Харин энэ бүхнийг шинжлэн судалж, нэгтгэн дүнжнэж, хөгжлийн чиг хандлага, арга замыг нь тодорхойлолдог тэр утгаар "эрх зүйн шинжлэх ухаан", энэ "шинжлэх ухааны салбар" гэгцлэг. Үүний учир «судлах зүйл»,

«судлах арга» гэхчлэн өгүүлдэг. Эдгээр нь тогтсон ойлголт гэж болно.

Энэ **язгуур** (суурь) ойлголтыг тулгуур, «загвар» болговол «харьцуулсан эрх зүй» гэдгийг аль утгаар нь хэрэглээд байгаа юм бэ? «Харьцуулсан эрх зүй» гэж объектив эрх зүй шиг нийгмийн харилцааг зохицуулдаг хэсэг хэм хэмжээ хаа ч байхгүй. Иймд түүнийг «салбар эрх зүй» гэсэн утгаар хэрэглэх нь үнэнд нийцэхгүй. Харин эрх зүй, эрх зүйн түүх, гүн ухаан зэрэг нийтлэг хийгээд эрх зүйн бүл, тогтоцдоо, салбар, төрөл зүйг дэлхийн хоёр буюу бүлэг улсын (бус нутгийн г.м), үндэсний, олон улсын түвшинд тухайлан судалдаг шинжлэх ухаан бол байсаар ирсэн. Монголд ч оноосон нэрээ олон хөгжиж байна. Үүнийг «**харьцуулсан эрх зүй судлал**»³ (сравнительное правоведение) гэх болсон. Үүнээс:

«Харьцуулсан эрх зүй судлал» бол эрх зүйн шинжлэх ухааны нэгэн бие даасан салбар мөн гэж урьдчилан хэлж болно.

Эрх зүйн түүхийн юм уу, ерөнхий онолыг «салбар эрх зүй» гэж болохгүй ч энэ **шинжлэх ухааны салбар** гэдэг шигээр өөрийн судлах зүйл, арга зарчим, зорилго, үр дүнтэй байдгаар нь шинжлэх ухааны салбар хэмээн ойлгохоос аргагүй.

Харьцуулсан эрх зүйн шинжлэх ухааны **судлах зүйлийн тухайд** гэвэл:

-харьцуулсан эрх зүйн онол, арга зүйн үндсэн асуудлууд;

-эрх зүйн бүлгүүдийн нийтлэг хийгээд онцлог;

-улсуудын буюу үндэсний эрх зүйн тогтолцоонуудын нийтлэг хийгээд онцлог;

-олон улсын ба үндэсний эрх зүйн нийтлэг, онцлог;

-дотоодын эрх зүйн салбар, институтын нийтлэг, онцлог;

-үндэсний хууль тогтоомжийн хөгжлийн түүхэн үе шатуудын нийтлэг, онцлог гэхчлэн эрэмбэлж, тоймолж болох юм. Гэхдээ энэ бол бүрэн гүйцэд жагсаалт огт биш бөгөөд жич дэлгэрэнгүй авч үзвэл зохих баримжаа төдий зүйл.

2.3. Арга гэдэг тухайд

«Харьцуулсан эрх зүй» гэхийн **хоёрдахь** бие даасан (тусгай) утга нь эрх зүйн үзэгдлүүдийг зохих түвшинд **харьцуулах**, буюу жишж, судлан буй үзэгдлүүдийн хоорондын **нийтлэг, онцлог, тусгай** шинжийг нээн илрүүлэхэд зориулагдсан **судалгааны арга** мөн болоход оршино. Энэ арга бол утгаа диалектикийн «ерөнхий», «тусгай», «онцгой» гэсэн гурвал категорийг эрх зүйн үзэгдэл, юуны өмнө түүх, гүн ухаан, ерөнхий ба салбар эрх зүйн онол, практикийн үзэгдэлд хэрэглэж байгаа нь болно. Эрх зүйн хөгжлийн дэлхийн болон улс дундын, мөн үндэсний хэмжээний **гол чиглэл, өвөрмөц байдал** хийгээд **давтагдашгүй (тусгай) онцлогийг** шинжлэх ухааны түвшинд тодорхойлоход түүний **зорилго, практик ач холбогдол** оршино. Эрх зүйн судалгаанд энэхүү аргыг өргөн хэрэглэж үр дүнг амьдралд нэвтрүүлэхэд **нэг талаар** эрх зүйн хөгжлийн олон улсын (даяаршлын) чиг хандлагыг; **нөгөө талаар** монгол орныхоо бүх талын өвөрмөц нөхцлийг тус тус зөв харгалзаж, **басхүү давтагдашгүй онцлогоо** нарийн тооцон үзэж байхыг ямагт бодолцож байвал зохино. Энэ бол харьцуулсан судлах аргыг хэрэглэхэд баримтлах зарчим, тавигдах бодит шаардлага мөн. Түүнээс биш бид бусад орон ялангуяа хөгжингүй орнуудын олон зуун жилийн заншсан хийгээд орчин үеийн шинэчлэгдсэн түвшиний эрх зүй, хууль тогтоомжийн практикийг харьцуулсан судлахдаа өнгөцөөр хуулан дууриах, туйлшруулан дөвийлгөж, өөрийн орныхыг үгүйсгэн буй үл ойшоон орхигдуулах, эсвэл судсанд ашигтай бөгөөд монголд нийцэлтэй практикийг үл хайхрахын аль аль нь Монголын харьцуулсан эрх зүйн шинжлэх ухаанд хийгээд аргад сөрөг нөлөөтэй. Ялангуяа

харьцуулсан судалгааны арга бол хуульч бүрийн үүрэг зорилгоо хэрэгжүүлэхэд хэрэглэх түгээмэл арга мөн. Өөрөөр хэлбэл, харьцуулсан эрх зүйг шинжлэх ухаан болохын хувьд нь зөвхөн энэ чиглэлээр мэргэсэн хуульч-судлаач эрхэлдэг бол судалгааны аргын хувьд хүн бүр хэрэглэх боломжтой юм. Харьцуулсан эрх зүйн:

«шинжлэх ухаан»

«Судалгааны арга» гэсэн энэ хоёр өөр утгыг, тэр нь хуульчдад хэрэг ямар хэмжээгээр холбогдох (хэрэглэгдэх)-ыг Рене Давид энгийнээр зураглал бичсанийг нь нотолгоо болгон дор сийрүүлэв.

«Бүх хуульч өмнөх зорилтоо их сайн биелүүлэхийн тулд харьцуулсан эрх зүйг сонирхох хэрэгтэй. Харьцуулсан эрх зүй бол хуульчдын нэг хэсэг нь зөвхөн арга, яг хэлбэл харьцуулах (судлах) арга, нөгөө хэсэгт нь огт өөр, эрх зүйг танин мэдэх шинжлэх ухааны харьцангуй бие даасан салбар мөн.

Харьцуулсан эрх зүйг зүгээр л арга болгон ашигладаг хуульчдын зэрэгцээ харьцуулсан судлаачид нь зөвхөн бусдаас ажил хэрэгтээ харьцуулалтыг амжилттай ашиглах хөрс суурийг нь бэлтгэж өгөх зорилго бүхий өөрийн гэсэн байр суурьтай.»⁴ гэжээ.

3. Харьцуулсан судлах аргыг хэрэглэхэд гардаг алдаанаас болгоомжил

3.1. Ажиллалт ба бусдын судалгаанаас үзэхэд

«Харьцуулсан эрх зүй», «харьцуулсан эрх зүй судлал» (шинжлэх ухаан), «эрх зүйн харьцуулсан судлах арга» гэсэн холбоотой боловч нарийн хэмжүүр (шалгуур)-ээр ялгагдах хэдэн ухагдахуун (нэр томьёо)-ны тухай дээр дурдав.



³ Ж.Амарсанаа, Б.Амарсанаа, Н.Отгончимэг нарын тус тусын дээр дурдсан ном зохиолд үз

⁴ Рене Давид, Камилла Жоффри Спиноза, "Основные правовые системы современности" М/О Москва, с. 14

Будуувчилбал манайхны нэрлэн буйгаар⁶ "харьцуулсан эрх зүй судлал" нь шинжлэх ухаан болохын хувьд "харьцуулан судлах аргыг" онол-арга зүйн үнднээс судлан боловсруулдаг. Өөрөөр хэлбэл тэр нь судлах зүйлийнх нь нэг. Дурдсан арга нь бас "харьцуулсан эрх зүй судлал"-д хэрэглэдэг (бусад түүхчлэх, логик шинжилгээний, социологийн тодорхой судалгааны гэхчлэн бусад аргын зэрэгцээх) гол арга. Энэ аргыг хэрэглэхэд ямар алдаа ихэвчлэн гэдгийг Оросын академик Ю.А.Тихомиров "залуу хуульчдад" зориулсан⁷ бүтээлдээ дэлгэрэнгүй авч үзсэн байна. Үүнээс санаа авч Монголынхоо өөрийн бодит "амьдрал"-ыг ажиглан үзэхэд харьцуулан судлах аргыг (нэг үгээр хэлбэл энэ тухай онолыг) хэрэглэхэд олонтаа ажиглагддаг болгоомжлоошгүй ганц хоёр алдаа хэрхэн гэдгийг энд тухайлан дурда!.

3.2. Объектоо буруу сонгох

Шинжлэх ухаан бол "бэгцэаллах, нуруундах"-ыг биш, ширхэгчлэн барьж авч, задлан үзэхийг шаарддаг. Эрх зүйд харьцуулах аргыг хэрэглэхдээ хооронд нь жишиж үзэх гэж буй асуудал буюу үзэгдлээ чухамхүү харьцуулсан эрх зүйн шинжлэх ухааны үнднээс урьдчилан сонгож тогтоох ёстой. Яг л химийн урвалг хийж туршидаг эхлээд түүнд орох элемент тэргүүтнээ илүү ч үгүй, дутуу ч үгүй олж тунгах хэрэгтэй шиг. Эрх зүйн судлал, туршилтад бол жишиж болохуйц буюу гол шинж бүрдлээрээ дүйхүүц үзэгдлүүдийг л харьцуулна шүү дээ. Улс бүр, улсын доторхи эрх зүйн салбар бүр харьцуулагдах, эс харьцуулагдах өөр өөр тогтолцоо, бүтэцтэй байдаг. Ижил хоёр нь даанч үгүй билээ. Бас харьцуулахдаа тодорхой зорилго, сонголт хийдэг. Номчирхох гэж биш, танин мэдэхээс гадна улсаа, эрх зүйн орчиндоо хэрэглэх, сайжруулах, шинэгтэх арга ухааныг олох, нэмэрлэх гэж харьцуулдаг. Харин харьцуулагдшагүй сонговол "халиох" тийш эргэнэ.

-эрх зүйн бүлүүдийн нийтлэг хандлага;

-Монголын үндэсний эрх зүйн өвөрмөц нөхцөл, зүй тогтол;

-бусад орны Монголд

"шилжүүллэн суулгаж" тохирохуйц үр ашигтай ололт энэ гурван талыг нэгэн зэрэг харгалзахад харьцуулсан эрх зүйн шинжлэл судлалыг чиглүүлэх нь зэрэг хандлага болно. Чингэхдээ зайлшгүй баримтлах нэг гол шаардлага буюу арга зүйн үндсэн зарчим нь «харьцуулагдах, эс харьцуулагдах» хоёрыг лавтай ялган үзэж сэрэмж болгоомжтой хандах явдал чухал юм. Энэ бол харьцуулсан эрх зүй судлалд гардаг элдэв алдаанаас сэргийлэн болгоомжлох гол арга зам мөн билээ. Энэ хүрээнд нэлээд давтагддаг алдаа нь:

Объект буюу судлагдахууны төрөл зүйлийг зөв сонгоход өөрийн бодит:

-эрх зүйн бүлийг зөв баримжаалах;

-үндэстэнүүдийн эрх зүйн тогтолцооноос өөрийн улсад боломжтой;

-эрх зүйн тогтолцооныхоо салбар, төрөл хэсэг (институт), түүдээрийн дэд хэсгүүдээс эргэнх үеэр нь онож сонгож (юм л бол «Монголд байгаагүй» гэж "залдгаа" үгэр түргэн хөсөр хаях) харьцуулах;

-үндэсний болон олон улсын эрх зүйн хамаарлыг үнэн зөв харгалзах;

-(Үндсэн хууль, эрүү, иргэний болон байцаан шийтгэх) тодорхой хуулийг эрэмбэлэн, төрөлжүүлж ерөнхий онолын хүрээнд тус тусад нь харьцуулан судалбал нийтлэг нь тулгуурлаж, онцлогийг олох, нөхцлөө зөв тодорхойлоход илүү боломж олоно.

3.2.1. Объектыг зөв сонгохид луужин (онол) хэрэгтэй. Бүхийн харьцуулалтыг барууны орнуудын болон мөн Оросын эрдэмтэд чамгүй судалж, нэлээд үндэслэгээ гаргасан байдаг. Францын нэрт судлаач агсан Рене Давидын «Орчин цагийн эрх зүйн үндсэн тогтолцоод» гэдэг бүтээл энэ талаар «сонгодогт» тооцогддогийг дурдахад илүүдэхгүй. Хуучин ЗХУ ба өнөөгийн ОХУ-д бусад орны Үндсэн хууль тогтоомжийг орчуулан цувралаар нийтэлж, АНУ, ХБНГУ, Франц, Япон зэрэг хөгжингүй орны эрх зүйн судалгааны томоохон бүтээлүүдийг олноор нь орчуулж шинжлэх ухааны

зохиж тайлбартайгаар нийтэлж ирсэн нь монголчууд бидэнд ч тус нөлөөгөө үзүүлсээр буй. Өдгөө манай залуу үеийнхэн Англия, Герман, Франц Хятад, Япон зэрэг хэлийг түргэн эзэмшиж байгаа нь мэдээлэл хүлээн авах чадавхийг эрс нэмэгдүүлээ. Өдөө онолын чадавхийг дээшлүүлэхэд онц анхаарах шаардлагатай байна. Ялангуяа харьцуулах зүйлийн нэг гол суурь тал болох "Монголоо" ултай судалж мэдэх хэрэгтэй нь бидэнд алхам тутам ажиглагдаж байна. Дэлхий гэж дээгүүр хий шуугилгүй дэргэдэхээ, төрөлх Монголоо мэд! Ингэхгүйгээр харьцуулах зүйл чинь хаягдлаа шүү гэмээр ажиглагдана. Цаадуул чинь бидэнд «Та нар манайхныг харьцуулаад өгчихөөч» гэхгүй «өөрсдийгээ л янзал» гэх байх шүү.

Монголын эрх зүйн салбаруудыг, ялангуяа дэд салбар, төрөл хэсгийг "дэлхийн эрх зүйн" тохирох бүлийн дотор нь биш, харин түүний дотор харьцуулалг хийлгүй алгасч, эсвэл нийлэмж муутай өөр өөр бүлээ аль нэг хэсгийг таслан авч харьцуулах хийгээд хэрэглэхийг оролдох нь элбэг үзэгдэх болжээ. Энэ хандлага танин мэдэхүүд төөрөгдөл авчирч, Монголын эрх зүйд хямрал нүүрлэхэд хүргэх нь гарцаагүй юм.

Нийтийн эрх зүйн хүрээнд гэхэд л төрийн байгуулалт, шүүх эрх мэдлийн асуудлаар аль «наашаа» гэсэн орны хууль зүйн практик судалж (утгаа өнгөц танилцаж) түгээмэл (common) болон эх газрын эрх зүйн хэм хэмжээ, практикийг хольцолдуулан бүдүүлж байна. Алх, тодорхой баримт гээл өнөөдөр төрийн удирдлагын ("засаглалын" гэх болж) хэлбэр, дэглэмийг харьцуулахдаа юуны урьд парламентын болон Ерөнхийлөгчийн бүгд найрамдах улсуудын Үндсэн хуулийг эрх зүйн практикийг биш, Үндсэн хууль болон хоёрдмол хаант засагтай Англи, Японыхыг судалж гул барих болсон нь гайхалтай. Яагаад гайхалтай гэвэл Үндсэн хуультаа хаант засгийг судалж болохгүй гэдэг талаасаа биш, адил төстэй хоёр дүрсийг алгасаад Англиа нь хачирхалтай. Ингээд л парламент,

⁶ Амарсанаа Б, Отгончимэг Н. нарын тус тусын номын нэр нь ийм. Өмнө дурдсангүй зүйл
⁷ Ю.А.Тихомиров. Курс сравнительного правоведения. Москва., 1996, с.422

Засгийн газар хоёроо холиод, төрийн тэргүүнээ гаргуунд нь хаядаг болж байна. Энэ бол «байнд ч үгүй, банзанд ч үгүй» гэгчийн жишээ юм.

Хувийн эрх зүй ч ялгаагүй. Иргэн, газар, экологийн эрх зүйд юу болж байна. Жишээлбэл, ашигт малтмал өмчлөх, зээмших, ашиглах талаарх хууль тогтоомж гэхэд эдгээр объектын нь хувийн өмчид байдаг орны хуулийг дууриалгаж, тэдгээр орны "зөвлөх"-үүдийг сонсчихоод Монголд энэ нь ард нийтийн хөрөнгө, төрийн (улсын) өмч гэсэн хууль, танин мэдэхүйн утгыг хүртэл алдагдуулж, асар их баялаг уурхайгаа хэдхэн долларын лицензээр хувийн өмчид шилжүүлдэг болов. Өөрөөр хэлбэл, Үндсэн хуулиа "хуга нуга" зөрчөөд улсын хөрөнгийг үзэгдэгүй ихээр завшилдаж үндэсний аюулгүй байдалд харш нөхцөл бүрдүүнхэд чирч гулдарч байна.

Уг нь зэсийн нөөцөөр алдартай Чийнин зэрэг орны төрийн өмчийн ордуудын тухай хууль, ХХ зууны эхэн үеийн буюу Богд хаант Монгол Улсын дэг журамтай жишээл Монгол түмэнд маань илүү нийлэмжтэй, тустай шүү дээ. Дээр нь онцлон хэлэхэд эрх зүйн тогтолцоо бол улс улсаа яахын аргагүй онцлогтой, өөр өөрийнх нь байдаг. Ийм болохоор хотонд байгаа хонинхооо хүч тэргүүт гадаадын биш, Монгол малчлаараа шинжүүлж үгийг нь сонсдог байвал тэнгэр суудалтнуудад газар дээр тогтох цаг нь уртасмаар.

3.3. Харьцуулах зүйлсийн түвшинг тохируулан сонгох нь
Энэхүү нэгэн гол шаардлагыг эс анзаарснаас элдэв гажилт үүсч байна. Бид бараг л хэнээрхэж, хэтэрхий давилуун хандаж байгаа гэмээр ч юм шиг. Түүнийг тод жишээ нь, эрх зүйн хоёр түвшний тогтолцоотой холбоот улсуудын дээд түвшинтэй нь өөрийн орны эрх зүй, хууль тогтоомжийг жишмхийг урьтал болгодог. Тэгсэнээр арга буюу ихээхэн зөрүүтэйг (тийм байлгүй яахав бидэнд ахдах юм чинь) олж хармагцаа «Монголынх» болохгүй байна гэх ухааны том том хийсвэр дүгнэлт хийдэг өвчин дэлгэрч байна. Энэ бол "харьцуулшгүй" харьцуулсны уршиг юм.

Ягаад ингэдэг билээ гэхээр бид чинь өөрийгөө мэддэггүй, "жижигхэн" (ирээдүй тогморно) орон гэдгээ анзаарахгүй их гүрнүүдтэй дүйж империализмд шийдвэрлэх цохилт өгнө" гэж хийрхэж байсан улс. Бодоод байхад бидний монголчууд нэг талаар их гүрний удамтай, нөгөө талаар хоёр зөрш маань их гүрэн байдаг болоод ч тэрүү өөртэйгээ дүйх түвшиний орнуудын жишгийг биш, өөрөөсөө асар том, огт өөр байгууламжтай орны жишээг загварчлан хуулах гэж оролддог зуршилтай. Одоо ч энэ «өвчин» бүрэн илааршаагүй байна. Жишээлэхэд, Монгол нь төрийн байгууламжийн хувьд нэгжээс (баг, сум, аймгаас) бүрддэг нэгдмэл улс. Тийм байтал гишүүн (муж) улсуудаас бүрддэг АНУ, ОХУ зэрэг их гүрнүүдийн төрийн байгууламжийн эрх-зөхион байгуулалтын үндсийг (зөвхөн холбооны түвшинд нь "харьцуулж") хууль, номоо бичиж, боловсруулдаг, зарладаг. Нутгийн захиргааг өөрчлөх төсөл хийхдээ л 200 хол давсан сая хүн амтай АНУ «50 аймагтай» байхад 2 сая гаруйхан хүнтэй манай «Монгол 21 аймагтай» байна, юу болж байна аа" гэхлэн уухайлдаг. Тэнд 50-ийн 1 муж улс нь хэдэн арван мянган "Каунти" (сумтай) байгааг огт судлан үзэлгүй дээгүүр шуурч олны, юуны өмнө дарга нарынхаа толгойг эргүүлдэг. Энэ мэт нь аргагүй л хулгана заантай гэрлэсэн тухай онигоог санагдуулдаг.

Эр хулгана эм заантай гэрлээд сарын дараа найзуудтайгаа уулзахдаа яс арьс болтоо турж ядарсан байж. Үүнийгээ тайлж ярихдаа: "эвэрга амьтантай гэрлэсэнээ л боллоо. Хошуун дээр нь очиж үнээд "бөгсөн" дээр нь очих, тэндээс буцаж хошуунд нь гэж нуруун дээгүүр нь хоёр тийш гүйсээр ийм болов гэж. Хэсэг хугацааны дараа уулзахад хулгана ихэд таргалж өнгө зүс орсон байж. Учрыг лавлаал: "Өвөн чинь уруул дээр нь очихоо больж урьдын нэг л газраа суудаг болсон" гэх ухааны нэг онигоо бий.

Жижиг улс бүхэл бүтэн холбоот их гүрний хэв загварыг бүх арга ясаар нь хуулах гэж

оролдох биш, өөрт хэрэгтэй газар нь, тохирох юмаа тааруулж олж жиших хэрэгтэй энэ онигоо сануулж байна.

Дээрх байгууламжийн асуудлыг бид холбооны түвшинд нь биш харин муж улсынхтай нь буюу өөр нэгдмэл улсынхтай харьцуулбал илүү тохиромжтой биш үү. "Сав саванда" гэдэг шүү дээ. Энд бас "харьцуулагдах", "эс харьцуулагдах"-ын учир шалтгаан оршино. Залуу судлаач Б.Амарсанаа харьцуулсан эрх зүйн судалгаа хийж гэж зориглоод «харьцуулж болох эсэхийг тунгаах» нь уул судалгааны анхны дүрэм болно гэж зөвлөснийг хүлээн зөвшөөрч хэрэгтэй юм.

Хувийн туршлагаас үзэхэд бид захиргааны эрх зүйн шинэтгэлийн тухайд "эх газрын" гэдгээр нь ХБНГУ эрх зүй бүлийн хувьд баримжаалж, харин хууль, тогтолцооны хувьд илүү дүйцэхээр нь түүний Муж улс (жишээ нь Бааври, Бранденбург зэрэг) буюу Зөмөлийн түвшинг шууд харьцуулж судлаад өвөрмөц нөхцөлөө харгалзан боловсруулсан байсан. Гэтэл Үндсэн хуулийн Цэц холбооны хэмжээнд зэрвэсхэн хараад л хуульд ноцтой буруу өөрчлөлт хийлгэж бидуулан иргэдийн эрхийг хохироох орхиё. Энэ бол объектын түвшинг буруу ухаарч харьцуулагдашгүй хоёр зүйлийг шууд холбоон үзэх гэсний алдаа мөн.

Тэгэхээр бүл, түвшин, зүйлийн хувьд харьцуулагдахуунаа зөв сонгож байгууштай. Сүүлийн үед зарим залуу "Монгол-Их Британий жишгийн эрх зүй" гэсэн чиглэлээр сонголт хийн сонирхолтой судалгаа явуулсан байна. Бусдыг танин мэдэхүйн ач холбогдолтой боловч Монголд 1921 оны хувьсгалын өмнөх «Улаан хацарт» (Шашны шүүхийн хэрэг шийдсэн данс бүртгэл)-ыг эс тооцвол албан ёсны "шүүхийн прецидент байгаагүй". Иймд "хэрэглэдэг", хэрэглэх боломжтой гэх санаа эх газрын тогтолцоот орны эрх зүйд нэлээд эргэлзээтэйг эрдэмтэд хэдийнэ тэмдэглэсэн байдгийг бодууштай.

Чингэхдээ эх газрын бүлийг жишиг болгох ерөнхий чиг шугамаа баримтлахын сацуу бусад бүлийн орны эрх зүйгээс, тэгэхдээ хууль

¹ Ухаачиг Батболдын Амарсанаа, "Харьцуулсан эрх", УБ, 2005 он, 17 дахь тал

² Захиргааны хэрэг янхан шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлээс зарим заалтыг хасуулж Засгийн газар, сонгуулийн маргааныг Захиргааны хэргийн шүүхийн бүрэн эрхээс хасаж тонуулсныг хэлэв-Б.Ч

тогтоомжоос нь эх газрынхтай ижилсэх илүү сайн практикийг оновчтой сонгон хэрэглэх болохыг үгүйсгэхгүй. Прецедентийн тухайд Англи-Саксоноос эх авсан жишээлбэл **тангаратгны шүүх дэх мэтгэлцэх зарчмыг** хэрэглэх оролдлогод мөрдөн байцаалтын нотолгоонд голлон үндэслэдэг эх газрын эрүүгийн шүүх эрх зүйд хэр тохирч байна вэ? Хуульд бичиж болох боловч мэтгэлцээн нь практикт нотлох баримтын үнэлэмжгүйд хүрээд байгааг анзаарахгүй, ёс болгоод байгаа юм биш биз!!! Энэ хандлагыг эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн харьцуулсан судалгаанд гүнзгий авч үзмээр бодогдоно.

3.4. Бүгдийг харьцуулах гэсэн хандлага байж боломгүй

Харьцуулсан эрх зүйд ашиглагдаж буй бас нэг анзааруштай (зөв, бурууг дүгнэх гэсэнгүй) зүйл бол **бусад улсад байдаг бүхэн Монгол Улсад байх ёстой, Монголд байгаа бүхэн бусад улсад байдаг юм** шингээр сэтгэх хандлага юм. Улсын Их Хурал дээр байн байн сонсогддог "дэлхийн бүх улс ийм байдаг" гэдэг үг бий. Иймэрхүү тойм хандлагаас үүдээд монголын эрх зүйг "бүх бүлийн хамаатан" болгож орон орны тохирох, тохирохгүй эрх зүйн дэглэм, хууль журмыг учрыг нь тунгаахан, үгүйгээр хуулбарлах болсон явдал юм. Иргэний хуулиа хар! Төсвийн хууль тогтоомжоо хар! Төвлөлийн багасгах Засгийн газрын хөтөлбөртэй атал Шинэ Зеландаас «Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн» маягийн хууль зөвөөрөн ирж захиргааднын үед ч байгаагүй бараг л "дайнс үеийнх" шиг хатуу төвлөрөл бий болгож, аймаг, сумын орлого, зарлагын төсвийг устгаад орон нутгаа хоосолж, олон сайдаа санхүүгийн "магнатууд" болгоод байна. Хажуугаар нь Шведийн вант улсаас нутгийн захиргааны шинэтгэл (реформ)-ийг судлан нэвтрүүлж "төвлөрөл сааруулж байна" гэж лоозондоод жил бүр цөөнгүй тооны судлаач, түшмэд тэр улсаар аялж, "төсөл тэргүүнтэн

хэрэгжүүлээ" гээд байна. Түүнээс сум, багт юу наалдан. Хатан хаант Англи буюу Их Британи Умард Ирландын вант Улсаас парламент Засгийн газрын "хелиос", парламент дахь намын арга барилыг авлаа гээд одоо юунд хүрээв? АНУ-ын Холбооны (дээд түвшиний) засаг захиргаанаас "агентлаг" аваад яамтай зөрүүлж олшруулснаас өөр дорвитой хожсон нь юу байна вэ? Эдгээр улстай харьцуулж болохгүй гэсэндээ биш. Харин харьцуулшгүй зүйл, дүйхгүй түвшинг нь объект болгосныг шүүмжилж байна.

Багцлан ярьвал ийм зүйл олон байгаа ч энэ бүхнийг харьцуулсан эрх зүйн үүднээс нэгтгэн дүгнэсэн нь нэн ховор үзэгдэнэ. Судлаачид маань гол төлөв гадны мэдээлэл цуглуулан дамжуулж, хууль хуулж, эсвэл номоос ном бүтээж байгааг хэлэхэд хатуудахгүй.

4. Дүгнэлтийн оронд

Энд эрх зүйг зөвхөн бясалгах биш, харин өөрчлөн шинэтгэж, зөвтгөн сайжруулахад харьцуулсан судалгааны гол зорилго оршиж байна. Өөрийн эх сурвалжийг өрөөллийнхтэй орон зай, цаг хугацаа, нийгэм байгалийн, түүх иргэншлийн нөхцөлд нь жишиж шинжиж, дүгнэх, зөвлөх нь харьцуулсан эрх зүй судлалын эрхэм шаардлага мөн.

Энэ талаар мөнөөх Рене Давидаас дахин дурдууштай: Харьцуулсан эрх зүй манай (XX) зууны эхээр эрчимтэй хөгжиж өнөө үед эрх зүйн шинжлэх ухаан, соёлын чухал язгуур махбодь болов. Эхэн үед, "эрх зүйн шинжлэх ухааны бие даасан салбар уу, шинжлэх ухааны харьцуулсан судлах арга уу", түүний мөн чанар, судлах зүйл, арга зорилго, шинжлэх ухаанд эзлэх байр, хэрэглэгдэх хүрээ гэхчлэн маргаан өдгөө хуучирч харьцуулсан эрх зүй хөл дээрээ босов".

Харьцуулсан эрх зүй нь эрх зүйн түүх, гүн ухаан, ерөнхий онол, хийгээд салбаруудад хэрэглэгдэж үндэсний эрх зүйг сайтар судлан мэдэх хийгээд боловсронгуй болгох боломжийг

олгодог⁹ гэж тэмдэглэжээ¹⁰.

Тийм ээ мэдэх, хэлэхээс гадна хийж бүтээх гэж судалдаг. Эцсийн хүчээ шавхах зүйл чинь бүтээхэд оршино. Ингэж үзэх нь зөв бол Монгол Улс эрх зүйнхээ шинэтгэлийг гүнзгийрүүлж буй өнөө үед харьцуулсан эрх зүйг:

-шинжлэх ухааны салбарын хувьд нь эрчимтэй хөгжүүлэх («харьцуулсан судалгааны ажлыг төвшүүлэн зангиддаг эрх хэмжээтэй аппарат»¹¹ судлаачдыг бие болгох зэргээр),

-судалгааны аргын хувьд нь өргөн бөгөөд оновчтой хэрэглэх, хуульч бүр суралцах явдал улам чухал болж байна. Энэчлэн хоёр талаасаа хичээвээс бид харьцуулсан эрх зүйг нэг талаар шинжлэх ухаан, нөгөөтэйгүүр судалгааны арга болгож чадна. Тийм чухал хэрэгцээ ч байна.

Гэхдээ харьцуулж судлахын оронд хаа хамаагүй зүйл хуулбарлахыг тэвчшлгүй. Академич Ж.Амарсанаа тэмдэглэн бичихдээ «УИХ-ын хууль тогтоох ажиллагааны сүүлийн 10 гаруй жилийн дүр зургийг тоймлохдоо зарим асуудалд шүүмжлэлтэй хандах нь зүйтэй... Энэ нь цаашид хуулийг цэгцлэх сайжруулахад хэрэгтэй байж болох талтай. Үүнд хууль батлахдаа үзэл баримтлалгүй байх, эрх зүйн тогтолцооны үүднээс асуудалд хандахгүй байх... гадны хуулийг хийсвэрээр хуулах зэргийг дурдаж болох юм. Ялангуяа Үндсэн хуулийн үзэл баримтлалд нийцээгүй эрх зүйн энэ бүрийн тогтолцоотой орны хуулийг хуулбарлаж байгаа нь хууль тогтоомж дотооддоо авчлалдаа муутай, зөрчилтэй болж хэрэгжих, бататгах үр нөлөө нь муу болдог байна» гэхчлэн тэмдэглэжээ¹². Академич С.Нарангэрэл, шинжлэх ухааны доктор, профессор Н.Лундэндорж нарын олон улсын энэ хуралд сонгож буй үндсэн илтгэлд энэ санаа туд тусгалаа олсон байна. Түүнд миний энд дурдсан болох, болохгүй санаа тус дэм, бас өдөөгүүр болохсон болов уу.

CR CR CR

⁹ Рене Давид, Камилла Жозеффе-Слинози, "Основные правовые системы современности" М/О Москва, 1990, с.8-9

¹⁰ Мөн ном, 11 дэх тал

¹¹ Баасан-Л. "Нийтийн ба хувийн эрх зүй: Харьцуулсан судлал". Эрдэм шинжилгээний семинар, илтгэлийн эмхтгэл. УБ: 2006 он, 8 дэх тал

¹² Амарсанаа,Ж. "Монгол Улсын эрх зүйн тогтолцоо ба харьцуулсан эрх зүй судлалын хөгжил". (Монгол Улс дахь эрх зүйн шинэтгэл ба харьцуулсан эрх зүй судлалын хөгжил) ХЗУТ. УБ, 2004 он, 11 дэх тал.

ОРОСЫН ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙ ДЭХ ЯЛ ШИЙТГЭЛИЙН ЗОРИЛГЫН ТУХАЙ

Эрүүгийн ял шийтгэл нь гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн зайлшгүй шаардлагатай, нэмэгдэл хэрэгслүүдийн нэг юм. Төр засгаас ял шийтгэлийн өмнө тавьж буй зорилт, түүнд хүрэх байдал нь эрүүгийн болон засан хүмүүжүүлэх бодлогод зайлшгүй нөлөөлөхөөс гадна гэмт хэрэгтэй бүхэлд нь тэмцэх үр дүнд нөлөөлөх юм.

Энэ асуудлыг шийдвэрлэх нь хүний эрх чөлөөг хасах ял шийтгэлийг эдлүүлдэг байгууллагуудын үүрэг зорилго, үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлоход зарчмын ач холбогдолтой, ганц хорих байгууллагуудын ч биш мөн бусад төрлийн ял шийтгэлийг эдлүүлдэг төрийн байгууллагуудад мөн адил ач холбогдолтой болно.

Тиймээс эрүүгийн эрх зүйн ял шийтгэлийн зорилгын асуудал нь салбар хоорондын шинжтэй юм.

Эрүүгийн ял шийтгэлийн зорилгын талаар өргөн хүрээтэй ярьж судалсан хэдий ч энэ асуудлыг шийдвэрлэсэн гэх нь эрт байгаа юм. Үүнтэй холбогдуулаад үзэл бодлоо илэрхийлэх гэсэн юм.

ОХУ-ын Эрүүгийн хуулийн



Авлигатай тэмцэх газрын
Мөрдөн шалгах хэлтсийн
мөрдөн байцаагч, комиссар,
докторант
Д.ЗОЛЖАРГАЛ

43.2-т ял шийтгэлийг нийгмийн шударга байдлыг тогтооход, ял шийтгэгдсэн этгээдийг хүмүүжүүлэх, гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилготой тэмцэх.

Энэ талаар Монгол Улсын хэмжээнд 2002-2006 оны хооронд шүүхээр ял шийтгүүлсэн ял шийтгэлийн байдлын судалгааг дараах байдлаар авч үзвэл:

Үүнд:

Өнөө үед ял шийтгэлийг

мөн чанарын хувьд үйлдсэн гэмт хэргийнх нь төлөө оноож байгаа залхаалт юм гэсэн бүх нийтээр хүлээн зөвшөөрсөн үзэл байдаг. Энэ үзэл санааг тогтсон, эрүүгийн болон ял шийтгэл эдлүүлэх эрх зүйн онолын хувьд зөв гэж үзэж болох юм. Иймээс бидний үзэж байгаагаар ОХУ-ын Эрүүгийн хуульд ял шийтгэлийг үйлдсэн гэмт хэргийн төлөө оноож байгаа цээрлүүлэлт биш харин төрийн албадлагын арга хэмжээний нэг гэж үзсэнээрээ нэг алхам ухарч байгаа юм.

Үр дүнд нь эрүүгийн эрх зүйн тодорхой байсан ойлголт нь тодорхойгүй, "угаагдсан" байдалтай болсон. Төрийн албадлагын арга хэмжээ асар их байхад үйлдсэн гэмт хэргийнх нь төлөө ял шийтгэл ногдуулах цээрлүүлэлт зөвхөн эрүүгийн эрх зүйд хамаардаг.

Үүнээс гадна хуульд "ял шийтгэл" –ийг тодорхойлсон байдаг нь онолын ач холбогдолгүй гэж бодож байна. Хийгдсэн тусгай судалгаануудын үр дүнгээс харахад энэ ойлголт, агуулга, утга санаа нь нийгэмд хангалттай ойлгомжтой байдаг юм байна.

Шүүхээс ногдуулсан ял шийтгэлийн байдал хүснэгтээр

д/д	Ялын төрөл	Бүтэн жилд				
		2002 он	2003 он	2004 он	2005 он	2006 он
1.	Нийт ял шийтгүүлсэн	13007	9029	9473	10153	7792
	Хорих ялаар бүгд	9577	6561	6686	6947	5454
	а/ Хорих ялыг биечлэн эдлүүлсэн	4552	2869	2926	3136	2660
	б/ Тэнссэн	4014	2794	2886	2915	1930
	в/ Ял эдлүүлэхийг хойшлуулсан	782	883	858	888	480
2.	Өршөөл үзүүлсэн	229	15	16	8	384
	Хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн	3412	2468	2661	3106	2314
	а/ Торгох ял	2964	675	672	745	609
	б/ Албадан ажил хийлгэх ял	40	271	396	645	538
	в/ Баривчлах ял	371	1492	1593	1716	1167
3.	Бусад ял	-	-	22	31	24
4.	Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ	-	-	104	69	-

Тиймээс хуульд зөвхөн ял шийтгэлийн зорилгуудыг л тодорхойлсон байх хэрэгтэй юм. Ял шийтгэлийн онолын нэг маргаантай асуудал нь залхаан цээрлүүлэх нь ял шийтгэлийн зорилгын нэг мөн үү гэсэн асуулт юм. Ихэнх эрүүгийн чиглэлийн эрдэмтэд залхаалтыг ял шийтгэлийн зорилгын нэг биш гэж үздэг байна. Бидний бодлоор төр ял шийтгэл ногдуулахдаа бусад зорилгын адил үйлдсэн гэмт хэргийн нь төлөө шударга залхаалтыг оноох зорилгыг агуулдаг.

Ял шийтгэлийн зорилгын нэг нь залхаан цээрлүүлэх явдал гэж үзвэл залхаан цээрлүүлэх гэдэгт гэмт этгээдэд түүний үйлдсэн гэмт хэргийнх нь өр төлөөсөнд түүнд зовлон шаналаа учруулах гэж ойлгоно /Н.А.Беляев, Ингахдээ "залхаан цээрлүүлэлт", "өр төлөөс" гэдгийг гэмт хэрэгтэнд өс хонзон санах гэдэгтэй адилтгаж үзээгүй байдаг. Тиймээс зөвхөн шударга, гэмт этгээд болон түүний үйлдсэн гэмт хэрэгт нь тохирох шийтгэлийн тухай ярьж байна гэдгээ тодотгох хэрэгтэй. Хэрэв оноосон шийтгэл нь нийгмийн зүгээс тавигдах үйлдсэн гэмт хэрэгт ял шийтгэлийг гарах ёсгүй гэсэн шаардлага, хүсэл сонирхолд нийцсэн, гэмт хэргийн гэм бурууд нь тохирсон тохиолдолд ийм шийтгэлийг ард иргэд шударга гэж үздэгийг үгүйсгэж болохгүй юм. /Б.С.Утевский, А.Л.Ременсон /.

Гэмт этгээдэд шударга ял шийтгэл оноож нийгмийн гишүүдийн хүсэл зорилгыг хангахдаа ард иргэдийнхээ шударга ёс, ёс суртахууны зарчмуудын тухай ойлголтуудаас хэрхэвч зөрөлдөж болохгүй, учир нь энэ нь төр засгийн хэвийн үйл ажиллагааг хангахад ашиг тустай байх төдийгүй иргэдийнхээ хууль болон хууль сахиулах байгууллагуудад итгэх итгэлийг бэхжүүлж, гэмт хэрэгтэй гэмтлээс үйл ажиллагаанд үр ашгтай байх болно.

Эрүүгийн хууль тогтоомжид хийсэн задлан шинжилгээгээр шударга залхаан цээрлүүлэлт нь ял шийтгэлийн нэг зорилго юм байна гэдэг дүгнэлтэд хүргэж байна.

Энэ нь ялангуяа хүнд, онц хүнд гэмт хэрэг үйлдсэн хүмүүст ял онооход илүү харагдаж байгаа юм.

Энэ үзэл бодлоо батлахын тулд доорхи нөхцөлүүдийг дурдаж

болох юм. Үүнд:

1/ шүүхээс гэмт этгээдэд ял оноохдоо зөвхөн гэмт хэрэг үйлдсэнийх нь төлөө ч биш мөн үйлдсэн гэмт хэрэгт нь ял шийтгэл оноодог. Тиймээс Эрүүгийн хуульд заасан ял шийтгэл нь үйлдсэн гэмт үйлдлийнх нь нийгмийн аюулын хэр хэмжээ, шинж чанарт нь тохирсон байх учиртай.

А.А.Жижигленко цагтаа /1924г./ шийтгэл нь ял шийтгэлд тодорхой агуулга, утга санааг өгч, үүгээрээ ял шийтгэлийг бусад ижил төстэй эрх зүйн хамгаалах хэрэгсэлээс ялгаж өгдөг, шийтгэлийн зорилго нь янз бүр байдаг бөгөөд нийгмийн хөгжлийн явцад өөрчлөгдөж болно, гэхдээ ямар ч тохиолдолд шийтгэл нь ял шийтгэлийн дотоод агуулга, мөн чанарыг хаах ёсгүй" гэж бичиж байжээ.

2/ ял шийтгэл оноохдоо шударга цээрлүүлэлтийн зорилгыг хангах гэж байгаа гэдгийг хугацаанаас нь өмнө тэнсэн (ОХУ-ын Эрүүгийн хуулийн 79 дүгээр зүйл) тухай хэм хэмжээнээс дүгнэж болох юм.

Одоо үйлчилж байгаа хуульд энэ хэм хэмжээг хэрэглэхийн тулд хоёр нөхцөл байдлыг харгалзан үздэг:

а/ шүүх ял эдэлж байгаа этгээд засарч хүмүүжихийн тулд заавал оноосон ялыг дуусгал эдлэх шаардлагагүй гэж үзэх,

б/ хуульд заасан ялын хагасыг биеэр эдлэх шаардлагагүй тохиолдолд.

Хэрэв хуульд заасан эдлээл зохих ялынхаа зохих хэмжээг эдлээгүй тохиолдолд шүүх тухайн хүнийг засарч хүмүүжихийн тулд үлдсэн ялыг заавал бичлээн эдлэх шаардлагагүй гэж үзсэн ч тухайн хүнийг суллах боломжгүй.

Ялан хуульд заасан эдлээл зохих ялынхаа зохих хугацааг эдлээхээс ч өмнө засарч хүмүүжиж болно шүү дээ. Тэгвэл ягаад хууль түүнийг чөлөөлөхийг хориголд байдаг билээ? Бидний үзэж байгаагаар түүнийг суллах боломжгүй явдал бол тухайн гэмт этгээд үйлдсэн гэмт хэргийнхээ төлөө хүлээвэл зохих цээрлэлийн хамгийн бага хугацааг ч эдлээгүй байгаа явдал юм байна.

3/ гэмт хэрэгтэнд ялын дээд хэмжээг онооход гэмт этгээдийг цээрлүүлэх гэсэн зорилго

тод томуруунаар харагддаг. Энэ тохиолдолд ял шийтгэлийн засан хүмүүжүүлэх зорилго шууд хаягддаг.

Төр ялын дээд хэмжээг оноохдоо гэмт хэрэгтнийг шударгаар залхаан цээрлүүлэх зорилго тавьдаг.

Ял шийтгэлийн зорилгын талаар ярихдаа ял шийтгэлийг хэрэглэдэг, хэрэгжүүлдэг, эрх зүйн тодорхой хэмжээний ухамсартай төрийн албан хаагчдын болон олон нийтийн үзэл бодлыг харгалзан үздэг байх хэрэгтэй.

Тиймээс залхаан цээрлүүлэлт нь ял шийтгэлийн нэг зорилго мөн үү гэдэг асуултын хариуг нийгмийн болон тусгай сэтгэл зүйн орноос хайх хэрэгтэй, логикийн болон хууль зүйн аргууд нь шахагдсан хэрнээ одоог хүртэл хэн нэгнийг итгүүлээгүй байгаа билээ.

Бид ялтнууд өөрсдөө болон ард иргэд залхаан цээрлүүлэлтийг төрийн ял шийтгэлийн нэг зорилго гэж хүлээж авч байгаа эсэхийг судлах хэрэгтэй гэж үздэг.

Ял шийтгэлийг хэрэглэдэг эрх бүхий алба хаагчдын дунд хийсэн судалгаагаар доорхи зүй харагдаж байна. Судалгаанд оролцсон 300 шүүгчийн 84 хувь нь шийтгэл тогтоол гаргахдаа шударга залхаан цээрлүүлэлтийг бусад ял шийтгэлийн нэгэн адил цаад гэм буруутай этгээдэд оноодог гэжээ. Судалгаанд оролцсон 300 прокурорын 74 хувь нь мөн шүүгч нартай ижил төрлийн хариулт өгсөн байна. Тэгвэл ОХУ-ын Хууль зүйн яамны удирдлага эрх зүйн Академид мэргэжил дээшлүүлж байгаа хорих байгууллагуудын төрөл бүрийн түвшний алба хаагчдаас судалгаанд оролцсон 800хүний 92 хувь нь хорих ял эдлүүлэх ял шийтгэл бол үйлдсэн гэмт хэргийнх нь төлөө оноож байгаа шударгаар залхаан цээрлүүлэх зорилготой гэж хариулав.

Төвийн хэвлэлүүдэд хийсэн судалгаанаас үзэхэд энэ талаарх олон нийтийн үзэл бодол харилцан адилгүй байдаг ч ихэнх нь ял шийтгэлийг чангатгахын тулд байдаг байна. Үүнээс үзэхэд эрдэмтэд, хорих байгууллагын ажилтнууд болон шүүгч, прокурор нарын үзэл бодолтой ард иргэдийн санал хол зөрүүтэй байна. Ард иргэдийн санал буруу гэж хэлэх

үндэслэлгүй бөгөөд энэ байдлыг нь харгалзан үзэхгүй байхын аргагүй юм.

Энэ асуудлыг судлах явцад хууль тогтоомжид заагдсан ял шийтгэлийн зорилго нь амьдралын бодит байдлыг тэр болгон илэрхийлэхгүй байгаа билээ.

Өнөөгийн нийгэмд ял шийтгэл нь засан хүмүүжүүлэх, урьдчилан сэргийлэх зорилго бүрэн дүүрэн биелүүлж чадахгүй байгаа нь нууц биш юм.

Гэмт хэрэгтэн болгон ял шийтгэл эдэлсэнээрээ засарч хүмүүждэггүй, хорих ял эдэлж байх хугацаандаа ч дахин гэмт хэрэг үйлддэг мөн тэр болгон зарим иргэний хувьд урьдчилан сэргийлэх арга хэмжээ болж чаддаггүй.

Хэрвээ ял шийтгэл оноосноороо нийгмийн шударга байдлыг сэргээж гэдэг зорилго тавих юм бол бидний үзэж байгаагаар нийгмийн шударга байдлыг хэзээ ч ямар ч төрлийн гэмт хэрэгт эрүүгийн ял шийтгэл оноосноор сэргээх боломжгүй. Тиймээс хууль тогтоомжид ийм зорилго тавих нь зүйд нийцэхгүй.

Дээрх байдлаас үзэхэд төр ял шийтгэл ногдуулаад хуульд заасан нэг ч зорилгодоо хүрэхгүй байна гэж үзэхээр байна. Гэхдээ бодит байдалд тийм биш юм. Төр хорих ял оноосноороо нийгмийг гэмт халдлагаас хамгаалах зорилгодоо хүрч байгаа юм.

К.Маркс ял шийтгэлийг "нийгэм өөрийн оршин тогтнох нөхцөл зөрчигдөхөөс өөрийгөө хамгаалж байгаа хэрэгсэл" гэж зүгээр ч нэг хэлэлцэж байх. Гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгэмээс тусгай байранд тусгаарлаж байгаагаараа төр нийгмийг түүний халдлагаас

хамгаалж нийгмийг гэмт хэрэгтнээс хамгаалах гэсэн зорилгодоо хүрч байгаа юм. ОХУ-ын Эрүүгийн хуулийн зорилт нь нийгмийн харилцааг гэмт халдлагаас хамгаалах, энх тайван, хүмүүсийн аюулгүй байдлыг хамгаалах, гэмт хэрэгээс урьдчилан сэргийлэх явдал мөн гэж ОХУ-ын Эрүүгийн хуулийн 2 дугаар зүйлд заасан байдаг, харин эдгээр зорилгоо хамгаалахын тулд ОХУ-ын Эрүүгийн хууль нь эрүүгийн хариуцлага ногдуулах зарчим, үндэслэлийг тодорхойлж мөн ямар нийгэмд аюултай үйлдлийг гэмт хэрэг гэж тооцох вэ, гэмт хэрэгт ямар ял шийтгэл болон эрүүгийн ямар бусад хариуцлагын арга хэмжээ оноох вэ гэдгийг тогтоосон байдаг.

Тэгэхээр ял шийтгэлийн нэг зорилго нь нийгмийг гэмт халдлагаас хамгаалах явдал гэдгийг хэлэх нь зүйд нийцэх байх.

Энэ зорилгод гэмт хэрэг үйлдсэн, гэм буруутай хүнд хуульд заасны дагуу шударга ял шийтгэлийг оноох тохиролдол бүртээ төр хүрч байгаа юм. Үүнтэй холбогдуулаад нийгмийг гэмт халдлагаас хамгаалах гэсэн зорилгыг ял шийтгэлийн нэг зорилго болгон хуульчлах ёстой байх.

Үүнээс үүдэн эрүүгийн хууль тогтоомжийн хамгаалах зорилго болон ял шийтгэл хоёрын хооронд ямар ялгаа байгаа юм бэ гэсэн асуулт зүй ёсоор тавигдах болно. Ялгаа бий /нэлэн том ялгаа бий/ нийгмийн харилцааг хамгаалах зорилго эрүүгийн хууль тогтоомж нийгмийн гишүүдийн зан үйлд өргөн хүрээтэйгээр нөлөөлөх нөлөөллөөр хангадаг.

Энд нийгмийн гишүүдийн эрх зүйн ухамсар, тэдний эрүүгийн

хуулийн талаарх мэдлэг, хариуцлага хүлээх ухамсарыг дээшлүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэхэд эрүүгийн эрх зүйн урамшуулал дэмжих хэм хэмжээг ашиглах зэргийг ашигладаг байна. Тиймээс гэм буруутай этгээдэд ял шийтгэл ногдуулах замаар нийгмийг гэмт халдлагаас хамгаалах нь төрийн эрүүгийн бодлогын зөвхөн нэг чиглэл юм.

Эндээс үзэхэд гэмт хэрэгтэй өргөн хүрээнд хийх тэмцэл нь давших шинжтэй харин эрүүгийн ял шийтгэл хүлээлгэх асуудал нь хамгаалалтын шинжтэй байвал зохих юм. Энэ нь ард иргэдэд олгох эрх зүйн хүмүүжил, урьдчилан сэргийлэх арга хэмжээ, гэмт хэргийг мөрдөх, илрүүлэх зэрэг нь ял шийтгэл гарцаагүй байх зарчим хангахын тулд идэвхтэй дайчин, давшингүй хэлбэртэй байхыг хэлж байгаа.

Харин ял шийтгэлийг хэрэглэх нь төрийн хамгаалах чиг үүрэгт хамаарна. Учир нь гэмт хэрэгтэн төрийн ашиг сонирхолд халдаж байгаа учраас.

Дээр дурдагдсаныг дүгнэхэд эрүүгийн хуулийн ял шийтгэлийн зорилго болон ойлголтын тухай тодорхойлсон зүйлийг доорхи байдлаар гаргаж болох юм.

Үүнд:

Ял шийтгэл нь үйлдсэн гэмт хэргийнх нь төлөө оноох байгаа шударга цээрлүүлэлт юм.

Ял шийтгэлийн зорилго нь нийгмийг гэмт халдлагаас хамгаалах, ял шийтгүүлсэн хүмүүсийг засан хүмүүжүүлэх, мөн ял шийтгэгдсэн хүмүүс дахин гэмт хэрэг үйлдэхээс болон бусад хүнийг гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх.



ОЛОН УЛСЫН ЭРҮҮГИЙН ШҮҮХИЙН РОМЫН ДҮРМИЙГ ҮНДЭСНИЙ ХЭМЖЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АСУУДАЛ

МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Олон улсын эрх зүйн тэнхимийн багш
М.УЯНГА

Олон улсын гэрээний дагуу үүрэг хүлээхийн учир

1998 онд Ром хотноо Олон улсын эрүүгийн Шүүхийн дүрэм батлагдсан нь олон улсын эрүүгийн эрх зүйн хөгжлийн шинэ үеийн эхлэл болсон юм. Хэдийгээр энэ Шүүхийг байгуулах ажил бүр 1945 оноос хойш эхэлсэн ч хүний эрх хийгээд хувь хүнд хариуцлага ногдуулах нь тухайн улсын дотоодын асуудал гэж үзэх, мөн Олон улсын эрүүгийн Шүүхээр авч хэлэлцэх асуудал, ялангуяа олон улсын хэмжээний гэмт хэргийн бүрэлдэхүүний талаар улс орнууд зөвшилцөлд хүрч чадахгүй байсан шалтгаанаар тус Дүрмийг батлах ажил 50 гаруй жилээр хойшлогдсон түүхтэй.

Хүний эрх нь уламжлал ёсоор аливаа улсын дотоод асуудал гэж тооцогдоор ирсэн. Өөрөөр хэлбэл, улс орон бүр бүрэн эрхийнхээ хэмжээнд иргэдийнхээ эдлэх эрх, хүлээх үүргийг тогтоож өгдөг байв. Гэвч нэг улсын эрх мэдэлд аливаа хүмүүсийн хувь заяаг шийдвэрлэх эрхийг үлдээх нь зарим тохиолдолд ямар аймшигтай үр дүнд хүргэж болдгийг Дэлхийн Хоёрдугаар дайн бидэнд харуулсан билээ.

Хүний эрх нь зөвхөн нэг улсын асуудал бус хүн, төрөлхтөний нийтлэг асуудал хүмүүнлэгийн анх Гуго Гроцийн гэх үзэл санаа интервенцийн¹ онолд тусгагдсан юм. Энэ нь аливаа нэг улсад хүний эрхийг удаа дараа зөрчих, мөн уг асуудал олныг хамарсан өргөн хүрээтэй шинжтэй бол олон улсын хамтын нийгэмлэг үүнийг үл тэвчих, таслан зогсоохыг тухайн улсаас шаардах, эсхүл олон улсын хамтарсан эсрэг арга хэмжээ авах ёстой гэсэн утгатай байсан бөгөөд үүгээрээ хүний эрхийн асуудлыг олон улсын хэмжээнд урьдахаас өөрөөр авч үзэх эхлэлийг тавьсан гэж олон судлаач үздэг.

Хэдийгээр улс орнууд тусгаар тогтнол, бүрэн эрхээрээ хаацгайлж

энэ онолыг эсэргүүцэж байсан боловч 1945 онд батлагдсан НҮБ-ын Дүрмийн 1 дүгээр зүйлд "Эдийн засаг, нийгэм, соёл болон хүмүүнлэгийн шинж чанартай олон улсын асуудлыг шийдвэрлэх, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэгийг үл харгалзан хүний эрх ба хэн бүхний үндсэн эрх чөлөөг хүндэтгэх явдлыг хөхиүлэн дэмжих, хөгжүүлэх талаар олон улсын хамтын ажиллагааг хэрэгжүүлэх зорилгыг НҮБ эрхэмлэнэ" гэж заажээ. Мөн "Иргэний ба улс төрийн эрхийн тухай Пакт"² - д оролцогч улс түүнд заасан хүний эрхийг хэрэгжүүлэх үүргийг харилцан хүлээхээр тохиролцсон байдаг бөгөөд тус Пактаар байгуулагдсан Хүний эрхийн Хөрөө, мөн оролцогч улсууд энэ тохиролцоогоо хэрхэн биелүүлж байгаад харилцан хяналт тавина гэж заажээ.

Олон улс эрүүгийн Шүүхийн Ромын³ дүрмийн гол агуулга нь хүний эрх нь үндэсний асуудал төдийгүй олон улсын асуудал мөн гэдгийг баталгаажуулсанд орших юм. Олон улсын эрүүгийн Шүүх нь олон улсын гэмт хэргийг буруутай хүмүүсийг мөрдөн мөшгөх, гэм буруутай этгээдэд хариуцлага ногдуулах эрхтэй юм. Ийм төрлийн эрхтэй олон улсын шүүх урьд нь байгуулагдаж байсан ч (Нюрнбергийн, Токиогийн, Югославын, Руандын гэх мэт), тэдгээр нь тодорхой хугацаа хийгээд тодорхой нутаг дэвсгэрт үйлдэгдэж байсан олон улсын гэмт хэргийг л авч хэлэлцэх эрхтэй байсан учир хязгаарлагдмал буюу ad hoc-ийн шинжтэй байв. Харин Олон улсын эрүүгийн Шүүх нь түүгээмэл шинжтэй бөгөөд тус Шүүхийг байгуулсан гэрээнд нэгдэн орсон улсад үйлдэгдсэн гэмт хэргийг авч хэлэлцэх эрхтэй болсноороо онцлог юм. Иймд уг шүүх хамгийн хүнд ноцтой гэмт хэргэ үйлдэгчдийг хариуцлага хүлээхгүй, ял шийтгэхгүй

үлдэхээс сэргийлэх хөшүүрэг болж байгаа төдийгүй хувь хүнийг зөвхөн дотоодын шүүхээр шүүх ёстой гэж үзэх үзэл санаанаас татгалзах, анх удаа дэлхийн түүхэнд олон улсын хэмжээнд хувь хүнд хариуцлага ногдуулах эрх зүйн суурийг тавьсан юм.

Монгол Улс нь уг гэрээг буюу Ромын Дүрмийг 2002 онд соёрхон баталсан бөгөөд тус Шүүхийн эрх мэдлийг хүлээн зөвшөөрсөн төдийгүй түүнийг үүсгэн байгуулагч 60 улсын тоонд багтаж, хамтран ажиллах, түүнийг заалтыг хэрэгжүүлэх амлалтыг өгсөн билээ.

Аливаа олон улсын гэрээнд нэгдэн орох нь тухайн улсын хувьд гэрээгээр хүлээсэн үүрэг биелүүлэх, хэрэгжүүлэх үр дагаврыг заавал үүсгэдэг. Олон улсын гэрээ нь олон улсын харилцааны олон төрлийн салбар дахь хамтын ажиллагааг хуульчилсан нэг хэлбэр юм. Олон улсын харилцаанд улсаас дээгүүр субъект гэж үгүй. Өөрөөр хэлбэл, олон улсын харилцаанд оролцож буй бүх улс тэгш эрхтэй бөгөөд аль нэг улс нь бусад улсыг захирах эрхгүй гэсэн үг юм. Ийм ч учраас олон улсын харилцаанд нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээг зөвшилцлийн үндсэн дээр бий болгодог бөгөөд үүний нэг жишээ нь олон улсын гэрээ юм. Олон улсын гэрээ нь тодорхой асуудлаар улс хоорондын болон засгийн газар хоорондын хамтын ажиллагааг зохицуулж байгаа бөгөөд харилцан бие биедээ өгсөн амлалтыг нь баталгаажуулж байгаа юм.

Иймд олон улсын гэрээгээр хүлээсэн үүрэг улс орнууд сайн дураар биелүүлж, хэрэгжүүлэх ёстой бөгөөд энэ талаар 1969 оны Олон улсын гэрээний эрх зүйн тухай Венийн Конвенцид⁴ олон улсын гэрээ, хэлэлцээрт нэгдэн орсон улс нь тухайн гэрээгээр хүлээсэн үүрэгээ "хууль тогтоох болон захиргааны арга хэмжээ

¹ Гуго Гроций, Дайн ба энхийн эрх зүйн тухай 3 боть ном. М., 1956, 562-563 дахь тал

² Иргэний ба улс төрийн эрхийн тухай Олон улсын Пакт, 1966 он, Төрийн мэдээлэл, тусгай дугаар I, 2005 он

³ Олон улсын эрүүгийн шүүхийн Ромын дүрэм, 1998 он, Төрийн мэдээлэл, тусгай дугаар II, 2005 он

⁴ Тусгай, онцгой гэсэн утгыг агуулж байгаа. Зохиогчийн тэмдэглэл

⁵ Олон улсын гэрээний эрх зүйн тухай Венийн Конвенц, 1969 он, Төрийн мэдээлэл, тусгай дугаар II, 2005 он

авах замаар хэрэгжүүлнэ” гэж заасан байдаг. Тухайлбал, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай Олон улсын 1966 оны Пактын⁶ 2 дугаар зүйлд: “оролцогч улс нь тус Пактад заасан хүний эрхийг хангах, хэрэгжүүлэх талаар хууль тогтоох болон бусад арга хэмжээг авна” гэж заасан байна. Гэвч бүх олон улсын гэрээг хэрэгжүүлэхэд нэг аргыг хэрэглэнэ гэж ойлгож болохгүй. Тухайн гэрээний зорилго, онцлогоос хамаарч түүнийг хэрэгжүүлэх арга, механизм нь ялгаатай байдаг.

Олон улсын эрүүгийн Шүүхийн Ромын дүрмийг хэрэгжүүлэх механизм

Монгол Улс Олон улсын эрүүгийн Шүүхийн Ромын дүрэмд гарын үсэг зурж, түүнийг хэрэгжүүлэх үүрэг хүлээнэсэс хойш өдгөө 5 гаруй жил өнгөрч байна. Тус Дүрмийг соёрхон баталсан олон улс түүнийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулсан байгаа. Тухайлбал, ХБНГУ, Канад, Франц зэрэг улс Олон улсын эрүүгийн Шүүхийн Ромын дүрмийг хэрэгжүүлэх талаар тусгай хууль баталж, эсхүл холбогдох хуулиудаа нэмэлт, өөрчлөлт хийсэн байна. Харин манай улс одоо хүртэл энэ гэрээгээр хүлээнэс үүргээ биелүүлээгүй байгаа гэхэд хэтрүүлэх болохгүй юм.

Энд нэг зүйлийг тодруулж хэлэхэд олон улсын эрүүгийн Шүүхийн Ромын дүрмийн бүхий л заалтыг үндэсний холбогдох хуулиудаа заавал тусгах үүргийг түүнд оролцогч улсуудад ногдуулсан байдаггүй нь үнэн юм. Өөрөөр хэлбэл, тус Дүрмийг соёрхон баталсан улс үг Дүрмээр заасан олон улсын эрүүгийн эрх зүйн зарчим, гэмт хэргийн бүрэлдэхүүн, ялын хэмжээнд өөрийн хууль тогтоомжийг заавал нийцүүлэх албагүй байдаг. Жишээ нь, оролцогч улс нь Олон улсын эрүүгийн Шүүхийн Ромын дүрэмд заасан олон улсын гэмт хэргийг үйлдэгчдэд цаазаар авах ял ногдуулахгүй байх заалтыг өөрийн хууль тогтоомжид заавал тусгах үүргийг хүлээдэггүй.

Үүний зэрэгцээ олон улсын эрүүгийн Шүүх нь түүний дүрмийг баталсан буюу уг шүүхийн үйл ажиллагааг хүлээн зөвшөөрсөн улсын нутаг дэвсгэрт олон улсын гэмт хэргэ үйлдсэн сэжиглэгдэж буй этгээдийг мөрдөн мөшгөх,

тэдэнд хариуцлага ногдуулах эрхтэй болдог гол учир нь байдаг. Энэ утгаараа олон улсын гэмт хэргэ үйлдэгчид нь тэдний амьдарч байгаа эсхүл оршин сууж буй оронд тэдний үйлдсэн гэмт хэргийг хуулиар тодорхойлож өгөөгүй, эсхүл эрх зүйн зохицуулалт байхгүй буюу хуульдаа Ромын дүрмийн дагуу нэмэлт өөрчлөлт оруулаагүй гэх мэт шалтгаанаар хариуцлагаас зайлсхийх боломжгүй болж байгаа юм.

Тэгвэл Олон улсын эрүүгийн Шүүхийн Ромын дүрмийг хэрэгжүүлэх гэж чухам юуг хэлээд байна вэ?

Олон улсын гэмт хэргийг авч хэлэлцэх үндэсний шүүхийн эрх мэдэл

Олон улсын эрүүгийн Шүүхийн Ромын дүрмийг олон улсын нийтийн эрх зүйн үндсэн арван зарчмын нэг болох улс гүрний бүрэн эрх, тусгаар тогтнолын зарчмыг⁷ хүндэтгэн боловсруулж баталсан юм. Өөрөөр хэлбэл, олон улсын харилцаанд оролцогч улс бүр нь засаглалаа тогтоох, хууль тогтоох болон шүүх эрх мэдлээ хэрэгжүүлэх эрхээ бүрэн эдлэнэ гэсэн утгатай юм. Дээр дурдсаны адилаар улс бүр нь нутаг дэвсгэрийн зарчмын үндсэн дээр өөрийн улсад үйлдэгдсэн гэмт хэргийн талаар мөрдөн мөшгөх үйл ажиллагаа явуулах болон гэм буруутай этгээдэд хариуцлага ногдуулах эрхтэй бөгөөд энэ эрх мэдлээ эрт дээр үеэс хамгаалж ирсэн.

Үүнийг мөн Олон улсын эрүүгийн Шүүхийн Ромын дүрэмд баталгаажуулсан байдаг. Тухайлбал, тус Дүрмийн 1 дүгээр зүйлийн 1 - д зааснаар “Олон улсын эрүүгийн Шүүх нь олон улсын хамтын нийгэмлэгийн сэтгэлийг тэмцэсэн, энэхүү дүрэмд дурдсан хамтын ноцтой гэмт хэргийн төлөө хариуцлага хүлээх ёстой этгээдийн хувьд хэргийг нь шүүн таслах үндэсний шүүх байгууллагад нэмэлт хөшүүрэг болно” гэжээ. Өөрөөр хэлбэл, үндэсний шүүх нь нутаг дэвсгэр дээр нь үйлдэгдсэн, эсхүл хуулиар түүний хэрэг шүүн шийдвэрлэх эрх мэдэлд харьяалагдаж байгаа олон улсын гэмт хэргийг авч хэлэлцэх эрхийг нэн тэргүүнд эдлэх юм.

Тухайн улс нь уг хэргийг өөрөө Олон улсын эрүүгийн

Шүүхэд шилжүүлэн өгсөн, эсхүл түүнийг шийдвэрлэх хүсэлгүй буюу чадваргүй нөхцөлд л Олон улсын эрүүгийн Шүүх нь тухайн хэргийг авч хэлэлцэх эрхтэй болно. Тухайлбал, Дүрмийн 17 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт: “Олон улсын эрүүгийн Шүүх нь хэрхэ тухайн улс зохих ёсоор мөрдөн байцаалт явуулах хүсэлгүй буюу үнэхээр чадваргүй тохиолдолд” хэргийг авч хэлэлцэх эрхтэй гэсэн байна.

Хэдийгээр Олон улсын эрүүгийн Шүүхийн Ромын дүрэмд “хүсэлгүй” болон “чадваргүй” гэдгийг тайлбарлаж өгөөгүй ч, мэргэжилтнүүдийн үзэж байгаагаар “хүсэлгүй” гэдэгт тухайн улсын эрх бүхий байгууллага нь санаатайгаар олон улсын гэмт хэргийг шалгах, мөрдөн байцаах хүсэлгүй, тухайлбал, эрх мэдэл бүхий хүмүүс нь авлигад автагдсан, шүүх, прокурор, мөрдөн байцаалт явуулах этгээд нь хараат бус байлдаа алдсан буюу гадны нөлөөнд байхыг хэлдэг. Дэлхийн туршлага, практикийг үндэслэхэд олон улсын гэмт хэргийг ихэвчлэн төрийн болон цэргийн өндөр албан тушаалтан үйлдэж байсан болохоор тэд нь шүүх болон хууль сахиулах байгууллагад нөлөөлж, хариуцлагаас мултрах тохиолдол ихээхэн гарч байсан байна.

Харин “чадваргүй” гэдэгт эрх зүйн болон улс төр, нийгэм, эдийн засгийн бодит байдлын хувьд ийнхүү мөрдөн байцаах буюу шүүн таслах үйл ажиллагаа явуулах боломжгүй нөхцлийг хэлдэг. Жишээлбэл, эрх зүйн хувьд гэдэгт хуулиар олон улсын гэмт хэргийг тодорхойлоогүйгээс болж мөрдөн байцаах буюу шүүх ажиллагаа явуулах боломжгүй байхыг, бодит байдлын хувьд гэдэгт тухайн улсад нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүссэн, дайны буюу зэвсэгт мөргөлдөөний байдал бий болсон зэрэгс дээрх мөрдөн мөшгөх үйл ажиллагааг явуулах боломжгүй буюу чадваргүй байхыг хэлж болох юм.

Дээрхээс харахад, үндэсний шүүх нь өөрөө хэнээр ч шахуулж шаардуулалгүйгээр олон улсын гэмт хэргийн талаар мөрдөн байцаалт явуулах, шүүх эрх мэдэлтэй юм. Гэвч зарим улсад энэ эрх мэдлээ хэрэгжүүлэхдээ зориураар “мэдэн будилдаг”, эсхүл санаатайгаар хэрэгжүүлэхгүй байх тохиолдол олонтаа гардаг учир Олон улсын

⁶ Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай Олон улсын Пакт, 1966 он, Терийн мэдээлэл, тусгай дугаар I, 2005 он

⁷ НҮБ-ын Дүрэм, 1945 он, Терийн мэдээлэл, тусгай дугаар II, 2005 он

эрүүгийн Шүүх нь олон улсын гэмт хэргэг буруутай этгээд ял шийтгэлгүй үлдэхээс сэргийлэх, тийм гэмт хэргэ үйлдэгчдийг шийтгэн цэдрүүлэх нэмэлт хошуурго болж байгаа юм. Олон улсын эрүүгийн Шүүх нь үндэсний шүүхүүдийн эрх мэдэлд халдаж байна, гаднаас ажилд нь оролцож байна гэж үзэх хүмүүс олон байдаг. Гэтэл олон улсын эрүүгийн шүүх нь ямар нэг гадаад улсын шүүх бус, харин олон улсын хамтын ажиллагааны үр дүнд бий болсон байгууллага юм.

Хэдийгээр Олон улсын эрүүгийн Шүүх нь шаардлагатай нөхцөлд олон улсын гэмт хэргийг авч хэлэлцэх эрхтэй гч үндэсний шүүх нь энэ эрх мэдлийг нэн тэргүүнд эдэлдэг гэдгийг дахин дурдах хэрэгтэй юм. Үнэхээр ямар нэг улс Ромын дүрмийг хүлээн зөвшөөрч байгаа бол түүнд заасан олон улсын гэмт хэргийг олон улсын стандартад (тохируулах) нийцүүлэн авч хэлэлцэх, шийдвэрлэх үүргийг хүлээх ёстой нь ойлгомжтой. Үүндээ үздэн Олон улсын эрүүгийн Шүүхийн Ромын дүрмийг хэрэгжүүлэхийн тулд үндэснийхээ хуулийг Ромын дүрэмд нийцүүлэх тухайн улсын үүрэг гарч ирнэ.

Энэхүү нийцүүлэх үйл ажиллагаа нь дараах зүйлийг анхааран хийдэг ёстой. Үүнд:

- гэмт хэргийг Олон улсын Ромын дүрэмд нийцүүлэн тодорхойлох;

- тэдгээрт ногдох ялын хэмжээг мөн дүрэмд нийцүүлэн тогтоох;

- хэргийн харьяалалд ямар зарчмыг хэрэглэх (нутаг дэвсгэрийн зарчим уу, хэргийн түүгээмэл харьяаллын зарчим уу);

- эрүүгийн хариуцлагын талаар Ромын дүрэмд нийцүүлж хуульдаа өөрчлөлт оруулах эсэх (Тухайлбал, захиргаачин, тушаал биелүүлэгчийн хариуцлага гэх мэт)-ийг анхаарах ёстой юм.

Олон улсын эрүүгийн Шүүхийн дүрэмд Олон улсын эрүүгийн шүүх нь дервен төрлийн гэмт хэргийг авч хэлэлцэх эрхтэй гэж заасан ч өдгөө дараах гурван төрлийн гэмт хэргийг авч хэлэлцэх эрхтэй байна. Эдгээр нь геноцид буюу төрлөөр устах гэмт хэргэ; хүн төрөлхтний эсрэг гэмт хэргэ; дайны гэмт хэргэ юм. Дөрөв дэх гэмт хэргэ буюу түрэмгийллийн гэмт хэргийн бүрэлдэхүүний талаар олон улсын хамтын нийгэмлэг нь зөвшилцөлд хүчн чадаагүй бөгөөд түүнийг батлаагүй болохоор Олон улсын эрүүгийн Шүүх нь тус хэргийг авч хэлэлцэх эрхийг одоогоор эдэлдэггүй болно.

Дээрхтэй уялдан, оролцогч ял нь өөрөө дээрх олон улсын гэмт хэргийг авч хэлэлцэнэ гэж үзэж байгаа бол эдгээр гэмт хэргийг үндэсний хуульдаа тодорхойлох ёстой.

Монгол Улсад 2002 онд шинэ Эрүүгийн хуульд батлагдаж, мөн хуулийн 11 дүгээр хэсэгт "Хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэргэ" гэсэн бүлгийг оруулж өгсөн байгаа. Энэ нь Монгол Улс үндэсний хуульдаа олон улсын эрүүгийн эрх зүйн хэм хэмжээг тусгах, цаашилбал олон улсын эрүүгийн үйлдэгчдийг хариуцлагад татах эрх зүйн суурийг тавьсаныг харуулж байгаа. Гэсэн хэдий ч судлаачдын үзэж байгаагаар энэ нь Олон улсын эрүүгийн Шүүхийн Ромын дүрмийн шаардлагад төдийлэн хүрэхгүй байгаа юм. Миний бие энэ өгүүлэлдээ зөвхөн Олон улсын эрүүгийн Шүүхийн Ромын дүрмийг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх механизмзын тухай асуудлыг хөндөх зорилго тавьсан учир, Монгол Улсын Эрүүгийн хуулийн олон улсын гэмт хэргтэй холбогдолтой заалтуудыг Ромын дүрэмтэй нийцүүлэн тодотгох асуудал нь тусгайлсан судалгаа шаардаж ажил болохыг л тэмдэглэхийг хүсч байна.

Олон улсын эрүүгийн Шүүхтэй хамтран ажиллах үүрэг

Олон улсын эрүүгийн Шүүхийн Ромын дүрмийн арван зургаан зүйлээс бүрдэх 9 дүгээр хэсэгт тус Шүүхтэй хамтран ажиллах болон түүнд хууль зүйн тусалцаа үзүүлэх талаар өгүүлсэн байдаг. Мөн уг дүрмийн 5 ба 6 дугаар хэсэг, мөн 18, 19, 54, 56-59, 72-73 дугаар зүйлүүдэд үүнтэй холбоотой заалтууд агуулагдсан байдаг.

Олон улсын эрүүгийн Шүүхийн дүрмийн 86 дугаар зүйл нь аливаа улсын зүгээс олон улсын эрүүгийн Шүүхтэй хамтран ажиллахын суурь үндэс болдог юм. Тус зүйлд "Оролцогч улсууд энэхүү дүрмийн заалтын дагуу хэрэг шүүн шийдвэрлэхэд нь хамаарах гэмт хэргийн мөрдөн байцаалт болон мөрдөн мөшгөлт явуулахад Шүүхтэй бүх талаар хамтран ажиллана" гэж заажээ.

Олон улсын эрүүгийн Шүүхтэй хамтран ажиллах нь тус Шүүхийн үйл ажиллагааг үр дүнтэй явуулах нэгэн чухал хөшүүрэг юм. Олон улсын эрүүгийн Шүүх нь өөрөө бий болсон байгууллага биш юм. Энэ нь Югославын цэргийн шүүхийн

адил хамтын чармайлтын үндсэн дээр бий болсон учир ганцаараа биш даан үйл ажиллагаа явуулахад хүндрэлтэй. Тухайлбал, өөр бусад улсад байгаа нотлох баримтыг цуглуулах, хохиргоо болон гэрчийг хамгаалах, сэжигтэнг шилжүүлэх гээд олон гөргийн гусламжийг холбогдох улсаас авах шаардлага гарна. Жишээлбэл, Югославын цэргийн шүүхийн хүрээнд хоёр түвшний хамтын ажиллагааны тогтолцоог тогтоосон байдаг. Үүнд, үндэсний шүүхүүд өөр хоорондоо хамтран ажиллах, хоёр дахь түвшинд нь үндэсний шүүх нь Югославын асуудлаар олон улсын шүүхтэй хамтран ажиллах.

Олон улсын эрүүгийн Шүүхийн Ромын дүрмийн 9 дэх хэсэгт дээрх хоёр түвшин дэх хамтын ажиллагааг хоёултан нь зааж өгсөн байгаа.

Олон улсын эрүүгийн Шүүхийн Ромын дүрэмд зааснаар хамтран ажиллах талаар дараах төрлийн үндсэн харилцаанууд үүсч байгаа юм. Үүнд: олон улсын эрүүгийн шүүх нь оролцогч улстай хамтран ажиллах; оролцогч улсууд өөр хоорондоо хамтран ажиллах; гэмт хэргтнийг олон улсын эрүүгийн шүүхэд хүлээлгэн өгөх; хохиргоо болон гэрчийг хамгаалах; хорих ялыг гүйцэтгэх зэрэг юм.

а) **Оролцогч улс нь олон улсын эрүүгийн Шүүхтэй хамтран ажиллах** талаар Дүрмийн 87 дугаар зүйлд заасан байна. Шүүх нь хамтран ажиллах талаар хүсэлтийг оролцогч улсад дипломат шугамаар, эсхүл эрүүгийн цагдаагийн олон улсын байгууллага буюу бус нутгийн аливаа холбогдох байгууллагаар дамжуулан гаргаж болно. Тэгэхээр оролцогч улс нь шүүхтэй хамтран ажиллах талаар эрх зүйн орчинг бүрдүүлэх үүрэгтэй. Тухайлбал, нотлох баримтыг цуглуулах, мэдээлэл өгөх, сэжигтэнг баривчилж, шүүхэд хүлээлгэн өгөх бололцоог бүрдүүлсэн байх ёстой. Зарим улсад энэ үүргийг холбогдох хуулийн гадаадын шүүх болон бусад эрх бүхий байгууллагагай хамтран ажиллах талаар заалтанд нэмэлт, өөрчлөлт оруулж хэрэгжүүлсэн байдаг.

Олон улсын эрүүгийн Шүүхийн Ромын дүрэмд Шүүхээс гаргасан хамтран ажиллах талаарх хүсэлтийг биелүүлэхээс тухайн орн гагталзах, эсхүл түүнийг биелүүлэхийг хойшлуулах талаар эдлэх эрхийг мөн заасан байдаг. Үүний зэрэгцээ оролцогч улс нь хүсэлтийг биелүүлэхээс үндэслэлгүйгээр татгалзах буюу хойшлуулсан

тохиолдолд түүний эсрэг хориг арга хэмжээ авах боломжгүй боловч, Олон улсын эрүүгийн Шүүхийн Ромын дүрмийг оролцогч улсуудын Ассамблей, НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн анхаарлыг хандуулах, бий болсон нөхцөл байдлыг авч хэлэлцүүлэх арга хэмжээг зохион байгуулж болохыг мөн дүрэмд тусгасан байдаг. Түүнчлэн ийнхүү татгалзах болон хойшлуулах болон хууль ёсны шалтгаан нь тухайн хэргийг үндэсний хэмжээнд авч хэлэлцэхээр болтгүй байгаа байж болох бөгөөд үүнийг ч харгалзсан байдаг.

б) Хоёр дахь харилцаа буюу **оролцогч улсууд өөр хоорондоо хамтран ажиллах талаар**. Энэ асуудал нь нэлээд их маргаан үүсгэсэн юм. Учир нь өөрийн улсын иргэнийг гадаад улсад шилжүүлэн өгөхгүй гэж зарим улсын үндэсний хууль тогтоомжид заасан байдаг. Тухайлбал, Монгол Улсын хууль, тогтоомжид Монгол Улсын иргэнийг гадаад улсад шилжүүлэн өгөхгүй тухай заалт байдаг. Тиймээс энэ үүргийг хэрхэн хэрэгжүүлэх талаар мөн үндэсний хууль тогтоомжид тусгах шаардлагатай юм.

в) Өөр нэг харилцаа нь **сэжигтэн Олон улсын эрүүгийн Шүүхэд хүлээлгэн өгөх юм**. Энэ нөхцөлд, оролцогч улс нь өөрийн иргэнийг, эсхүл өөрийн нутаг дэвсгэрт оршин сууж байгаа бөгөөд олон улсын гэмт хэргэрт сэжиглэгдэж байгаа гадаадын иргэн, харьяалагчгүй хүнийг Олон улсын эрүүгийн Шүүхэд шилжүүлэн өгөх асуудал үүсч байгаа юм. Оролцогч улс нь энэ талаар хамтран ажиллах эрх зүйн орчинг бүрдүүлэх үүрэгтэй. Гэвч энэ нь олон улсын эсэргүүцлийг нэлээд төрүүлдэг. Учир нь дээр дурдсанчлан ихэнх улсын хууль тогтоомжид өөрийн улсын иргэнийг гадаад улсад шилжүүлэн өгөхгүй гэсэн байдаг бөгөөд зарим улс нь энэхүү заалтаар үүргээ хаачаахад хандлаа гарч байсан.

Олон улсын эрүүгийн Шүүх нь гадаад улсын шүүх бүх бөгөөд олон улсын хамтын нийгэмлэгийн хамтын ажиллагааны үндсэн дээр бий болсон болохоор олон улсын төлөөлөгчдөөс бүрдэх олон улсын байгууллага юм. Иймд олон улсын эрүүгийн шүүхэд өөрийн иргэнийг хүлээлгэн өгөхийг гадаад улсын шүүхэд шилжүүлэн өгөхтэй адилтган авч үзэж болохгүй юм. Харин өөрийн нутаг дэвсгэрт байгаа гадаадын иргэн, харьяалагчгүй

хүнийг Олон улсын эрүүгийн шүүхэд шилжүүлэх асуудлыг шийдвэрлэхэд хүндлэл учирч болзошгүй. Гэхдээ гадаад орнуудын туршлагыг судлахад гадаад улсын харьяалагч байгаа гэмт хэргийн сэжигтэнг шилжүүлэх журмыг энэ нөхцөлд хэрэглэсэн байдаг. Мөн зарим улсад хэргийн түгээмэл харьяаллын зарчмыг хэрэглэхийг заасан байдаг юм.

г) **Хохирогч болон гэрчийг хамгаалах талаар** Олон улсын эрүүгийн шүүхийн Ромын дүрэмд онцгойлон анхаарсан байдаг бөгөөд энэ талаар тус дүрмийн 75, 79 болон 87 дугаар зүйлийн 4.9-д тус тус заасан байна. Үүнтэй нийцүүлэн оролцогч улс үндэсний хууль тогтоомжоо хохирогч болон гэрчийг хамгаалах журмыг тогтоосон байх үүрэгтэй.

д) **Шүүхийн шийдвэр биелүүлэхэд оролцогч улсын гүйцэтгэх үүрэг**. Олон улсын эрүүгийн Шүүхийн шийдвэрийг биелүүлэхэд Шүүх нь оролцогч улстай хамтран ажиллах шаардлага гардаг. Олон улсын эрүүгийн Шүүх нь өөрөө хорих байгууллагууд, мөн тухайн Шүүхээр авч хэлэлцсэн гэмт хэргийн хохирогч нь шүүхийн байгаа газраас өөр газар байх, шүүхийн шийдвэрийг оролцогч улсын нутаг дэвсгэрт гүйцэтгэх нөхцөлд хохирлыг барагдуулах, гэм буруутай этгээдийн ялыг эдлүүлэх ажиллагааг Шүүх ганцаараа хэрэгжүүлэх боломжгүй байдаг. Ийм учраас оролцогч улс, тэдний эрх бүхий байгууллагатай хамтарч ажиллах, тэднээс тусламж авах зорьцог гардаг. Иймд оролцогч улс тус бүр нь энэ талаар мөн үндэсний хуульдаа тусгах өгөх шаардлагатай болно.

Олон улсын гэрээг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэхэд бүх нөхцөлд үйлчлэх нэг мөр бүхий арга байдаггүй. Энэ нь тухайн гэрээний онцлог, зорилго, агуулгааг хамаарна. Ихэвчлэн тухайн олон улсын гэрээнд түүнийг хэрэгжүүлэх механизм буюу арга, хэрэгслийг нь зааж өгсөн байдаг.

Олон улсын эрүүгийн Шүүхийн Ромын дүрмийг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх гэдэгт үндсэндээ хоёр зүйлийг ойлгодог болох нь дээрхээс харагдаж байна. Үүнд: нэгдүгээрт, Олон улсын эрүүгийн Шүүхийн үйл ажиллагааг үр дүнтэйгээр хэрэгжүүлэхийн тулд тус дүрмийг соёрхон баталсан улсууд үг

шүүхтэй идэвхтэй хамтран ажиллах, хоёрдугаарт, хэрэн тухайн улс өөрөө Олон улсын эрүүгийн Шүүхийн Ромын дүрэмд заасан гэмт хэргийг авч хэлэлцэх сонирхолтой бол үндэсний хууль тогтоомжоо Ромын дүрмийн үзэл санаа, агуулгад нийцүүлэх явдал юм.

Хэдийгээр Монгол Улс нь Ромын дүрмийг соёрхон батлаад 5 жилийн нүүр үзэж байгаа ч тус дүрмийг хэрэгжүүлэх ажил манайд үндсэндээ хийгдээгүй болно. Энэ талаар олон улсын эрх зүй судлаачдад олон санал, санаачилга гаргасан боловч, манай улсад энэ ажил төдийлэн урагшилж өгөхгүй байгаа нь үнэн болно.

Er нь манайд сүүлийн үед олон улсын гэрээг соёрхон батлаад, харин түүнийгээ хэрэгжүүлэх ажлыг огт зохион байгуулахгүй, гүйцэтгэхгүй байх практик илэрхий ажиглагддаг тухай гадаадын судлаачид тэмдэглэх болно.

Өнөө үед Олон улсын эрүүгийн Шүүхийн Ромын дүрмийг соёрхон баталсан 100 гаруй улс байгаа. Эдгээрээс Баруун Европын ихэнх орно, мөн Азийн орнуудын Бүгд Найрамдах Солонгос Улс уг дүрмийг хэрэгжүүлэх эрх зүйн орчинг үндсэнд нь бүрэн бүрдүүлсэн байна. Эдгээр орны туршлагыг судлахад Олон улсын эрүүгийн Шүүхийн Ромын дүрмийг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэхэд үндсэн хоёр аргыг сонгосон нь харагдаж байна. Тухайлбал, ХБНГУ, Канад зэрэг улс нь Олон улсын эрүүгийн Шүүхийн талаар тусгай хууль баталсан байна. Харин Бүгд Найрамдах Солонгос Улс зэрэг зарим орно холбогдох хуулиуддаа нэмэлт, өөрчлөлт оруулжээ.

Дэлхийн том гүрэн болох АНУ, ОХУ, Япон, Хятад зэрэг улс Олон улсын эрүүгийн Шүүхийн Ромын дүрмийг соёрхон батлаагүй байгаа. Гэвч Олон улсын эрүүгийн Шүүхийн талаар албан ёсны вэб хуудасны¹ хамгийн сүүлийн мэдээнд Японы Засгийн газар Ромын дүрмийг соёрхон батлах ажлыг бэлтгэж, хууль тогтоомжоо судалгаа хийж, түүнийг дээрх дүрэмд нийцүүлэх арга хэмжээг судалж байгаа гэж бичсэн байсныг анхаарах нь зүйтэй юм.

* * *

¹ www.iccnw.org

ОЛОН УЛСЫН ХУДАЛДААНЫ ЭРХ ЗҮЙ БА ХҮНИЙ ЭРХИЙН ХООРОНДЫН УЯЛДАА, ХОЛБООНЫ ТУХАЙ ТОВЧ ТАНИАЦУУЛАГА

Худалдаа ба хүний эрхийн хоорондын харилцааг ярих үед бид бүхэн нийгмийн бодлогын холбоосын тухай ярих ёстой болж байгаа юм.

Худалдаа ба хүний эрхийг сайжруулах, хөдөлмөрлөх эрх болон хүрээлэн буй орчин (эдгээр нь одоо бүгд олон улсын эрх зүйн тогтолцоонд хатуу суурилсан) зэрэг олон янзын нийгмийн зорилтуудын холбоос бол судлах хүрээ нь өсөн нэмэгдэж буй чухал асуудал юм.

Худалдаа болон хүний эрх хоёр нь чухам ямар хүрээнд өөр ойлголт болох, ямар хүрээнд давхцаж байна вэ? Дараах диаграмаар үзүүлж болох юм.



Давхцал оршдог гэхдээ олонхийн ярьдаг шиг тийм том биш болов уу.

А. Саваа буюу Хүний эрх болон бусад улсын нийгэм, улс төрийн бодлогод нөлөөлөх зорилгоор худалдааны бодлогыг хэрэглэх.

Худалдаа болон янз бүрийн нийгмийн бодлогын холбоосын тухай ярихад бусад улсын зохих бодлогод худалдаа хэрхэн нөлөөлөх тухай боддог. Ялангуяа, хүлээж авч боломгүй бодлогын эсрэг арга хэмжээ, шийтгэл болгон худалдааны бодлогыг хэрэглэж болно гэдэг. Өөрөөр хэлбэл, бусад улсыг тухайн худалдааны бодлогоо өөрчлөхөд шахалт үзүүлэх саваа, дохиур болох юм.

Иймэрхүү жишээ олныг дурдаж болно:

1. Хүний эрхийн үзүүлэлттэй холбоотойгоор АНУ-ын зүгээс БНХАУ-д үндэсний нэн тааламжтай



ХЗҮТ-ийн Олон улсын эрх зүйн секторын эрдэм шинжилгээний ажилтан
П.БАЯР

нөхцөл үзүүлэхийг 1980 онд зогсоож байсан.

2. Хүний эрхийг үгүйсгэсэн болон ардчиллыг нухчин дарсны улмаас АНУ-ын зүгээс Куба улсад худалдааны хориг арга хэмжээ авсан.

3. АНУ-ын Массачусетс мужийн зүгээс Мьянмар улс нь хүний эрх болон хөдөлмөр эрхлэх асуудлыг ноцтой зөрчсөний улмаас тус улсаас бараа худалдан авахыг зогсоосон.

4. ӨАБНУ болон Родезид тавьсан худалдааны хориг арга хэмжээ.

5. Далайн мэлхийг хамгаалах үүднээс тусгай хэрэгсэл хэрэглэж загас агнуур болон сам хорхой барихыг загасчдаасаа шаардаагүй улсуудаас сам хорхой импортлохыг хориглосон шийдвэрийг АНУ-ын зүгээс гаргаж байсан билээ.

Энэ мэт маш урт жагсаалт үргэлжлэх бөлгөө. Энэхүү саваа хэмээх худалдааны арга хэмжээ нь нэг талаар үр дүнд хүрдэг зохистой мэт боловч нөгөө талаар үр дүн нь тэрхүү эдийн засгийн салбарын бизнес эрхлэгчдэд хүндээр тусдаг болохыг анхаарах хэрэгтэй юм.

Б.Лууван буюу хүний эрх болон бусад улс орны нийгэм, улс төрийн бодлогод нөлөөлөх

худалдааны санаачилгыг хэрэглэх.

Тодорхой нэг бодлогыг батлах эсвэл хэвээр хадгалж байхыг бусад улс оронд урамшуулж байх санхүүгийн түлхэц болох зорилгоор энэхүү бодлогыг хэрэгжүүлдэг. Хамгийн тод томруун нэгэн жишээ бол хөгжиж буй орнуудад үзүүлж буй худалдааны хөнгөлөлт болох тэдгээр орноос оруулж буй зарим бараа, үйлчилгээнд тарифийн хөнгөлөлт эдлүүлэх GSP буюу Давуу эрхийн ерөнхий системийн хөтөлбөр юм.

Эргээд энэхүү хөнгөлөлтөө татах нь бас савааны арга болох юм.

Тухайлбал, АНУ-ын зүгээс Чили асуудал үзүүлж байсан дээрх дэглэмийг хөдөлмөр эрхлэлтийн олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн тэр түвшинд хангалттай арга хэмжээ аваагүй учраас буцаан татсан байдаг.

В. Олон улсын гэрээнд худалдааны арга хэмжээг тусгах.

Худалдааны арга хэрэгслүүд саваа болон луувангийн аль нь ч байсан гэсэн олон улсын гэрээнд тусгалаа олж болно. Жишээлбэл, Аюултай зүйл худалдаалах тухай олон улсын конвенц (CITIES) болон Озоны давхаргыг цооцоолж нөлөөлж буй хүчин зүйлийн тухай Монреалын протокол аль аль нь худалдааны арга хэмжээг багтаасан байдаг.

Г. Нийгмийн нөхцөл байдлыг хамааралгүй үйлдвэрлэгдсэн бараа, үйлчилгээнд чөлөөт үнийн өрсөлдөөнт зах зээл нөлөөлөх нь.

Тодорхой зах зээл дээрх салбар үнийн хувьд маш мэдрэмтгий байдаг.

Тодорхой хэрэглэгчид тэдгээр бараа, үйлчилгээ хүний эрхийн, хөдөлмөрийн, хүрээлэн буй орны ямар нөхцөлд үйлдвэрлэгдсэнээс үл хамааран үндэ суурилсан эдгээр салбараас худалдан авах хандлагатай байдаг. Өндөр өрсөлдөөн нь хөдөлмөр, хүний эрх,

хүрээлэн буй орчинд сөрөг нөлөө үзүүлэх бага өртгийг шаардаад эхэлдэг. Ялангуяа гадаад хөрөнгө оруулалтыг татахаар өрсөлдөж буй нөхцөлд энэхүү явдал тохиолддог. Энэхүү асуудал нь хүрээлэн буй орчин, хөдөлмөр, хүний эрхийн стандарт бага улсад үйлдвэрлэлийн өртөг бага байна гэж үздэг. Тодорхой дэвшилтэт технологи ашигладаг улсын хувьд арай өөр явдал тохиолддог. Энэ бол ажилгүйдэл. Ажилгүйдлээс үүдэлтэй ядуурал, гэмт хэрэг, хүний эрхийн зөрчил юм.

Д.Хариуцлагатай үйлдвэрлэсэн бараа, үйлчилгээнд ёсгүй удирдлага болгосон зах зээл буюу дээшээ өрсөлдсөн спирал.

Хүрээлэн буй орчин, нийгэмд хор хөнөөлгүй үйлдвэрлэгдсэн бараа бүтээгдэхүүнийг сонгох боловсорсон хэрэглэгчдийн ангилал. Дийлэнх хэрэглэгчийн хандлага ийм байвал үйлдвэрлэгчид болон засгийн газар стандартаа дээшлүүлэхийг эрмэлзэх болно. Энэхүү хандлага АНУ, Япон, Европын өндөр хөгжсөн орнуудад өрнөж буй үйл явц юм.

Е. Эдийн засгийн хөгжил нийгмийн бодлогын дэвшилтэд нөлөөлөх нь.

Дэлхийн худалдааны байгууллагын Нарийн бичгийн дарга нарын газрын зарим гишүүн худалдаа нь хүрээлэн буй орчинд эерэг хамааралтай байж болно гэж мэтгэдэг. Хүний эрх болон хөдөлмөрийн харилцаатай ч мөн адил. Энэ байр суурь бол худалдааны либералчлал нь үр дүнг сайжруулж, эдийн засгийн хурдыг нэмэгдүүлдэг ба эдийн засгийн хөгжил нь улмаар хүрээлэн буй орчныг сайжруулах, боловсрол, дэвшилтэт үзэл бодлоо солилцоход нэмэлт нөөц бололцоогоор хангана гэсэн олон дээр үндэслэсэн юм. Хөгжингүй орнуудад хүний эрх, хөдөлмөр, хүрээлэн буй орчны стандарт хөгжиж байгаа орнуудыг бодвол эдийн засгийн өсөлтөөсөө хамаараад хавьгүй илүү байдаг.

Зөвхөн хүрээлэн буй орчны тохиолдлыг авч үзэх аваас зарим нь эдийн засгийн өсөлт нь хүрээлэн

буй орчны доройтолд хөтөлдөг гэж эсрэг байр суурь илэрхийлдэг. Тодорхой хэмжээний бохирдолтын хувьд үнэн боловч бүх төрлийн бохирдолт болон доройтол орох ёсгүй. Хүрээлэн буй орчин болон эдийн засгийн хөгжил хоёрыг тэнцвэржүүлж авч явах ёстой. Энэ бол тогтвортой хөгжил хэмээх ойлголтод байх ёстой зүйл юм.

Е. Хүний эрхийг сайжруулах мэт зорилгын цаана орших протекционист зорилго.

Нийгмийн бодлогын зорилгыг дэвшилтэд шатанд гаргахад худалдааны арга хэмжээ авахад худалдаа болон нийгмийн бодлого хоёрын хоорондын холбоо мөн оршиж байдаг боловч олон улсын хэмжээнд өрсөлдөгч багатай дотоодын бизнест протекционист ашиг сонирхлын үүднээс дэмжлэг үзүүлэх нь байдаг. Жишээлбэл, олон улсын эрх зүйч нарын сайн мэдэх Сам хорхой, яст мэлхийн маргаан¹ бөгөөд Сам хорхойны торонд яст мэлхийн орохоос сэргийлж чадаагүй улсуудаас сам хорхой импортлохгүй байх тухай АНУ-ын Засгийн газрын зүгээс таавьсан хориг нь АНУ-ын дотоодын бизнесмэнүүдэд таатай дэмжлэг болсон гэхэд эргэлзэх зүйлгүй юм.

Ж. Гэрээний тайлбар-Худалдааны гэрээг Хүний эрхийн болон Хүрээлэн буй орчин, Хөдөлмөрийн баримт бичигт баталсан нэр томъёогоор тайлбар хийх нь.

Олон улсын гэрээний тухай Венийн Конвенцийн 31 дүгээр зүйлийн 3.с)-д талуудын хоорондын харилцаанд хэрэглэгдэх олон улсын тухайн гэрээ, конвенцийг тайлбарлахдаа агуулгаар нь тайлбарлавал зохино гэсэн байдаг. Зохих талуудын соёрхон баталсан Дэлхийн худалдааны байгууллагын Тариф худалдааны ерөнхий хэлэлцээрийн (ТХЕХ гэх) 20 дугаар зүйлийг тайлбарлахад хэрэглэх журмыг тогтоож болно.

Жишээлбэл, Сам хорхой ба яст мэлхийн маргаан дээр Дэлхийн худалдааны байгууллагын Давж заалдах шатны байгууллага маргаанд оролцогч талууд хэрэгт

хамаарах тодорхой тооны хүрээлэн буй орчны тухай олон талт гэрээг соёрхон баталсан байсан хүрээг тогтоосон байна. Ингэж шалгах нь ТХЕХ (1947)-ын 20 дугаар зүйлийг хэрэглэх үндэслэл байсан эсэхийг тогтоох байсан юм. Давж заалдах шатны байгууллагаас хүрээлэн буй орчны тухай олон талт хэлэлцээрийг шалгах нь Дэлхийн худалдааны байгууллагын гэрээний тодорхой заалтуудыг тайлбарлахад зохих хэмжээгээр хамааралтай болохыг санал болгож байгаа юм. Үүнтэй адилаар, хамаарах олон улсын бусад зарчим, хэм хэмжээг нэгэн адил хэрэглэж болох юм.

ТХЕХ/ДХБ ба хүний эрх, хөдөлмөрлөх эрх болон ардчиллын үйл явц хоорондын эрх зүйн хамаарал

Үндэсний болон үндэсний нэн тааламжтай нөхцөл үзүүлэх болон бусад ТХЕХ бий болсон бусад олон эрхийг олон улсын эрх зүйд өлж харж чадаагүй байна. ТХЕХ байгаагаар буй улс орон гадаад бодлогын зорилгодоо хүрэхийн тулд өөрийн худалдааны бодлогыг өөрийн зоргоор түлхүү хэрэглэх байсан.

ТХЕХ-ийн дэглэм бий болсноор олон улсын түвшинд эрх зүйн статус-квог өөрчилсөн ба эдийн засгийн, эрх зүйн болон улс төрийн онцгой хамааралтай эрх, үүргийн цогц тогтолцоо мөндрөхөд хүрсэн юм.

ТХЕХ/ДХБ-ын тогтолцооны хүрсэн амжилт бол чөлөөт худалдаа, эдийн засгийн өсөлт ба маргаан шийдвэрлэх асуудлаар наанадаж санаснаасаа гадуур хоёр үр дүнд хүрсэн юм. Дэлхийн худалдааны байгууллагын гишүүд ялангуяа АНУ, Европын холбоо² олон улсын худалдааны тогтолцоог бусад гишүүнд үзүүлэх давуу эрх утгаар хэрэглэхийг оролдсон бөгөөд гишүүн орнууд ТХЕХ болон Дэлхийн худалдааны байгууллагын маргаан шийдвэрлэх тогтолцоогоор шийдвэрлэж байхаар тэдгээр арга хэмжээг эсэргүүцэхийг оролдож байсан.

Дэлхийн худалдааны

¹ United States-Import Prohibition of Certain Shrimp and Shrimp Products, AB-1998-4, WT/DS58/AB/R (12 October 1998).

² ТХЕХ 1947 бол ТХЕХ 1994 болон ДХБ-ыг байгуулах эрх зүйн үндэс болсон хэлэлцээрийн нэг юм.

³ АНУ-д энэ бол хүрээлэн буй орчны болон өрсөлдөөний бодлогын хүрээнд бодит зүйл ба Европын холбоод үүнийг өрсөлдөөний болон хөдөө аж ахуйн бодлогын хүрээнд харж болно.

байгууллагын хэлэлцээр гишүүн орнуудад гадаад бодлогын зорилго тухайлбал, хүний эрхийг хамгаалах болон ардчиллыг бэхжүүлэхэд худалдааны бодлогыг хэрэглэхийг ямар хүрээнд зөвшөөрдөг бас эс зөвшөөрдөг бэ?

Үүнийг авч үзэхийн өмнө хүний эрх болон ардчиллын зорилгод дөхөм болох зорилгоор худалдааны арга хэмжээ авсан тухай Дэлхийн худалдааны байгууллагын хөндлөнгийн хэсэг болон давж заалдах байгууллагын ямар нэгэн шийдвэр одоогоор байхгүйг тэмдэглэх нь зүйтэй болов уу. АНУ болон Мьянмар улсын хоорондын маргаанд АНУ-ын Холбооны дүүргийн шүүхээс Массачусеттс мужийн Мьянмар улсаас бараа худалдан авахыг хориглосон хууль нь Үндсэн хууль зөрчсөн байна гэж шийдвэрлэсэн ба уг шийдвэрийг давж заалдсан тул Дэлхийн худалдааны байгууллагын хөндлөнгийн хэсгээр шийдвэрлүүлэхээр болж байсан байна.

Дэлхийн худалдааны байгууллагын шийдвэр нь хүний эрх, ардчилал болон хөдөлмөрийн асуудалд хамааралтай эсэхийг үнэлэхдээ Дэлхийн худалдааны байгууллагын гишүүн нь зарим төрлийн бараа үйлчилгээнд импортын хориг тавих зэрэг худалдааны арга хэмжээ авахдаа хүний эрх болон хөдөлмөрийн эрхийн стандартыг тодотдын болон олон улсын хэмжээнд хөндсөн эсэхийг авч үзэнэ. Мөн тухайн худалдааны арга хэмжээг авахдаа ТХЕХ-ийн 3 болон 11 дүгээр зүйлийг зөрчсөн эсэх болон худалдааны арга хэмжээ авсан гишүүн орон ТХЕХ-ын 20 дугаар зүйлээр зөвтгөж байгааг авч үзэх шаардлагатай юм.

Дахин боловсруулсан түлшний хэрэг дээр Давж заалдах шатны байгууллагаас АНУ-ын авсан

худалдааны арга хэмжээ нь импортлох буй түлшний химийн найрлагад нөлөөлөх замаар агаарын чанарыг сайжруулах зорилготой байсан нь 20 дугаар зүйлийг хангаж байна гэж үзсэн байдаг. Сам хорхой ба яст мэлхийн хэрэг дээр Давж заалдах шатны байгууллагаас АНУ-ын авч хэрэгжүүлсэн худалдааны арга хэмжээ нь далайн яст мэлхийг сам хорхойн торонд орж үхэхээс сэргийлсэн арга хэмжээ болсон ба 20 дугаар зүйлийг мөн хангаж байна гэж үзсэн юм. Гэсэн хэдий боловч Давж заалдах байгууллага тухайн авч хэрэгжүүлсэн тэрхүү арга хэмжээг буюу импортод хориг тавьсан нь 20 дугаар зүйлийн g-ын оршил нөхцлийг хангахгүй байгаа учраас хүчингүй болгосон ба 20 дугаар зүйлд хийсэн Давж заалдах шатны байгууллагын тайлбар нь наад зах нь 3 шалтгаантай байдаг.

Нэгдүгээрт, давж заалдах шатны байгууллагын хоёр шийдвэр хоёулаа 20 дугаар зүйлийн g-д хэрэглэгдэх хуулийн үйлчлэх хүрээ хязгаар байдаг гэсэн ТХЕХ-ийн Хөндлөнгийн хэсгийн дүгнэлтээс арай өөр байгаа юм.⁴ Энэ нь гишүүн орнуудад нийгмийн зорилгоо хэрэгжүүлэхдээ өөрийн нутаг дэвсгэрээс гадна худалдааны бодлогыг хэрэглэж болох эсвэл үндэсний хуулийн үйлчлэлээс гадна харьяаллын зарчмыг хэрэглэж болох хаалгыг нээж өгсөн юм. Хоёрдугаарт, худалдаатай холбоотой хүрээлэн буй орчны арга хэмжээ нь хязгаарлагдмал байгалийн нөөц баялгийг хамгаалахад хамаарна гэж үзсэн байна. Энэ нь 20 дугаар зүйлийг хэрэглэн гадаадын хамгаалалтын үйл явцад нөлөө үзүүлэх арга хэмжээг одоо зөвтгөхөд хялбар болж байгаа юм. Гуравдугаарт, дээрх хоёр хэрэг дээр Давж заалдах шатны байгууллага ил болон далд утгаар хязгаалагдмал нөөц баялгийг юу бий

болгож байгаа тухай өргөн утгаар авч үзсэн. Ургамал, амьтан магадгүй хүн,⁵ ашигт малтмал, цэвэр агаар, ус энэ бүгд хязгаарлагдмал нөөц баялг мөн юм. Энэ бүхнээс гадна гишүүн орнууд дараах шалгуурыг хангасан гэх нотлох баримтгүй байх шаардлагатай. Үүнд, худалдааны арга хэмжээ авч хэрэгжүүлэхээс өмнө хамтран ажиллах арга замыг эрэлхийлэх ёстой. Үүнд олон улсын хэлэлцээр байгуулах гэх мэт арга замууд орж болох. Мөн дээр авч үзсэн хоёр хэрэг дээр холбогдох бусад олон улсын гэрээ байгаа эсэх 20 дугаар зүйлийг хэрэглэх үндэслэл байсан эсэхийг тогтооход чухал ач холбогдолтой зүйл болсон юм. Хэрэв дотоод арга хэмжээг аваагүйгээр шууд худалдааны арга хэмжээ авсан бол ялгаварлагдсан явдал болох байсан. Due process болон хүндэтгэн үзэх шалтгаантай байх гэсэн шалгуурууд байх ёстой.⁶

Бүх нийтээр хүлээн зөвшөөрсөн хүний эрх, улам чөлөөтэй болж буй олон улсын худалдааны эрх зүйн зорилго нь хүний эрхээ эдлэх болон эдийн засгийн бүтээгдэхүүн бий болгох боломж, чадвар аль ч улсад ижил байх нэг стандартыг бий болгохыг зорьж байгаа юм. Энэ бүхний үр дагавар нь зарим улс оронд үнэ, тариф ямар нэгэн шалтгаангүй өсч буй мэт харагдах, хөдөлмөрийн өртөг өндөр болох, ажилгүйдэл өсөн нэмэгдэх, мэргэжлийн боловсон хүчин гологдох зэрэг олон зүйлээр ирэх болно. Эрх зүйн глобализацийн шилжилтийн үе гэж өдгөө дэлхийн зарим эрдэмтэн үүнийг нэрлээд байна.⁷ Энэ үеийг даван туулах арга зам бол Хүний эрхийг Олон улсын худалдааны эрх зүй ялангуяа Дэлхийн худалдааны байгууллагын эрх зүйд ойртон янгууль, уялдаа, холбоотой хөгжүүлэх юм. Эрх зүйн аргын тухайд тусгайлан авч үзэх болно.

CR CR CR

⁴ In TUNA I, supra note 17, GATT-ын Хөндлөнгийн хэсэг 20 дугаар зүйлийн b болон g-г тайлбарлахдаа эрх зүйн үйлчлэх хязгаар байна гэж үзсэн.

⁵ 20 дугаар зүйл g-ийг хүнд хамаатай эсэх талаар тодорхой бус боловч Сайжруулсан түлшний хэрэг дээр гурван шалгуурыг хангаж байгаа юм. Үүнд: үнэт зүйл, байгалийн бүтээгдэхүүн, дуусдаг гэх шалгууруудыг хүн хангаж байгаа юм.

⁶ Arthur E. Appleton "World Trade Organisation: Implications for Human Rights and Democracy" "Human Rights and Democracy for the 21st Century" VolXXIX(2000)

⁷ Агарт Э. Англтон, "The legality of Environmental Labelling programs Pursuant to the WTO agreement and General international law" сэдвээр хууль зүйн ухааны докторын зэрэг хамгаалсан, АНУ. Швейцарь, БНСУ зэрэг улсад хуульч, Дэлхийн худалдааны байгууллагын хэлэлцээрт эксперт зэрэг ажил хийж байсан, Ernst-Ulrich Petersmann, Женевийн Их Сургуулийн профессор "The WTO Constitution and Human Rights", Journal of International Economic Law (2000)19-25 Oxford University

ДЭЛХИЙН ХУДАЛДААНЫ БАЙГУУЛЛАГЫН ЭРХ ЗҮЙН АЧ ХОЛБОГДЛЫГ ЭРГЭЦҮҮЛЭХҮЙ

Оршил

1995 онд Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээрийн суурин дээр үндэслэн байгуулагдсан Дэлхийн худалдааны байгууллага (ДХБ) нь арав гаруйхан жилийн хугацаанд гадаад худалдааны нийтлэг дэглэмийг 151 гишүүн орны хэмжээнд тогтоож чадсанаар жинхэнэ глобал шинж чанартай, нөлөө бүхий олон улсын байгууллага болсон билээ.

Олон улсын худалдаа нь хүний хэрэглээг дэлхийн хэмжээнд ижил түвшинд хүргэх нэгэн хүчин зүйл болсон хэдий ч сөрөг нөлөө үзүүлж байгааг нь үгүйсгэхийн аргагүй. Үүний нэг жишээ нь чөлөөт худалдааны хөлд бохирдож буй байгаль орчин юм.

Үүнийг бид өөрийн орны жишээндээ ч харж болно. Өнөөдөр нийслэл хотын маань дүр зургийг Япон, Солонгос, Герман зэрэг оронд үйлдвэрлэсэн гоёмсог машингүйгээр төсөөлөх боломжгүй ч мод, зэс, бугын эвэр, тарваганы арьс гэх зэрэг байгалийн баялгийг урд хөрш рүү ихээр зөөж, байгалийн тэнцвэрт байдал алдагдаж байна.

Тийм ч учраас өнөөгийн олон улсын худалдааны тогтолцооны гол хандлагыг тодорхойлогч Дэлхийн худалдааны байгууллагын гүйцэтгэж буй үүргийн тухайд дэлхий нийтийн санал бодол нэгдмэл биш байна.

Даяарчлалыг эсэргүүцэгчид хийгээд хүний эрхийг хамгаалагчид ДХБ, түүний явуулж байгаа бодлогыг шүүмжилсээр байна. Эл шүүмжлэл нь ч зарим талаар үндэслэлтэй билээ. Тухайлбал, Ази, Африкийн олон орон ДХБ-д нэгдэн орж, зах зээлээ нээлттэй болгосноор эдийн засгийн зарим салбар нь нуран унасан түүх цөөнгүй бий. Ялангуяа, хөдөө аж ахуйн салбарт, Европын Холбоо болон АНУ-ын төрийн ивээл дор хямд бүтээгдэхүүний нийлүүлэлт орж ирэн, өртөг өндөртэй, уламжлалт арга технологиор үйлдвэрлэсэн, өрсөлдөх чадваргүй дотоодын бүтээгдэхүүнийг зах зээлээс шахан гаргаснаар, олон тариачин өрх аж амьдралын эх



ХБНГУ, Бремений их сургуулийн магистрант
Ц.МОНГОЛХАТАН

үүсвэрээ алдахад хүрч байна.

ДХБ-ын үйл ажиллагаа эрдэмтэд, судлаачдын сонирхлыг ихээхэн татдаг. Эл байгууллагын үйл ажиллагаатай холбоотой эрдэм шинжилгээний шүүмжлэлт хэлэлцүүлэгт хөгжингүй төдийгүй хөгжиж буй орны эрх зүйч, эдийн засагч, нийгэм судлаачид өргөн хамрагдаж, идэвхтэй оролцох болжээ.

Монгол Улс 1997 онд ДХБ-ын гишүүн болсон авч энэ байгууллагын талаарх судалгаа хангалттай хийгдээгүй байгаа нь тун харамсалтай. ДХБ, түүний эрх зүйтэй холбоотой, монгол хэлээр хэвлэгдсэн материал хайх явцад, "Олон талт худалдааны хэлэлцээний Уругвайн үе шатны дүнд байгуулсан эрх зүйн зарим баримт бичиг"-ийн орчуулга, Г.Сэсээрийн "Дэлхийн худалдааны байгууллагын эрх зүйн зарим асуудал" зэрэг цөөн номоос өөр зүйл олдохгүй бэрхшээл тулгарч байсныг нуух юун. Эдийн засгийн талаас Монгол-Германы хамтарсан төслөөс (Экспортны баримжаатай Үйлдвэр Худалдааны Бодлого) хийсэн цуврал судалгааг эс тооцвол судалгаа бараг хийгдээгүй байна.

ДХБ-ын эрх зүй нь өргөн хүрээтэйн дээр, нарийн ээдрээтэй асуудлуудыг хамардаг. Иймд энэхүү өгүүллийн эхний хэсэгт Дэлхийн худалдааны байгууллагын эрх зүйн үндэс хийгээд Монгол Улсын

хүлээсэн үүргийг товч танилцуулна. Түүнчлэн сүүлийн арван жилд ДХБ-ын эрх зүй Монгол Улсад ямар ач холбогдолтой байсан бэ гэсэн асуултад хариу өгөх болно.

Аливаа улс орон олон улсын байгуулагад нэгдэн орохдоо үндэснийхээ эрх ашгийг дээдлэхийн сацуу эрх, үүргийн тэнцвэрийг хадгалахыг эрмэлздэг билээ. ДХБ шиг ийм ээдрээтэй тогтолцоотой байгууллагад Монгол Улс олж авсан эрхээ бодитой эдэлж чадаж байна уу гэсэн асуулт зүй ёсоор тавигдаж байна. Энэ асуултад ч хариулахыг хичээлээ. Мөн Монгол Улс нь ДХБ-ын гишүүн орныхоо хувьд юунд илүү анхарах вэ, дотоодын эрх зүйн ямар зохицуулалтыг хийвэл ДХБ-ын гишүүнчлэлийн үр шимийг хүртэх боломжтой талаар санал бодлоо хуваалцахыг зорилоо. Эл өгүүлэлд ДХБ-ын эрх зүйтэй холбоотой асуудлыг цогцоор нь авч үзэх боломж хязгаарлагдмал байсан тул зарим нэг тодорхой асуудлыг л хөндсөн болно.

1. Дэлхийн худалдааны байгууллагын эрх зүйн талаар

Дэлхийн худалдааны байгууллагын гол үйл ажиллагаа нь дэлхий дахинд чөлөөт худалдааг хөгжүүлэхэд чиглэдэг. Үүнд улс орныхоо зах зээлийг хамгаалсан протектианст бодлогыг халж, улс гүрнүүд харилцан тохиролцооны үндсэн дээр худалдааны саяд тогтворыг аажмаар устгахад тэргүүн зэргийн ач холбогдол өгдөг билээ.

ДХБ-ын тогтолцоо нь олон талт худалдааны хэлэлцээний Уругвайн үе шатны үр дүн мөн. Энэ нь нийт 60 шахам хэлэлцээр, харилцан ойлголцох баримт бичиг, шийдвэр, тунхаглал болон бусад баримт бичгээс бүрдсэн цогц баримт юм. Эдгээрийг агуулгын хувьд үндсэн зургаан хэсэгт хувааж болно:

- ДХБ-ын бүтэц зохион байгуулалтыг зохицуулсан хэлэлцээр,

- Барууны худалдаа ба хөрөнгө оруулалт, үйлчилгээний худалдаа болон оюуны өмч гэсэн

үндсэн гурван чиглэлд хийсэн гэрээжүүд (Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээр (ТХЕХ 1994). Худалдаатай холбогдсон хөрөнгө оруулалтын арга хэмжээ, Үйлчилгээний худалдааны тухай ерөнхий хэлэлцээр, Оюуны өмчийн эрхийн худалдаатай холбогдсон асуудлын тухай хэлэлцээр).

- Маргаан шийдвэрлэх механизм тогтоосон хэлэлцээр,
- Худалдааны бодлогыг хянах механизм тогдорхойлсон хэлэлцээр.

Дэлхийн худалдааны байгууллага нь дэлхийн худалдаатай холбоотой асуудлыг өргөн цар хүрээтэй зохицуулсан бөгөөд барааны худалдааны салбарт хамгийн нарийвчилсан зохицуулалтыг хийсэн байдаг. Үүнийг дагалдах хэлэлцээрүүдийн жагсаалтаас харж болно.

ТХЕХ 1994-ийн VII зүйлийг хэрэгжүүлэх тухай хэлэлцээр (Гаалийн үнэлгээ), Ачуулахын өмч хяналтын тухай хэлэлцээр (АӨХТХ), Худалдаан дахь техникийн саад тотгорын тухай хэлэлцээр (ХТСТ), Эрүүл ахуй, ургамлын эрүүл ахуйн арга хэмжээ авах тухай хэлэлцээр (ЭАУЭА), Импортын тусгай зөвшөөрөл олгох журмын тухай хэлэлцээр, Хамгаалах арга хэмжээний тухай хэлэлцээр, Тагаас, саармагжуулах арга хэмжээний тухай хэлэлцээр (ТСАХТХ), ТХЕХ 1994-ийн VI зүйлийг хэрэгжүүлэх тухай хэлэлцээр (Демпингийн эсрэг дүрэм) (ДЭД), Худалдаатай холбоотой хөрөнгө оруулалтын арга хэмжээний тухай хэлэлцээр (ХХОАХ), Сүлжмэл, нэхмэл бүтээгдэхүүн болон хувцасын тухай хэлэлцээр, Хөдөө аж ахуйн тухай хэлэлцээр, Гарал үүслийн талаарх дүрэм, журмын тухай хэлэлцээр гэх мэт.

Дээрх хэлэлцээрийг гишүүн орнууд бүгд хүлээн зөвшөөрөх үүрэгтэй. Түүнээс гадна заавал нэгдэн орохгүй байж болох хязгаарлагдмал тооны оролцогчидтой худалдааны дөрвөн гэрээ бас бий. Үүнд, Иргэний агаарын тээврийн онгоц худалдах тухай хэлэлцээр, Засгийн газрын худалдан авалтын тухай хэлэлцээр, Сүүн бүтээгдэхүүний тухай олон улсын хэлэлцээр, Ухрийн махны тухай олон улсын хэлэлцээр ордог. Эрх зүйн эдгээр баримт бичигт

тулгуурлан бий болж байгаа олон талт худалдааны тогтолцоо нь дараах зарчимд тулгуурладаг:

1. Худалдаанд ялгааарлан гадуурхах явдал гаргахгүй байх зарчим.

Энэ зарчим нь үндэсний нэн тааламжтай нөхцөл болон импортын барааг дотоодын бараа тавартай ижил харьцах бодлогоос бүрдэнэ. Эл зарчим нь барааны худалдаа, үйлчилгээ, оюуны өмчийн салбарт ДХБ-аас гаргасан журамд тусгагддаг. Гэвч салбараасаа хамаараад цар хүрээний хувьд ялгаатай байж болно. Үндэсний нэн тааламжтай нөхцөл олгох гэдэг нь гишүүн орнууд бусад гишүүн орны бараанд аль нэг өөр орны бараанд олгодогос дутуугүй тааламжтай нөхцөл олгож байна гэсэн үг юм.

2. Харилцан солилцох зарчим.

Энэ зарчмыг нь улс гүрнүүд үндэсний нэн тааламжтай нөхцөлийг бие биетэйгээ харилцан солилцсоны үндсэн дээр хэрэгжүүлдэг. Эл зарчим нь гадаадын зах зээл дээр гарах боломжийг нээж өгч байгаа юм. Улс орнууд тус тусдаа хэлэлцээр хийснээс давуу нөхцөл олж авах боломжийг олгож байгаа юм.

3. Хүлээсэн үүрэг амлалтаа заавал биелүүлэх зарчим.

ДХБ-ын гишүүн орон хүлээсэн үүрэг амлалтын жагсаалтад тусгагдсан импортын тарифыг заавал дагаж мөрдөх үүрэгтэй. Тарифын дээд хязгаарыг зөвхөн худалдааны түншүүдтэйгээ хэлэлцээр хийсний үндсэн дээр л өөрчилж болно. Тэгэхдээ худалдааны түншүүдэд тарифын хязгаарыг өөрчилснөөс болж гарсан алдагдлыг төлөх үүрэг хүлээж болзошгүй анхаарах хэрэгтэй. Эрх ашиг нь зөригдсэн тал маргаан шийдэх бүрэлдэхүүнд (МШБ) хандаж болно.

4. Ил тод байх зарчим.

ДХБ-ын гишүүн орнууд нь худалдаатай холбоотой дүрэм журмыг хэвлэх, захиргааны шийдвэрийг хянан шалгах байгууллагыг ажиллуулах үүрэг хүлээдэг. Түүнчлэн өөр гишүүн улс хүсэлт гаргавал мэдээлэл өгөх, худалдааны бодлогодоо гарсан өөрчлөлтийг цаг тухайд нь ДХБ-д мэдээлж байх ёстой. Гишүүн улс бүрийн худалдааны бодлогыг тогтмол хянах тогтолцоо нь энэхүү

зарчмыг хэрэгжүүлэхэд тусалдаг. ДХБ нь зах зээлийг урьдчилан тооцох, тогтвортой байлгах үүднээс квот, бусад тоон хязгаар тавих боломжийг арилгахад үйл ажиллагаагаа чиглүүлдэг.

5. Хэлэлцээрээр хүлээн зөвшөөрсөн нөхцөлд хамгаалалтын арга хэмжээ авах зарчим.

Засгийн газар нь худалдааг тодорхой нөхцөлд л хязгаарлана. Үүнийг зөвшөөрсөн заалтуудыг гурван үндсэн төрөлд ангилж болно. Нэгдүгээрт, эдийн засгийн бус нийгмийн зорилтыг хэрэгжүүлэх үүднээс, хоёрдугаарт, шударга өрсөлдөөний дэмжих зорилгоор, гуравдугаарт, эдийн засгийн шалтгаанаар худалдаанд хязгаарлалт хийх заалт байдаг.

ДХБ нь дээрх зарчмыг баримталж ажиллахын зэрэгцээ дараах үүргийг хүлээдэг. Үүнд:

- холбогдох худалдааны хэлэлцээрүүдийг хэрэгжүүлэх, захиран зохион байгуулах болон дэмжлэг үзүүлэх,

- хэлэлцээ хийх,
- маргаан шийдвэрлэх,
- худалдааны бодлогыг хянах,
- олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах ёстойг тус тус дурддга.

2. Монгол Улс ба Дэлхийн худалдааны байгууллага

1997 оны 1 дүгээр сард Монгол Улс ДХБ-ын гишүүн болсон билээ. ДХБ-д элсэн орсноос хойш дотоодын эрх зүйн хэм хэмжээг ДХБ-ын эрх зүйд нийцүүлэх, гадаадын хөрөнгө оруулагчдад эрх зүйн таатай орчин бүрдүүлэх талаар цаашаахааргүй ажил хийж, худалдааны дэглэмээ үндсээр нь өөрчлөн, либералчилсан. Тухайлбал, тарифын түвшинг бууруулж, импортлох эрх авахад тавьдаг шаардлагыг хялбар дөт болгох арга хэмжээг авсан билээ.

Олон улсын хууль Г.Сэсээр „Дэлхийн худалдааны байгууллагын эрх зүйн зарим асуудал“ бүтээлдээ Монгол Улс ДХБ-д нэгдэн ороход авсан үүрэг амлалт, түүний хэрэгжилтийн талаар дэлгэрэнгүй өгүүлсэн байдаг. Мөн ДХБ болон Монгол Улсын Засгийн газраас гаргасан „Монгол Улсын худалдааны бодлогыг хянан үзэх“ тайланд (2005) худалдааны бодлого, түүний хэрэгжилттэй холбоотой асуудлыг

дэлгэрэнгүй мэдээлсэн байна. Иймд өгүүллийн энэ хэсэгт зөвхөн тарифын асуудлыг авч үзье.

Монгол Улс худалдааныхаа бодлогыг тарифаар дамжуулж хэрэгжүүлдэг юм. ДХБ-ын гишүүн орны хувьд Монгол Улс гадаад худалдаагаа зөвхөн тарифын тусламжтайгаар зохицуулах үүрэгтэй. Гаалийн татварын түвшинг хэлэлцээний үндсэн дээр тогтоож, аажмаар бууруулан, цаашдаа эл түвшинг өсгөхийг хориглодог. Орон бүр үндэсний тарифын жагсаалт гаргаж өгөх ёстой. Тэгэхдээ өөрийн тарифын буултгыг тусгах ёстой бөгөөд үүнээс дээш тариф, бусад хураамж тогтоохгүй байх үүрэг хүлээдэг.

Монгол Улс 1997 онд ДХБ-ын гишүүн болохдоо ялгавартай тарифтай байхаар тохиролцож байжээ. Энэ нь тухайн үед бусад улс оронтой сонирхсон барааны талаар тарифын хэлэлцээ хийх чухал хэрэгсэл болгох учиртай байв. Гэтэл төсвийн орлого нэмэгдүүлэх үүднээс импортын тарифыг хэсэг хугацаанд тэглэж байсан түүх бас бий. Г.Сэсээрний хэлснээр, гаалийн татварын тариф нь аливаа улс орны худалдааны бодлогын илрэл болохоос биш төсвийн орлого хөөцөлдөх хэрэгсэл байж таарахгүй.¹

Одоогийн байдлаар Монгол Улс руу импортоор орж байгаа барааны ихэнхэд үнийн дүнгээс тооцсон 5 хувийн гаалийн татвар ногдуулж байна. ДХБ-д нэгдэн орох тухай Протоколд тарифын дээд хязгаар нь 20 хувь байхаар тохиролцсон байдаг. Эл хязгаарын хүрээнд Монгол Улс одоо байгаа тарифаа нэмэгдүүлдэг боломжтой.

Өнөөдөр мөрдөгдөж байгаа жигд тарифын бүтэц нь гаалийн үйл ажиллагааг энгийн хялбар болгох, зах зээлийн гажуудлыг багасгах, ил тод байдлыг нэмэгдүүлэх зэрэг сайн талтай боловч засгийн газрын хэлэлцээр хийх үед Монгол Улсад ашигтай хөшүүрэг болж чадах эсэх нь эргэлзээтэй байна. Тухайлбал, хоёр хөрштэйгөө тааламжтай нөхцөлтэйгөөр

тохиролцоо хийх хэлэлцээрийн үед хоёр талаас буулт хийхэд манай улсын зүгээс санал болгох зүйл алга байна. Дашрамд дурдахад, германы судлаач Вольфганг фон Лингэсхайм-Зайбике худалдааны бодлогын үүднээс авч үзвэл, Монгол Улсад жигд тарифын тогтолцоо тохирох эсэхийг бодож үзүүштэй гэж зөвлөсөн байдаг.²

3. Дэлхийн худалдааны байгууллагын эрх зүйн ач холбогдол

2005 онд ДХБ-ын 10 жилийн ойд зориулан гаргасан номонд бичсэн өгүүлэлдээ Д.Цогтбаатар, 1997 оноос 2005 хүртэлх хугацаанд ДХБ нь Монголд төдийлөн ач холбогдолтой байгаагүй³ хэмээн үнэлсэн байдаг. Тэрээр энэхүү дүгнэлтээ манай худалдааны гол түнш болох хоёр хөрш гишүүн биш байсны улмаас Монголын худалдааны дийлэнх хэсэг ДХБ-ын эрх зүйн хүрээнээс гадуур явагдаж байсан хийгээд, ДХБ-ын хууль нь барваны худалдаанд төвлөрдөг тул манай экспортын гол бүтээгдэхүүн болох ашигт малтмал үүнд хамраахгүй байсанд үндэслэн гаргасан аж. Харин урд хөрш маань ДХБ-ын гишүүн болж, ОХУ гишүүнээр элсэх бэлтгэлээ хангаж буй үед уг нөхцөл байдал өөрчлөгдөж, ДХБ-ын эрх зүй манай орны хувьд улам бүр ач холбогдолтой болсоор байгааг тэмдэглэв.

ДХБ-ын эрх зүйн хүрээнд шийдвэрлэж болох олон асуудал байна. Тухайлбал, хоол хүнсний аюулгүй байдлынхаа асуудлыг ДХБ-ын эрх зүйн хүрээнд шийдвэрлэх боломжийг судалж үзэх хэрэгтэй байна. Эрүүл ахуйн шаардлага хангаагүй хүнсний бүтээгдэхүүн урд хөршөөс орж ирсээр байгааг зүгээр хараад сууж байгаа нь зохисгүй. ДХБ-ын эрх зүйн хүрээнд хамгаалалтын арга хэмжээ авч болох эсэх, өөр ямар эрх зүйн зохицуулалт хийж болохыг нарийвчлан судлах шаардлагатай байна.

Монгол, Хятадын хоорондын

худалдааны өөр нэг ноцтой асуудал нь татаас юм. Сүүлийн жилүүдэд Хятад улс татаасыг зээлийн хэлбэрээр олгож байна. Монголоос ноос, ноолуур худалдан авдаг аж ахуйн нэгжүүдэд хятадын эрх баригчид хөнгөлөлтгүй нөхцөөр зээл өгч байгаа нь манай улсын стратегийн ач холбогдол бүхий ноолуурын салбар, цаашилбал Монголын эдийн засагт хохирол учруулж байна. Өнөөдөр зээл нь ямар нөхцөлд ДХБ-ын дүрэмд үл нийцэн, экспортын татаас тотоогдох эсэхийг тодорхойлох боломжгүй байгаа нь харамсалтай. Учир нь ийм зээлийн бодлогыг зохицуулсан дүрэм журмыг ч нийтлээгүй байна.⁴

ДХБ-ын хэм хэмжээний үүднээс татаасын хэргийг батлахад хэцүү байдаг учраас ихэнх улс орон худалдааны үйл ажиллагаагаа хэвийн байдалд нь буцаан оруулахын тулд демпингийн эсрэг арга хэрэгслийг ашиглаж байна. Учир нь демпингийн шалгуурт нийцэж байгаа эсэхийг тогтоох нь илүү хялбар байдаг. ТХЕХ-ийн 6 дугаар зүйлийн дагуу ДХБ-ын гишүүн улсууд демпингийн эсрэг арга хэмжээ авахыг зөвшөөрдөг.⁵ Тиймээс Монгол Улс демпингийн эсрэг хуулийг аль болох даруй гаргаж хэрэгтэй байна. Монгол Улс аль ч тохиолдолд энэ асуудлыг ДХБ-ын хэм хэмжээний хүрээнд цаашид судалж, шалгах, үнэлэх, цаашилбал, Хятадын татаасын эсрэг худалдааны томоохон түнш болох АНУ, Европын Холбооноос авч буй арга хэмжээг анхааралтай ажиглаж, шаардлагатай нөхцөлд тэдгээр оронтой хамтран ажиллах хэрэгтэй.

4. Цаашид анхаарах зүйл

Монгол Улс нь ДХБ-д элссэн цагаасаа хойш хүлээсэн үүргээ биелүүлдэг анхаарлаа хандуулж, өөрийн улсын хууль тогтоомжийг ДХБ-ын эрх зүйтэй нийцүүлэхэд л төвлөрч ажилласнаас бус, ДХБ-аар дамжуулан эрх ашаа хамгаалахад төдийлөн анхаарч байсангүй. Гэтэл олон улсын

¹ Сэсэр Г., Дэлхийн худалдааны байгууллагын эрх зүйн зарим асуудал, 202 дахь тал

² Фон Лингэсхайм-Зайбике В., ДХБ-д Хятад улс нэгдэн орох нь Монгол Улсад нөлөөлөх нь, 59 дэх тал

³ Tsoygotbaatar D., Case study Mongolia in Managing the Challenges of WTO Participation - 45 Case Studies, p.443

⁴ Фон Лингэсхайм-Зайбике В., ДХБ-д Хятад улс нэгдэн орох нь Монгол Улсад нөлөөлөх нь, 32 дэх тал

⁵ Мөн тэнд, 60 дахь тал

худалдаа нь ашиг сонирхлын тэмцэлтэй явагддагийг мартаж болохгүй. Иймд Монгол Улс нь ДХБ-тай хамтран ажиллахдаа дараах зүйлд анхаарлаа хандуулах шаардлагатай байна.

1. Экспортыг хөгжүүлэх,
2. Маргаан шийдвэрлэх механизмыг ашиглах,
3. ДХБ-ын үйл ажиллагаанд идэвхтэй оролцох.

Экспортыг хөгжүүлэх

Монгол Улс нь ДХБ-ын гишүүнийхээ хууль ёсны эрх, давуу байдлаа бүрэн ашиглахын тулд экспортыг дэмжсэн идэвхтэй бодлого явуулах шаардлагатай. Иймд Монгол Улсын хувьд бэлэн болон хагас боловсруулсан бүтээгдэхүүнийг экспортод гаргах нь ач холбогдолтой. Тэгэхдээ барааны нэр төрлийг нэмэгдүүлэх, шинэ техник, технологийг ашиглахад чиглэсэн бодлого үгүйлэгдэж байна.

ДХБ нь эрх зүйн хувьд гадаадын зах зээл дээр гарах боломжийг олгодог боловч хөгжиж буй орнуудад зах зээл дээр гарахад багагүй бэрхшээл учирдаг. Юуны өмнө, хөгжилтэй орны барааны стандарт болон тавигддаг бусад шаардлагыг хангах хэрэгтэй болдог. Иймд гадаадын зах зээл дээр гарахад мэдээлэл, бас эрх зүйн мэдлэг хэрэгтэй байна.

Европын холбоо, АНУ, Япон, Канад зэрэг хөгжилтэй орнууд хөгжиж буй зарим орны экспортын бараанд татварын хөнгөлөлт /preference/-ийг олгодог. Гэтэл Монгол Улс энэ боломжийг бүрэн ашиглаж чадахгүй байна. Иймд үндэсний үйлдвэрлэлийг төрийн зүгээс дэмжих, тэгэхдээ ДХБ-аас зөвшөөрсөн хэлбэрээр тусламж үзүүлэх нөхцлийг бүрэн ашиглах хэрэгтэй байна.

БНСУ болон Зүүн өмнөд Азийн зарим орны туршлагаас үзэхэд "гарааны тэнцүү нөхцөл" нь үндэсний үйлдвэрлэгчдэд ихээхэн ач холбогдолтой байсан аж.⁶ Гэтэл Монголын дотоод, гадаад зах зээл дээр гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид үндэсний аж ахуйн нэгжүүдтэй харьцуулахад өрсөлдөх давуу боломжийг олгосон

байдаг. Монголын татварын болон гаалийн тарифын тухай хуулиудаар гадаадын хөрөнгө оруулалттай үйлдвэрүүдийг татвар, тарифаас тодорхой хугацаагаар чөлөөлсөн байдаг. Иймд Монголын экспортлогчдыг гадаад зах зээлд дээр өрсөлдөх гарааны тэнцүү нөхцлөөр хангах зайлшгүй шаардлага байна.

Маргаан шийдвэрлэх механизмыг ашиглах

ДХБ-ын эрх зүй зөрчигдсөн тохиолдолд, гишүүн орнууд маргаан шийдвэрлэх байгууллагад хандаж болдог. Энэ нь манайх шиг жижиг орны хувьд бүр ч ач холбогдолтой гэж үзэж байна. Маргаан шийдвэрлэх үйл явц нь уг асуудлыг зохицуулах дүрэм, журмын тухай харилцан ойлголцох баримт бичгийн дагуу явагдана. Маргаан шийдвэрлэх байгууллага нь гаргасан зөвлөмжийг биелүүлэх талаар нэлээд хатуу байр суурь баримталдаг. Тийм ч учраас маргаан шийдвэрлэх тогтолцоо нь ДХБ-ын эрх зүйн хэрэгжилтийг хангах чухал хэрэгсэл болж чадсан билээ.

Монгол Улс нь өдгөөг хүртэл маргаан шийдвэрлэх механизмыг ашиглаагүй байна. Бусад хөгжиж буй орны туршлагаас харахад эдийн засгийн хувьд ноёрхох байр суурь эзэлдэг орнуудын эсрэг эл механизмыг ашиглан, эрх ашгаа хамгаалж чадсан жишээ олон байдаг.

Манай хүчирхэг хоёр хөрш ДХБ-ын гишүүн болсон тохиолдолд бид хэзээ эсг цагт энэхүү механизмыг ашиглах зайлшгүй байдалд орох нь дамжиггүй.

Иймд энэ чиглэлээр мэргэшсэн хуульчдыг бэлтгэх хэрэгтэй байна. Учир нь ДХБ-ын нэг онцлог нь харьяангүй бие даасан шинжтэй (self contained) систем юм.⁷ ДХБ нь эрх зүйн хэм хэмжээ тогтоохдоо олон улсын ерөнхий ба салбар эрх зүйгээс төдийлөн хамаарахгүй, зөвхөн өөрийн эх сурвалжуудыг ашигладаг. Ийм учраас маргаан шийдвэрлэх үйл явцад мэргэжлийн түвшинд оролцож чадах мэргэшсэн хуульчид хэрэгтэй байна.

ДХБ-ын үйл ажиллагаанд идэвхтэй оролцох

ДХБ нь нэг талаас манай орны хувьд ихээхэн ач холбогдолтой байгууллага, нөгөө талаас бид гишүүнчлэлийн өндөр хураамж төлдөг учраас гишүүн орны хувьд идэвхтэй оролцоотой байж, үр шимийг нь хүртэх хэрэгтэй. Манай улсад хөгжиж буй орнуудын нэгэн адил санхүүгийн болон хүний хүчин зүйлийн бэрхшээл тулгарч байна. Жишээ нь, ДХБ-д манай төлөөлөгчийн газар байхгүй тул Женев дэх НУБ-ын төлөөлөгчийн газар давхар хариуцдаг. Энэ нь ажлын ачааллаас болоод ДХБ-ын үйл ажиллагаанд идэвхтэй оролцож чадахгүйд хүргэсэн байж болох юм. Иймд ДХБ-ын үйл ажиллагаанд идэвхтэй оролцох тал дээр төрийн зүгээс санаачилга гарган, дэмжих хэрэгтэй байна.

Дүгнэлт

Өнөөдөр улс хоорондын худалдаа өргөжин хөгжиж, даяарчлал эрчимжиж байна. Дэлхийн худалдааны харилцаа, түүний хэм хэмжээг тогтоосон ээдрээтэй нарийн тогтолцоо бүрэлдэн буй болжээ. Ийм нөхцөлд ДХБ-ын эрх зүй нь улс орон бүрд ач холбогдолтой болсоор байна.

Монгол Улсын хувьд хоёр хөрш тэйгөө тогтоосон худалдаа-эдийн засгийн харилцааг шинэчлэх, тэгэхдээ ДХБ-ын эрх зүйн хүрээнд харилцааны шинэ нөхцлийг өөрсдийн идэвхтэй оролцоотойгоор буй болгох таатай боломж бүрдэж байна.

Энэхүү нэр хүндтэй ажилуулагын идэвхтэй гишүүн нь байж, бүрдэн буй болсон таатай нөхцөл боломжийг бүрэн ашиглаж, үр шимийг нь хүртэхэд бид өөрсдийн зүгээс шалтгаалах бүхнийг цаг алдалгүй хийх хэрэгтэй байна.



⁶ Дойд Г., Монголын экспортын өнөөгийн байдал, эрчимжүүлэх арга зам, 29-32 дөх тал
⁷ Matsushita M., Schoenenbaum T., Mavroridis P., The world trade organization, p. 76

«ГАДААД УЛСЫН ИРГЭН» ГЭХ ОЙЛГОЛТЫН ОХУ-ЫН ХУУЛЬ ТОГТООМЖ ДАХЬ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Энэхүү өгүүллийг орчин үеийн ОХУ-ын хууль тогтоомжд ашиглагдаж байгаа "гадаадын иргэн" гэсэн ойлголтын эрх зүйн дүн шинжилгээнд зориулагдсан бөгөөд он дарааллын хөгжлөөр товч авч үзэж болно.

Олон янзын үндэс, угсаа болоод иргэншил бүхий хүмүүс өнөөгийн дэлхий ертөнцийн нэгдэл нягтрал болон харилцан хамаарлын талаар дүгнэлт хийх боллоо. ОХУ тусгаар тогтносон цагаасаа энхийн бодлого, улс орнуудтай энх тайвнаар зэрэгцэн орших болон сайн хөршийн харилцааг дэмжиж ирсэн. ОХУ-ын хилийн нээлттэй байдал, мөн оросын аж ахуйн үйл ажиллагаа эрхлөгчдийн хувийн үйлдвэрүүдийн эздийн хувьд гадаад эдийн засгийн үйл ажиллагааны чөлөөт байдал болон гадаадын хөрөнгө оруулалтын хувьд оросын эдийн засгийн нээлттэй байдал, ажил хэргийн холбоо, аялал жуулчлалын хөгжил зэрэг нь манай орныг зорьж байгаа болон манай оронд амьдрах гадаадын иргэдийн тоог эрс нэмэгдэхэд хүргэсэн.

Орчин үед үүсээд байгаа байдал, улс орны болоод нийгмийн аюулгүй байдлыг хангах шаардлагыг өндөрсгөж буй дэлхий нийтийн нөхцөл байдал нь энэхүү зорилгыг биелүүлж чадахгүй эрх зүйн хэм хэмжээний тогтолцоог бий болгохыг шаардаж байна. Энэ нь ОХУ-ын цагаачлалын асуудлыг хөндөхөд хүргэсэн юм. 2002 оныг хүртэл үйлчилж байсан 1981 оны "ЗХУ дахь гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай" хууль нь шинэ нөхцөл байдалтай нийцэхгүй байсан юм. Шинээр бий болсон цагаачлалын хууль тогтоомжийн хүрээнд хэд эхэнд эрх зүйн акт батлагдан гарсан. Жишээ нь, 2002 оны 7 дугаар сарын 24-ний өдөр "ОХУ дахь гадаадын иргэдийн эрх зүйн байдлын тухай" холбооны хууль¹, 2003 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр "ОХУ-аас гарах болон ОХУ-д нэвтрэх журмын тухай" холбооны хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" г.м холбооны хууль батлагдсан. ОХУ-ын Ерөнхийлөгч болон Засгийн газар нь цагаачлалын асуудлыг шийдвэрлэхэд мөн оролцсон бөгөөд 2005 оны 3 дугаар сарын



Буриадын улсын их сургуулийн
Хууль зүйн факультетын
Олон улсын болон Үндсэн
хуулийн эрх зүйн тэнхимийн
ассистент
А.Г.ТЫШКЕНОВА

9-ний өдөр ОХУ-ын Ерөнхийлөгчийн зарлигаар ОХУ-ын Дотоод хэргийн үндсэн харьяа Холбооны цагаачлалын алба байгуулагджээ². Уг байгууллага байгуулагдсан явдал нь ОХУ руу гадаадын иргэд нэвтрэх болон ОХУ-д байхгүй холбоотой асуудлыг төрийн зүгээс шуурхай шийдвэрлэх нэн шаардлагатайг баталж байгаа юм.

Өгүүллийн хүрээнд манай орны хууль тогтоомж дахь "гадаадын иргэн" гэсэн ойлголтын эрх зүйн зохицуулалтын товч он дараалал болон, ОХУ-ын цагаачлалын бодлогын шинэ эхлэл алхам болсон "ОХУ дахь гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай" холбооны хуулийн "гадаадын иргэн" гэсэн нэр томьёоны эрх зүйн зохицуулалтын шинэчлэлийн талаар авч үзэхийг зорив.

"Гадаадын иргэн" гэсэн нэр томьёоноос гадна хууль тогтоомж мөн зохиолуудад "гадаад хүн" гэсэн нэр томьёо хэрэглэгдэж ирсэн бөгөөд хэрэглэгдсээр байна. Түүний хууль зүйн бодит утга санаа нь өнөөг хүртэл нэгдмэл байдлаар тодорхойлогдоогүй

бөгөөд, өргөн болон явцуу утгаараа хэрэглэгдсээр байна. Өргөн утгаараа, "гадаад хүн" гэдэг нь хүрэлцэн ирсэн улс орныхоо иргэн нь бус бүх этгээд бөгөөд харин явцуу утгаараа тухайн улс орны нутаг дэвсгэрт байгаа ч өөр улсын иргэншил бүхий этгээд юм.³ Улс орны хууль тогтоомжийн хөгжлийн янз бүрийн үед өөр өөр нэр томьёог хэрэглэж байсан. Иймээс оросын "гадаадын иргэн" гэсэн ойлголтын он дарааллын тодорхойлолыг авч үзье.

Оросын хууль тогтоомжийн хөгжлийн хувьсгалаас өмнөх үед "гадаад хүн" гэсэн нэр томьёог хэрэглэж байсан бөгөөд түүний агуулга нь ийнхүү тайлбарлагдаж байжээ.⁴ "Гадаад хүмүүсийн байдлын тухай" хуулийн эмхтгэлийн 817 дугаар зүйлд "тогтоосон журмын дагуу Оросын харьяатад ороогүй бусад гүрний харьяатуудыг "гадаад хүн" хэмээн" тооцож байжээ. Тиймээс зөвхөн бусад улсын харьяатууд Орос улсад гадаад хүн гэж нэрлэгдэж байв.

Зөвлөлтийн хууль тогтоомж бий болох үед гадаад хүн гэдэгт ЗСБНХУ-ын нутаг дэвсгэр дээр түр болон байнга оршин суугаа аль нэг гадаад улсын иргэншилгүй эрх бүхий, ЗСБНХУ-ын иргэн бус этгээдийг ойлгож байсан.⁵ "Гадаад хүн" гэсэн нэр томьёо нь 1918 оны ЗСБНХУ-ын Үндсэн хуульд хуульчлагдан хэрэглэгдэж байсан. Уг Үндсэн хуулийн 20 дугаар зүйлд: "бүх үндэстний хөдөлмөрчдийн эв санааны нэгдлийн үндэснээс Оросын бүгд найрамдах улсын нутагт хөдөлмөрлөхөөр болон ажилчдын андид хамаарах буюу газар тариалан бусдын хөдөлмөрийг ашигладаггүй амьдрах байгаа гадаадын иргэдэд Оросын иргэдийн бүх улс төрийн эрхийг олгох бөгөөд тийм гадаадын иргэдэд ямар нэг албан ёсны хүндрүүлэггүйгээр Оросын иргэний эрх олгохыг Орон нутгийн Зөвлөлүүдэд үндэснээр" гэж заажээ. 1924 оны Үндсэн хууль нь мөн зүйлүүддээ "Гадаад хүн" гэсэн ойлголыг хэрэглэж байсан боловч зарим нэг эрх зүйн актад "гадаадын иргэн" гэсэн нэр томьёо гарч ирснийг тэмдэглэж хэрэгтэй. Жишээ нь, 1924 оны 10 дугаар сарын 29-ний өдөр ЗХУ-ын

¹ Российская газета от 31.07.2002 г. N 140

² Российская газета от 12.03.2004 г. N 50

³ Кузнецов М.Н. Иностранцы граждане и лица без гражданства на территории СССР. М. 1985. С. 7

⁴ Алексеев А.С. Русское государственное право. М., 1895. С. 305

⁵ Правовое положение иностранцев в РСФСР: Справочник для иностранцев, опантов, беженцев. М., 1923. С. 4

тэмдэглэжээ. Уг нэр томьёонууд нь 1931 оны ЗХУ-ын иргэншлийн тухай хуулийн заалтад хэргэн зэрэг ашиглагдаж байсныг тэмдэглэх хэрэгтэй.⁶ Эдгээр нэр томьёоны агуулга нь хуулиудад тайлбарлагдаж байгаагүй бөгөөд адил угтгай хэмээн тооцогдож байсан. ЗХУ-ын 1936 оны Үндсэн хууль болон ЗСБНХОУ-ын 1937 оны Үндсэн хуульд зөвхөн "гадаадын иргэний" тухай яригддаг бөгөөд "гадаад хүн" хэмээх ойлголт дурдагддаггүй. Гэвч 1938 оны "ЗХУ-ын иргэний тухай" ЗХУ-ын хуульд "гадаад хүн" хэмээх ойлголт дахин хэрэглэгдэх болжээ.⁸ Дээрхи актад дүн шинжилгээ хийсний үндсэн дээр "гадаадын иргэн" болон "гадаад хүн" гэсэн ойлголтууд нь нэгэн адил хэрэглэгдэж байсан гэсэн дүгнэлт хийж болно. 1977 оны ЗХУ-ын болон 1978 оны ЗСБНХОУ-ын Үндсэн хууль батлагдсны дараа нөхцөл байдал өөрчлөгдсөн. Эдгээр Үндсэн хуулийн текстэнд "гадаадын иргэн", "харьяалалгүй этгээд", "гадаад хүн" гэсэн нэр томьёонууд ашиглагдаж болсон. Жишээ нь, 1977 оны ЗХУ-ын Үндсэн хуулийн 37 дугаар зүйлд гадаадын иргэн, харьяалалгүй этгээд гэсэн хоёр төрлийн этгээдийн эрх, үүргийг заасан байдаг. Харин уг хуулийн орогнолын эрхэд хамаарах 38 дугаар зүйлд гадаадын иргэдийн тухай заасан байдаг. Өөрөөр хэлбэл, гадаад хүн гэдэгт орогнолын эрх олж авсан гадаадын иргэн болон харьяалалгүй этгээдийг ойлгож байсан. "Гадаадын иргэн"-ий хууль тогтоомжийн тодорхойлолтод юу хамаарах вэ гэвэл 1981 оны 7 дугаар сарын 24-ний өдрийн "ЗХУ дахь гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай" ЗХУ-ын хуулийн нэгдүгээр зүйлийн нэг дэх хэсэгт үүнийг баталгаажуулж өгсөн байдаг. Гадаадын иргэн гэдэгт ЗХУ-ын иргэн биш бөгөөд гадаад улсын иргэн гэдгээ батлах, баталгаагүй этгээдийг ойлгож байсан.

"Гадаадын иргэн" болон "гадаад

хүн" гэсэн ойлголтыг хамаарч байдаг "гадаад хүн" гэсэн нэр томьёог ашиглах нь зохимжгүй юм гэж бодогдож байна. Нэгдүгээрт, Орос хэлний тайлбар толинд "гадаад хүн" гэж өөр улсын иргэн, харьяатыг хэлнэ. Харин харьяалалгүй этгээд нь өөр улсын иргэншил болон харьяалалгүй байна гэж нарийн тодорхойлсон байдаг.⁹ Хоёрдугаарт, "гадаадын хүмүүс" хэмээх ерөнхийлсөн нэр томьёо нь хууль тогтоомжийн нэр томьёоллод тодорхойгүй байдлыг бий болгож, хууль хэрэглэх явдалд маргаан үүсгэж болох юм.

Ийм төсөөлөл нь Оросын хууль тогтоогчдоод байсан болов уу хэмээн бодож байна. Учир нь өнөөгийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжид "гадаад хүн" гэсэн нэр томьёо нь хэрэглэгдэхгүй байгаа бөгөөд "гадаадын иргэн", "харьяалалгүй этгээд" гэсэн ойлголтыг гаргаж өгсөн. 1993 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн 5242-1 тоот "ОХУ-ын иргэдийн нэг газраас нөгөөд шилжих, ОХУ-ын нутаг дэвсгэрт оршин суух газраа сонгох эрхийн тухай" холбооны хуулийн нэгдүгээр зүйлийн гуравт хууль тогтоогч "ОХУ-ын иргэн биш этгээд" гэсэн ойлголт хэрэглэгддгийг дурдах хэрэгтэй.¹⁰ Уг нэр томьёог хэрэглэх болсон нь Үндсэн хууль судлаач эрдэмтдийн дунд гадаадын иргэн болон харьяалалгүй этгээд гэсэн хоёр нэр томьёог багтаасан "ОХУ-ын иргэн биш этгээд" гэсэн ойлголт хэрэглэх саналыг гаргахад хүргэсэн.¹¹ Одоогийн байдлаар ОХУ-ын хууль тогтоомжид "гадаадын иргэн" хэмээх ойлголтын хэд хэдэн тодорхойлолт байна.

2002 оны 7 дугаар сарын 25-ны өдрийн 115 тоот "ОХУ дахь гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай" холбооны хуулийн хоёрдугаар зүйлийн нэгд гадаадын иргэн гэдэгт ОХУ-ын иргэн биш бөгөөд гадаад улсын иргэн (харьяат) болох нотолгоотой этгээдийг ойлгоно.¹² Харьяалалгүй этгээд гэдэгт ОХУ-ын иргэн биш бөгөөд гадаад улсын иргэн (харьяат) болох нотолгоогүй этгээдийг ойлгоно гэсэн байдаг. Уг зүйлийн хоёрдугаар хэсэгт холбооны хуулийн зорилгод нийцүүлэн холбооны хуулиар харьяалалгүй этгээдэд зориулан гадаадын иргэнд зориулж гаргасан дүрмээс ялгарч

тусгай дүрэм батлагдсанаас бусад үед "гадаадын иргэн" нь өөртөө "харьяалалгүй этгээд" гэсэн ойлголтыг багтаана гэж заасан байдаг.

2002 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн 64-ФЗ тоот "Иргэншлийн тухай" холбооны хууль зарим нэг зүйлээрээ өөр тодорхойлолт өгсөн байдаг.¹³ Уг хуулийн гуравдугаар зүйлд гадаадын иргэн гэдэгт нь ОХУ-ын иргэн биш бөгөөд гадаад улсын иргэн (харьяат) болох этгээдийг ойлгоно гэсэн байдаг.

Дээрхи нэр томьёоллын дундаас эхнийх нь хамгийн оновчтой бөгөөд зөв гэж үзэж болох юм. Учир нь иргэншил нь батлагдсан байх ёстой бөгөөд тухайн этгээд аль нэг улсын иргэншилд байгаагаа өөрөө бие дааж нотлох үүрэгтэй.¹⁴ Хэрвээ тухайн этгээд өөрийн иргэншлийн талаар нотлож чадахгүй бол түүнийг харьяалалгүй этгээд (апатрид) гэж тооцдог.

Энэхүү өгүүллийн төгсгөлд "гадаад хүн" гэсэн ойлголт нь бичиг үсэг үүссэн үеэс хууль зүйн болон өдөр тутмын үгсийн санд оршоор ирсэн байна. Цаг хугацааны явцад уг ойлголын утга өөрчлөгдөж, Бидний ойлгож байгаагаар "Гадаадын иргэн", "харьяалалгүй этгээд" гэсэн ойлголтын зэрэгцээгээр "гадаад хүн" гэсэн нэр томьёог хэрэглэх нь хууль тогтоомжийн түвшинд хүндэрл үүсгэж хэрэглээний тодорхойгүй байдлыг үүсгэж байгаа ажээ. Гэвч хууль тогтоомжийн ойлголтын хүрээнд "харьяалалгүй этгээд" гэсэн ойлголтосо ялгагдах гадаадын иргэний ойлголтын нарийн тодорхойлолт аажмаар боловсрогдож байна. Орчин үеийн ОХУ-ын хууль тогтоомжид "Гадаадын иргэн" гэдэгт ОХУ-ын иргэн биш бөгөөд гадаад улсын иргэн (харьяат) болох нотолгоотой этгээдийг ойлгодог болохыг дахин хэлье. "Гадаад хүн" гэдэг ойлголт юу хамаарах вэ гэвэл хуулийн бодлоор энэ нь "Гадаадын иргэн" гэсэн ойлголтаа адил юм. Учир нь хууль зүйн нэм зохиолуудад "харьяалалгүй этгээд" гэсэн ойлголтын хувьд "апатрид" гэсэн нэр томьёо байдаг.

BSOS

⁶ Положение о союзном гражданстве 1924 г. // СЗ СССР. 1924. № 23. С. 202

⁷ Положение о гражданстве СССР 1931 г. // СЗ СССР. 1931. № 24. С. 196

⁸ Закон СССР «О гражданстве СССР» 1938 г. // Ведомости Верховного Совета СССР. 1938. № 11

⁹ Ожегов С.И. Словарь русского языка. М., 1988. С. 203

¹⁰ Российская газета от 10.08.1993 г. № 152

¹¹ Герасименко Ю.В. Правовые основы статуса лиц, не являющихся гражданами России (история, современность, перспективы). М., 2003. С. 12

¹² Российская газета. 31.07.2002 г. № 140

¹³ Российская газета. 05.06.2002 г. № 100

¹⁴ Герасименко Ю.В. Правовые основы статуса лиц, не являющихся гражданами России (история, современность, перспективы). М., 2003. С. 11

Ажилтныг ажилд нь эгүүлэн тогтоосон шүүхийн шийдвэрийн хэрэгжилт буюу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 67 дугаар зүйлд мониторинг хийсний дүнд дараах зөрчил, дутагдал байна гэж үзлээ.

1. Ажил олгогчид нь ажилтныг ажлаас үндэслэлгүй халсан хууль бус тушаал, шийдвэрүүдийг олноор гаргадаг. Энэ нь судалгааны хүрээнд 2003-2006 он хүртэл нийслэлийн зургаан дүүргийн шүүхээр шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр, Захиргааны хэргийн шүүхээс шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр, Төрийн албаны зөвлөлийн дүгнэлтэд хийсэн судалгаагаар тогтоогддог.

Тухайлбал, нийслэлийн Чингэлтэй, Сүхбаатар, Хан-Уул, Баянзүрх, Баянгол, Сонгинохайрхан дүүрэг болон нийслэлийн Захиргааны хэргийн шүүхэд 2003 онд төрийн албан хаагчийг ажлаас халсан тухай маргаан 166 байсан ба үүнээс 75 төрийн албан хаагчийг ажилд нь эгүүлэн тогтоосон. 2004 онд төрийн албан хаагчийг ажлаас халсан тухай маргаан 148 байсан ба үүнээс 64 төрийн албан хаагчийг ажилд нь эгүүлэн тогтоосон. 2005 онд төрийн албан хаагчийг ажлаас халсан тухай маргаан 174 байсан ба үүнээс 92 төрийн албан хаагчийг ажилд нь эгүүлэн тогтоосон байна.

2. Шүүхээс ажилтныг өмнөх ажилд нь эгүүлэн тогтоосон шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр гарч хүчин төгөлдөр болсон хэдийг ч энэхүү шийдвэр нь биеллээдэхгүй байх нь элбэг байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албанаас авсан 2003-2006 онд ажилд эргүүлэн тогтоох гүйцэтгэх баримт бичгийн судалгаанаас үзэхэд, Хан-Уул, Сүхбаатар, Баянгол, Баянзүрх зэрэг дүүргийн 11 иргэн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиглагаа хийгдсэн боловч өмнөх ажилдаа эргүүлэн томилогдож чадаагүй байна.

Шүүхийн шийдвэр биелэгдэхгүй байгаа шалтгаан нөхцлийг тогтоох болон шийдвэр гүйцэтгэгч нарт учирч байгаа бэрхшээлийг илрүүлэх зорилгоор Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албаны шийдвэр гүйцэтгэгч нараас анкетны асуулга авахад дараах байдал ажиглагдаж байна. Үүнд:

- Шүүхийн шийдвэрийг үл биелүүлэн ажилтныг өмнөх ажил, албан тушаалд нь эгүүлэн авдаггүй шалтгаан нь юу байдаг вэ? гэсэн асуултад: Ажлын байр нь цомхотгогдсон гэж 10 буюу 24.3 хувь, Удирдах албан тушаалтан шүүхийн шийдвэрийг хүлээн авдаггүй гэж 17 буюу 41.4 хувь, Ажлын байранд нь өөр хүнийг ажиллуулсан учир асуудлыг хэрхэн зохицуулахаа мэддэггүй гэж 12 буюу 29.2 хувь, Шүүхийн шийдвэр биелүүлэх эрх зүйн механизм учир дутагдалтай байдаг гэж 8 буюу 19.5 хувь, бусад гэж 7 буюу 17 хувь гэсэн хариулсан байна.

-Шүүхийн шийдвэр гүйцэтгэх явцад Танд ямар саад бэрхшээл учирдаг вэ? гэсэн асуултад: Удирдах албан тушаалтны дарамт, доромжлол – 15 буюу 36.5 хувь, Шийдвэр биелэлтэнд цаг хугацаа, зардал их шаардагддаг үнэааны гэх мэт - 15 буюу 36.5 хувь, Авлига, хэл хатууль санал болгодог-хариулт өгөөгүй, Хөндлөнгийн хүмүүсээс дарамт их ирдэг-7 буюу 17 хувь гэсэн хариулт өгсөн байна.

- Шүүхийн шийдвэр биелэхгүй байгаа нь ямар хүчин зүйлтэй холбоотой байдаг вэ? гэсэн асуултад: Удирдах ажилтны үйл ажиллагаатай – 22 буюу 53.6 хувь, Төрийн албаны хүнд суртал- 11 буюу 26.8 хувь, Аль нэг нам, үдс төрийн хүчний ашиг сонирхол, дарамт, шахалт-8 буюу 19.5 хувь, Шүүхийн шийдвэр гүйцэтгэгч нарын мэдлэг, ур чадвар муу-2 буюу 4.8 хувь, Бусад-4 буюу 9.7 хувь гэсэн хариулт өгсөн байна.

-Шүүхийн шийдвэрийн хэрэгжилтийг хангахын тулд ямар арга хэмжээ авах хэрэгтэй гэж бодож байна вэ? гэсэн асуултад: Шүүхийн шийдвэрийг санаатай үл тоон, биелүүлэхгүй байгаа удирдах албан тушаалтан оноох хуулийн арга хэмжээг чангатгах- 37 буюу 90 хувь, Ажлаас халах, ажилд эгүүлэн тогтоох хуулиудын агуулгын зөрчлийг арилгах, тэдгээрт дүн шинжилгээ хийх 4 буюу 9.7 хувь, бусад-4 буюу 9.7 хувь гэсэн хариултуудыг өгсөн байна.

3. Шүүхийн шийдвэр биелэгдэхгүй явдал нь иргэдийн хөдөлмөрлөх эрх, түүнтэй холбоотой зохистой амьжиргаатай байх зэрэг олон эрхийг зөрчиж, тэдний амьдрал ахуйд хүндээр

нөлөөлдөг.

Шүүхийн шийдвэрээр ажилдаа эргэн орж чадахгүй байгаа иргэдтэй уулзан ярилцахад иргэд шүүхийн шийдвэрийн дагуу ажилдаа эргэн орж чадахгүй байх нь тэдний хувьд гэр бүлийн хувьд, нийгмийн харилцааны хувьд, тэтгэвэр, тэтгэмжийн хувьд зэргээр маш их хохирдог болох нь харгдаж байна.

4. Шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийг биелүүлэхгүй байгаа буруутай албан тушаалтнуудад Захиргааны хариуцлагын болон Эрүүгийн хуулийн дагуу хариуцлага хүлээлгэдэггүй.

Эрүүгийн хуулийн 258 дугаар зүйлийн 258.1-д:

Хуулийн хүчин төгөлдөр болсон шүүхийн шийтгэх тогтоол, шийдвэр, магадлал, шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжийг санаатай биелүүлээгүй, эсхүл биелүүлэхэд нь зориуд саад учруулсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас таав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, нэг зургаас хоёр зуун тавин цаг хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

хэмээн хуульчилсан боловч энэ зүйл, ангиар Цагдаагийн ерөнхий газрын Хэрэг бүртгэх газрын хэмжээнд 2005-2007 оны эхний хагас жилд эрүүгийн хэрэг үүсгэж шалгасан тохиолдолд байхгүй Нийслэлийн прокуратурын газраас авсан судалгаа харуулж байна.

5. Ажил олгогчийн буруутай үйл ажиллагаа болох ажилтныг ажлаас буруу халсан хууль бус тушаал шийдвэр гаргаснаас болж төсөвт тодорхой хохирол учирч энэ нь эргэн төлөгддөггүй байна.

Энэ нь мониторингийн явцад судалсан үзсэн ажилгүй байсан хугацааны цалин хөлсийг ажилтанд олгож шийдвэрлэсэн шийдвэрээс харгагдаж байна. Гэхдээ төсөвт учирсан энэ мөнгө нь ажил олгогч нь зөвхөн төсвийн байгууллага эсвэл төрийн өмчийн оролцоотой аж

ахуйн нэгжид хаммаарна.

Тухайлбал, нийслэлийн Чингэлтэй, Сүхбаатар, Хан-Уул, Баянзүрх, Баянгол, Сонгинохайрхан дүүрэг болон нийслэлийн Захиргааны зэргийн шүүхэд 2003 онд төрийн албан хаагчийг ажлаас буруу халснаас ажилгүй байсан хугацааны цалин олговорт 7253036 төгрөг 2004 онд 17135976 төгрөг, 2005 онд 28323394 төгрөг нийт 52712406 төгрөгийг гаргуулан ажигланд ажилгүй байсан хугацааны цалинд олгосон байна.

6. Шүүхийн шийдвэр биелэгдэхгүй байх явдал нь эргээд тухайн хэрэг маргааныг шийдвэрлэхэд гарсан бүх зардал нь (тухайлбал, ажлаас үндэслэлгүй халсан, өөр ажилд буруу шилжүүлсэн нэхэмжлэлтэй хэргийг шийдвэрлэхэд гарсан шүүгчийн цалин хөлс г.м) үргүй зардал болж хувирахад хүргэж байна.

Шүүхийн шийдвэр гарах хүртэл бүхий л үйл ажиллагаа нь төсвийн зардлын хүрээнд явагддаг. Дээрх судалгааг гаргахын тулд нийслэлийн Баянзүрх дүүргийн шүүхээс 2007 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 2007 оны 6 дугаар сарын 1-ний хооронд нийтдээ "ажлаас буруу халсан, өөр ажилд буруу шилжүүлсэн" 11 хэргийг шийдвэрлэсэн ажиллагаанд ажиглалтын болон баримтын судалгаанд шинжилгээ хийх аргуудыг хослуулан тухайн төрлийн хэрэг маргааныг шийдвэрлэхэд гаргах төсвийн зардлыг дунджаар гарав.

Дээрх судалгааны дүнгээс

үндэслэн судалгааны багаас дараахь дүгнэлт болон зөвлөмжийг гаргасан болно.

Дүгнэлт

1. Шүүхээс ажилтныг өмнөх ажилд нь эгүүлэн тогтоосон шийдвэрийн биелэлт хангалтгүй.

2. Үүнээс үүдэн шүүхийн шийдвэрийн дагуу ажилдаа орж чадахгүй байгаа иргэд амьдрал ахуй, тэтгэвэр, тэтгэмж болон олон эрхээрээ хохирдог.

3. Төсвийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн хувьд шүүхийн шийдвэрээр ажилтанд олгогдсон ажилгүй байсан хугацааны цалин эргээд хууль бус тушаал, шийдвэр гаргасан буруутай албан тушаалтнаас төлөгддөггүй ба энэ нь төсвийн хууль бус зарцуулалт болдог.

4. Ажилтныг өмнөх ажилд нь эгүүлэн тогтоосон шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийг санаатайгаар биелүүлэхгүй байгаа буруутай албан тушаалтнуудад зохих хуулийн дагуу хариуцлага хүлээлгэдэггүй.

ЗӨВЛӨМЖ

1. Ажилтныг ажилд нь эгүүлэн тогтоосон шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийг биелүүлэхгүй байгаа буруутай албан тушаалтанд Захиргааны хариуцлагын болон Эрүүгийн хуульд заасан хариуцлагыг ногдуулах практикийг тогтоох.

2. Шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийг биелүүлэхгүй байгаа буруутай албан тушаалтанд ногдуулах Захиргааны хариуцлагын

тухай хуульд байгаа торгуулийн хэмжээг нэмэгдүүлэх.

3. Ажлаас буруу халсан, өөр ажилд буруу шилжүүлсэн тухай маргааныг шийдвэрлэхэд альтернатив арга буюу эвлэрүүлэх зуучлах, аргыг шүүхийн өмнөх шатанд өргөнөөр хэрэглэдэг болох.

4. Ажилтныг буруу халснаас төсөвт хохирол учруулсан тохиолдолд буруутай албан тушаалтанд хуулийн дагуу хариуцлага хүлээлгэх эрх зүйн орчинг бүрдүүлэх.

5. Шүүхийн шийдвэрээр ажилтныг ажилд нь эгүүлэн тогтоосон тохиолдолд ажилтанд олгож байгаа ажилгүй байсан хугацааны цалин хөлсийг хууль бус тушаал, шийдвэр гаргасан буруутай албан тушаалтнаас гаргуулах эрх зүйн орчинг боловсронгуй болгох.

6. Ажлаас буруу халсан ажилтныг ажилд нь эгүүлэн тогтоосон шүүхийн шийдвэрийг шүүхээс гаргахдаа илүү тодорхой, ойлгомжтой гаргаж байх. Тухайлбал, шүүхийн шийдвэрийг биелүүлэх хүртэл хугацаанд ажилгүй байсан хугацааны цалинг олгодог гэж тусгах.

7. Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, энэ талаарх эрх зүйн орчинг сурталчлах.



АЛБАДАН АЖИЛ ХИЙЛГЭХ ЯЛ НОГДУУЛСАН ШҮҮХИЙН ШИЙТГЭХ ТОГТООЛЫГ ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГААНЫ ОНЦЛОГ, ПРАКТИКИЙН ЗАРИМ АСУУДАЛ

Албадан ажил хийлгэх ял нь Эрүүгийн хуульд 2002 онд шинээр тусгагдан хэрэглэгдэж байгаа ялын өвөрмөц төрөл юм.

Эрүүгийн хуульд "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тодорхойлсон газарт, нийгэмд ашигтай ажлыг цалин хөлсгүйгээр хийлгэхийг албадан ажил хийлгэх ял" хэмээн тодорхойлж, уг ялыг зөвхөн үндсэн ялын шинж чанартай ногдуулахаар хуульчилжээ.

Иймээс албадан ажил хийлгэх ял нь Эрүүгийн хуульд орсон ялын шинэ төрөл үү аль эсвэл уламжлалт ялын төрөл байсан эсэхийг тогтоох, уг ялын төлөвшил хөгжил, цаашдын чиг хандлага, зүй тогтлыг судалснаар уг ялыг гүйцэтгэх ажиллагааны онцлог, түүнд тавих хяналтын тогтолцоог тогтоох суурь үндэс болж өгөх юм.

Өмнө үйлчилж байсан Эрүүгийн төрөлжсөн хуулиудаас үзэхэд:

1934 оны Шүүх цаазын бичгийн 4 дүгээр бүлэгт заасан шийтгэх ялуудын төрөлд "Хорихгүйгээр албадан ажил хийлгэх" гэсэн нэр томъёогоор хэрэглэсэн байдаг ба 21 дүгээр зүйлд "Хорихгүйгээр албадан ажил хийлгэх нь уул ял шийтгүүлэгчийг ажил үйлдвэрээр засан сайжруулах ба сахилга журамтай болгохын тулд хэрэглэнэ". Хорихгүйгээр албадан ажил хийлгэх явдлыг нэг долоо хоногосой найман сар хүртэл тогтооно, гэж заасан бөгөөд "үндэсний улаан цэргийн жинхэнэ албана бүхий цэргийн хүмүүсийг хорихгүйгээр албадан ажил хийлгэх үл болно"² гэжээ. Мөн 25 дугаар зүйлд "Хэрэв ногдсон торгуулийг эс төлвөөс шүүн таслах газраа хорихгүйгээр албадан ажил хийлгэхийг тогтоогоод 50 төгрөг бүрийн төлөө 1 сар албадан ажил хийлгэх болгон гүйцэтгэж болно" гэж заасан байна.

Мөн албадан ажил хийлгэх



ШШГЕГ-ын Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих тасгийн ахлах байцаагч, ахлах дэслэгч
Ч.ӨНӨРЦЭЦЭГ

ялтай ойролцоо, төстэй ял байсны нэг нь Засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ял юм. Энэ "... ялыг улс, хоршорлол, олон нийтийн тодорхой байгууллагын хамт олны дотор, ердийн ажилчдын хийдэг ажлыг хийлгэж, цалингаас цөөн хувийн суутгал хийж, улсын орлогод оруулан, зохих хувийг яптанд олгож эдлүүлдэг байсан тул албадан ажил хийлгэх ялыг бодвол хагас албадлагын шинжтэй байжээ.

Үүнээс дүгнэхэд албадан ажил хийлгэх ял нь шинэчлэн батлагдсан Эрүүгийн хуульд орсон ялын шинэ төрөл бус өнөөг хүртэл шүүхийн практикт хэрэглэгдэж ирсэн уламжлалт ялын төрөл болох нь харагдаж байгаагийн зэрэгцээ өмнөх хууль тогтоомжид өөр өөр нэр томъёоллоор хуульчлагдаж байсан хэдий ч утга агуулга, үндсэн шинж, онцлогийнхоо хувьд уламжлалт болсон ойлголтоо хадгалсаар иржээ. Дээрх байдлаас дүгнэж үзэхэд албадан ажил хийлгэх ялтай

ойролцоо төрлийн ял байжээ. Гэхдээ ялын тогтолцоонд ялын шинэ төрлийг нэмэхдээ бус уг ялын мөн чанар, агуулгыг хуульч хэрэглэгчид хэрхэн ойлгож, практикт яаж хэрэгжүүлж, төлөвшүүлж байна вэ? гэдгээс уг ялын үр нөлөө шууд хамаарч, ялын зорилго хангагдаж байх ёстой.

Албадан ажил хийлгэх ялыг гадаад орнуудад "Нийгэмд үйлчлэх ял" гэсэн нэр томъёоллоор хэрэгжүүлж байгаа боловч зорилго, мөн чанарын хувьд манайд хэрэглэж буй албадан ажил хийлгэх ялтай төстөвтэй байна.

Хуульд "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас тодорхойлсон нийгэмд ашигтай ажил хийлгэх замаар албадан ажил хийлгэх ялыг эдлүүлэх" -ээр заажээ. Тэгвэл хууль тогтоогчоос "Нийгэмд ашигтай ажил" гэж юу болох, ямар ажлыг нийгэмд ашигтай гэж үзэх талаар тодорхой ойлголтыг хуульчилж өгөөгүй бөгөөд зарим судлаач үүнийг "...тухайн нутаг дэвсгэрийн тохижилт үйлчилгээний чиглэлийн биеийн хүчний ажлууд"³ хэмээн тодорхойлсон байна.

Тэгвэл "Нийгэмд ашигтай ажил" гэдгийг Та юу гэж ойлгож байна вэ? гэсэн асуултыг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад ажиллаж буй эрх олгогдсон 167 тойргийн шийдвэр гүйцэтгэгчээс саналын хуудсаар авахад:

-төрийн байгууллагад хийж буй ажил гэж 50 шийдвэр гүйцэтгэгч;

-эмзэг бүлэгт чиглэгдсэн нийгмийн халамж үйлчилгээний ажиллагаа гэж 81 шийдвэр гүйцэтгэгч;

-энэ талаар огт ойлголт байхгүй гэж 36 шийдвэр гүйцэтгэгч харуул өгчээ. Эцэст нь дүгнэхэд энэ талаар нэгдсэн ойлголт байдаггүй нь дээрх санал асуулгын дүнгээс харагдаж байна.

Практикт ихэвчлэн албадан ажил хийлгэх ялыг эдлүүлэхдээ зөвхөн хот тохижуулах ажилд (гудамж, талбайн хог цэвэрлэх, мод услах гэх мэт) туслуулах хэлбэрээр

¹ Эрүүгийн хуулийн 50 дугаар зүйлийн 50.1 дэх заалт

² 1934 оны Шүүх цаазын бичгийн 4 дүгээр бүлэг

³ Г.Совд Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар, УБ; 2002, 69 дэх тал

ялын биелэлтийг хангуулж ирсэн нь Тохжилт, үйлчилгээний компанид хог цэвэрлэх нь нийгэмд ашигтай ажил мэт ойлгогдож байна. Тохжилт, үйлчилгээний компани нь тодорхой төсөвтэй, батлагдсан орон тоотой бөгөөд яланг цалингүй ажиллуулах нь тухайн байгууллагын хувьд ашигтай юм. Гэтэл албадан ажил хийлгэх ял шийтгүүлсэн ялтны ажлын үр дүнг нийтээр эсвэл тодорхой нутаг дэвсгэрийн хүн ам хүртсэнээр уг ажлын нийгэмд ашигтай шинж илэрч байх ёстой.⁴

Ийнхүү хууль тогтоогчоос нийгэмд ашигтай, ашиггүй ажил хэмээн ялган заагласны зэрэгцээ нийгэмд ашигтай ажлын төрлүүдийг тодорхойлоогүй явдал нь учир дутагдалтай байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас тодорхойлсон нийгэмд ашигтай ажил нь тухайн ажил олгогч байгууллагын хувьд байнгын ажлын байранд хийгдэх ажил бус тухайн аж ахуй нэгжийн хувьд ажлын ачаалал нэмэгдсэн эсвэл богино хугацаанд гүйцэтгэх шаардлагатай ажил байх нь илүү тодорхойтой юм. Практикт энгийн иргэнд ажил олдохгүй байхад ялтнаар хийлгэх ажил байхгүй мэтээр ярьдаг. Тэгвэл нийгмийн хэрэгцээ шаардлагын үүднээс заавал хийгдэх шаардлагатай ажлууд байдаг боловч тэдгээрийг цэргийн алба хаагч, сургуулийн сурагч, аль эсвэл захиргааны журмаар баривчлагдсан хүмүүсээр хийлгэдэг. Мөн өнөө үед ихээр яригдаж байгаа гэр хорооллын барилгажуулах, 40 мянган айлын орон сууцны хөтөлбөр гэх мэт төслийн хүрээнд тусгай мөргөжил, мэдлэг шаардагдахгүй ажлууд ихээр байдаг. Тэгвэл эдгээр ажлыг ялтнаар ягаад хийлгэх болохгүй гэж...

2002 онд батлагдсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай Монгол Улсын хуулийн 96 дугаар зүйлийн 96.6, 96.7 дахь хэсгүүдэд "Албадан ажил хийж буй ялтны цалин хөлсийг гэмт хэргийн улмаас бусдад учруулсан хохирлыг нөхөн төлөхөд суугтана", "ялтан өр төлбөргүй бол албадан ажил хийсэн ялтны цалин

хөлсийг улсын төсөвт оруулах"⁵ талаарх эрх зүйн зохицуулалт цалин бөгөөд уг заалтууд нь ялтан цалингаараа учруулсан хохирлоо нөхөн төлөх, төлбөргүй бол цалин олгохгүй гэсэн агуулгыг илэрхийлж байсан. Уг хуулийн заалт практикт хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байсан. Өөрөөр хэлбэл, ялтны хөдөлмөрийн хөлсийн суутгал хийгддэггүй байсан гэж ойлгож болно. Дээрх заалтыг хэрэгжүүлэх шатанд ялтны 1 цагийн хөдөлмөрийн хөлсийн хэмжээг нэгдсэн байдлаар тогтоогоогүй, харин гэрээнд харилцан тохиролцож тогтоохоор заасан байсан.

Хуулийн зохицуулалтаас харахад төлбөргүй ялтан нь цалин хөлсөө улсын төсөвт оруулж, төлбөртэй нь гэмт хэрэг үйлдсний улмаас бусдад учруулсан хохирлоо төрөөс төлүүлэн, завшиж байгатай нэгэн адил ойлгогдож хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар албадан ажил хийлгэх ял шийтгүүлсэн ялтанд хөдөлмөрийн хөлс олгох, суугтах талаарх заалтыг хүчингүй болгосон боловч уг заалтыг хүчингүй болгохын оронд ял эдэлж буй ялтны хөдөлмөрийн хөлсийг Засгийн газраас тогтоосон 1 цагийн хөдөлмөрийн хөлсийн үнэлгээтэй ямар харьцаатай байхыг тооцон үнэлээг тогтоож, албадан ажил хийлгэх ял шийтгүүлсэн ялтны хөдөлмөрийн хөлсийг дараах байдлаар эрх зүйн зохицуулалтыг хийх нь давуу талтай гэж үзэж байна.

Албадан ажил хийлгэх ял шийтгүүлсэн ялтны хөдөлмөрийн хөлсийг тусгайлан байгуулсан зохих санд төвлөрүүлсэн гэмт хэрэг үйлдсэн этгээдийн бусдад учруулсан хохирлыг эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр барагдуулах ял эсвэл гэмт хэрэгцээ урьдчилан сэргийлэх ажилд зарцуулах нь илүү үр дүнтэй байж болох юм.

Тухайлбал, хадгаламж, зээлийн хоршооны хохирогчдын хохирлыг төрөөс эргэн төлөгдөх

нөхцөлтэйгээр 50 хувиар барагдуулахаар хууль батлагдан гарч, хэрэгжиж байгаа бөгөөд иргэдийн татварын мөнгөнөөс дээрх төлбөрийг барагдуулж байхаар хэрэг, зөрчилд ногдуулан торгуулийн мөнгө, албадан ажил хийж буй ялтны хөдөлмөрийн хөлс, улсын орлогод оруулж (эд хөрөнгө хураах ял) хураагдсан орлогын эх үүсвэрийг хуримтлуулж "Хуримтлалын сан" байгуулах нь илүү оновчтой байсан болов уу. Гэхдээ манай улсын хувьд төлбөрийг шууд санд хуримтлуулах нь Төсвийн тухай хуультай зөрчилдөх тул санд төвлөрүүлэх мөнгөн хөрөнгийг тухай бүрт нь төсвийн хууль тогтоомжоор шийдвэрлэн өгч байвал тохиромжтой юм.

Албадан ажил хийлгэх ялыг ялын бусад төрөлтэй харьцуулахад гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хамгийн хөнгөн, эдлэхэд боловцоотой бөгөөд өөрөөр хэлбэл, хорих ялтай харьцуулахад эргэж нөлөөлөх нөлөөлөл, төрөөс гаргах зардал хөрөнгө бага зэрэг ашигтай шинжээрээ ялгардаг бол торгох ялаас хэрэгжих бодит шинжээрээ давуу талтай юм. Албадан ажил хийлгэх ял нь тухайн ялтны төлбөрийн чадвартай эсэхэд хамааралгүй зөвхөн хөдөлмөрлөх чадвартай нь холбоотойгоор хэрэгжидэг байна. Ялтан үйлдсэн гэмт хэргийнхээ төлөө нийгэмд ашигтай ажил хийж, зохих хамт олны дунд орж тэдэнтэй хамтран ажилласнаар ялтан өөрийн зөргө байр суурийг мэдэрч ойлгоход уг ялын нөлөөлөл их юм.⁶

Хорих ял нь эдийн засгийн хувьд зардал их гардаг. Нэгдүгээрт, хоригдогсдыг хооллох, байрлуулах, хувацлах, бусад үндсэн үйлчилгээг үзүүлэхэд татвар төлөгдөөс хуримтлуулсан мөнгө ихээр зарцуулагдаж байдаг. Хоёрдугаарт, хоригдогсдын ихэнх нь ноцтой гэмт хэрэгтэн бус ихэвчлэн хөнгөн гэмт хэрэг /хуял, эд хогшлыг гэмтээсэн/ үйлдсэн ялтнууд байна. Хорих ял эдлэх буй нэг ялтанд зарцуулж буй зардлыг 2006 оны байдлаар авч үзвэл жирийн дэглэмтэй хорих илд ял эдэлж буй нэг хоригдолд хонгт

⁴ Хүний эрх сэтгүүл, УБ; 2004 он, 25 дахь тал

⁵ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай Монгол Улсын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, 2007 оны 8 дугаар сарын 3-ны одрийн хуулиар 96.6, 96.7 дахь заалтыг хүчингүй болгосон

⁶ Хүний эрх сэтгүүл, УБ; 2004 он, 22 дахь тал

2755 төгрөг буюу жилд 1005568 төгрөгийг зарцуулдаг гэж бодоход жилд дунджаар 6000 ялтан хорих ялыг биечлэн эдэлж байна гэж бодоход төрөөс хэдий хэмжээний мөнгө зарцуулах нь ойгломжтой юм. Хорих ялыг их хэмжээгээр хавтгайруулан ногдуулснаар хорихоос өөр төрлийн ялын нэр хүнд буурч, улмаар уг ял нь гэмт явдалтай тэмцэх, үр нөлөөтэй хэрэглүүр болж чадахгүй байдалд хүрнэ.⁷

2005 онд нийт 10153 ялтан ял шийтгүүлсэн байх бөгөөд үүнээс 3106 хүнд хорихоос өөр төрлийн ял ногдуулсан ба нийт ялын дотор 30.6 хувийг эзэлж байсан бол 2006 онд нийт 7792 ялтан ял шийтгүүлж үүнээс 2314 хүнд хорихоос өөр төрлийн ял ногдуулж, нийт ялын дотор 29.7 хувь, албадан ажил хийлгэх ялыг 538 хүнд ногдуулжээ.⁸



2007 оны 9 дүгээр сард хийсэн судалгаанаас үзэхэд албадан ажил хийлгэх ял шийтгүүлэгсдийн 90 орчим хувь нь эрэгтэй байсан ба уг ялаар шийтгүүлэгсэд нь гэр бүлийн хувьд тогтворгүй, олон хүүхэдтэй, амьжиргааны түвшин доогуур орлоготой⁹ байдаг зэргээс шалтгаалан ял эдлэх явцад ажил олгогч байгууллагын эд материал, багаж хэрэгслийг хулгайлах эсвэл унаа, хоолны мөнгө байхгүйгээс болж ажлаа орхих, дутуу хийх зэрэг шалтгааны улмаас шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулахад хүндрэлтэй нөхцөл байдлууд практикт ихээр гардаг байна.

Албадан ажил хийлгэх ял эдэлсэн ялтанд холбогдох гүйцэтгэх баримт бичгээс харахад ажилласан цаг нь ихэвчлэн өдөрт 10 цагийн хугацаагаар ялыг эдлүүлсэн байх ба ажил хийж буй ялтан нь хэдийгээр ял эдэлж байгаа ч ажлын нэг өдрийн дотор зохих хугацаанд түр амрах, хөдөлмөрийн хууль тогтоомжийн дагуу асуулгүй, эрүүл нөхцөлөөр хангагдах, ажил үүргээ гүйцэтгэхэд нь зайлшгүй шаардлагатай ажлын багаж хэрэгсэл, хувцас зэргээр хангагдах эрхтэй билээ.

Албадан хөдөлмөрийг устгах тухай Конвенц, Албадан ба заавал хийх хөдөлмөрийг устгах тухай Конвенцуудад албадан хөдөлмөрт үл тооцох тохиолдлуудыг заасны дотор шүүх үйлдсэн гэмт хэрэгт нь шийтгэл болгон эрхлүүлж буй хөдөлмөрийг албадан хөдөлмөр гэж үзэхгүй гэжээ. Тэгэхээр ялтны хийж

ялыг эдлүүлэх боломж бий юу? гэсэн асуулдаг:

- Боломжтой гэж 93 шийдвэр гүйцэтгэгч,

- Боломжгүй гэж 36 шийдвэр гүйцэтгэгч,

- Ял авсан учир ялаа л эдлэх ёстой гэж 38 шийдвэр гүйцэтгэгч.

2. Албадан ажил хийлгэх ялыг үндсэн ял байхад хэтэрхий хөнгөн ял гэж Та боддог уу? гэсэн асуулдаг:

- Хөнгөн ял гэж 86 шийдвэр гүйцэтгэгч,

- Үндсэн ял байхад тохирно гэж 75 шийдвэр гүйцэтгэгч,

- Хэлж мэдэхгүй байна гэж 6 шийдвэр гүйцэтгэгч туустус хариулт өгчээ.

Дээрх санал асуулгыг эцэст нь дүгнэж үзэхэд хэрвээ ялтан ял шийтгүүлэхээс өмнө эрхэлж байсан ажлаа гүйцэтгэхийн хамт шүүхээс ногдуулсан ялыг шийдвэр гүйцэтгэгчээс өдөрт эдлүүлэхээр тогтоосон хугацаанд (цагт) ялыг эдлэх боломж байгаа нь харагдаж байгаа боловч практикт эл ялыг хэрэгжүүлэхдээ ялтны алдахгүй байх үүднээс ялыг богино хугацаанд хурдан дуусгаж, гүйцэтгэх баримт бичгийг хаах сонирхол давуу байдаг байна. Мөн хөдөө орон нутгийн алслагдсан суманд ялтны албадан ажил хийлгэх ялыг эдлүүлэх тохиолдолд шийдвэр гүйцэтгэгч хяналтыг биечлэн хэрэгжүүлэх боломжгүй байдаг учраас ихэвчлэн сум, багийн Засаг даргаар хяналтыг тавиулахаас гадна нөгөө талаар биечлэн хяналт тавих зорилгоор аль болох аймгийн төвд ялыг (гэрээс нь хол) эдлүүлэхийг эрмэлздэг байна. Алслагдсан суманд ажиллаж байгаа ялтанд хяналт тавихдаа тухайн сумын хэсгийн байцаагчидтай хамтран ажиллах нь илүү үр дүнтэй.

Улсын хэмжээнд 2003-2007 онд нийт 1960 хүнд шүүхээс албадан ажил хийлгэх ял ногдуулсан бөгөөд түүний биелэлтийн байдлыг авч үзвэл:



буй хөдөлмөр нь зарим талаараа албадлагын мэт боловч агуулгаараа албадан хөдөлмөрт хамаарахгүй нь харагдаж байна.



Албадан ажил хийлгэх ялыг эдлүүлэх ажиллагааг оновчтой болгох, ялын биелэлтийг хангах зорилгоор шийдвэр гүйцэтгэх байгууллагад ажиллаж байгаа 167 тойргийн шийдвэр гүйцэтгэгчээс авсан зарим санал асуулгын дүнгээс харахад:

1. Ялтан өмнө эрхэлж байсан ажлаа гүйцэтгэхийн хамт шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас тодорхойлсон газарт өдөрт 3 цагийн хугацаагаар албадан ажил хийлгэх

⁷ Нарангарал С. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй /ерөнхий анги/. УБ, 1999 он

⁸ Монгол Улсын дээд шүүхийн 2006 оны жилийн тайлан 36 дахь тал

⁹ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх тасгийн 2007 оны 9 дүгээр сарын Албадан ажил хийлгэх ял шийтгүүлсэн ялтны судалгаа



Дээрх байдлаас дүгнэхэд албадан ажил хийлгэх ялыг хэрэгжүүлэх, уг ялыг төлөвшүүлэх, хяналтын тогтолцоог бий болгохын тулд тодорхой ажлуудыг үе шаттайгаар хийх шаардлагатай байна. Тухайлбал:

- уг ялын зорилтыг ханган, хэрэгжүүлэхийн тулд ялыг ногдуулахаас эхлэн эдлүүлэх үйл ажиллагааг эрхэлдэг албан хаагчид /Тухайлбал: шүүгч, шийдвэр гүйцэтгэгч г.м./-ыг сургах, тэдэнд арга зүйн дэмжлэг үзүүлэх, ялтыг ажиллуулах аж ахуйн нэгж, байгууллагын зохих ажилтнуудад ял болон ял эдлүүлэх ажиллагааны талаар эрх зүйн зөв ойлголт өгч, бэлтгэх зэрэг арга хэмжээг иж бүрнээр нь хэрэгжүүлэх;

- Улсын дээд шүүхээр "Нийгэмд ашигтай ажил" гэсэн ойлголтыг тайлбарлуулж нэг мөр ойлголттой болохын зэрэгцээ албадан ажил

хийлгэх ял шийтгүүлсэн ялтаар хийлгэж болох, аль эсвэл болохгүй ажлын төрөл, жагсаалтуудыг тодорхойлох; (тусгай, мэргэжлийн ур чадвар шаардагдахгүй гэх мэт)

- Төрийн болон төрийн бус байгууллагуудыг сайн дурын үндсэн дээр албадан ажил хийлгэх ялыг эдлүүлэх ажиллагаанд оролцуулж, хэвшүүлэх, тэднийг урамшуулах;

- Албадан ажил хийж буй ялтын 1 цагийн хөдөлмөрийн хөлсний үнэлгээг Засгийн газраас тогтоосон 1 цагийн хөдөлмөрийн хөлсний үнэлгээтэй ямар харьцаатай байхыг тогтоож энэ чиглэлээр судалгааны ажил явуулж, ялтын 1 цагийн хөдөлмөрийн хөлсний үнэлгээг тогтоох;

- Ялтанд хөдөлмөрийн хөлсийг олгохгүйгээр зохих санд төвлөрүүлж, гэмт хэргийн улмаас иргэдэд учирсан хохирлыг нөхөн төлөх аль эсвэл гэмт хэргээс урьдчилан

сэргийлэх ажилд зарцуулдаг тогтолцоонд шилжүүлэх;

- Гадаад орнуудад энэ төрлийн ялыг гүйцэтгэж буй байдлыг судалж, өөрийн орны онцлогт тохирсон оновчтой тогтолцоог бүрдүүлэх;

- Албадан ажил хийлгэх ял шийтгүүлсэн ялтын урьд эрхэлж байсан ажлыг хийлгэн ялын биелэлтийг хангах нөхцөл бололцоог судалж, үндэслэлтэй, практикт чиг баримжаатайгаар хэрэгжүүлэх;

- Хэвлэл мэдээллийн хэрэгслийг ашиглан, уг ялын давуу талыг сурталчилж, нийгэмд эерэг ойлголтыг төлөвшүүлэх, хэлэлцүүлэг зохион байгуулах нь албадан ажил хийлгэх ялыг нийгэмд хэвшүүлэн хэрэгжүүлэхэд тодорхой нөлөөлөл үзүүлэх болов уу.



ХОРИХ ЯЛЫН ҮР НӨЛӨӨ, ТҮҮНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Хорих ял нь гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн зайлшгүй шаардлагатай, нэмэгдэл хэрэгслүүдийн нэг юм. Төр засгаас ял шийтгэлийн өмнө тавьж буй зорилт, түүнд хүрэх байдал нь эрүүгийн болон засан хүмүүжүүлэх бодлогод зайлшгүй нөлөөлөөхөөс гадна гэмт хэрэгтэй тэмцэх бодлогод ч нөлөөлөх юм. Тиймээс эрүүгийн эрх зүйн ял шийтгэлийн зорилго нь салбар хоорондын шинжтэй асуудал болоод байна.

Эрүүгийн ял шийтгэлийн зорилгын талаар өргөн хүрээтэй ярьж судалсан хэдий ч энэ асуудлыг шийдвэрлэсэн гэж ярих нь эрт байгаа юм. Монгол Улсын Эрүүгийн хуулийн 45 дугаар зүйлд "Эрүүгийн хариуцлагын зорилго нь иргэн, нийгмийг гэмт халдлагаас хамгаалах, гэмт хэргийн улмаас зөрчигдсөн эрхийг сэргээх, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг цээрлүүлэх, хүмүүжүүлэх, гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэхэд оршино" гэжээ.

Монгол Улсын Их Хурал 2002 онд Эрх зүйн шинэтгэл хөтөлбөрийн хүрээнд Эрүүгийн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг шинэчлэн баталсан билээ. Нийгэм, эдийн засгийн болон амьдралын хэв маягийн өөрчлөлттэй уялдан Монголын нийгмийн амьдралд өөрөг, сөрөг олон шинэ үзэгдэл бий болж үүнтэй холбоотойгоор гэмт хэрэг үйлдэгдэж байгаа шалтгаан нөхцөл, сэдэл, зорилго, арга хэрэгсэлд ч өөрчлөлт гарсан. Монгол Улсын төрөөс эрүүгийн ял шийтгэлийн талаар баримтлах бодлого, хорих ял эдлүүлэх ажиллагаа, Эрүүгийн хуульд заасан хорих ялын (буюу шүүхээс ногдуулсан хорих ялын) хэмжээ үйлдсэн гэмт хэрэг, гэмт хэрэгтний гэм бурууд тохирсон эсэх, хорих ял эдлүүлэх нөхцөл байдал нь хорих ялын урьдчилан сэргийлэх, цээрлүүлэх, хүмүүжүүлэх зорилгыг хэрхэн хангаж буй байдал, өөрөөр хэлбэл, хорих ял үр нөлөөгөө өгч буй эсэхийг тодорхойлоход судалгааны зорилгоо чиглүүлсэн



ХЗУТ-ийн Криминологийн судалгааны секторын эрдэм шинжилгээний ажилтан
Г.ОЮУНБОЛД

болно.

Судалгааг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаа, түүнд дагаж мөрдөж байгаа хууль тогтоомж, журам, зааврууд хэрхэн хэрэгжүүлдэг талаар Баянзүрх дүүрэг дэх эмэгтэйчүүдийн 407 дугаар хорих ангид хорих ял эдэлж буй хоригдлууд, тус хорих ангиас "Буян" ХХК-д болон түүний охин компани болох "Алтан жимс" ХХК-д гэрээгээр ажиллаж байгаа ялтнууд, насанд хүрээгүй хүмүүсийн хорих 411 дүгээр ангид ял эдэлж байгаа ялтнуудын дунд явуулав.

1. Анкетийн судалгаа


Судалгаанд хамрагдсан 119 ялтны 72.3 хувь нь анх удаа ял шийтгүүлсэн, 25.2 хувь нь 2-3 удаа

ял шийтгүүлсэн, 1.7 хувь нь 4-өөс дээш удаа ял шийтгүүлсэн, 83.2 хувь нь жирийн дэглэмтэй хорих ангид ял эдэлж байгаа бол 6.8 хувь нь чанга дэглэмтэй хорих ангид ял эдэлж байлаа.


"Бусдын эд хөрөнгийг хулгайлах" гэмт хэрэгт асуулгад хамрагдсан ялтнуудын 19.8 хувь буюу 15 ялтан шийтгүүлсэн байна. Үүнээс 145.4-т заасан зүйл, хэсгээр 9 ялтан буюу 7.6 хувь, 145.3-т заасан зүйл, хэсгээр 1 буюу 0.8 хувь, 145.2-т зааснаар 5 буюу 4.2 хувь нь шийтгүүлсэн байна.

- Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэрэгт асуулгад хамрагдсан ялтнуудын 6.7 хувь буюу 8 ялтан шийтгэгдсэнээс 147.2-т заасан зүйл, хэсгээр 5 буюу 4.2 хувь, 147.3-т заасан зүйл, хэсгээр 3 буюу 2.5 хувь нь тус тус шийтгэгдсэн байна.

Хорих ялаар шийтгүүлсэн ялтнуудын хувьд дийлэнх нь бусдын өмчийн эсрэг гэмт хэрэг тэр дундаа бусдын эд хөрөнгийг залилан мэхлэх, хулгайлах гэмт хэргүүд болон бусдыг санаатай алах гэмт хэрэг үйлдсэн байна. Өөрөөр хэлбэл, хорих ял эдэлж байгаа ялтнуудын 1/3 хувь нь залилан, 1/3 хувь нь хулгай, үлдэх 1/3 хувь нь бусдыг санаатай алах гэмт хэрэгт ял шийтгүүлсэн байна. Энэ нь тухайн ялтнуудын /насанд хүрээгүй хүмүүс, эмэгтэй ялтнууд/ нийгэмд эзлэх байр суурь бага, эдийн засгийн хувьд хараат, амьдралын боломж тааруу, гэр бүлийн хувьд хүчирхийлэл дарамтанд байвца байрса шалтгаан болсон байна.



Хорих ялаар шийтгүүлсэн байдлыг үзэхэд:



5 жил хүртэл хорих ялаар шийтгүүлсэн ялтнууд судалгаанд хамрагдсан ялтнуудын 6.7 хувь байгаа нь 2006 оны 6 дугаар сарын 23-нд Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ойг тохиолдуулж "Өршөөлийн тухай хууль" батлагдан гарч, хөнгөн, хүндэтгэр гэмт хэрэг анх удаа үйлдсэн ялтнууд суллагдсантай холбоотойгоор гарч байгаа үзүүлэлт юм.

Өршөөлийн тухай энэхүү хууль гарсантай холбогдуулан 411 дүгээр хорих ангид ял эдэлж байсан хүүхдүүд суллагдсан боловч нэг жил хагас хүрэхгүй хугацаанд 50 гаруй хоригдолтой болсон нь анхаарал татахгүй байхын арагуй байсан юм.

1. Хорих ялаар шийтгүүлсэн эмэгтэйчүүдийн ар гэрт ямар өөрчлөлт гарсныг судлахад /давхардсан тоогоор/ :

- 49 хувь нь тэднээс найз нөхөд нь нүүр буруулсан,
- 46.2 хувь нь ах дүү, хамаатан садны хүмүүс нүүр буруулсан,
- 36.1 хувь нь орон гэрээ алдсан,
- 35.3 хувь нь гэр бүл салсан,
- 27.7 хувь нь хүүхэд сургуулиас завсардсан, эд хөрөнгөө алдсан,
- 23.5 хувь нь гэр бүлийн хэн нэг нь нас барсан,
- 16.8 хувь нь хүүхэд гэр оронгүй, тэнэмэл амьдралтай болсон гэж хариулжээ.

Үүнээс үзэхэд хорих ял эдэлж байгаа ялтнуудаас ах дүү, хамаатан садны хүмүүс нь нүүр буруулж, эд хөрөнгө, орон гэрээ алдах, хүүхэд нь сургуулиас завсардах, тэнэмэл болох, гэр бүлийн хэн нэгэн нас барах, гэр бүл салах зэргээр тэдний ар гэр нь хорих ялын цээрлэлийг давхар амсаж байна.

2. Ялтнууд ял эдэлж байх хугацаандаа бусдад учруулсан хохирлоо нөхөн төлсөн эсэх талаарх асуулагдаж оролцогчдын




Хохирлоо бүтдийг нөхөн төлсөн	42%
Зарим хэсгийг төлсөн	18.5%
Огт төлөөгүй	16%

3. Огт төлөөгүй буюу хагас төлсөн шалтгааныг судлахад :

- 43 ялтан буюу 36.1 хувь нь төлбөрийн чадваргүй,
- 23 ялтан буюу 19.3 хувь нь хорих ялаа биечлэн эдэлж байгаа учраас төлөхгүй,
- төлөх хүсэлгүй гэсэн 8 ялтан буюу 6.7 хувь байна.


Энэ байдлаас үзэхэд хорих ялаар шийтгүүлсэн ялтнууд төлбөрийн чадваргүй, хорих ялаа биеэр эдэлж байгаа учраас хохирол барагдуулах хүсэлгүй, гэмт хэргийн улмаас бусдад учруулсан хохирлоо барагдуулах явдал хангалтгүй байна.

4. Судалгаанд хамрагдсан ялтнуудаас ял эдэлж буй орчин нөхцөл, хүндрэл бэрхшээлийн талаарх асуулагдаж: /давхардсан тоогоор/



Энэ байдлаас дүгнэхэд хорих ял эдлүүлэх ахуй дэглэм, орчин нөхцөл муу, ар гэрээсээ хол ял эдэлж байгаа учраас эргэлт авах боломж тааруу, хоол үнд болон ариун цэвэр сахих гэх мэтийн наад захын хэрэгцээний хангамж багаатай байна.

5. Асуулагдаж гарсны дараа учрах бэрхшээлийн талаар судлахад:



Үүнээс үзэхэд ял эдэлж буй ялтнуудын ихэнх нь хорихоос суллагдаад гарахад тэдэнд учрах бэрхшээл ихтэй, нэн ялангуяа тэднийг амьдралд хүлээн авах хэн нэгэнтэй үйл ойлголцох байдал бий болно гэсэн айдастай байна.

6. Хорих ял эдэлж байгаа ялтнуудаас хорих ял цээрлүүлэх зорилгоо хангаж байгаа эсэхийг асуулахад асуулагдаж оролцогчдын

- 61.3 хувь буюу 73 ялтан тийм,
- 12.6 хувь буюу 15 ялтан нь үгүй гэж хариулсан байна.

Үүнээс үзэхэд хорих ял цээрлүүлэх зорилгоо хангаж байна гэж үзэж болох юм. Гэхдээ энэхүү цээрлүүлэх зорилго нь ихэнхдээ ялтнуудыг залхаах, цөхрөөх, амьдрах итгэлийг бууруулах байдалд хүргэдэг нь харагдаж

байсан. Ялтнууд ногдуулсан хорих ялыг тэдний үйлдсэн гэмт хэргийн гэм бурууд тохирсон байх ёстой гэж үздэг ба зарим хэсгийн зүгээс аль болох хөнгөн ял оноохыг илүүд үзэж хорих ялын дэглэм нь үйлдсэн хэргийн хүнд, хөнгөн, давтан үйлдсэн зэрэг байдлаас ялгаатай байх нь засрал хүмүүжилд нөлөөлдөг гэсэн байна. Хорих ял эдэлж байгаа ялтнууд аль болохоор жирийн дэглэмтэй, цөөн жилээр хоригдох сонирхолтой, хурдан суллагдах хүсэл нь тэднийг ингэж хариулахад хүргэсэн байна.


7. Та хорих ангиас суллагдаад хамгийн түрүүнд юу хийх эсэхийг асуухад: Нийт санал асуулгад оролцогчийн 100 ялтан буюу **84.0 хувь** нь ажилд орно гэсэн ба үлдэх цөөн хувь нь хариулаагүй, ямар ч аргаар хамаагүй мөнгөтэй болно, өөрийн дураар амьдарна гэж хариулсанаас үзэхэд ихэнхи ялтан хорих ялаа эдэлж дуусгаад цаашид нийгэмд ажил хийж амьдрах дур сонирхолтой байгааг харуулж байна.

8. Төр засаг холбогдох байгууллагуудын зүгээс ямар арга хэмжээ авбал ялтны засрал хүмүүжилд сайнаар нөлөөлөх өз гэдгийг асуулаад оролцогч ялтнуудаас судлахад:



Ялтнуудын зүгээс хорих ялын хэмжээг хэт урт биш байх, хугацаанаас өмнө суллаж байх нь засрал хүмүүжилд сайнаар нөлөөлдөг гэж үзэж болохоор байгаа ч хорих ял эдэлж байгаа ялтнууд нь хорих ялын цэрлэлийн үр нөлөөг ямар нэг хэмжээгээр амсаж, аль болох хурдан суллагдах гэснээс энэ хариулыг сонгосон болов уу гэж судлаачийн хувьд дүгнэж байна.

9. Мөн санал асуулаад оролцсон 119 ялтнаас засарч хүмүүжиж байгаа эсэхийг судлахад /давхардсан тоогоор/:



Хорих ялаар шийтгэгдсэн ялтнууд нь гэр бүлийн хүчирхийлэл, дарамт шахалт, санхүү эдийн засгийн байдал, ар гэрээ тэмээх асуудал, мөнгөний бэрхшээлд орсон, өрх гэр толгойлдог, амьжиргааны эх үүсвэргүй нь тэдний нуруун дээр дарамт учруулдаг, өөрийн

гэнэн итгэмтгүй, эрх зүйн мэдлэггүй байдал, бусдад уруу татагдсан, нийгэм дах хар тал болох ажилгүйдэл, ядуурал, арихдал зэрэг нийтлэг шалтгааны улмаас гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн байна.

II. Ярилцлагын судалгаа

Ярилцлагыг нэгдүгээрт, ногдуулсан ял, гэм буруугийн хэмжээ хоорондоо тохирсон эсэх, хоёрдугаарт, хорих ял хувь хүнд ямар нөлөө үзүүлж байгаа болох, гуравдугаарт, хорих ял эдлүүлэх байгууллага хуульд заасан хорих ялын зорилгыг биелүүлэхийн төлөө яаж ажиллаж байгаа болохыг тогтоох гэсэн зорилготой хийв.

1. Ял шийтгэлийн цэрлүүлэх зорилгоо хангаж байгаа эсэхийг асуухад:

- 73 буюу 61.3 хувь нь цэрлүүлэх зорилго хангагдаж байна,
- 15 буюу 12.6 хувь нь хангагдахгүй байна
- 8 буюу 6.7 хувь нь мэдэхгүй
- 8 буюу 6.7 хувь нь хагас дутуу хангаж байна гэж хариулжээ

Үүнээс үзэхэд хорих ялын цэрлүүлэх зорилго нь хорих ялын хүмүүжүүлэх болон урьдчилан сэргийлэх зорилгуудыг бодвол илүү хангагдаж байна гэж үзэж болохоор байна.

2. Хорих ял хувь хүнд ямар нөлөө үзүүлж байгаа талаар ялтнуудтай ярилцахад:



- Хорих ял надад сайн нөлөө үзүүлж байгаа би засарч байна гэх ялтан 18 буюу 31.0 хувь,

- Хорих ял надад ямар ч нөлөө үзүүлэхгүй байна гэх ялтан 7 буюу 12.0 хувь,

- Биеийн эрүүл мэнд, сэтгэл санаагаар хохирч байна гэх 4 буюу 6.8 хувь,

- Улам эвдэрч, муу санаатай болж байна гэх 19 буюу 32.7 хувь,

- Залхаж байна, ар гэрийн хүмүүс, үр хүүхэд давхар яллагдаж байна гэх ялтан 10 буюу 17.2 хувь байлаа.

Олон ялтан хүнийг ингэж олон жил хорьсноос цөөн жил хатуу чанга дэглэмд, байнгын ажил хөдөлмөртэй байлгавал засрах, гэмших, цэрлээл амсах тал дээр илүү ач холбогдолтой гэдгээ хэлж байсан. Олон жил хоригдсоны дараа нийгэмших, энгийн иргэдийн нэгэн

адилаар амьдрахад улам л төвөгтэй болдог, ажил мэргэжлээсээ хэт хөндийрэх, найз нөхөд цөөрөх, гэр бүлийн амьдрал бүр ч хүнд хэцүү байдалтай болох зэрэг нь шоронд орсон эхний өдрөөс л сэтгэл зүйн хүнд дарамт болдог тухай ярих хүн цөөнгүй байлаа.

3. Ярилцлагын урвандуугаар зорилго болох хорих шийтгүүлээс нь ялтынг хорих ялаас эдлэх хэргийн нөхцлийг хангаж чадаж байгаа эсэх талаар судлахад

Ярилцлагад оролцогч нийт ялтын ихэнх хувь нь хорих анги аль болох нөхцөл боломжийг дээшлүүлэх тал дээр хүч анхаарлаа хандуулдаг боловч дан өөрсдийн бололцоогоор үүнийг бийлүүлэх боломжгүй, үүнд төр засгаас хөрөнгө мөнгөний асуудал дээр нь

анхаарах хэрэгтэй гэж байв.

Цөөн тооны ялтнууд сургалт хүмүүжлийн ажлууд төдийлөн тогтмол зохион байгуулагддаг байдаггүй гэж байсан. Ангийн алба хаагчид заримдаа яриа хийдэг, зохиогддог ажлууд нь төдийлөн үр дүн гардаггүй, ялтнуудаас өөрсдөөс нь их шапгаалдаг гэж байв. "Буян" ХХК-д ажиллаж байгаа ялтнууд сургалт хүмүүжлийн ажилд хамрагдаж чаддаггүй гэдгээ хэлж байсан болно. Ярилцлагад оролцсон ялтнууд эрх зүйн талаар мэдлэг муутай байдаг. Энэ талын сургалт төдийлөн зохион байгуулагддаггүй хэлж байв. Ялтнууд өргөдөл, хүсэлтээ хаана, ямар албан тушаалтанд гаргах талаар ойлголт муу байв.

ШҮҮХЭЭС НОГДУУЛСАН ЯЛ ШИЙТГЭЛИЙН БАЙДАЛ (2002-2006 ОН)

Ялын төрөл	Бүтэн жилд				
	2002 он	2003 он	2004 он	2005 он	2006 он
Нийт ял шийтгүүлсэн	13007	9029	9473	10153	7792
Хорих ял шийтгүүлсэн	9577	6561	6686	6947	5454
Хорих ялыг биечлэн эдлүүлсэн	4552	2869	2926	3136	2660
Хорих ялыг тэнссэн	4014	2794	2886	2915	1930
Хорих ял эдлүүлэхийг хойшуулсан	782	883	858	888	480

III. Хууль тогтоомжийн судалгаа

№	Хуулийн заалт	Хэрэгжиж байгаа байдал
1.	Эрүүгийн хуулийн 45 дугаар зүйл. Эрүүгийн хариуцлагын зорилго нь иргэн, нийгмийг гэмт халдлагаас хамгаалах, гэмт хэргийн улмаас эерэгцдсөн эрхийг сэргээх, гэмт хэргэ үйлдсэн этгээдийг цэвэрлүүлэх, хуульчлүүлэх, гэмт хэргэ үйлдэхээс урьдчилан сэргийлэхэд оршино.	Анхетийн болон ярилцлагын судалгаанаас үзэхэд эрүүгийн хариуцлагын дээрх зорилгоос хорих ял нь цэрэгжүүлэх зорилгоо илүүтэйгээр хангаж байна. Харин урьдчилан сэргийлэх, хуульчлүүлэх зорилгоо тэр бүр хангаж чадахгүй байна.
2.	115 дугаар зүйл. Ялтын эрх, үүрэг ... тогтоосон хэмжээний илчлэгтэй хоол, түүнчлэн хувцас, байраар хангагдаж, энэ хуульд заасны утас, захирдаар харилцах, илгээж авах, өөрийн нэр дээр мөнгөн гуйвуулта авах, явуулах, сонин, сэтгүүл захиалах, хорих байгууллага дахь номын санг ашиглах эрхтэй.	Хорих ял эдэлж байгаа ялтнуудын дээр дурдсан эрхийг хангах талаар хорих ангиудаас санаачилгагүй ажилладаг, мөөгөцдөртэй, тогтоосон хэмжээгээс сүүлдээ, агааржилт муутай байранд ял эрдэгдэж, сонин, сэтгүүл захиалах, утас, захирдаар харилцах боломж байдаггүй гэдгээ хэлж байна.
3.	111 дүгээр зүйл. Эмэгтэй ялтын ял эдлүүлэх Ял эрдэг байх хугацаандаа амьжирсан ялтын 0-1 насны хүүхэдтэй нь хамт байлж болно. Энэ хуулийн 111.5-д заасны дагуу хорих анги нь эхийн хамт байгаа 0-1 насны хүүхдийг эрүүл мэнд өсөж бойжих, аюулгүй орчинд бүрдүүлсэн тусгай байр, нөхцөлөөр хангана.	Онц хүнд гэмт хэргэ үйлдэж хорих ял шийтгүүлсэн эмэгтэй ялтын хүүхэдтэй нь хамт дээр заасан нөхцөлд ял эдлүүлэх гэхээр чанга дэглэмд эдлүүлэх боломжгүй байна. /Хуульд тусгайлан заасан зохицуулалт хэрэгтэй байна/
4.	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 126 дугаар зүйлийн 126.2-т Ялтан ногдуулсан ялын Эрүүгийн хуульд заасан хэсгийг эдлэсэн, засарч хүмүүжсэнээ зан байдлаараа харуулж, гэмт хэргэ үйлдсэний улмаас учруулсан хохирлоо төлсөн бол түүнийг ялаас хугацааны өмнө суллах саналыг хорих ангийн дарга шүүхэд гаргана гэж шинэ зохицуулалт оруулж өгсөн.	Өнөөгийн байдлаар хорих ангид нь ажлын хүчээр дутмаг нийт ялтын ердөө 50-60 хувь нь л ажил нийлж байна. Хорих ялтын хөдөлмөрийг орлогоос учруулсан хохирлоо төлсөн нь дунджаар 4 хувийг эзлэж байгаа нь тун бага үзүүлэлт юм. 2002 оноос хойш тэнсэн суллагдсан байдлыг судалж үзэхэд үндсэндээ ялтын эрх гэрлийнх нь хохирлыг барагдуулсан байна.
5.	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.2-д Хорих ял эрдэг байгаа ялтын төлбөрийг түүний өмчлөлийн эд хөрөнгөөс төлүүлсний дараа дутуу хэсгийг төлүүлэхээр ялтын ял эрдэг байгаа хорих ангийн захиргаанд гүйцэтгэх баримт бичиг явуула. Түүнчлэн 66 дугаар зүйлийн 66.3-г гүйцэтгэх баримт бичгийг хайтан авсан хорих ангийн захиргаа ялтын хөдөлмөрийн хөнгөнөөс сар бүр суугагч хийх шийдвэр гүйцэтгэгчид шилжүүлж гэрээ зааж өгсөнөөс гадна Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 126 дугаар зүйлийн 126.2-т Ялтан ногдуулсан ялын Эрүүгийн хуульд заасан хэсгийг эдлэсэн, засарч хүмүүжсэнээ зан байдлаараа харуулж, гэмт хэргэ үйлдсэний улмаас учруулсан хохирлоо төлсөн бол түүнийг ялаас хугацааны өмнө суллах саналыг хорих ангийн дарга шүүхэд гаргана гэж хуульд шинэ зохицуулалт оруулж өгсөн байна.	Жирийн дэглэмтэй хорих ангийн ялтын хорих байгууллага орийн болон өөрийнхөө хувь нийлүүлсэн, хамтарсан аж ахуйн нэгжид, эсвэл бусад аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулсан зохих хангалттайгаар хөдөлмөрлүүлж болно гэсэн дээрхи заалт тэр бүр эрэгжиж боломжгүй байна. Хоригдлуудын зүгээс хөдөлмөр эрхэлдэг боловч цалин хөлс авдаггүй, эрхэлж байгаа хөдөлмөр нь хорих ангийн аж ахуйн болон дотоод үйл ажиллагаа, үйлдвэрлэлт байдаг юм байна. Түүнчлэн хорих ангийн зүгээс байгууллага аж ахуйн нэгжид ялтнаар ажил хийлгээд улсын төвлөрсөн тосноос дутуу санхүүжилдээ ялтантай холбогдож гарах зардал болж Дархмиалан, дулаан, хоол хүнс, хувцас, ус, ялтын эрүүл мэндийн даалгав, эм гэх мэт шууд зарцуулдаг тосгоо алдаж учраас жирийн дэглэмтэй хорих ангийн ял эрдэг байгаа ялтнууд энэ талаар ямар нэг ойлголт байхгүйг орсондөө хийх ёстой ажил гэж үздэг үүнд нь хорих ангийн зүгээс ажлын хөнгөнгөө урамшуулж хэвшсэн байдаг юм байна.

6.	118 дугаар зүйл, Ялтын тусад нь ял эдлүүлэх 118.3.Ижил дэгдэмтэй хорих ангид, янх удаа ял орлож байгаа ялтын дагалт гэмт хэрэг үйлдсэн ялтнаас, асарч хүмүүжж байгаа ялтын зэвсэг олохгүй байгаа ялтнаас, түүнчлэн зүйдэн засгийн гэмт хэрэг үйлдсэн ялтын тус тусад нь ял эдлүүлнэ.	Олон жилийн хорих ял шийтгүүлсэн дэглэм буурч ирсэн ялтаны анх удаа хорих ял шийтгүүлж ирсэн ялтнуудтай нэг дөр байгааг зэрэг дарах зэвсэгт зэрхсэн тохиолдол нэлээд байна.
7.	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 121 дүгээр зүйлд Илтэнд хийсэн хөдөлмөрийн нь тоо, чөлөөт тохирсон хөлс олгоно. Гэрээний үндсэн дээр ялтан ажиллуусан ажил олгогч ялтын хөдөлмөрийн хөндийг хорих ангийн дансанд илжүүлнэ. Хорих ангийн өөрийн үйлдвэрлэл дээр ажиллуусны болон энэ хуулийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 121.2-г зөвсөн дагуу илжлэж ирсэн цалин хөлсөөсө бүх төрлийн талбар суултан хэийг үндэх хэсгийг ялтын хорийн дансанд төвлөрүүлнэ. Үүний дагуу төвлөрсөн цалин хөлсийн 10 хүрвэн хувийг ялтан сар тутам авч хэрэглэх эрхтэй ба үлдсэнийг суулагдах үед өөрт нь олгоно.	Хөдөлмөрийн хөлсийн хэмжээг ахин судлах, ялтын хөдөлмөрийн хөлсийн хэмжээг хувийг ялтын өөрийн дансанд илжүүлж, хэвнэн хувийг хорих ангийн дансанд төвлөрүүлэх талаар тодорхой заах өгөх, Засгийн газраас гаргасан тоотгоолд нийцүүлэх, шаардлагатай бон хүчингүй болгож ахин гаргуулах. Ялтнуудыг гэрээгээр ажиллуулах, бусад аж ахуйн нэгж байгууллага хувь хүмүүстэй тогтоох харилцааг өргөжүүлэх талаар хорих ял эдлүүлж байгууллагын зүгээс анхаарах, үндэс барилда, хөдөө аж ахуйн салбарт ажиллах талаар холбогдох төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах, тэдний урвимуулах.
8.	128 дугаар зүйл, Ялтын ахуйн нөхцөл 128.1.Ялтын эрүүл ахуй, ариун цэвэрийн тусгайлан тогтоосон шаардлага хангасан байр, ахуйн нөхцөлөөр хангана. Хорих анги нь ялтын ор, хөжил, гудас, цагаан хэрэглэл болон хүйтэн, дулааны улирлын зориулалттай нэг зэвгарын гадуур хуцсаар хангах ба ялтан хувиасаа дотуур хуцсаас, дулаан хангана, цөм, бээлий, өвөл, зуны гутал өмсөхийг зөвшөөрнө. ...ялтанд хөдөлмөрийн хууль тогтоомжид зөвсөн ажлын тусгай хуцсаас, хамгаалах хэрэгсэл, хоол олгоно.	Судалгаанд хамрагдсан ялтнууд цагаан хэрэглэл, нэг зэвгарын гадуур хуцсаар хангах байгаа нь тааруу ихэвчлэн ар гэрээсээ амруулдаг, хөдөлмөр эрхлэж байгаа ялтнуудыг ажлын тусгай хуцсаас хамгаалах хэрэгсэлээр хангагдаггүй, санхүүгийн хувьд баршталттай гэж байна.

Судалгааны ажлын дүгнэлт

- Хорих ялын цээрлүүлэх үр нөлөө ялтнуудад тодорхой хэмжээгээр хурдаг боловч олон жилийн хорих ял тэднийг улам бүр залхаас, амьдрах итгэлгүй байдалд хүргэдэг байна. Ялтнууд хорих ялаас залхсан, зөвхөн ажил хийж шагналын хонго авч шоронгоос л хурдан суллагдах хүсэлтэй байна.

- Хорих ялын урьдчилан сэргийлэх зорилго нь хангалтгүй хэрэгжиж байна гэж дүгнэж болохоор байна. Санал асуулганд оролцсон ялтнуудын нэлээд хувь нь давтан гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн, зарим нь бүр 3 ба түүнээс дээш удаа ч ял шийтгүүлсэн ба гараад амьдрах зорилго, итгэл байхгүй байна.

- Хорих ял нь хүмүүжүүлэх зорилгоо хангахгүй байна. Судалгааны дүнгээс үзэхэд дийлэнхи ялтан хорих ял эдэлж байхдаа улам бүр эвдэрч муу санаатай болж байгаа, засарч хүмүүжих боломжгүй гэж байсан юм. Хорих байгууллага хорих ялын хүмүүжүүлэх зорилгыг хангахын тулд төрөл бүрийн арга хэмжээг зохион байгуулдаг боловч төдийлөн нааштай үр дүн гардаггүй, зохиодог арга хэмжээ нь тогтмол байж чадаагүй, хуучирсан, нэгэн хэвийн, ял эдлэх нөхцөлийг сайжруулахын тулд өөрийн боломжийн хэрээр анхаардаг, хорих ял нь хүмүүжүүлэх

зорилгоо биелүүлэхэд төдийлөн сайн нөлөө үзүүлж чадахгүй байна гэж дүгнэв.

- Ялтан ял эдэлж байх хугацаандаа хөдөлмөр эрхлэж хохирлоо барагдуулах талаар ямар нэгэн санаачилгагүй байдаг. Хорих ангийн зүгээс хөдөлмөр эрхлүүлдэг боловч хөдөлмөрийн хөлс нь ялтын өдөр тутмыг хэрэгцээ бусад зүйлд зориулагдаад дуусдаг, хөдөлмөрийн хөлсийн үнэлгээ /Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 1/53 тоот тушаалаар батлагдсан/ бага, эрэгтэй ялтнууд болон насанд хүрээгүй ялтнууд хөдөлмөр эрхлэх боломж бага. Энэ талын мэдлэг байхгүй байсан юм.

- Хорих ял эдлүүлэх нь төрөөс үргүй зардал гаргахад хүргэдэг. Нэг ялтан хорих ял эдлэхдээ төрөөс дулаан хуцсаас хунар, хоол, орон байр, гэрэл дулаан, харуул хамгаалалтын, сургалтын гэхчилэн жилд 605200 төгрөгний, 10 жил ял эдлэхэд 6 сая 5210 төгрөгний зардал гаргаж ял эдлэх юм. Зүй нь ялтаар тодорхой хэмжээний хөдөлмөр эрхлүүж улсаас гарсан зардлыг нөхөн төлүүлэх ёстой ч хорих ангийн өдөр тутмын аж ахуйн үйл ажиллагаанаас хэтэрч чадахгүй байна.

- Бусдын өмчийн эсрэг гэмт хэргүүд нэн ялангуяа бусдын эд зүйлийг хулгайлах, дээрэмдэх, танхайрах зэрэг эрүүгийн хэргийг хүндрүүлэх бүрэлдэхүүнтэйгээр

үйлдсэн тохиолдолд ихэвчлэн 8 ба түүнээс дээш жилийн хорих ял оноогоор заасан байгаа нь шоронд ял эдэлж байгаа ялтнуудын тоог ихэсгэж, улмаар хорих ялын үр нөлөөг бууруулахад хүргэж болзошгүй байна.

Судалгааны ажлын хүрээнд гаргах санал

Нэг.Зохион байгуулалтын хүрээнд:

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар болон харьяа хорих ангуудын хамтын ажиллагаа, зохион байгуулалт, ажлын үр дүнг дүгнэх арга-чиглалаа өөрчлөх зэрэгтэй байна. Өөрөөр хэлбэл, хорих ялын үр нөлөөг сайжруулах тэр дундаа хүмүүжүүлэх, гэмт хэрэгээс урьдчилан сэргийлэх чиг үүргийг онцгой анхаарч ажиллах зэрэгтэй байна. Хорих ял эдлүүлэхэд наад захын стандартын шаардлага эрүүл ахуйг хангасан дэглэмд эдлүүлэх, хоригдлын хөдөлмөрлөх, хохирлоо нөхөн төлүүлэх боллоцоо, хөдөлмөрөөр хангах аж ахуйн нэгж, байгууллагуудыг татан оролцуулж, урвимуулж байх зэрэгтэй байна.

2. Хорих байгууллага бүр өөрийн гасан мэргэжлийн сэтгэл зүйчтэй байх шаардлагатай. Хорих ял шийтгүүлсэн хүмүүсийн хувьд амьдралын ердийн хэв маяг нь өөрчлөгдөж, хийж дасан ажил, мэргэжлээ орхиход хүрч,

ойр дотны хүмүүсээ алдах, оюун санаа хямрах, үзэл санаа, эрүүл мэнд нь доройтох зэргээр биеийн болоод сэтгэл зүйн маш их өөрчлөлтөд ордог. Олон нийтээс тусгаарлагдсан, хязгаарлагдмал нөхцөлд ял эдэлж буй эдгээр хүний сэтгэл зүйн онцлог, өөрчлөлт, дасан зохицол, айдас түгшүүр, залхсан, хэн нэгэнд өширхсөн, гомдсон зэрэг зан араншингийн өөрчлөлт зэргийг судалж, тэдэнд сэтгэл зүйн зөвлөгөө өгч, дэмжлэг үзүүлдэг байх шаардлагатай байна. Энэ нь хорих ялын үр нөлөөг дээшлүүлэх, хоригдийн нийгэмшүүлэхэд чухал ач холбогдолтой.

3. Мөн нийгмийн болон техникийн хурдацтай хөгжлийн энэ эрин зуунд хоригдлуудыг ч түүнээс хол дутахааргүй байдалдаа хөгжих боломжоор хангах. Жишээлбэл, гадаад хэл, компьютерийн анхан шатны мэдлэг олгох, хорих байгууллагад олон жил амжилттай сайн ажиллаж буй чиглэлээр (тухайлбал, нарийн боов, оёдол, барилгын болон нэхмэл, сүлжмэлийн ажил хийж буй, эдгээр мэргэжлийг сайн эзэмшсэн хоригдлуудад) мэргэжлийн үнэмлэх олгох талаар төрөөс нэгдсэн байдлаар арга хэмжээ авах.

Хоёр.Хууль тогтоомжийн хүрээнд:

1. Гадаадын зарим орны эрүүгийн ял эдлүүлэх ажиллагаа, эрх зүйн зохицуулалт янз бүр байдаг. Тухайлбал, АНУ-д орон нутгийн шоронд аюул багатайд тооцогдох хоригдлуудыг хорьж ялыг нь эдлүүлдэг байна. Насанд хүрээгүйчүүдийн хорих ялыг тэдэнд зориулан байгуулсан

газарт буюу хүмүүжлийн сургуульд эдлүүлдэг. Тэндхийн дэглэм, харуул хамгаалалтын систем нь насанд хүрээгчдийнхтэй харьцуулахад харьцангуй зөөлөн ба насанд хүрээгүй хоригдлууд өдөрт нь шоронгийн байрлалд ажиллаж, сурах бөгөөд шөнө нь гэртээ очиж хонож болдог. Энэ нь хоригдлын хүмүүжилд нааштай нөлөө үзүүлдэг юм байна. Энэ мэт шинэлэг байдлыг анхаарч хуульдаа оруулж өгмөөр мэт санагдана.

2. Эрүүгийн хуулийн ялын бодлогод зарчмын шинжтэй өөрчлөлт хийж хуульд зааснаас хөнгөн ял ногдуулах заалтыг оруулж өгөх /1996 оны Эрүүгийн хуулийн 39 дүгээр зүйлд "Хуульд зааснаас хөнгөн ял ногдуулах, 50 дугаар зүйл "Ялаас хугацааны өмнө тэнсэн суллах буюу ялыг өөр төрлийн хөнгөн ялаар солих, 18 насанд хүрэхийн өмнө гэмт хэрэг үйлдсэн этгээдийг ялаас хугацааны өмнө тэнсэн суллах буюу ялыг хөнгөн ялаар солих гэх мэт заалтууд байсан/ шаардлагыг бий болгож байна.

4. Анх удаа санамсар болгоомжгүйгээр гэмт хэрэг үйлдсэний улмаас хорих ялаар шийтгэгдсэн ялтануудын хорих ял эдлэх хугацаандаа эрхэлсэн ажил хөдөлмөрийг ажилласан жилд оруулан тооцох асуудлыг судлах. Тухайлбал, 1996 онд батлагдсан ОХУ-ын Эрүүгийн ял эдлүүлэх хуульд Хоригдлуудын засан хүмүүжүүлэх колонийн үйлдвэрлэлд ажилласан хугацааг урсулд ажилласан хугацаанд оруулан тооцох, хөдөлмөрт хамрагдаж байгаа хоригдолд жилд ажлын 12-18 хоногийн амралт олгох, 30

хүртэл насны хоригдол ерөнхий боловсролын сургалтад заавал хамрагдахыг хуульчилсан байна. Энэ стандартад нийцүүлэх, үгүй дээ гэхэд ядаж ойртуулах хэрэгтэй байгаа юм. Түүнчлэн одоо дагаж мөрдөж байгаа Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын А/53 тоот тушаалд заасан хөдөлмөрийн хөлс 2000-2500 төгрөг байх заалт хөдөлмөрийн хөлсний шинээр тогтоосон хэмжээнээс доогуур байгаа ба өөрчлөх хэрэгтэй байна.

5. Ялтныг хугацаанаас өмнө суллахад түүний хөдөлмөр эрхлэлт, хохирол нөхөн төлөлт, хүмүүжсэн байдлыг харгалзан үзэж байх талаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Эрүүгийн хуульд нарийн тодорхой заалтуудыг оруулж өгөх.

Өршөөлийн тухай хууль батлагдан гарсанаар хорих ял эдэлж байгаа ялтны тоо буурсан боловч ахин өсөх хандлагатай байна. 2002 оны энэхүү Эрүүгийн хууль нь хуульд зааснаас хөнгөн ял шүүхээс ногдуулах боломжийг үндсэндээ хаасан, хорих ял ногдуулах нь давамгайлсан, ял шийтгэл ногдуулах бодлогын хувьд хатуу хууль болжээ. Хэдийгээр гэмт хэрэг үйлдэж, ял эдэлж буй ч төрийн хууль цаазын бодлогын гол зорилго нь тэднийг зөвхөн цээрлүүлэхдээ бус харин хүмүүжүүлэх, дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэхийг урьдах болгож буй тул хоригдлыг нийгэмшүүлэх, шоронгоос гараад ажил, хөдөлмөр эрхэлж, дахин гэмт хэрэг үйлдэхгүй амьдрах боломжийг олгоход илүү анхаардаг байх нь зүйтэй гэж үзэж байна.



ШИЛЖИН СУУРЬШИХ ХӨДӨЛГӨӨНИЙ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ЦААШИД АНХААРАХ АСУУДАЛ

Дэлхий дахинд даяарчлалын үйл явц эрчимжиж эдийн засаг, үйлдвэрлэл, үйлчилгээ, соёлын урсгал чөлөөтэй болж, түүний хөгжлийн үйл явцыг зөв оновчтой ашиглах, нийгмийн хөгжлийг түргэтгэх таатай боломж аливаа улс оронд улам бүр нээлттэй болж байна.

Энэ бол хил хязгаарыг үл хайхрах мэдээлэл технологийн урсгал, түүнийг түгээгч улс хоорондын шилжих хөдөлгөөний үр шим гэж үзэж болох юм.

Шилжих хөдөлгөөн нь улс орны нийгэм, эдийн засаг, хүн амын өсөлт, төрийн нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмж, боловсрол, соёлын үйлчилгээ, иргэдийн амьжиргааны түвшин, нийгмийн халамж, хамгааллын асуудалд зөрөг болон сөрөг үр дагаврыг бодитойгоор үзүүлж байдаг нийгмийн томоохон үзэгдлийн нэг юм.

2005 онд зохиогдсон "Хүн амын шилжих хөдөлгөөний асуудлаарх Үндэсний дээд хэмжээний уулзалт"-аас шилжих хөдөлгөөний сөрөг нөлөөг бууруулах, төв, иргэний нийгэм, хувийн хэвшил, гэр бүлийн хамтын ажиллагааг бүх талаар сайжруулан иргэнд ээлтэй, үндэсний аюулгүй байдлыг дэмжсэн эрх зүйн орчинг бүрдүүлж хэрэгжүүлэх арга хэмжээг авах нийгмийн хэрэгцээ шаардлага байна гэж үзсэн билээ.

Иймд эрчимжиж байгаа гадаад, дотоод шилжих хөдөлгөөний урсгалыг зөв чиглүүлэн, улс орны хөгжлийн хурдцыг эрчимжүүлэх бодлоготой уялдауулан хүн ам болон тэдэнд хүргэх нийгмийн үйлчилгээг оновчтой байршуулах талаар хэлэлцэн зөвшилцөх, ойлголт, үйл ажиллагааг нэгтгэх зорилго тавьснаараа хүн амын шилжих хөдөлгөөний асуудлаарх Үндэсний дээд хэмжээний уулзалт ач холбогдолтой болсон юм.

Шилжих хөдөлгөөнтэй холбогдсон харилцааг Иргэний бүртгэлийн тухай, Иргэний хууль, Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Харьгаатын тухай хууль,



ИБМУТ-ийн Иргэний үнэмлэх,
шилжилт хөдөлгөөний асуудал
хариуцсан мэргэжилтэн
М.СЭЛЭНГЭМӨРӨН

Статистикийн тухай, Архивын тухай, Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хуулиуд болон бусад хууль тогтоомжоор зохицуулж байна. Монгол Улсын Их Хурлаас 2004 онд баталсан "Монгол Улсын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого" нь хүн амын шилжилт хөдөлгөөний талаарх бодлогын үндсэн баримт бичиг болно.

2006 онд НҮБ-ын Хүн амын сангийн дэмжлэгтэй хийсэн "Хүн амын дотоод шилжих хөдөлгөөний оролцооны аргаар үнэлэх" судалгааны үр дүнгийн урьдчилсан тайлан гарсан ба "Монгол Улсын хүн амын дотоод шилжих хөдөлгөөний чанарын судалгааны тайлан" нь шилжилт хөдөлгөөнд оролцогчийн өнөөгийн нөхцөл байдал үнэлгээ өгөх, шилжилт хөдөлгөөний зэрэг, сөрөг үр дагаврын нөлөөлөл, шилжилт хийх болон шалтгааныг гүнзгийрүүлэн судлах болон хүн амын шилжих хөдөлгөөний асуудлаарх Үндэсний дээд хэмжээний уулзалтаас гарсан зөвлөмжийг хэрэгжүүлэх, шийдвэрлэхэд шаардлагатай мэдээллийг цуглуулах ач холбогдолтой юм.

Хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн Монгол Улсын шинэ

үндсэн хуулиар баталгаажсан иргэд амьдран суурьших газар нутгаа чөлөөтэй сонгох боломжийг олгосноор манай иргэд гадаад улс орнуудад ажиллах, сурах, амьдрах зорилгоор шилжин суурьших, дотооддоо алс хязгаар нутгаас амьдрал хөжж зах зээлд дөхөөр Улаанбаатар, Дархан, Эрдэнэтийг зорьдог их нүүдэл хөдөөд сумын төвөөс аймгийн төв рүү, аймаг, нийслэл болон төвлөрсөн суурин руу чиглэж байна.

Ялангуяа хот руу чиглэсэн их нүүдэл сүүлийн жилүүдэд улам бүр эрчимжиж Монгол Улсын нутаг дэвсгэрт 2006 онд аймаг, хотоос 34432 иргэн бүрмөсөн шилжин явж, 27941 иргэн шилжин ирсэн байна. Мөн онд аймаг, хотоос бүрмөсөн шилжин явагсдын тоогоор Улаанбаатар, Дархан-Уул, Сэлэнгэ, Төв, Орхон аймаг тэргүүлж байсан бөгөөд эдгээр 5 аймагас 14764 хүн шилжин явсан нь нийт шилжигсдийн 42.9 хувийг эзэлж байв. Баян-Өлгий, Говьсүмбэр, Дундговь, Өмнөговь аймагас 1247 хүн шилжин явсан нь нийт шилжигсдийн 3.6 хувь байгаа нь эдгээр аймагт шилжих хөдөлгөөн харьцангуй бага байна. Шилжигчдийн ихээхэн хувь нь төв болон баруун бүсээс тухайлбал Төв, Увс, Завхан аймгуудаас нүүдэллэн ирсэн байна.

2006 онд шилжин явсан иргэдийн 63 хувь нь Улаанбаатарт, 5.8 хувь нь Дархан-Уул, 3.2 хувь нь Дорноговь аймагт тус тус суурьшсан нь нийт шилжин явсан иргэдийн 72 хувь болж байв.

Гэтэл 2007 оны эхний хагас жилд аймаг, хотоос бүрмөсөн шилжин явсан хүмүүсийн тоо 17417 болж 2006 оны эхний хагас жилтэй харьцуулахад 1.0 хувиар, шилжин ирсэн хүмүүсийн тоо 15908 болж 49.08 хувиар тус тус өсөв.

2007 оны эхний хагас жилд шилжин явсан иргэдийн 60.8 хувь нь Улаанбаатарт, 6.7 хувь нь Дархан-Уул, 5.0 хувь нь Сэлэнгэ, 4.7 хувь нь Орхон аймагт тус тус суурьшсан нь нийт шилжин явсан иргэдийн 77.2 хувь болж байна. Бүртгэлээр Дундговь аймагт нэг ч хүн бүрмөсөн шилжин ирээгүй байна.

Хүн амын орон сууцны 2000 оны тооллогын дүнгээс үзэхэд

шилжин ирээг 3 хүн тутмын нэг нь Улаанбаатар хотод суурьшж, шилжүүлэггүй оршин сууж буй иргэд нийт хүн амын 7 хувийг эзэлж байгаа бөгөөд нийслэлийн нийт хүн амын бараг гуравны нэгийг шилжин ирэгсэд бүрдүүлж байна. Нийслэлийн нийт хүн амын 64.6 хувь нь уугуул иргэд, 35.4 хувь нь өөр бүс нутгаас янз бүрийн хугацаанд шилжин ирэгсэд байна.

Хүн амын шилжилт хөдөлгөөнд оролцогчдын шалтгааныг тодруулан үзвэл шилжин ирэгсдийн ихэнх нь ажил эрхлэх, хот суурин газар бараадаж зах зээлд ойртох, амьдрал ахуйгаа дээшлүүлэх, үр хүүхдүүдийнхээ алс ирээдүй бодож сургууль соёл хөвчлөлд эсвэл эмчлүүлэх зэрэг боловсрол, эрүүл мэндийн чанартай үйлчилгээг авахыг хүсдэг байна.

Иргэд Үндсэн хуулиар олгогдсон эрхээ эдлэхийн зэрэгцээ иргэний үүргээ биелүүлдэг байх хэрэгтэй. Өөрөөр хэлвэл, шилжигсэд хууль тогтоомжийг хэрэгжүүлж улсын хүн амын иргэний бүртгэлд бүрэн хамрагдаж байх шаардлагатай.

"Монгол Улсын нутаг дэвсгэрт иргэн шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэх, мэдээлэх журам"-ын 3.2-д "Иргэн аливаа засаг захиргааны нэгжид 180 хоногоос дээш хугацаагаар буюу бүрмөсөн шилжин ирсэн бол 10 хоногийн дотор холбогдох сум, дүүргийн Засаг даргын Тамгын газарт оршин суугаа газрынхаа хаягаар бүртгүүлж, иргэний үнэмлэхдээ тэмдэглэл хийлгэнэ" гэсэн заалтыг иргэд биелүүлэхгүй, иргэний баримт бичгийн зайлшгүй шаардлага гарахгүй л бол хаягийн хөдөлгөөний бүртгэлээ хийлгэхгүй хайнга ханддаг зөрчил арилахгүй байна.

Шилжих хөдөлгөөнд оролцдог оршин сууж байсан сум, хорооноос шилжүүлгээ авч, шилжин ирсэн хаягаараа зохих ёсоор хахгийн хөдөлгөөнөө тухай бүр хийлгэхгүйгээс бүртгэлийн зөрчил нэлээд гарч байна.

Бүртгэл нь шилжих хөдөлгөөний маш чухал асуудал хэвээр байгаа бөгөөд төв суурин руу шилжих хөдөлгөөнийг багасгахад нөлөөлж чадахгүй байгаагаас гадна хэд хэдэн удаа бүртгэлийн эрх зүйн тогтолцоонд өөрчлөлт оруулсан боловч эдгээр нь шилжих хөдөлгөөнийг сааруулахаар боловсрогдож чадаагүйтэй санал цэн байна. Харин бүртгэлийн үйл явцыг төлбөргүй болгож харьцангуй хөнгөвчилсөн нь оновчтой шийдвэр болж чадсан юм.

Иргэд шилжилт хөдөлгөөний бүртгэлд хамрагдахгүй байх нь нийгмийн халамж, үйлчилгээ авахад өөрсөд нь сөрөг үр дагавартай бөгөөд шилжин ирэгсэд хотын ажилгүйдэл, ядууралд ч зохих хувиар нөлөөлж байгаа юм.

Монгол Улсын Засгийн газрын 2002 оны 214 дүгээр тогтоолоор батлагдаж 2007 онд нэмэлт, өөрчлөлт орсон "Монгол Улсын нутаг дэвсгэрт иргэн шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэх, мэдээлэх журам"-аар шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэх, мэдээлэх харилцааг зохицуулдаг.

Энэ журамд "Иргэн аливаа засаг захиргааны нэгжид 180 хоногоос дээш хугацаагаар буюу бүрмөсөн шилжин ирсэн бол 10 хоногийн дотор холбогдох сум, дүүргийн Засаг даргын Тамгын газарт оршин суугаа газрынхаа хаягаар бүртгүүлж, иргэний үнэмлэхдээ тэмдэглэл хийлгэнэ. Харин 31-180 хоногийн хугацаагаар буюу түр шилжин суурьших тохиолдолд байнга оршин суудаг нутаг дэвсгэрийнхээ бүртгэлийн дэвтэрт "түр эзгүй" гэсэн тэмдэглэл хийлгэж, түр оршин сууж буй нутаг дэвсгэрийнхээ баг, хорооны Засаг даргад 7 хоногийн дотор бүртгүүлэх үүрэгтэй" гэж заасан. Энэ хугацаа нь НҮБ-ын зөвлөмжид заасан хугацаатай үндсэндээ тохирч байгаа болно.

Монгол Улсын Иргэний бүртгэлийн тухай хуулийн 26 дугаар зүйлд "...шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэх ажлыг нутаг дэвсгэрийн харьяаллын хувьд иргэдийн аймагас аймагт, аймагас нийслэлд, нийслэлээс аймагт шилжин суурьших хөдөлгөөнийг зохицуулж, бүртгэх мэдээлэх ажлыг аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар эрхлэхээр, харин аймаг болон нийслэлийн дотор шилжин суурьших хөдөлгөөнийг зохицуулж бүртгэх, мэдээлэх ажлыг сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар хариуцахаар хуульчилсан.

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт иргэний бүх төрлийн бүртгэлийн ажлыг нэгтгэн зохион байгуулж удирдах ажлыг аймаг, нийслэлийн Засаг дарга, 16 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт уг чиг үүргийг сум, дүүрэгт тэдгээрийн Засаг дарга хэрэгжүүлэхээр, мөн хуулийн 19 дүгээр зүйлийн 10 дахь хэсэгт "...иргэдийн шилжилт хөдөлгөөн, хөдөлмөр эрхлэлтийг зохицуулах, тэднийг иргэний бүртгэлд хамруулах арга хэмжээ

авахыг баг, хорооны Засаг даргын чиг үүрэг байхаар тус тус хуульчлан заасан юм.

Иймд иргэний бүх төрлийн бүртгэлийн ажлыг нэгтгэн зохион байгуулж удирдах, иргэдийг шилжилт хөдөлгөөний бүртгэлд бүрэн хамруулах ажлыг нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд зохион байгуулж ажиллах нь бүх шатны засаг дарга нарын үндсэн чиг үүргүүдийн нэг юм. Хуулийн эдгээр заалтын дагуу манай бүх шатны Засаг дарга нар, захиргааны байгууллагууд нь иргэн хүн оршин суугаа газартаа бүртгүүлэхийн ач холбогдлыг таниулж, ойгуулан сурталчлах, иргэдийг хууль дүрмийг мөрдөн хэрэгжүүлж ажиллахад нь хяналт тавих, эрхээ эдлээд үүргээ биелүүлэхгүй байгаа иргэдийг тооцож хариуцлагыг өндөржүүлэх шаардлага ч зүй ёсоор үргэн гарч байна.

"Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" Засгийн газрын 2007 оны 263 дугаар тогтоолд шинээр орсон "... бүх шатны сургуулийн Удирдлага хичээлийн шинэ жил эхэлснээс хойш 1 сарын дотор засаг захиргааны бусад нэгжээс шилжин сууралцагч иргэдийн оршин суугаа хахгийн бүртгэлийг тухайн аймаг, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газарт ирүүлж байх, мөн шүүхийн шийдвэрээр хорих газраас суллагдаж байгаа болон цэргээс халагдаж байгаа иргэдийн бүртгэлийг төв, орон нутгийн иргэний бүртгэлийн байгууллагад тус тус хургуулж байхаар, түүнчлэн гадаад улсад 180 хоногоос дээш хугацаагаар оршин суугаа иргэдийг тухайн улсад суугаа дипломат төлөөлөгчийн газар нь бүртгэж Гадаад хэргийн яам цахим сүлжээгээр ИБМУТ-д ирүүлнэ" гэсэн заалтууд нь шилжилт хөдөлгөөний болон иргэний бүртгэлийг цаашид сайжруулахад чухал ач холбогдолтой арга хэмжээ болсон юм.

Баг, хорооны Засаг дарга нарын эрхлэн хөтөлдөг хүн ам, орхийн бүртгэл нь иргэний бүртгэлийн салшгүй хэсэг гэдгийг "Иргэний бүртгэлийн тухай" хуульд заасан бөгөөд энэ нь хүн амын анхан шатны бүртгэл юм. Хүн ам орхийн бүртгэл нь хүн амын статистик мэдээллийн эх үүсвэр болдог учраас нарийн хөтөлж, баяжилт хөдөлгөөн хийж, зохих хяналтыг төвөн ажиллаагүйгээс үүдэн зөвхөн шилжилт хөдөлгөөний асуудалд төдийгүй нийгмийн халамжийн үйлчилгээнд ч гажуудал үүсгэхэд нөлөөлж байна.

Тус төвөөс шилжилт хөдөлгөөний бүртгэлтэй холбоотой зөрчлийг арилгах зорилгоор 2006, 2007 онд иргэний бүртгэлийн улсын үзлэг хийж холбогдох арга хэмжээг авч байна.

Энэ онд "Иргэний бүртгэлийн улсын үзлэг явуулах тухай" Монгол Улсын Засгийн газрын 2007 оны 129 дүгээр тогтоол, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 127 дугаар тушаал гарч иргэний бүртгэл, мэдээлэл, баримт бичиг, шилжилт хөдөлгөөний асуудлыг цэгцлэх, иргэдийн хаягийн бүртгэлийн үнэн зөв эсэхийг шалгаж, хаягийн хөдөлгөөний өөрчлөлтийг мэдээлэлд бүрэн шинэчлэн тусгах хаягийн бүртгэлгүй засаг захиргаа завсардаж буй иргэдийн зөрчлийг арилгуулах зорилгоор 2007 оны 6 дугаар сард улсын хэмжээнд "Иргэний бүртгэлийн улсын үзлэг"-ийг зохион байгуулав.

Айл өрхүүдээр үзлэг хийхдээ өрхийн бүртгэлийн дэвтрийн хөтөлөлт, баяжлал, шилжиж явсан, ирсэн иргэдийн хөдөлгөөнийг хэрхэн тусгаж байгаа байдал зэргийг үзэж шалгахын зэрэгцээ иргэдийн баримт бичгийн хаяг, оршин сууж буй хаяг тохирч байгаа эсэх, үндсэн бүртгэлтэй хаягаа өөр газар түр буюу байнга оршин суудаг эсэх түүнчлэн иргэд үндсэн засаг захиргааны нэгжинхээ хүн амын бүртгэлээ хасуулахгүйгээр шилжин суурьшсан зөрчлийг илрүүлэхэд онцгой анхаарч ажилласан юм.

Үзлэгээр улсын хэмжээнд 63952 өрхийн 317359 иргэн баримт бичгийн зөрчилтэй байснаас хаягийн зөрчилтэй 85535, огт баримт бичиггүй 6578, оршин суугаа дахар хаягийн бүртгэлтэй 22364, засаг захиргааны шилжүүлэггүй, оршин суугаа хаягийн бүртгэлгүй, түр оршин суух хугацааг хэтрүүлсэн 40472, бүртгэлээс хасуулаагүй хаана оршин суугаа нь тодорхойгүй байгаа иргэд 95837, өөр орон нутгаас ирсэн зөвшөөрөлгүй оршин суугаа 9613 өрхийн 29881 иргэн байна. Үүнээс 13055 өрхийн 17234 иргэн оршин сууж байсан орон нутгаасаа шилжүүлээс аваагүй дун гарсан болно.

Үзлэгийн мөрөөр харьяалах нутаг дэвсгэрийн засаг захиргааны байгууллагын албан ёсны зөвшөөрөлгүйгээр шилжин ирсэн, явсан иргэдийг бүртгэж, зөрчлийг арилгах талаар хугацаатай үүрэг даалгавар өгөхийн зэрэгцээ харьяалах аймаг, нийслэл, сум, дүүрэгтэй нь холбоо тогтоож тухайн иргэний хувийн хэрэг болон шилжүүлгийн маягтыг ирүүлэх, бүртгэх арга хэмжээ авч байна.

Тухайн нутаг дэвсгэрт шилжин ирсэн боловч хаягийн бүртгэлээ хийлгээгүй иргэдийг тогтоож бүрэн шийдвэрлэх, харьяа нутаг дэвсгэрийн засаг захиргааны албан ёсны шилжүүлэггүй, засаг захиргаа завсардсан, түр оршин суух хугацааг хэтрүүлсэн эсвэл тухайн нутаг дэвсгэрийн засаг захиргааны бүртгэлээс хасуулаагүй, хаана оршин суугаа нь тодорхойгүй байгаа иргэдийн судалгааг гаргаж дүгнэлт хийх, зөрчил арилгах, иргэний үнэмлэхээ аваагүй иргэдийг бүрэн үнэмлэхүүжлэх зэрэг ажил хийж байна.

Цаашид иргэдийн шилжилт хөдөлгөөний асуудлаар анхаарах асуудлууд:

-Сум, хорооны түвшинд иргэний бүртгэл, мэдээ хариуцсан орон тооны ажилтан бий болгож тогтвор суурьшилтай байх баталгааг нь хангах, үүнтэй холбогдуудын хүн амын бүртгэлийн нэгдсэн тооллоог оновчтой болгож, эрхлэх байгууллагын чиг үүрэг, Бүтэц, зохион байгуулалтын зарим арга хэмжээ авах шаардлагатай байгаа юм.

-Засаг дарга нар өөр өөрийн шатанд бүртгэл, шилжилт хөдөлгөөний асуудлыг бүрэн хариуцахгүй байгаагаас шилжилт хөдөлгөөний "дурын" урсгал бий болсныг онцгой анхаарч ажиллах.

-Шилжих хөдөлгөөнийг бууруулахын тулд орон нутагт хүн амын эдийн засгийн байдал, амьдралын нөхцөл, боловсролын чанарыг сайжруулах, амьдрах сонирхлыг татах эдийн засгийн хөшүүрэг бий болгох, хөдөөгийн хөгжлийг дэмжих төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх асуудал хамгийн чухал байна.

-Нийслэлд шилжин ирсэн иргэдийн асуудлыг тусгайлан бодовсруулсан хөтөлбөрийн дагуу богино хугацааны дотор нэг мөр шийдвэрлэх зорилт тавьж, төр засгийн бүх шатны байгууллага хамтран ажиллах нь зүйтэй юм.

-Нийгэм, эдийн засгийн бодлого хөтөлбөрийг боловсруулахдаа хүн амын ердийн болон механик өсөлт, нийгмийн суурь үйлчилгээг хуртас болгож хэрхэн нөлөөлөх талаас нь сайтар нягталж, салбар хоорондын болон мэргэжлийн байгууллагын оролцоо ажлын уялдаа холбоог сайжруулах нь чухал юм.

-Шилжигчид болон ядуучуудын хүний эрхийг хамгаалах, тэдэнд нийгэм, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх, ядуурлаас сэргийлэхэд чиглэгдэх төрийн бодлогын

арга хэмжээг тусгайлан авах нь зүйтэй. Үүний тулд бодлогын арга хэмжээ, тэдгээрийн зохицуулалтад шаардлагатай үндсэн мэдээлэлд хангах асуудал чухал байна. Жишээ нь, Улаанбаатарт шилжин ирэгдийн шалтгаан, бүртгэлгүй иргэдийн нийгмийн үйлчилгээний хүртээмж, чанарыг тодорхойлох, амьжиргааны гол эх үүсвэр, өрхийн орлого, хэрэглээний бүтцийг тодорхойлох, ядуурал ба шилжих хөдөлгөөний хоорондын хамаарлыг тодорхойлох ядуурлын үндсэн үзүүлэлтүүдийг гэр ба байшин хороолол, шилжигч ба шилжигч бус хүн амаар тодорхойлох бодлогын зөвлөмж гаргах ч шаардлага бий.

-Засаг захиргааны бүртгэлд хамрагдах тэр дундаа өрх, хүн амын бүртгэл, шилжих хөдөлгөөнд оролцох бүрдээ бүртгүүлж байхын ач холбогдлыг хүн амад сурталчилсан таниулах ажлыг системтэй зохион байгуулах, бүртгүүлээгүй иргэдэд хүлээлгэж хариуцлагыг эрх зүйн хувьд тодотгох.

-Цаашид нэгэнт оршин суух газраа сонгоод суурьшсан, түр хойшлуулах шалтгааныг иргэдийг шууд бүртгэх, оршин сууж байсан газар нь элдэв дарамт шахалтгүй бүртгэлээс хасах зэрэг чөлөөтэй, энгийн, хүнд сурталгүй, мэдээлэл холбооны тундолоогийг ашигласан иргэний бүртгэлийн системийг улс даяар хэрэглэх эрх нь чухал байна.

-Шилжих хөдөлгөөнийг сааруулахын тулд орон нутагт хүн амын эдийн засгийн байдал, амьдралын нөхцөл, боловсролын чанарыг сайжруулах, амьдрах сонирхлыг татах эдийн засгийн хөшүүрэг бий болгох, хөдөөгийн хөгжлийг дэмжих оновчтой, үр дүнтэй төлөвлөгөө, төсөл хөтөлбөр гаргаж хэрэгжүүлэх.

-Нийгэм, эдийн засгийн бодлогын хөтөлбөрийг боловсруулахдаа хүн амын ердийн болон механик өсөлт, нийгмийн суурь үйлчилгээг хуртас болгож хэрхэн нөлөөлөх талаас нь сайтар нягталж, салбар хоорондын болон мэргэжлийн байгууллагын оролцоо, ажлын уялдаа холбоог сайжруулах зэрэг болно.

-----Оо-----

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙН САЛБАРТ 12 ЖИЛ

Монгол Улсын Эрх зүйн шинэтгэлийн салбарт хамтран ажиллах эрх зүйн шинэтгэлийг цогц угтаар нь хэрэгжүүлэх зорилгоор Германы Техникийн Хамтын Ажиллагааны Нийгэмлэг (ГТХАН) нь 1995 оноос эхлэн Монгол Улсын хууль зүйн салбарт төсөл хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд энэхүү хамтын ажиллагаа энэ ойд 12 дахь жилдээ ургажилж байна. 1995 оны 5 дугаар сараас Монгол Улсын Хууль зүйн яамтай /хуучин нэрээр/ хамтран "Монгол Улсын Эрдийн засгийн эрх зүйн шинэтгэл" төслийг буцалтгүй тусламжийн хэлбэрээр хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд Эрх зүйн шинэтгэлийн хүрээнд хуулийн төсөл боловсруулахад зөвлөгөө өгөх, хуульчдыг сургах, давтан сургах, хуулийн байгууллагын бүтэц, зохион байгуулалтад зөвлөгөө өгөх, эрх зүйн сурталчилгаа болон эрх зүйн судалгаа гэсэн чиглэлээр үйл ажиллагаагаа явуулсан юм.

Энэхүү төслийн үргэлжлэл нь хуульчдад зориулсан сургалт, хуулийн төсөл боловсруулахад зөвлөгөө өгөх, эрх зүйн сурталчилгаа гэсэн дугаар чиглэлийн дор 2003 оны 8 дугаар сараас эхлэн "Хуульчдын сургалт ба давтан сургалт" төсөл нэртэйгээр үйл ажиллагаагаа хэрэгжүүлж байна. ГТХАН-ийн хуулийн төсөл энэхүү 12 жилийн хугацаанд ажил бүтээлийн араин их санг бүрдүүлжээ.

Тус төслөөс үндсэн чиглэл, дайчлах хүрээнд өнгөрсөн үе, ацаанд хийж бүтээсэн ажлуудынх нь талаар тоймлон хүргэхэд, юуны өмнө Монгол Улсын Хууль зүйн яам болон УИХ-д 30 гаруй хуулийн төсөлд зөвлөгөө өгснөөс Иргэний, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай, Газар өмчлүүлэх, Хөдөлмөрийн, Хуульчдыг сонгон шалгаруулах журмын тухай зэрэг 14 хууль УИХ-аас батлагдсан бөгөөд Иргэний болон Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн шинжлэх ухааны тайлбарыг тус төслөөс болон Улсын дээд шүүхийн Иргэний танхимаас гаргажээ.

Түүнчлэн хуульчдад зориулсан сургалтын хүрээнд 1996 оноос эхлэн Монголын шүүгч нарт зориулсан сургалтуудыг тогтмол явуулж,

нийтдээ найман удаагийн тойргийн сургалтад монголын бүх шүүгчийг хамруулсан ба нийт 13 шүүгч багш тус төслөөс бэлтгэгдсэн байна. Мөн долоон прокурор – багшийг бэлтгэж, прокуроруудад зориулан 2 удаагийн тойргийн сургалтыг зохион байгуулсан байна. 2004 оноос эхлэн Монголын нотариатч болон шийдвэр гүйцэтгэгч нарт зориулсан сургалтуудыг дөрвөн жил дараалан зохион байгуулсан бөгөөд 4 шийдвэр гүйцэтгэгч – багшийг бэлтгэсэн байна. ХЗҮТ-ийн ажилтнуудад зориулсан сургалтыг 2008 оноос эхлүүлсэн бөгөөд тус төвийн багш, эрдэм шинжилгээний ажилтнуудад зориулсан герман хэлний сургалтыг зохион байгуулсан.

Хууль сахиулах байгууллагын бүтэц, зохион байгуулалтад зөвлөгөө өгөх чиглэлээр ҮХЭХБ-ээрийг /хуучин нэрээр/ анх үүсгэн байгуулахад нь тус байгууллагыг байгуулах хуулийн төсөл боловсруулахаас эхлээд байгууллага бие даан үйл ажиллагаагаа явуулах хүртэлх бүхий л явцад зөвлөгөө өгч хамтран ажилласан байна. Мөн шүүхийн бүтэц, зохион байгуулалтад зөвлөгөө өгөх хүрээнд Сонгинохайрхан зэрэг хэд хэдэн шүүхэд "Загвар шүүх" дэд төслийг амжилттай хэрэгжүүлсэн бөгөөд шүүгч, прокуроруудын өдөр тутмын ажилд зориулсан "Judge" болон "Prosecutor" зэрэг програм хангамжуудыг боловсруулсан байна. Энэхүү програм хангамжуудыг АНУ-ын Монгол улсын хөгжлийн агентлагас хэрэгжүүлж буй Шүүх эрх мэдлийн шинэтгэлийн хөтөлбөртэй хамтран орон нутгийн шүүх, прокурорын бүх байгууллагад хэрэгжүүлсэн.

Эрх зүйн сурталчилгааны ажлын хүрээнд 1997 оноос эхлэн "Хуулийн цаг" нэвтрүүлгийг ард иргэдэд хууль тогтоомжийг сурталчлах зорилгоор тогтмол нэвтрүүлсээр ирсэн бөгөөд 2005 оноос үр нэвтрүүлгийг телевизийн олон ангит жүжиг хэлбэрээр илүү сайжруулан олон нийтэд хүргэж эхэлсэн бөгөөд 2007 оныг дуустал 200 орчим ангийг ТВ-9 телевизээр гаргасан. Түүнчлэн "Дэнс" төлөшүүх, "Хууль таны амьдралд", "Таны хуулийн мэдлэгт", "Хуулийн цаг" зэрэг телевиз, радиогийн нэвтрүүлгүүдийг бэлтгэн МҮТВ,

Монголын радио, МН-25 болон С-1 телевизүүдээр олон нийтэд хүргэсэн байна. Хөдөө, орон нутгийн эрх зүйн сурталчилгааг дэмжих зорилгоор "Эрх зүйн сурталчилгааг орон нутагт хэрэгжүүлэх" нь сэдэвт минитөлсүүдийг давхардсан тоогоор 13 аймагт хэрэгжүүлсэн байна.

Мөн түүнчлэн Хуулийн цахим сан болон хууль сахиулах байгууллагуудын нэгдсэн вэб хийх ажилд дэмжлэг үзүүлснээс гадна иргэн ба аж ахуйн эрх зүйн чиглэлийн 40 орчим ном, товхимол, 10-аад сонин, сэтгүүлийг эрхлэн гаргасан байна. Монголын эрх зүйн салбарын хамгийн том сэтгүүл болох "Хууль дээдлэх ёс" сэтгүүлийг цаашид бие даан үйл ажиллагаагаа явуулах чадвартай болоход нь дэмжих үүднээс 2 жил гаруй хугацаанд хамтран ажиллав. Мөн олон тооны семинар, симпозиум, эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулснаас гадна УИХ, Хууль зүй, дотоод хэргийн яам, Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокурорын газар болон дээр хууль сахиулах байгууллагын удирдагч ажилтнуудын ХБНГУ-д хийж айлчлал, сургалт, семинарыг зохион байгуулсан байна.

Төслөөс хийж гүйцэтгэсэн ажлаа дүгнэх, үр дүнг нь тодорхойлох зорилгоор болон хууль сахиулах байгууллагуудын захиалга суултээр эрх зүйн салбарын хүрээнд социологийн судалгаа, шинжилгээний томоохон ажлыг социологийн судалгааны байгууллагуудтай хамтран гүйцэтгэж, санхүүжүүлж байсан.

ГТХАН-ээс Монгол Улсын хууль зүйн салбарт хэрэгжүүлж буй төсөл нь үндсэндээ Монголын хууль сахиулах байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтыг сайжруулах болон ажилтнуудынх нь мэдлэг, чадварыг дээшлүүлэх ажилд бүрэн хэлбэрээр зөвлөгөө өгөх, хамтран ажиллахад чиглэдэг бөгөөд мөн энэхүү хамтын ажиллагааг тогтмол үр дүнтэйгээр хадгалааг гол зорилго болгодог.

ГТХАН-ийн "Хуульчдын сургалт ба давтан сургалт" төсөл



МОНГОЛ ДАРХНЫ ТАЙХАМЧИЙГ

Цэлмэг хэрнээ зэврүүн, жавар тачигнасан тэр нэгэн өглөө Зайсангийн аманд байрлах Нэгдсэн хорих 401 дүгээр ангийг зорин гарлаа. Учир юунд гэвэл энд миний өгүүллийн баатар ажилладаг юм. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Сургалтын төвийн захирал О.Эрдэнэчулуунтай уулзаж, соёлын өвөөр дамжуулан хүн хүмүүжүүлж болдгийг өөрийн нүдээр харах гэсэн хэрэг.

Өгүүллийн баатар чинь "О.Эрдэнэчулуун нь Улаанбаатар хотноо 1958 онд төрсөн" гэж эхлэх



Монгол үндэсний хийд бүхий Шатар

дээр одоо Хууль зүйн үндэсний төвийн захирал, тухайн үеийн Хууль зүйн сайд, академич Ж.Амарсанаа гуай очсон юм. Тэр үед миний бүтээл таалагдсан юм байлгүй. "Манайд ял эдэлж байгаа, ажлын байргүй олон хүн байна. Сийлчихдэг, гарын дүйтэй, зурчихдаг авьяаслаг хүмүүс бий. Эдгээрийг ажилтай болгох хэрэгтэй байна. Тийм болохоор туршаад, нэг сургалт зохион байгуулж үзээч" гэж хэлсэн юм. Ингээд л би гэдэг хүн Шүүхийн шийдвэр биелүүлэх ерөнхий газрын

харьяанд очиж, хоёр жил туршилтын журмаар ажиллалаа.

Тэгтэл дарга нар ч "Энэ сургалт ер нь их зүгээр юм байна" гээд байнгын үйл ажиллагаа явуулдаг болсон юм даа. Хүн сэтгэл гаргаад ажиллахаар байгууллага нь татаад авчихдаг л юм байна

хөдөлмөрлөж буй олон хүн байдаг юм байна. "Бид хоригдол гэхээр бууруу ойлгодог. Эхэндээ эвгүй л дээ. Анх очиход тортой хааша л угтаж авсан. Дотор нь ажиллахаар өөр шүү. Дархан гэдэг өөрийн хүсэл мөрөөдлөөс



Урган дархан
О.Эрдэнэчулуун

шалтгаалдаг мэргэжил. Энэ мэргэжлийн "А" үсгийг бусдад заагаад, шавь нар маань овоо гаршаад, бүтээл гаргах шинжтэй болохоор бас хоргодоод байх юм" гэж О.Эрдэнэчулуун багш шавь нараа өмөөрсөн, бас тэднээрээ бахархан өгүүлнэ.

Алх тог тогхийн дуугарах Сургалтын төвд яваад ороход цэвэр цэмцгэр юм. Хүний нүүр өөд үл харах дархчуулыг харахад зүрх зүсмээр ч гарын хөдөлгөөнөөр урган гарах хэз угалз хэн хүний нүдийг булаана.

намтар шигээ хэтэрхий даруу, эгэл нэгэн. "Сурах зүйл минь дуусаагүй л байна" гэж өгүүлэх энэ эрхмийн хийсэн бүтээснийг харсан хэн ч "Их мөрөн дөлгөөн, эрдэмт хүн даруу" гэдэг үгийн утгыг ухаарах шиг болно.

Харин дүрслэх урлагийн үндсэн төрөл болох монгол дархны мэргэжилд 1975 оноос өнөөг хүртэл 30 жил өөрийгөө зориулсан түүний урласан бурхан шүтээнээс авахуулаад шашны эд хэрэглэл, ахуйн хэрэглээ, гоёл чимэглэлийн бүтээлүүд нь монгол дархны урлагт гэнэт өөрийн гэсэн байр сууриа олсныг мэргэжил нэгт нөхөд нь хүлээн зөвшөөрч үнэлдэг.

О.Эрдэнэчулуун дэлхийд ур хийцээрээ гайхагддаг монгол дархны урлагт өөрийн гэсэн мөрийг үлдээхийн зэрэгцээ хүнийг хүмүүжүүлж буй буяны үйлсээрээ нэрээ таимгалдаг юм.

17 наснаасаа хойш алх, дөш нийлүүлэн, алт, мөнгийг "уйлуулж" буй түүнээс: "Та яагаад гэнэт хууль сахиулах байгууллагын харьяаны хүн болчих вэ?" гэж асуухад минь "1996 онд болсон дархчуулын үзэсгэлэн



Сумогийн их Аварга (Екозуна)
Д.Дагвадорж (Асашёрюу)-ийн хувийн хэрэгцээнд зориулж хийсэн, 12 жил, найман тахил бүхий Хэт хулга.

билээ" гэж хариулсан юм.

Бусдыг хохироосны хоо төлөө "Төрийн төмөр нүүр"-ээр шийтгүүлэн, ял эдэлж буй хүмүүс энгийн бидэнд эмээхээр харагддаг нь үнэн. Шорон гэж хараад, дотор нь ажиллахад битгий хэл хэлээд хүйт оргиулах тэр байгууллагад гэмшсэн сэтгэлийн халуун илчээо



Монгол Улсын хэмжээнд 6000 хоригдол байдаг. Эдгээрээс хорих ялын хугацаа, хүнд, хөнгөн эсэх, ялын төрөл, авьяас, гарын ур дүй гэсэн нарийн шалгуурт ороод 30-аад нь Сургалтын төвд суралцаж, боловсрогддог. Эдгээр 30 орчим хүнээс тав, зургаа нь л удаан хугацааны хичээл зүтгэлээрээ сайн дархан болдог гэхээр багшийн



Суралцаж төгсөхөд үйлдсэн бүтээлийн бэлгэц

нөр хичээнгүй хөдөлмөр, дархан мэргэжлийн нарийн чанд шалгуурыг өөрийн эрхгүй мэдрэх шиг болно. Залин мэхлэгч, хулгайч хорыг дархны сургалтад хамруулахгүй гэсэн зарчим надад бий гэж багш хатуурхах ч "Эрдэнэчулууны шавь хийгүй сайн байгаасай. Сайн сайхан яваа шавь нараа харах нь миний хувьд том бахархан шүү" гэж бас уярна.

О.Эрдэнэчулуун ахуйн хэрэглээ, гоёл чимэглэл гээд олон төрлөөр дарх хийдэг гэлээ ч бурхан шашны эд өлгийн зүйлийг дагнан хийдэг. "Торонд хашигдсан" шавь нараа ч буян хурааж, хүмүүжүүлэхийг эрхэмлэдэг. О.Эрдэнэчулуун "Би сургууль соёл төгсөөгүй, удам дамжсан дархан биш. Цэвэр оролдлого хичээллээрээ энэ мэргэжилд гаршсан. Миний аав Очир гэж том лам байсан. Тийм ч болохоор шашны эд өлгийн зүйлд би арай илүү ханддаг" гэж бяцхан нууцаа ам халаад ч гэх үг задалсан юм. Бурхан шашны эд өлөг гэдэг дархан хүнээс дан ганц авьяас, гарын дүй төдийгүй сэтгэлгээний цар, дэг, тигийг хэмжээ алдахгүй хийх тэвчээрийг шаарддаг.

Нагтээ бурханч лам Г.Пүрэвбат "Үндэсний уламжлалт бурхан шашныхаа урлаг, соёлыг бид бүхэнд нь ороход 60-70 жил болжээ. Он удаан жил мартагдсан энэ их соёлын өвөө сэргээх шилжилтийн үедээ яваа өнөө үед бурхан шашны урлалд нэгэн уран хүн гаршиж дадна гэдэг нэн чухал бөгөөд баярлууштай үйл явдал юм. Жирийн тахил, хэрэглээний эдээс авахуулаад, бурхны лагшингийн шүтээнийг хүртэл бүтээж байгаа энэ цагийн цөөн хүний нэг нь О.Эрдэнэчулуун билээ. Шүтээн урлагыг хийхэд зайлшгүй нарийн, зөв хийх боловсрол чухал. О.Эрдэнэчулуун нь шүтээн урлалын талд машад боловсорч, өөрийгөө хөгжүүлэн, мэргэжлийн төвшинд хүртэл хийж буй монголын уран дархны шинэ үеийн төлөөлөл юм. Түүний хийж бүтээсэн

бүтээл бурхны шашны эд өлгийн зүйлд хийж, ур чадвараараа өөрийн байрны хэдийн олжээ" гэж үнэлсэн байдаг. Энэ бол дан ганц хоосон магтаал биш ээ. Шавь нарынхаа хамт хийж бүтээсэн олон зүйл нь



О.Эрдэнэчулуун шавийн хамт



төр засгийн хэмжээнд үнэлэгддэг юм билээ.

-Монголын Соёлын сангаас 1992 онд зохион байгуулсан "Монгол үлдэц-92" үзэсгэлэнд оролцож, алтан шармал, гуулин цутгуур "Бодь суварга" бүтээлээрээ хоёрдугаар байрын шагнал.

-1995 онд Патентийн газар, Дизайн өрөөудын холбооноос зохион байгуулсан "Шинэ загварын бүтээгдэхүүн" үзэсгэлэнд оролцож, мөнгөн цутгамал, алтан шармал "Ногоон Дарь эх" бүтээлээрээ нэгдүгээр байр.

-Монголбанкны захиалгаар "Төрийн сангийн шүтээн" хийх тендерд ялан 10 кг алтаар дэг, тиг алдалгүй Намсрай бурхныг урлан бүтээсэн.

-Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор болсон "Монгол дархан-2004" үзэсгэлэнгээс Шашны урлалын төрөлд тэргүүн байрын шагнал хүртсэн уран бүтээлч юм.

Мөн Гандантэгчилэн хийдээс 1995 онд XIV Далай ламыг Монгол Улсад айлчлахад зориулж бэлэглэх Бурхан багшийн мөнгөөр хийх уралданд шалгарч, 2003 онд Амарбаясгалант хийдийн захиалгаар цамын баг, хувцасны металл хийцүүд, цэвэр мөнгөн Дамдинчижоо бурхан урласан бөгөөд их лам Гурдаваа Ренбүчийн

хүсэлтээр Доржшүгдэн бурхныг дөрвөн дагуултай нь бүтээж хийдэд нь залсан байна. Олны талархлыг хүлээгээд буй Зайсангийн аманд байрлах Бурхан багшийн сэрэг дүр бүхий Өндөр гэзэн Занабазарын нэрэмжит шашны зан үйлийн төвийн шашны эд хэрэглээний шавь нарын хамт нөр их хөдөлмөр гарган бүтээжээ.

Хийсэн бүтээсэн нь төр засгийн хэмжээнд хүртэл үнэлэгддэг ч эгэл даруухан хүн гэдэг одоо цагт бусдын цилиг, ширвэж авах болсон тэр зэрэг цолыг өндөрт өргөж, жинхэнэ утгаар нь эрхэмлэж явна. Таны хүртсэн хамгийн



Эхнэр Эрдэнэчимэгийн хамт урласан Цагаан Дарь эхийн хатгамал дүр, хөөмөлдөг, эрдэнийн чулуу шигтгэн хийсэн зууны хамт Монгол Улсын Ерөнхийлөгч П.Очирбат АНУ-д төрийн айлчлал хийхдээ тус улсын Ерөнхийлөгч Жорж Буш-д бэлгээсэн юм.

том шагнал юу вэ гэсэн сэтгүүлч миний асуултад "1996 онд Оюуны өмчийн газраас зохион байгуулсан монгол дархан, урлаачдын төрөлжсөн үзэсгэлэнд 10 кг цэвэр мөнгөөр урласан "Мөнгөн мод" бүтээлээрээ оролцон, тэргүүн байрыг эзэлж, Монгол Улсын 15 дахь шилдэг зохион бүтээгч цол тэмдэг, үнэмлэхээр шагнагдсан" гэж О.Эрдэнэчулуун гуай харуулсан юм.

Булган нутгийн бурхан ухаантай хүү бунят үйлсийн тамгаараа нэрээ мөнхөлж явна.

Д.Уянга

Монголын Шүүгч эмэгтэйчүүдийн холбоо Олон улсын Шүүгч эмэгтэйчүүдийн холбооны гишүүн боллоо

Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 10 дахь хэсгийн "...иргэн... өөрсдийн ашиг сонирхолын...үүднээс олон нийтийн байгууллага байгуулах...сайн дураараа эвлэлдэн нэгдэх..." эрхтэй гэсэн тунхаглал, Шүүхийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1 дэх хэсгийн "...Шүүгч өөрийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах, мэргэшлээ дээшлүүлэх, шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах зорилгоор мэргэжлийн олон нийтийн байгууллагад эвлэлдэн нэгдэх эрх эдлэнэ..." гэсэн заалтыг үндэслэл болгон Монголын шүүгч эмэгтэйчүүд

үзэл бодол, санаа зоригоо нэгтгэн, сайн дурын үндсэн дээр шинээр анх удаа Шүүгч эмэгтэйчүүдийн холбоог үүсгэн байгууллаа.

Монголын Шүүгч эмэгтэйчүүдийн холбоо 2007 оны 7 дугаар сарын 5-ны өдөр үүсгэн байгуулагдаж мөн оны 8 дугаар сарын 6-ны өдөр улсын бүртгэлд бүртгүүлж үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн юм.

Монголын Шүүгч эмэгтэйчүүдийн холбоо нь үйл ажиллагаагаа өргөжүүлэхийн тулд Олон улсын Шүүгч эмэгтэйчүүдийн холбоонд гишүүнээр элсэх зорилт тавьсан билээ.

Олон улсын Шүүгч эмэгтэйчүүдийн холбоо нь 1991 онд байгуулагдаж 87 улсын шүүхийн бүх шатны шүүгч эмэгтэйчүүдийг эгнээндээ нэгтгэсэн 4000 гаруй гишүүнтэй ашгийн төлөө бус байгууллага юм.

Олон улсын Шүүгч эмэгтэйчүүдийн холбоотой зэрэгцэн 1993 онд эмэгтэйчүүдэд сургалт явуулдаг "Эмэгтэй шүүгч нарын сан" байгуулагдсан бөгөөд уг сан нь эмэгтэйчүүд болон хүүхдүүдэд хамааралтай эрх зүйн асуудлыг хөндсөн олон нийтийн сургалтуудыг санхүүжүүлдэг байжээ.

2002 онд эдгээр байгуулага нь өөрчлөн зохион байгуулагдаж 2003 оноос "Олон улсын Шүүгч эмэгтэйчүүдийн холбоо" гэсэн нэрийн дор үйл ажиллагаагаа явуулах болсон байна.

Олон улсын Шүүгч эмэгтэйчүүдийн холбоо нь зохион байгуулж буй сургалт, хамтын үйл ажиллагаагаараа дамжуулан хүний эрхийг хамгаалах, хүйсийн ялгаралтан гадуурхах явдлыг устгах, эмэгтэйчүүдийн эрхийг бэхжүүлэх зорилготой бөгөөд эмэгтэй шүүгч нар нэгдэж хамтран ажилласны үр дүнд нийгмийн аливаа өөрчлөлтөд чухал хувь нэмэр оруулах боломжтой гэж үздэг байна.

Монголын Шүүгч эмэгтэйчүүдийн холбоо нь Олон улсын Шүүгч эмэгтэйчүүдийн холбооны гишүүн болох хүсэлтээ албан ёсоор гаргаж, уг холбооны гишүүн болох шаардлага болсныг хангасан тул 2007 оны 11 дүгээр сард Олон улсын Шүүгч эмэгтэйчүүдийн холбооны гишүүн болсон юм.

МОНГОЛДОО АНХНЫХ!

Телесериалын анхны DVD



Монголын анхны хамгийн олон ангит телесериал "Хуулийн цаг" нэвтрүүлгийн DVD-г Хууль зүйн үндэсний төвийн "Есон туг" телестудидээ бэлтгэж Та бүхэндээ толилуулж байна.

Та "Эрүүгийн хэргийн цуврал 30 анги", "Иргэний хэргийн цуврал 30 анги"-ийг дуртай үедээ, дуртай газраа, хэдэн ч удаа, хэний ч хамт үзэж болно.

60 анги, 20 цагийн телесериалыг 120-хон мянган төгрөгөөр авах боломжийг бүү алдаарай.

Харилцах утас:



“Хууль дээдлэх ёс” сэтгүүлийн 2007 оны нийтлэлийн жагсаалт

№	Сэдвийн нэр	Зохиогчийн нэр, эрхэлсэн ажил	Нийтлэгдсэн дугаар
---	-------------	-------------------------------	--------------------

Төрийн байгуулалтын хууль тогтоомж

1.	Нэр төр, алдар хүнд ба төрийн бодлогын зохицуулалт	Ш. Сүхбаатар /МУИС-ийн докторант/	2007 он №1/16/
2.	Парламентийн гишүүний "иммунетит" ба "индемитет" эрхийн тухайд	А. Түвшинтулга /ХЗҮТ-ийн Төрийн байгуулалтын хууль тогтоомжийн секторын эрдэм шинжилгээний дэд ажилтан /	2007 он №1/16/
3.	Хүний эрх, хүний хөгжил		2007 он №1/16/
4.	Монголын байгаль /өнгөрсөн, өдгөө, ирээдүй/ хойч үе	О. Амархүү /хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор, гавьяат хуульч/	2007 он №2/17/
5.	БНСУ-ын Үндсэн хуулийн шүүх, Ази дахь Үндсэн хуулийн хяналтын тэргүүлэх загвар	Э. Лхагвасүрэн /Үндсэн хуулийн цэцийн ажилтан/	2007 он №2/17/
6.	Гадаадад амьдарч буй Монгол Улсын иргэдийн сонгуулийн эрхийн тухайд	Д. Үүрцайх /ХБНГУ-ын Бонн хотын Их сургуулийн докторант /	2007 он №2/17/
7.	Хүүхдийн эрхийг хамгаалах салбар дахь орчин үеийн төрийн эрх зүйн бодлого	Ц. Алтанцэцэг /ОТИС-ийн ХЭС-ийн захирал/	2007 он №2/17/
8.	Ард түмний бүрэн эрхт байдал /Сувернитет/ ба төрийн хэлбэрийн сонголт, цаашдын зорилт	Б. Чимид /ХЗҮТ-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, гавьяат хуульч, доктор, профессор/	2007 он №3/18/
9.	Дүүрэг, түүний эрх зүйн байдал	Т. Ганчимэг / ХЗҮТ-ийн Сургалтын төвийн багш, хууль зүйн магистр/	2007 он №3/18/
10.	Монгол Улсын Тагнуулын байгууллагын ажилтны эрх зүйн байдал	Якушев С.Ц	2007 он №3/18/
11.	Нийтийн эрх зүй дэх захиргааны гэрээ хувийн эрх зүйн гэрээнээс ялгагдах онцлог, шүүхийн хяналт	Ц.Цогт /Нийслэлийн Захиргааны хэргийн шүүхийн шүүгч/	2007 он №4 /19/

Шүүх эрх мэдэл

1.	Шүүх таслах ажлаас шүүх эрх мэдэлд шилжих үйл явц	Т. Уранцэцэг /ОХУ-ын Эрхүү хотын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн докторант/	2007 он №1/16/
2.	Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх нотолгооны онол, практикийн асуудал	Д. Пунцаг /Улсын дээд шүүхийн шүүгч/	2007 он №1/16/
3.	Иргэний хэргийн шүүхийн шийдвэрийг шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянах ажиллагаа	Д. Хуяг /МУИС-ийн Хууль зүйн сургуулийн ахлах багш, докторант/	2007 он №1/16/
4.	Шүүхийн практикийн талаарх зарим асуудал	М. Ариунаа /ОТИС-ийн Хууль зүйн сургуулийн багш/	2007 он №1/16/
5.	Нийслэлийн шүүхийн 80 жил	Д. Дамдин-Од /Нийслэлийн шүүхийн шүүгч/	2007 он №2/17/
6.	Дэлхий шүүхэд итгэнэ	А. Доржготов /Улсын дээд шүүхийн шүүгч/	2007 он №2/17/
7.	Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх хугацааны зарчим	Р. Мухийт /ХЗҮТ-ийн Төрийн байгуулалтын хууль тогтоомжийн секторын эрдэм шинжилгээний ажилтан/	2007 он №3/18/
8.	Шинээр илэрсэн нөхцөл байдал	А.Доржготов /Улсын дээд шүүхийн шүүгч/	2007 он №4/19/
9.	Шүүхийн жишиг ба заншил	Б.Гүнбилэг /ХЗҮТ-ийн Олон улсын эрх зүйн секторын эрдэм шинжилгээний ажилтан/	2007 он №4/19/

Криминологи

1.	Хүн худалдах, худалдан авах гэмт хэргийн талаарх судалгаа, санал, дүгнэлт	Б. Сарантуяа /Нийслэлийн шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн/	2007 он №1/16/
2.	Гэмт хэргийн ангиллын ба ял ногдуулахын тохироо	Ц. Дарьжав /ОТИС-ийн Хууль зүйн сургуулийн багш, өмгөөлөгч/	2007 он №1/16/
3.	Ялын эрх зүйн зохицуулалтад хийсэн дүн шинжилгээ	Ц. Одончимэг /ХЗҮТ-ийн Криминологийн судалгааны секторын эрдэм шинжилгээний ажилтан/	2007 он №1/16/

4.	Шүүхээс ял ногдуулахад учирч буй бэрхшээл	Б. Сарантуяа /Нийслэлийн шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн/	2007 он №2/17/
5.	ДНК шинжилгээ	Д. Батхуяг /хуульч/	2007 он №2/17/
6.	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд Эрүүгийн хуулийн гүйцэтгэх үүрэг, тулгамдаж буй зарим асуудал	О. Амарсайхан /Цагдаагийн академийн Эрүүгийн эрх зүйн тэнхимийн багш, докторант/	2007 он №2/17/
7.	Өмгөөлөгч ба мөрдөн байцаагчийн харилцаа	Ж. Наранцацрал /ОТИС-ийн Хууль зүйн сургуулийн багш/	2007 он №2/17/
8.	Танхайг тандахуй	О. Алтангэрэл /МӨХ-ны Сургалтын хорооны дарга/	2007 он №2/17/
9.	Эрүүгийн болон захиргааны хариуцлагын хууль тогтоомжийн харьцуулсан судалгаа	Г. Оюунболд /ХЗҮТ-ийн Криминологийн судалгааны секторын эрдэм шинжилгээний ажилтан/	2007 он №3/18/
10.	Эрүүгийн байцаан шийтгэх хууль дахь криминалистикийн хэл болон монгол хэл зүйн зарим асуудал	Б. Жаргалсайхан /Нийслэлийн цагдаагийн газрын Эрэлч нохойн алба, Үнэрийн лабораторийн эрхлэгч, докторант /	2007 он №3/18/
11.	Хүүхдийн гэмт хэргийн шүүн таслах ажиллагаанд гарч буй хүндрэл бэрхшээл, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ	Б.Сарантуяа /Нийслэлийн шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн/	2007 он №4/19/
12.	Криминалистикийн экспертизийн ангиллын онол, практикийн зарим асуудалд	Б.Жаргалсайхан /НЦГ-ын Эрэлч нохойн алба, Үнэрийн лабораторийн эрхлэгч, докторант, цагдаагийн дэд хурандаа/	2007 он №4/19/
13.	Цагдаагийн байгууллагын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэдийг татан оролцуулах зарим асуудал	Л.Цэрэнням /НЦГ-ын Олон нийтийн харилцааны хэлтсийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тасгийн ахлах байцаагч, цагдаагийн хошууч, магистрант/	2007 он №4/19/
14.	Мансууруулагч олсны ургамлын хууль бус хэрэглээтэй холбоотой зарим асуудал	С.Хаш-Эрдэнэ /Их Засаг их сургуулийн магистрант/	2007 он №4/19/

Прокурорын хяналт

1.	Ял эдлүүлэх ажиллагаанд тавих прокурорын хяналтыг боловсронгуй болгох зарим асуудал	Ц. Мөнхбат /УЕПГ-ын Ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих хэлтсийн прокурор, докторант/	2007 он №1/16/
2.	Эрүүгийн хууль дахь хээл хахуудийн гэмт хэргийн зохицуулалтыг боловсронгуй болгох асуудал	Э. Амарбат /УЕПГ-ын хяналтын прокурор/	2007 он №2/17/
3.	Эрүүгийн хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагааны тухай	Д. Баянжаргал /УЕПГ-ын Хэрэг бүртгэх ажиллагаанд хяналт тавих хэлтсийн туслах /	2007 он №3/18/
4.	Эд хөрөнгийн хохирол, түүнийг нотлох ажиллагаа	Х.Батчимэг /УЕПГ-ын хяналтын прокурор, хууль зүйн магистр/	2007 он №4/19/

Иргэний хууль тогтоомж

1.	Гэрээний эрх зүй дэх тулгамдсан асуудал – Зах зээл	Ц. Давхарбаяр /МУИС-ийн ХЗС-ийн Иргэний эрх зүйн тэнхимийн багш, докторант/	2007 он №1/16/
2.	Хоршооны хуулийг “Хадгаламж, зээлийн хоршооны хуулийн төсөл”-тэй харьцуулан судалсан нь	Д. Эрдэнэчимэг /ХЗҮТ-ийн Иргэний хууль тогтоомжийн секторын эрдэм шинжилгээний ажилтан/	2007 он №1/16/
3.	Иргэний эрх зүйн маргааныг эвлэрүүлэн зууцлах үйл ажиллагаа	О. Алтангэрэл /Иргэний эрх зүйн туслалцаа үзүүлэх, маргааныг эвлэрүүлэн зууцлах төвийн менежер/	2007 он №1/16/
4.	Оюуны өмчийн харилцаанд мерчендайзын гүйцэтгэх үүрэг	Г. Жаргал /МУИС-ийн докторант/	2007 он №1/16/
5.	Гэрлэгчдийн эд хөрөнгийн хамгаалалт ба гэрэлтийн гэрээ	Б. Ариунтуул /ХЗҮТ-ийн ажилтан/	2007 он №1/16/
6.	Аккредитивийн хэлбэр, төрөл	Г. Батчимэг /хуульч/	2007 он №1/16/
7.	Төрийн жинхэнэ албан хаагч болон төрийн үйлчилгээний албан хаагчийн хөдөлмөрийн харилцааны зохицуулалтын харьцуулалт	С. Болормаа /МУИС-ын Хууль зүйн сургуулийн Иргэний эрх зүйн тэнхимийн багш, докторант/	2007 он №2/17/
8.	Бараа, үйлчилгээний тэмдгийн эрх зүйн зохицуулалтын талаарх зарим асуудал	С. Эрдэнэболор /ОТИС-ийн Хууль зүйн сургуулийн багш/	2007 он №2/17/
9.	Арбитрын тухай хуулиудыг харьцуулан судалсан нь	М. Сувд /ОТИС-ийн Хууль зүйн сургуулийн багш/	2007 он №2/17/

10.	Интернетээр гэрээ байгуулах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох зарим асуудал	Р.Очирбал /ОТИС-ийн Хууль зүйн сургуулийн багш/	2007 он №2/17/
11.	Гэрлэлт болон түүнтэй холбогдох зарим асуудал	Д.Янжмаа /ИБМУТ-ийн Төв, орон нутгийн иргэний бүртгэл хариуцсан ахлах мэргэжилтэн/	2007 он №2/17/
12.	"Know-how" болон "Know-how" гэрээний тухай	Ш.Хишигсүрэн /ХЗҮТ-ийн Иргэний хууль тогтоомжийн секторын эрдэм шинжилгээний ажилтан/	2007 он №3/18/
13.	Эзэмшил- эд юмсын эрх зүйн нэг ухагдахуун болох нь	А.Дэлгэрмаа ЛТХАН-ийн "Хуульчдын сургалт ба давтан сургалт" төслийн ажилтан /	2007 он №3/18/
14.	Хадгаламж, зээлийн хоршоодын дампуурлыг түүний эрх зүйн зохицуулалттай холбон тайлбарлах нь	Д.Түвшинтамир /ИӨХ-ны гишүүн өмгөөлөгч, "Номин Холдинг" ХХК-ийн Эрх зүйн газрын дарга, хууль зүйн ухааны магистр/	2007 он №3/18/
15.	Гэр бүлийн хөрөнгийн маргаан ба шүүхийн практик	О.Отгонтуяа /ХЗҮТ-ийн Иргэний хууль тогтоомжийн секторын эрдэм шинжилгээний ажилтан/	2007 он №4/19/
16.	Сэтгэл санааны гэм хорын тухай ойлголт буюу гүтгэлэг, нэр төр гутаах асуудлын талаарх эрх зүйн зохицуулалт	Ш.Үнэнтөгс /Хууль зүй, дотоод хэргийн яамны мэргэжилтэн/	2007 он №4/19/

Олон улсын эрх зүй, харьцуулсан эрх зүй

1.	Японы эрх зүйн тогтолцоо ба түүнд шүүхийн жишгийн эзлэх байр суурь	Б.Гүнбилэг /ХЗҮТ-ийн Олон улсын эрх зүйн секторын эрдэм шинжилгээний ажилтан/	/2007 он №1/16/
2.	Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөн	П.Баяр /ХЗҮТ-ийн Олон улсын эрх зүйн секторын эрдэм шинжилгээний ажилтан/	2007 он №1/16, 2 /17/
3.	"PRIVATUM" ба "PUBLICUM" нэр томъёоны тухай ойлголт	Э.Серик /ХЗҮТ-ийн Олон улсын эрх зүйн секторын эрдэм шинжилгээний дэд ажилтан/	2007 он №1/16/
4.	Монгол Улсын хууль тогтоомжийг Палермогийн конвенцид нийцүүлэх нь: Өнөөгийн байдал	Д.Зүмбэрэлхам /ХЗҮТ-ийн Криминологийн судалгааны секторын эрхлэгч, хууль зүйн доктор, профессор/	2007 он №2/17/
5.	БНХАУ-ын гэр бүлийн эрх зүйн зохицуулалт	И.Түвшинзаяа /ХЗҮТ-ийн Эрх зүйн мэдээллийн нэгдсэн системийн ажилтан/	2007 он №2/17/
6.	Олон улсын хөдөлмөрийн байгууллагаас гаргасан зарим конвенцын судалгаа	С.Ганцацэг /ХЗҮТ-ийн Иргэний хууль тогтоомжийн секторын эрдэм шинжилгээний ажилтан/	2007 он №2/17/
7.	ИБУИНВУ ба Монгол Улсын жишгийн эрх зүй /харьцуулалт/	Б.Гүнбилэг /ХЗҮТ-ийн Олон улсын эрх зүйн секторын эрдэм шинжилгээний ажилтан /	2007 он №3/18/
8.	Английн эрүүгийн эрх зүйн онцлог	Б.Эрдэнэбат /ОТИС-ийн Хууль зүйн сургуулийн багш, магистр/	2007 он №3/18/
9.	Харьцуулах, эс харьцуулах эрх зүй	Б.Чимид /ХЗҮТ-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор, профессор, гавьяат хуульч/	2007 он №4/19/
10.	Оросын эрүүгийн эрх зүй дэх ял шийтгэлийн зорилгын тухай	Д.Золжаргал /Авиатгай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсийн мөрдөн байцаагч, комиссар, докторант/	2007 он №4/19/
11.	Олон улсын эрүүгийн шүүхийн Ромын дүрмийг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх асуудал	М.Уянга /МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Олон улсын эрх зүйн тэнхимийн багш/	2007 он №4/19/
12.	Олон улсын худалдааны эрх зүй ба хүний эрхийн хоорондын уялдаа, холбооны тухай танилцуулга	П.Баяр /ХЗҮТ-ийн Олон улсын эрх зүйн секторын эрдэм шинжилгээний ажилтан/	2007 он №4/19/
13.	Дэлхийн худалдааны байгууллагын эрх зүйн ач холбогдлыг эргэцүүлэхүй	Ц.Монголхатан /ХБНГУ-ын Бремений их сургуулийн магистрант/	2007 он №4/19/
14.	"Гадаад улсын иргэн" гэх ойлголтын ОХУ-ын хууль тогтоомж дахь эрх зүйн зохицуулалт	А.Г.Тышкенова /Буриадын улсын их сургуулийн Хуулийн факультетын Олон улсын болон Үндсэн хуулийн тэнхимийн ассистент/	2007 он №4/19/

Шүүхийн шийдвэр гүйцэтгэл

1.	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа, үр дүн, гарч буй хүндрэл	Ш. Эрдэнэбат /хуульч/	2007 он №1/16/
2.	Хорих байгууллага дахь амиа хорлох үзэгдэл, түүнтэй тэмцэх асуудлыг боловсронгуй болгох зарим асуудал	Д. Золжаргал /Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албаны Баянзүрх дүүргийн шийдвэр гүйцэтгэгч, дэслэгч/	2007 он №1/16/
3.	Дэлхийн засан сайжруулах байгууллагын хэтийн төлөв байдал, өнөөгийн тулгамдсан асуудал	Р. Оюунбадам /Эмэгтэйчүүдийн хорих ангийн дарга, хурандаа/	2007 он №1/16/
4.	Иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааны зарим асуудал	Н. Дугармаа /МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Иргэний эрх зүйн тэнхимийн ахлах багш/	2007 он №2/17/
5.	Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны тулгамдсан асуудал	Д. Ороосоо /ХЗУТ-ийн Криминологийн судалгааны секторын эрдэм шинжилгээний ажилтан/	2007 он №2/17/
6.	Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны төлөвшил	А. Түвшинтулга /ХЗУТ-ийн Төрийн байгуулалтын хууль тогтоомжийн секторын эрдэм шинжилгээний ажилтан/	2007 он №3/18/
7.	Хорих ял эдлүүлэх ажиллагаанд тулгамдаж буй зарим асуудал	Д. Баасансүрэн /хуульч, хууль зүйн ухааны магистр/	2007 он №3/18/
8.	Шоронгийн архитектур, түүнийг боловсронгуй болгох арга зам	Р. Оюунбадам /гавьяат хуульч, хурандаа/	2007 он №3/18/
9.	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 67 дугаар зүйлд хийх мониторингийн дүн, цаашид хэрэгжүүлэх зөвлөмж	С.Болормаа /МУИС-ийн Хууль зүйн сургуулийн багш, докторант/	2007 он №4/19/
10.	Албадан ажил хийлгэх ял ногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг гүйцэтгэх ажиллагааны онцлог, практикийн зарим асуудал	Ч.Өнөрцэгцэг /ШШГЕГ-ын Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих тасгийн ахлах байцаагч, ахлах дэслэгч/	2007 он №4/19/
11.	Хорих ялын үр нөлөө, түүнд хийсэн дүн шинжилгээ	Г.Оюунболд /ХЗУТ-ийн Криминологийн судалгааны секторын эрдэм шинжилгээний ажилтан/	2007 он №4/19/

Эрх зүйн үйлчилгээ

1.	Интернет ба эрх зүй	Р. Очирбал /ОТИС-ийн Хууль зүйн сургуулийн багш/	2007 он №1/16/
2.	Үндэсний эрх зүйн тогтолцоонд нотариатын эзлэх байр суурийг тодорхойлох асуудал	Ч. Баянжаргал /Хууль зүйн магистр, нотариатч/	2007 он №1/16/
3.	Нотариатчдын ёс зүйн үндсэн зарчим, нотариатч төрийн чиг үүргийг хэрэгжүүлэгч болох нь	Д. Дуламцоо /Баянгол дүүргийн тойргийн нотариатч/	2007 он №2/17/
4.	Нотариатчаар гэрчлэгдэж буй үйлдэл, түүнийг өргөжүүлэх боломж	Д. Намсрайжав /нотариатч/	2007 он №3/18/
5.	Шилжин суурьших хөдөлгөөний өнөөгийн байдал, цаашид анхаарах асуудал	М.Сэлэнгэмөрөн /ИБМУТ-ийн мэргэжилтэн/	2007 он №4/19/

Өгүүлэг

1.	Багш нь гэмт хэрэгтэн байжээ		2007 он №2/17/
2.	Зарлан дуудах		2007 он №3/18/

Мэдээ, мэдээлэл

1.	Монгол Улсын Ерөнхийлөгч хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаатай танилцлаа	2007 он №1/16/
2.	Бизнесийн холбогдолтой Монгол Улсын хуулиуд CD нийтийн хүртээл боллоо	2007 он №1/16/
3.	"2007 оны 8 дугаар сарын 9-ний Улсын Их Хурлаар батлагдсан Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн зарим зүйл, звалтыг хэрэглэх журмын тухай" Улсын дээд шүүхийн тогтоол	2007 он №3/18/
4.	Монгол Улсын хууль зүйн салбарт-12 жил	2007 он №4/19/
5.	Монголын Шүүгч эмэгтэйчүүдийн холбоо Олон улсын Шүүгч эмэгтэйчүүдийн холбооны гишүүн боллоо	2007 он №4/19/
6.	Монгол дархны гайхамшиг	2007 он №4/19/
7.	"Хууль дээдлэх ёс" сэтгүүлийн 2007 оны нийтлэлийн жагсаалт	2007 он №4/19/

Заншлын эрх зүйн асуудлаар олон улсын эрдэмтэд санал солилцлоо



Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийн хяналт, шинжилгээ, үнэлгээг хэлэлцэв

“Монгол Улсын Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийн хяналт, шинжилгээ, үнэлгээ” нэгдсэн тайланг хэлэлцэх бага хурал Хууль зүйн үндэсний төвд боллоо. Бага хурлыг Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Баясгалан удирдав.

“Монгол Улсын Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийн хяналт шинжилгээ, үнэлгээ” нэгдсэн тайланг ажлын хэсгийн ахлагч, доктор Т.Мэндсайхан танилцуулж, ажлын хэсгийн зөвлөх, доктор, профессор, гавьяат хуульч Б.Чимид нэгдсэн тайлангийн 3 дахь хэсэг буюу “Нэгдсэн дүгнэлт”-ийн төсөлд зөвлөмж өгөн, ажлын хэсгийн зөвлөх, академич Ж.Амарсанаа нэгдсэн тайлангийн 4 дэх хэсэг буюу “Санал”-ын төсөлд өгөх зөвлөмжийг танилцуулав.

Бага хурлын үеэр “Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийг дусгаж, өөр хэлбэрээр үргэлжлүүлэх нь зүйтэй юм” гэсэн дүгнэлтэд хүрсэн байна.

Хууль зүйн үндэсний төв, “Их Засаг” их сургууль, Буриадын улсын их сургууль хамтран “Монгол, Буриадын заншил, заншлын эрх зүй” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний бага хурлыг 11 дүгээр сарын 22-ны өдөр зохион байгуулав.

Олон улсын эрдэм шинжилгээний бага хуралд Буриадын улсын их сургуулийн Дорнод судлалын стратеги судалгааны төвийн захирал, доктор, профессор Л.В.Шулунова, Эрх зүйн ба төрийн онол, түүхийн болон үндэсний хуулийн эрх зүйн тэнхимийн эрхлэгч, доктор, профессор А.Т.Тумурова, А.Г.Тышкенова зэрэг эрдэмтэн зочид хүрэлцэн ирсэн юм.

Алдаатай бодлогын улмаас төдий л судлагдаагүй гэх энэ салбар эрх зүйн талаар илтгэгчид үзэл бодлоо илэрхийлснээс МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Монгол төр, эрх зүйн түүхийн судлалын төвийн эрхлэгч, доктор, дэд профессор Б.Баярсайханы “Монголын хууль цаазын эх сурвалжийн нэрийн тухай” сэдэвт илтгэл анхаарал татав.

Хурлын төгсгөлд Хууль зүйн үндэсний төвийн захирал, академич Ж.Амарсанаа, Буриадын улсын их сургуулийн Дорнод судлалын стратеги судалгааны төвийн захирал, доктор, профессор Л.В.Шулунова нар шинжлэх ухаан, боловсролын салбарт хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурлаа.

Хүүхдийн эрхийн хамгаалал эрдэмтэн судлаачдын анхааралд байна



Хууль зүйн үндэсний төвд 12 дугаар сарын 20-ны өдөр “Гэмт хэргийн хохирогч насанд хүрээгүй хүмүүсийн эрхийн хамгаалал” сэдэвт бага хурал болов.

Хууль зүй, дотоод хэргийн яам, Гэмт хэргээс урьачилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Дэлхийн зөн олон улсын байгууллага, Хууль зүйн үндэсний төв, Хүүхдийн төлөө үндэсний газар, Хүчирхийллийн эсрэг үндэсний төв хамтран энэхүү хурлыг зохион байгуулсан юм.

Ядуурал, ажилгүйдэл, гэр бүлийн хүчирхийлэл, сургууль завсардалт гээд өнөөгийн нийгэмд буй бараан бүхэн хүүхдийг гэмт хэргийн золиос болгож байгааг хуралд оролцогчид эмзэглэн онцолж байлаа.

Энэ удаагийн хуралд тавьсан илтгэлүүдээс Хууль зүйн үндэсний төвийн Криминологийн судалгааны секторын эрдэм шинжилгээний ажилтан Г.Оюунболдын “Хүүхдийн гэмт хэргээс урьачилан сэргийлэх ажлын чанар, үр нөлөөг дээшлүүлэх нь”, Хүүхдийн төлөө үндэсний газрын хүүхэд хамгааллын мэргэжилтэн Г.Ундрахын “Хохирогч хүүхдийн оролцоог дээдлэх нь” сэдэвт илтгэл анхаарал татсан юм.